*тоглох* дургай  
*идэх* дургүй  
*унших* ном  
*гэгээрүүлэх* яам

надо *итти*  
*приходить* не нужно  
намерен *войти*  
хочет, любит *играть*  
не хочет, не любит *кушать*  
книга *для чтения*  
министерство *просвещения*

Поэтому будущее причастие в словарях помещается как бы вместо русского неопределенного наклонения, например:

<b>бичих</b>	писать	<b>мэдэх</b>	знать
<b>суух</b>	сидеть	<b>харих</b>	уходить домой

2. Окончаниями будущего причастия являются:

1) **-ах, -эх, ох, -өх** (по гармонии гласных), если основа глагола оканчивается на какой-либо согласный, кроме шипящих или палатализованных, например:

**ор** + **ох** = **орох** войти  
**яв** + **ах** = **явах** ийти  
**ир** + **эх** = **ирэх** приходить  
**дөр** + **өх** = **дөрөх** гореть

**судал** + **ах** = **судлах** изучать  
**дуус** + **ах** = **дуусах** кончать  
**дүүр** + **эх** = **дүүрэх** наполняться

2) **-их**, если основа глагола оканчивается на какой-либо шипящий согласный или палатализованный, обозначаемый при помощи мягкого знака **ь** или гласного **и**, которые при этом выпадают, например:

**унш** + **их** = **унших** читать  
**бич** + **их** = **бичих** писать  
**хөгж** + **их** = **хөгжих** развиваться

**харь** + **их** = **харих** уходить домой  
**зовни** + **их** = **зовних** мучиться

3) **-х**, если основа глагола оканчивается на любой гласный, например:

**суу** + **х** = **суух** сидеть  
**бай** + **х** = **байх** быть  
**нүү** + **х** = **нүүх** кочевать

**нуу** + **х** = **нуух** скрывать  
**зөвлө** + **х** = **зөвлөх** советовать  
**гарга** + **х** = **гаргах** выпускать

3. Необходимо запомнить, что будущее причастие в сочетании с глаголом **болов** (становиться, быть) выражает действие, которое близко к совершению. Поэтому в данном сочетании глагол **болов** в той или иной форме переводится на русский язык как «скоро», например:

Би явах *болов*.

Миний дүү сургуульд явах  
*болов*.

Миний аав ирэх *болов*.

Я *скоро* пойду.

Мой младший брат *скоро* пойд-  
дет в школу.

Мой отец *скоро* придёт.

4. Форма будущего причастия в орфографическом отношении имеет то особое исключение, что она при наращении к ней падежных окончаний никогда не теряет гласную своего последнего слога, например:

явахад	когда пойдёт
ороход	при входе
орохыг	о том, что войдет
орохын тул	чтобы войти
орохоор	чтобы войти
орохоос өмнө	до того, как войти
орохтой хамт	одновременно со входом

Со значением и употреблением причастий в изменяемых (падежных) формах мы познакомимся в дальнейших текстах.

5. Причастие прошедшего времени (гүйцэд өнгөрсөн цагийн нэр тэмдгийн төлөвт үйл үг) или прошедшее причастие выражает действие, состоявшееся или совершенное в прошлом, например:

Багш *ирсэн*.

Сурагчид *явсан*.

Учитель *пришел*.

Ученики *ушли*.

В своем сказуемом употреблении прошедшее причастие иногда сопровождается связкой **байна**, которая может опускаться, например:

Багш явсан [байна].

Сурагчид ирсэн [байна].

Учитель [оказывается] ушел.

Ученики [оказывается] пришли.

6. Окончаниями прошедшего причастия являются **-сан, -сэн, -сон, -сөн** (по гармонии гласных), например:

яв + сан = явсан ушел, ушедший

суу + сан = суусан сел, севший

ир + сэн = ирсэн прибыл, прибывший

нүү + сэн = нүүсэн перекочевал, перекочевавший

ор + сон = орсон вошел, вошедший

хөгж + сөн = хөгжсөн развился, развивавшийся

эхэл + сэн = эхэлсэн начал(ся), начавший(ся)

7. Как мы увидим в дальнейших текстах, причастия существенно отличаются от изъявительных форм, могущих быть в предложении только сказуемым, тем, что они в предложении могут быть:

1) сказуемым, находясь в конце предложения (багш *ирсэн* — учитель *прибыл*);

2) определением, находясь перед каким-нибудь именем (*ирсэн* багш — *прибывший* учитель [учитель, *который* *прибыл*]);

3) дополнением, будучи даны в форме какого-нибудь падежа (багшийн *ирснийг* би мэдэв — о *приходе* учителя [о том, *что* *пришел* учитель] узнал я);

4) обстоятельством, также будучи даны в форме какого-нибудь падежа (багшийн *ирэхэд* та юу хэлэв? — что вы сказали, *когда* *прибыл* учитель?);

5) подлежащим, будучи даны в форме именительного падежа и часто сопровождаясь лично-притяжательными частицами (багшийн хэзээ *ирэх нь* одоо ил биш — не ясно теперь, *когда* *прибудет* учитель).

Стало быть, причастия (в отличие от изъявительных форм глагола) могут склоняться по всем падежам так же, как и имена.

## У П Р А Ж Н Е Н И Я

### 1. Переведите на монгольский язык:

1) Вчера я написал письмо. 2) Я перевел этот урок на монгольский язык. 3) Вы вчера слушали доклад? 4) Вчера вы занимались? 5) Вчера вечером я был в кино. 6) Ты читал вчера биографию Гоголя? 7) Да, я вчера прочитал биографию Гоголя. 8) Можно ли взять вашу книгу? 9) Да, можно взять мою книгу. 10) Домашнее задание писать карандашом нельзя, нужно писать чернилами. 11) Я завтра поеду в город Улан-Батор. 12) Мой младший брат придет завтра.

### 2. Ответьте на следующие вопросы:

1) Та маргааш танай дээд сургуульд очих уу? 2) Та нодниг юу хийсэн байна? 3) Энэ нөхөр өнөөдөр Бүгд Найрамдах Монгол Ард Улсад явах уу? 4) Бид Улаанбаатар хотод хэзээ явах вэ? 5) Орж болох уу? 6) Та маргааш юу хийх санаатай байна? 7) Таны багш ирэх болов уу? 8) Өнөөдөр ямар хичээл болох вэ? 9) Бидэнд ямар багш монгол хэл заах вэ? 10) Та өнөөдөр орой ямар ном унших вэ? 11) Та Москва хотод хэзээ ба хаанаас ирсэн бэ? 12) Та өчигдрийн сонин уншсан уу? 13) Та өнөөдөр хэдэн цагт боссон бэ? 14) Өчигдөр ямар өдөр байсан бэ? 15) Бүтэн сайн өдөр юу болсон бэ? 16) Бүтэн сайн өдөр та юу хийсэн бэ? 17) Чи номын сангаас ирээд юу хийх вэ? 18) Маргааш ямар илтгэл болох вэ? 19) Энэ илтгэл хаа болох вэ? 20) Энэ илтгэлийг хэн хийх вэ? 21) Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Газрын зүй хэн заах вэ?

### 3. Вставьте пропущенные окончания будущего и прошедшего причастий:

1) Би өчигдөр хичээл давт... байна. 2) Бид бүтэн сайн өдөр амр... ба зугаац... байна. 3) Би өчигдөр тавдугаар хичээлийг давт... байна. 4) Маргааш бид монголоор яр... ба бич... юм. 5) Би өчигдөр сайхан кино үз... байна. 6) Өнөөдөр таны дүү хаа яв... вэ? 7) Та маргааш өглөө хэдэн цагт бос... вэ? 8) Намын үүрийн нарийн бичгийн дарга ямар яриа хий... бэ? 9) Та өчигдөр ямар хичээлийг орчуул... бэ? 10) Таны аав гэртээ яв... уу? 11) Миний аав маргааш гэртээ яв... юм.

### 4. Напишите сочинение на тему «Как я провел свой выходной день».

## 7 ДОЛООДУГААР ХИЧЭЭЛ СЕДЬМОЙ УРОК

---

### ЯРИА

Чи одоо яах гэж байна? Би одоо энэ номыг унших гэж байна. Тэгээд би бол Зөвлөлтийн ба Монголын ард түмний ах дүүгийн харилцааны тухай илтгэл сонсох гэж байна. Одоо илтгэгч энд ирэх болов. Чи өнөөдөр хэдэн цагт гэртээ харих гэж байна? Би өнөөдөр оройн долоон цагт гэртээ харих гэж байна.

Чи ирэх бүтэн сайн өдөр юу хийх гэж байна? Би ирэх бүтэн сайн өдөр нөхрийндөө зочлон очих гэж байна. Чиний нөхөр чамайг урив уу? Тиймээ, миний нөхөр намайг гэртээ урив.

Та хэнээс захидал авав? Би эгчээсээ захидал авав. Миний эгч бол бид цөм мэнд сайн байна гэж бичив. Таны эгч хаа сууна? Миний эгч хөдөө нутагтаа сууна. Таны эгч ямар ажил хийж байна? Миний эгч дунд сургуульд багшилж байна.

Чиний аав чамд юу хэлэв? Миний аав надад: «Сахилга баттай, эрдэм сайн сур!» гэж хэлэв. Чи энэ сургуулийг хэзээ төгсгөнө? Би энэ сургуулийг ирэх жилд төгсгөнө.

Одоо нөхөр Дорж хаа байна? Нөхөр Дорж номын дэлгүүрт очив. Нөхөр Дорж сурах бичиг ба бэх худалдаж авах гэж явсан юм.

Энд олон оюутан нар ирэв. Тэд юунд ирэв? Тэд бол Зөвлөлтийн ба Монголын ард түмний эв найрамдлын тухай илтгэл сонсох гэж энд ирэв. Одоо удахгүй илтгэл эхэлнэ.

Чиний аав хаа очоод ирэв? Миний аав урждар хөдөө гараад ирэв. Миний аав «Хөдөө нутагт цас ороод хүйтэн болов» гэж хэлэв. Одоо гадаа ширүүн салхи салхилж байна. Миний ээж бол «салхивчийг хаа!» гэж хэлэв. Би салхивчийг хаав.

Таны нутагт цас бороо их ордог уу? Манай нутагт цас бороо их ордоггүй юм. Манай нутагт цас бороо ховор ордог.

Заримдаа ган болно. Одоо бид гагтай тэмцэж байна. Чийг их болно. Бид ганг ялна!

Нөгөөдөр үдэш манай дээд сургуульд юу болох вэ? Нөгөөдөр үдэш манай дээд сургуульд үдэшлэг болох юм.

## Слова

**ях** что делать? как быть?  
**зөвлөлтийн** советский  
**ард түмэн** народ  
**ах** дүүгийн братский  
**харилцаа(н)** взаимоотношение  
**илтгэгч** докладчик  
**долоо(н)** семь  
**ирэх** эд. будущий, наступающий  
**хань (нөхөр)** друг  
**зочлох** гостить  
**урих** приглашать  
**эгч** старшая сестра  
**суух** эд. жить, проживать  
**хөдөө(н)** худон (*сельская местность*)  
**нутаг** родимый край; кочевье; местность  
**багшлах** преподавать, учить  
**төгсгөх** закончить, окончить  
**жил** год  
**дэлгүүр** магазин  
**юунд** зачем, почему  
**[эв]найрамдал** дружба, мир

**удахгүй** скоро  
**очоод ирэх** съездить, сходить  
**урждар** позавчера  
**цэс(ан)** снег  
**орох** эд. итти, выпасть (*о дожде и снеге*)  
**хүйтэн** холодно; холодный  
**гадаа** на улице, на дворе, вне (дома)  
**ширүүн** порывистый, сильный  
**салхи(н)** ветер  
**салхилах** дуть (*о ветре*)  
**бороо(н)** дождь  
**чийг** влага; осадки  
**сар** месяц  
**хуурай** сухо; сухой  
**ган(г)** засуха  
**тэмцэх** бороться  
**ялах** победить  
**үдэшлэг** вечер, вечеринка  
**нөгөөдөр** послезавтра  
**нөхрийнд** к товарищу (на дом)  
**хамтралчид** колхозники

## ГРАММАТИКА

1. Глагол **гэх** (говорить, сказать) в форме соединительного деепричастия весьма употребителен в монгольском языке и имеет следующие основные значения:

1) в сочетании с глаголом **байх** после другого глагола, данного в форме будущего причастия, значит *собираться*, например:

Би кинонд явах *гэж байна*.  
Багш өчигдөр цэцэрлэгт очих *гэж байсан*.  
Сурагчид одоо хичээл давтах *гэж байна*.

Я *собираюсь* итти в кино.  
Учитель вчера *собирался* отправиться в парк.  
Ученики теперь *собираются* повторить урок.

2) перед речевыми глаголами означает *что* (иными словами, форма **гэж** служит средством передачи прямой речи, которая на русский язык чаще всего переводится косвенной речью), например:

Цас оров *гэж* хэлэв.  
Маргааш ирнэ *гэж* бичив.

Сказал, *что* выпал снег.  
Написал, *что* прибудет завтра.

Багш ирэв гэж мэдэв.

Узнал, что учитель пришел  
(или: подходит).

3) перед прочими, неречевыми, глаголами и после любого другого глагола, данного в форме будущего причастия, значит *чтобы*, например:

Сурагчид ном унших гэж номын санд очив.

Ученики пошли в библиотеку, *чтобы* прочитать книгу.

Багш хичээл хийх гэж хичээлийн тасалгаанд оров.

Учитель вошел в аудиторию, *чтобы* провести урок.

Өглөөний хоол идэх гэж хоолны газарт явав.

Отправился в столовую, *чтобы* позавтракать.

Примечания. а) Речевыми глаголами называются все те глаголы, которые сопровождают прямую или косвенную речь, например, *хэлэх* говорить, *бичих* написать, *унших* читать, *сонсох* слышать, *хариулах* отвечать, *асуух* спросить, *мэдэх* знать и т. п.;

б) перед неречевыми глаголами и после других глаголов, данных в любой изъявительной или причастной форме, форма *гэж* очень часто выражает мнимую причину, несостоятельный повод или отговорку и переводится на русский язык словами «говоря» или «ссылаясь на то, что..», например:

Их хүйтэн болов гэж гэртээ сууна.

Сидит дома, *говоря*, что стало очень холодно.

Багш ирэхгүй гэж хичээл давтсангүй.

Не повторил урок, *ссылаясь на то*, что учитель не придет.

Цас их орсон гэж сургуульд явсангүй.

Не пошел в школу, *ссылаясь на то*, что снегу выпало много.

## У П Р А Ж Н Е Н И Я

### 1. Переведите на монгольский язык:

1) Товарищ Дамдин ушел в институт, чтобы принести учебник. 2) Я пришел сюда, чтобы прочитать вчерашнюю газету. 3) Послезавтра я собираюсь ехать в г. Чойбалсан. 4) Мой товарищ написал, что в г. Чойбалсан выпал снег. 5) Что ты собираешься делать завтра вечером? 6) Завтра вечером я собираюсь итти на студенческий вечер. 7) Кто сказал, что товарищ Дамдин принес учебник? 8) Я сказал, что товарищ Дамдин принес учебник. 9) Наш преподаватель сказал, что завтра мы будем читать и разговаривать по-монгольски. 10) Что сказал наш преподаватель? Наш преподаватель сказал, что завтра нужно принести учебники. 11) Что здесь написано? 12) Здесь написано, что *колхозники* победили засуху.

### 2. Ответьте на следующие вопросы:

1) Чи өвлийн амралтаар хаа явах гэж байна? 2) Чи юу худалдаж авах гэж байна? 3) Чи яах гэж номын санд явна? 4) Чи

одоо ямар ном унших гэж байна? 5) Та хэнтэй хичээл давтах гэж байна? 6) Зөвлөлтийн ба Монголын ард түмний эв найрамдлын тухай хэн илтгэл хийх гэж байна? 7) Одоо хэн энэ хичээлийг бэлтгэх гэж байна? 8) Одоо хэн номын санд явах гэж байна? 9) Чойбалсан хотод их цас оров гэж хэн хэлэв? 10) Та ном худалдаж авах гэж хаа явна? 11) Өнөөдөр хэн Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Газрын Зүйн хичээлийг давтах гэж байна? 12) Та ямар хичээлийг давтах гэж байна? 13) Чи хэнд захидал бичих гэж байна? 14) Чи энэ номыг надад хэзээ өгөх гэж байна? 15) Чи манай дээд сургуулийг төгсгөөд хаа ажиллах гэж байна? 16) Хөдөө нутагт их цас ороод хүйтэн болов гэж хэн хэлэв? 17) Та хэнтэй гэртээ харих гэж байна? 18) Чи хэзээ тэшүүрээр гулгаж тоглох гэж байна? 19) Танай багш, яах хэрэгтэй гэж хэлэв? 20) Чиний аав бол ямраар сурах хэрэгтэй гэж хэлэв?

3. Напишите сочинение на тему «Что рассказал мой преподаватель».

## 8 НАЙМДУГААР ХИЧЭЭЛ ВОСЬМОЙ УРОК

---

### ХУРАЛ БОЛОВ

Нөхөр Дорж манайд ирээд: «Өнөөдөр манай дээд сургуульд багш нар ба албан хаагчдын хурал болох юм, бид тэр хуралд очоод ирье» гэж хэлэв. За, тэгье гэж би хариулав. «Одоо бид явъя» гэж нөхөр Дорж хэлэв. Бид тус хуралд ирэв.

Тус хуралд манай дээд сургуулийн багш нар ба албан хаагчид суулцав. Хурлыг манай дээд сургуулийн хичээл ангийн эрхлэгч нээв. Тэгээд хурлын тэргүүлэгчдийг сонгов.

Тус хуралд манай дээд сургуулийн захирал «Энэ хичээлийн жилийн нэгдүгээр хагасын дүн ба цаашдын зорилгын тухай» илтгэлийг хийв.

Илтгэгч бол «Манай дээд сургууль хичээлийн жилийн нэгдүгээр хагаст урьдхиас илүү их амжилтыг олов» гэж тэмдэглэв. Илтгэгч бол бид бүх ажлаа онц сайнаар зохиож, үлгэртэй болгоё, манай оюутан нарын сурлага хүмүүжлийн ажлын чанарыг улам сайжруулъя, оюутан нарын үзэл суртлын хүмүүжлийг өндөр шатанд гаргая» гэж хэлэв.

«Мөн багш нарын мэрэгжил ба улс төрийн мэдлэгийг дээшлүүлье» гэж уриалав. «Манай бүх анхаарлыг эдгээр зорилгонуудыг биелүүлэх хэрэгт зориулъя, эдгээр зорилгонуудыг биелүүлэх тухай ярилцъя» гэж хэлээд өөрийн илтгэлийг төгсгөв.

Илтгэлийн дараа олон хүн манай дээд сургуулийн ажлыг цаашид сайжруулах тухай санал шүүмжлэлийг гаргав. Намын үүрийн нарийн бичгийн дарга: «би ярья» гэв. Тэр бол манай оюутан нарыг Маркс, Энгельс, Ленин, Сталины онолоор зэвсэглүүлэх ба тэдгээрийг хичээлээс гадуур хүмүүжүүлэх тухай ярив. Түүний дараа коммунист залуучуудын эвлэлийн үүрийн дарга ба үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга нар үг хэлэв. Мөн олон багш нар санал шүүмжлэл гаргав.

Тус хурал бол манай оюутан нарын хичээл ба коммунист хүмүүжлийг дээд шатанд гаргах тухай ба багш нарын мэрэгжил ба улс төрийн мэдлэгийг дээшлүүлэх тухай чухал тогтоол гаргав.

Хурал төгсөв. Чи хаа явах гэж байна? Би гэртээ харина. За, сайн яваарай. Нөхөр Дамдинд баяр хүргээрэй. Чи энэ хурлын тухай ханын сонинд бичээрэй. Мөн энэ хичээлийг орчуулаарай. Чи маргааш эрт ирээрэй. Чи номын сангаас сонирхолтой ном авчраарай. Чи долоодугаар хичээлийг сайтар давтаарай. Чи гэрийн даалгаврыг биелүүлээрэй. За, баяртай, сайн яваарай.

## С л о в а

тэгье ладно, давай  
тус данний, это  
эрхлэгч заведующий  
сонгох избирать, выбирать  
хичээлийн жил учебный год  
хагас половина  
дүн(г) итог  
зорилго задача, цель  
цаашдын дальнейший  
урьдахь прежний, предыдущий  
илүү лучше  
амжилт успех, достижение  
олох зд. добиться  
тэмдэглэх отметить  
зохиох организовать  
үлгэртэй образцовый, примерный  
хүмүүжил воспитание  
чанар качество  
сайжруулах улучшать  
үзэл суртлын идейный, идеологиче-  
ский  
өндөр высокий  
шат(ан) уровень, ступень

мэрэгжил квалификация  
улс төрийн политический  
мэдлэг знание. кругозор  
дээшлүүлэх поднять, повышать  
уриалах призывать  
бүх все  
анхаарал внимание  
эдгээр эти  
биелүүлэх выполнить, реализовать  
хүн человек  
санал мнение  
шүүмжлэл критика  
онол теория  
зэвсэглүүлэх вооружать  
тэдгээр они  
хүмүүжүүлэх воспитывать  
үйлдвэрчний эвлэл профсоюз  
үг слово, речь  
мөн зд. также  
тогтоол резолюция, постановление  
баяр привет  
хүргэх передать  
сайтар хорошенко

## ГРАММАТИКА

1. К группе повелительных форм относится форма обращения первого лица обоих чисел (нэгдүгээр биеийн хүсэх төлөв). При помощи этой формы говорящий либо выражает свое намерение

совершить какое-либо действие, либо приглашает второе лицо совместно с ним, говорящим, что-либо сделать, например:

За, одоо би *явья!*  
Маргааш хуралд *очьё!*

Ну, я теперь *пойду!*  
*Пойдем* (пойду) завтра на собрание!

Энэ номыг *авья!*

Давай *возьмем* эту книгу!; Дай *возьму* эту книгу!

2. Окончаниями формы обращения первого лица являются:

1) **-ья, -ьё**, если основа глагола с задними гласными оканчивается на согласный, например:

гар + **ья** = **гарья** выйдем!  
униш + **ья** = **унишья** прочтем!  
ор + **ьё** = **орьё** войдем!  
ол + **ьё** = **ольё** найдем!  
оч + **ьё** = **очьё** пойду!, пойдем!

2) **-ье**, если основа глагола с гласными переднего ряда оканчивается на любой согласный, например:

бич + **ье** = **бичье** напишу!; напишем!  
хүр + **ье** = **хүрье** достигну!; достигнем!  
ир + **ье** = **ирье** приду!; придем!

3) **-я, -ё, -е**, если основа оканчивается на любой гласный или (на письме) на мягкий знак, например:

хая + **я** = **хаяя** брошу!; бросим!  
хаа + **я** = **хаая** закрою!; закроем!  
нээ + **е** = **нээе** открою!; откроем!  
боо + **ё** = **бооё** обверну!; обвернем!  
боль + **ё** = **больё** перестану!; перестанем!  
гарга + **я** = **гаргая** вынесу!; вынесем!

По-русски подобные обороты часто передаются в сочетании с глаголом «давай» или «давайте», например: **явья** — давай я пойду!; давай пойдем!

3. Форма обращения второго лица будущего времени (урьдаас хүсэх төлөв — форма выражения желания на будущее) выражает пожелание или повеление совершить что-либо в будущем, а не в момент речи, например:

Манайд *ороорой!*                      *Заходи* к нам!  
Маргааш *яваарай!*                    *Пойдешь* завтра!

4. Окончаниями формы обращения второго лица будущего времени являются:

1) **-аарай, -ээрэй, -оорой, -өөрэй**, если основа глагола оканчивается на краткий гласный, кроме **и**, или на любой согласный, например:

**гарга + аарай = гаргаарай!** выпусти [потом]!  
**гар + аарай = гараарай!** выйдешь, выходи [потом]!  
**ол + оорой = олоорой!** найди [потом]!  
**ир + ээрэй = ирээрэй!** приходи!  
**өргө + өөрэй = өргөөрэй!** поднимешь!

2) **-иарай, -иорой**, если основа глагола оканчивается на гласный **и** или мягкий знак **ь**, который при этом выпадает, например:

**соль + иорой = солиорой!** переменишь!  
**залги + иарай = залгиарай!** проглотишь!  
**холь + иорой = холиорой!** смешаешь!

3) **-гаарай, -гээрэй, -гоорой, -гөөрэй**, если основа глагола оканчивается на дифтонг или долгий гласный, например:

**хаа + гаарай = хаагаарай!** закроешь!  
**нээ + гээрэй = нээгээрэй!** откроешь!  
**нөө + гөөрэй = нөөгөөрэй!** сбереги!  
**хий + гээрэй = хийгээрэй!** сделаешь!  
**нүү + гээрэй = нүүгээрэй!** перекочуешь!  
**гүй + гээрэй = гүйгээрэй!** беги [потом]!

## У П Р А Ж Н Е Н И Я

### 1. Переведите на монгольский язык:

1) Товарищи, давайте проведем этот урок. 2) Давайте пригласим на наше собрание заведующего учебной частью. 3) Давайте поговорим о нашей дисциплине. 4) Идемте в библиотеку нашего института. 5) Товарищ Дамдин, пойдем на доклад директора нашего института. 6) Давайте я схожу в учебную часть. 7) Приезжай к нам в следующий выходной день. 8) Давайте поговорим по-монгольски. 9) Улучшим учебно-воспитательную работу наших студентов.

### 2. Ответьте на следующие вопросы:

1) Та хэний илтгэлийг сонсов? 2) Та ямар илтгэлийг сонсов? 3) Илтгэгч юу хэлэв? 4) Хэдэн хүн санал шүүмжлэл гаргав? 5) Хэн үг хэлэв? 6) Хэн юу хэлэв? 7) Ямар тогтоол гаргав? 8) «Чи сайн яваарай» гэж хэн хэлэв? Та одоо юу хийнэ? 9) «Энэ номыг уншъя» гэж хэн хэлэв? 10) Илтгэгч бол оюутан нарын үзэл суртлын хүмүүжлийн тухай юу хэлэв? 11) Одоо бид юу хийнэ?

3. Составьте по два предложения, используя каждый из следующих глаголов в двух формах обращения:

явах, хийх, хэлэх, тэмдэглэх,  
хариулах, сайжруулах, дээшлүүлэх,  
ярилцах, төгсгөх, бичих, авчрах,  
унших, биелүүлэх, хүмүүжүүлэх.

Образец: үзэх

1) Бид энэ зургийг үзье! 2) Чи маргааш үзээрэй.

## 9 ЕСДҮГЭЭР ХИЧЭЭЛ ДЕВЯТЫЙ УРОК

---

### ОНЦ САЙН СУРЛАГЫН ТӨЛӨӨ!

Бид бол манай дээд сургуулийн багш нар ба албан хаагчдын хурлын тогтоолыг хэрэгжүүлэх ёстой байна. Манай оюутан нар бол онц сайнаар сурах ба өөрсдийн улс төрийн мэдлэгийг дээшлүүлэх ёстой юм.

Оюутан бүхэн өөрийн цагийг зөвөөр хуваарлах ёстой. Онцчууд бол өөрсдийн цагийн хуваарыг зөвөөр зохиодог юм. Миний нөхөр Дамдин манай дээд сургуульд сурдаг билээ. Тэр бол өөрийн цагийг зөвөөр хуваарладаг билээ.

Зарим оюутан нар өөрийн цагийг зөвөөр хуваарлахын ач тусыг ойлгоогүй байгаа юм. Иймд тэд бол амралтыг бүрмөсөн мартаж, өдөр шөнөгүй хичээл хийдэг байна. Энэ бол тэдгээрийн сурлага ба эрүүл мэндэд хортой юм. Иймд цагийг зөвөөр ашиглах хэрэгтэй.

Онц сайн сурахын төлөө багш нарын лекци хичээлүүдийг анхааралтайгаар сонсон товч тэмдэглэл хийж авах хэрэгтэй. Оюутан бүхэн хичээлийг давтах ба багш нарын даалгаврыг заавал биелүүлдэг байх ёстой. Одоо давтлага болно. За, давтлагыг эхэлье.

Давтлага бол сурлагын эх мөн. Хичээлийг хэрхэн давтах бэ? Гэрэл сайтай, чимээ шуугиан багатай газарт очиж хичээл давтах хэрэгтэй. Хичээлийг өглөө эрт давтах хэрэгтэй. Өглөө эрт хүний тархи юмыг сайнаар тогтоодог юм.

Цагийг зөв ашиглах хэрэгтэй. Хичээлийг нэг цаг хиртэй давтаад, гадаа гарч цэвэр агаарт жаахан зугаацах хэрэгтэй. Хичээлийг хэд дахин анхааралтайгаар унших хэрэгтэй. Тэгээд тус хичээлийн тухай сайтар бодох хэрэгтэй. Үүний дараа товч тэмдэглэл хийх хэрэгтэй. Бас дасгал хийдэг байх хэрэгтэй.

Онцчууд бол сул сурлагатай оюутан нарт туслалцах ёстой. Нэг оюутан бол нөгөө оюутны төлөө санаа зовж туслалцах ёстой. Зарим өвчтэй хэвтэж хичээлээс хоцрогдсон оюутан нартай хичээлийг давталцаж туслах хэрэгтэй.

Чи энэ хичээлийг давтав уу? Үгүй, давтаагүй байна. Үүнийг заавал давтаарай! Чиний нөхөр гэртээ явав уу? Яваагүй байна. Энэ ном хаа байв? Энэ ном энд байв. Одоо таны дүү юу хийж байна? Одоо миний дүү сурч байгаа юм.

### С л о в а

төлөө за, для, чтобы  
хэрэгжүүлэх реализовать, выполнить  
өөрсдийн свои  
бүхэн каждый  
хуваарлах распределить  
цагийн хуваар режим для, расписание  
ач тус значение; польза  
ойлгох понимать  
бүрмөсөн полностью, совсем  
мартах забыть  
өдөр шөнөгүй день и ночь  
турш в течение  
эрүүл мэнд здоровье  
хортой вредно  
товч тэмдэглэл конспект  
заавал обязательно  
эх мать

хэрхэн как, каким образом  
гэрэл свет, освещение  
чимээ шуугиа(н) шум  
гархи мөзг  
тогтоох эд. запоминать, закреплять  
в памяти  
хиртэй приблизительно, примерно  
дахин раз  
хэдэн эд. несколько  
бодох думать, подумать  
дасгал упражнение  
онцчууд отличники  
сул слабо, слабый  
санаа зовох беспокоиться, заботиться  
өвчтэй больной  
хэвтэх лежать  
хоцрогдох отставать  
билээ *связка прошедшего времени со значением «был»*

## ГРАММАТИКА

1. а) Многократное причастие (дахин давтан үйлдэх чанартай нэр тэмдгийн төлөвт үйл үг) выражает действие, которое совершается кем-либо систематически или является характерной особенностью какого-либо предмета. Поэтому данное причастие в необходимых случаях переводится на русский язык с добавлением таких слов, как «по обыкновению», «обычно» и т. п., например:

Би өдөр бүр ном *уншдаг*.

Я [обычно] ежедневно *читаю* книги.

Цас хавар *хайлдаг*.

Снег *тагт* весной.

б) Если многократное причастие сопровождается связкой **байна**, которая почти всегда опускается, то она выражает действие, свойственное предмету в настоящее время или во все времена, например:

Би энд *суудаг* (байна).

Я [обычно] *сигжу* здесь (говорящий в момент речи может стоять или ходить).

Намар хүйтэн *болдог* (байна).

Осенью *становится* холодно.

Если же какое-либо действие было свойственно предмету в прошлом или будет таковым в будущем, то соответственно употребляются связки прошедшего времени (**билээ** или **байсан**) или — будущего (**болох**), например:

Би энд суудаг билээ.	Я [обычно] <i>сидел</i> здесь.
Багш өдөр бүр асуудаг байсан.	Учитель [обычно] <i>спрашивал</i> ежедневно.
Сурагчид тэнд ном уншдаг болох.	Ученики <i>будут</i> [обычно] <i>читать</i> книги там.

в) Окончанием многократного причастия является **-даг, -дэг, -дог, -дөг**, например:

яв	+	даг	=	явдаг	ходящий
ир	+	дэг	=	ирдэг	приходящий
ор	+	дог	=	ордог	входящий
өргө	+	дөг	=	өргөдөг	поднимающий
нүү	+	дэг	=	нүүдэг	кочующий
бай	+	даг	=	байдаг	находящийся

2. а) Настоящее или несовершенное причастие (гүйцэд бус өнгөрсөн цагийн нэр тэмдгийн төлөвт үйл үг) в качестве сказуемого обозначает действие настоящего времени, чаще всего начавшееся до момента речи, например:

Манай нөхөр сургуульд *байгаа* Наш товарищ *находится* в юм. школе.

Однако данное причастие в подобном употреблении встречается очень редко, ибо оно чаще всего употребляется с отрицанием **гүй**, обозначая действие, которое не состоялось, но должно еще совершиться (по русски такое действие обозначается при помощи оборота «еще не...»), например:

Манай багш одоо <i>ирээгүй</i> .	Наш учитель <i>ещё не пришел</i> (подразумевается: но еще придет).
Би тэнд <i>яваагүй</i> .	Я там <i>еще не был</i> (но буду).

б) Окончаниями настоящего или несовершенного причастия являются:

1) **-аа, -ээ, -оо, -өө**, если основа глагола оканчивается на любой согласный или краткий гласный, кроме **и**, например:

гар	+	аа	=	гараа	выходящий
ир	+	ээ	=	ирээ	приходящий
ор	+	оо	=	ороо	входящий
зөвлө	+	өө	=	зөвлөө	советующий

2) **-иа, -ио**, если основа глагола оканчивается на гласный и или мягкий знак ь, который при этом выпадает, например:

харь + иа = **хариа** уходящий домой  
соль + ио = **солио** меняющий  
залги + иа = **залгиа** проглатывающий

3) **-гаа, -гээ, -гоо, -гөө**, если основа глагола оканчивается на долгий гласный или дифтонг, например:

хаа + гаа = **хаагаа** закрывающий  
нээ + гээ = **нээгээ** открывающий  
зөө + гөө = **зөөгөө** таскающий  
нүү + гээ = **нүүгээ** кочующий  
суу + гаа = **суугаа** сидящий  
бай + гаа = **байгаа** сущий  
гүй + гээ = **гүйгээ** бегающий

## У П Р А Ж Н Е Н И Я

**Переведите на монгольский язык:**

1) Мы всегда конспектируем урок. 2) Отличники учебны ежедневно повторяют слова уроков. 3) На уроке монгольского языка мы разговариваем по-монгольски. 4) Я каждый день читаю монгольские газеты. 5) Мой старший брат еще не приехал из Улан-Батора. 6) Я каждый вечер хожу в библиотеку.

**2. Ответьте на следующие вопросы:**

1) Чи бүтэн сайн өдөр юу хийдэг вэ? 2) Та хэрхэн хичээл давтдаг вэ? 3) Чи цагийн хуваар хийдэг үү? 4) Чи хаа хичээл давтдаг вэ? 5) Чи ямар сонин уншдаг вэ? 6) Чиний аав хаа ажилладаг вэ? 7) Та нар дасгал хийдэг үү? 8) Чи хэзээ зугаацдаг вэ? 9) Та лекци сонсоод товч тэмдэглэл хийдэг үү? 10) Өнөөдрийн хичээлд хэн ирээгүй байна? 11) Чи хэзээ кино үздэг вэ? 12) Чи өвчтэй хэвтэж хичээлээс хоцрогдсон оюутан нартай хичээлийг давталцаж тусалдаг уу? 13) Чиний аав ямар дугуйланд сурдаг вэ?

**3. Вставьте в текст пропущенные окончания глаголов, отвечая на вопросы:**

1) Хэн гэртээ юу хий... юм бэ? 2) Та юу март... байна? 3) Та хэзээ энэ номыг унш... байна? 4) Хэн юугаар дээд сургуульд ир... байна? 5) Хэн бүтэн сайн өдөр юу үз... байна? 6) Хэн гэртээ харь... байна? 7) Хэзээ хичээл тар... байна? 8) Таны багш хаа ор... байна? 9) Хэн ямар сур... байна? 10) Та ямар трамвайгаар ир... байна? 11) Хэн хаа хоол ид... байна? 12) Хэн юу зөв ашигла... байна? 13) Хэн монгол сонин хаа унш... байна?

14) Хэн өөрийн цагийг зөвөөр хуваарл... байна? 15) Ямар сурлагатай оюутан нар хурлын тогтоолыг хэрэгжүүл... байна? 16) Хэн юунд бахд... вэ? 17) Онцчууд цагийг ямраар ашигл... вэ? 18) Хэн товч тэмдэглэл хийж ав... байна? 19) Та хаа хичээл давт... вэ? 20) Та хичээл тавтаад юу хий... байна? 21) Та өдрийн цагт зугац... уу? 22) Та хичээлийн дараа хэдэн цаг хиртэй давтлага хий... байна?

4. Приготовьте рассказ на тему «За отличную учебу и за хорошую дисциплину», используя глагольные формы восьмого и девятого уроков.

## 10 АРАВДУГААР ХИЧЭЭЛ ДЕСЯТЫЙ УРОК

---

### ЗОЧЛОВ

Өчигдөр орой миний өвгөн аав надтай утсаар ярив. Тэр бол: «Чи бүтэн сайн өдөр манайд ирээрэй» гэж урив. Би бүтэн сайн өдөр эрт босож, нүүр гараа угаагаад, хувцасны шүүгээ дотор байгаа гоёлын хувцсаа өмсөв. Тэгээд эндээс хол биш оршиж байгаа дэлгүүрээс өвгөн аав эмэг эх хоёртоо бэлэг худалдаж авав. Би бол үүний дараа энд ойр байгаа трамвайн зогсдог газарт очиж, трамвайд суугаад явав.

Би бол хотын төвд суудаг өвгөн аав эмэг эх хоёрынхоо байранд орох гэж явна. Би тэдний байрын хаалгыг тоншив. Миний эмэг эх үүдийг нээж өгөв. Би өвгөн аав эмэг эх хоёртоо зүрхний мэндчилгээ хүргээд, өөрийн бэлгийг өгөв. Тэд нар бол: «бид баярлалаа» гэж хариулав. Би тэдэнтэй ярилцав.

Миний эмэг эх намайг янз бүрийн хоолоор дайлав. Тэр архи хундагалав. Би бол: «Та нарын эрүүл мэндийн төлөө хундагыг өргөө!» гэж хэлээд, аягалсан архийг уув. Бид үдийн хоолны дараа утга зохиол, ший ба хөгжмийн тухай яриа хийв. Мөн сонирхолтой радио нэвтрүүлэг сонсов.

Миний өвгөн аав хананд өлгөсөн олон сайхан зургуудын тухай ярив. Нэг хүний зураг зааж: «Энэ бол чиний аавыг бичигт сургасан багшийн зураг юм» гэв. Бас нэг том сайхан байшингийн зураг зааж: «Энэ бол багш нарыг бэлтгэх дээд сургуулийн байшин юм» гэж хэлэв.

Би өвгөн аавынхаа байранд удаан суув. Одоо гэртээ харих цаг болов. Намайг миний өвгөн аав үдэв. Бид хувцсаа өмсөөд гадаа гарав. Сэрүүн салхи үлээж байв. Миний өвгөн аав: «Чиний сууж гэртээ харих трамвай удалгүй ирнэ» гэж хэлэв. Бид хэдэн минут хүлээв. Тэр трамвай ирэв. Миний өвгөн аав:

«Сайн яваарай!» гэж хэлэв. Би өвгөн аавдаа: «Сайн сугаарай!» гэж ерөөв. За, баяртай гэж хэлээд, би трамвайд сууж явав. Би бол том сайхан байшингуудын хажуугаар явж, гэртээ ирэв. Москвагийн оройн байдал бол маш сайхан байна.

## С л о в а

зочлох *эд.* гостить, принимать гостей  
 өвгөн аав дедушка  
 утас *эд.* телефон  
 гоёлын хувцас выходной костюм,  
 наряд  
 хол даалеко  
 эмэг эх бабушка  
 бэлэг гостинец, подарок  
 ойр близко  
 зогсолт остановка  
 хаалга *эд.* дверца  
 тонших стучать(ся)  
 зүрхний сердечный  
 мэндчилгээ(н) привет  
 янз бүрийн разный  
 хоол(он) кушанье  
 хүндлэх угощать  
 архи вино, водка

хундагалах наливать в рюмку, бокал  
 хундага рюмка, бокал; тост  
 өргөх поднимать  
 уух пить  
 үдийн хоол обед  
 утга захиол художественная лите-  
 ратура  
 хөгжим музыка  
 нэвтрүүлэг *эд.* передача  
 заах *эд.* показывать  
 сургах учирь, обучать  
 том большой  
 үдэх провожать  
 сэрүүн прохладный  
 үлээх дуть  
 удалгүй скоро  
 хажуугаар мимо  
 ерөөх [по]желать блага (добра)

## ГРАММАТИКА

1. Как уже было отмечено (см. стр 59), причастие оказывается определением, если оно находится перед каким-нибудь именем, например:

*унишсан хүн* прочитавший че-  
 ловек (человек, который про-  
 читал)

*унишдаг хүн* человек, имеющий  
 обыкновение читать (который

имеет обыкновение читать)

*унишж байгаа хүн* читающий  
 человек (человек, который  
 читает)

*униших хүн* человек, который  
 прочитает

*унишаагүй хүн* человек, кото-  
 рый еще не читает

2. Как известно, причастия вместе с зависящими от них сло-  
 вами называются причастными оборотами. Причастные обо-  
 роты, находясь перед каким-нибудь именем, оказываются развер-  
 нутыми определениями, а в переводе на русский язык соответствуют  
 придаточно-определятельным предложениям, определятельным  
 причастным оборотам и именным оборотам определятельного ха-  
 рактера, например:

*Өчигдөр багшид сэтгүүл ав-  
 чирсан* сурагчид.

Ученики, которые вчера принес-  
 ли учителю журнал (принес-  
 шие вчера учителю журнал).

*Бидэнтэй хамт ном уншсан хүн.*

*Манай хотын төвд сууж байгаа ажилчин.*

*Нар гарах цаг.*

*Шинэ сурагчдыг элсүүлэн авах комисс.*

*Хурлын тогтоол боловсруулан бэлтгэх комисс.*

*Улс ардын аж ахуй ба соёл боловсролыг хөгжүүлэх төлөвлөгөө.*

*Унших ном.*

Человек, который вместе с нами прочитал книгу (прочитавший вместе с нами книгу).

Рабочий, который живет в центре нашего города.

Время восхода солнца (время, когда восходит солнце).

Приемная комиссия в учебном заведении (по приему новых учащихся).

Комиссия по выработке резолюции собрания.

План развития народного хозяйства и культуры.

Книга для чтения.

## УП РА Ж Н Е Н И Я

### 1. Переведите на монгольский язык:

1) Студент, который сейчас придет сюда, слушал интересную радиопередачу. 2) Мой брат, который Вас знает, передает Вам привет. 3) Товарищ, который привез подарки, сейчас слушает доклад. 4) Студенты, которые живут недалеко от института, идут сюда пешком. 5) Этот студент, который сидит здесь, провожал своего товарища. 6) Здесь сидит студент, живущий в общежитии. 7) Сейчас сюда придет товарищ, приехавший из Улан-Удэ. 8) Эту книгу дал мне студент, изучающий монгольский язык. 9) Сегодня я проводил товарища, уехавшего в Улан-Батор. 10) Мой младший брат учится в педагогическом техникуме. 11) Мы ждем товарища, уезжающего в Иркутск. 12) Я получил письмо от товарища, собирающегося поступить в наш институт. 13) Мы разговаривали с преподавателем, работающим в Университете.

### 2. Ответьте на следующие вопросы:

1) Энд ирсэн нөхөр юу авчрав? 2) Дээд сургуулиас хол суудаг оюутан нар энд юугаар ирдэг вэ? 3) Та нарт хичээл заадаг багш хаа суудаг вэ? 4) Есөн цагт эхлэх хичээлийг хэн багш заах вэ? 5) Таныг үдсэн нөхөр хаа суудаг вэ? 6) Бидэнтэй утга зохиол ба хөгжмийн тухай ярьсан оюутан одоо хаа байна? 7) Танд захидал бичсэн нөхөр одоо хаа сууж байна? 8) Таны өвгөн аав эмэг эх хоёртой уулзсан хүн энд ирэв үү? 9) Өчигдөр илтгэл хийсэн оюутан одоо хаа байна?

### 3. Приготовьте рассказ на тему «Я был в гостях у товарища».

## ТОО БОДЪЁ

Самданы охин тоо бодож сууна. Арван нэг дээр хорин гурвыг нэмбэл хэд болох вэ? Арван нэг дээр хорин гурвыг нэмбэл гучин дөрөв болно. Дөчин зургаагаас хорин есийг хасвал хэд үлдэх вэ? Дөчин зургаагаас хорин есийг хасвал арван долоо үлдэнэ. Наймыг долоогоор үржүүлбэл хэд болох вэ? Наймыг долоогоор үржүүлбэл тавин зургаа болно. Жаран зургааг зургаад хуваавал хэд болох вэ? Жаран зургааг зургаад хуваавал арван нэг болно.

Манай багш оюутан бүхэнд нэжээд ном, хошоод дэвтэр, гурваад үзэг, дөрвөөд харандаа өгөв. Одоо та хаанаас ирэв? Би уншлагын танхимаас ирэв. Тэнд олон хүн байна уу? Одоо уншлагын танхимд зуугаад хүн ном ба сонин уншиж байна. Барагцаалбал тэдний дөрвөний нэг хувь бол багш нар ба албан хаагчид байна. Тэнд цөөн биш, олон хүн сууж байна.

Одоо Дамдин, Дорж, Жамц гурвуул зугаацаж явна. Тэдэнтэй таван оюутан нар уулзав. Тэдгээр оюутан нар наймуулаа манай дээд сургуулийн оюутан нар юм. Тэдгээр оюутан нар наймуул кино үзэв.

Манайд нөхөр Самдан ирэв. Би түүнтэй ярилцав. Нөхөр Самдан бол: «Чиний өвгөн аав эмэг эх хоёр хэдэн настай вэ? Гэж асуув. Миний өвгөн аав ерэн хоёр настай, миний эмэг эх наян таван настай юм гэж би хариулав. Таны хүү, охин хоёр хэддүгээр ангид сурч байна? Манай хүү наймдугаар ангид сурч байна. Манай охин нэгдүгээр ангид сурна.

Октябрийн агуу их хувьсгал хэдэн онд мандав? Октябрийн агуу их хувьсгал [нэг] мянга есөн зуун арван долоодугаар онд мандсан юм. Энд сууж байгаа нөхөр Октябрийн агуу их хувьсгалын тухай илтгэл хийх гэж байна.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хүн амын тоо хэд вэ? Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хүн амын тоо дөрвөн зуун далан таван сая гаруй юм. Өөрөөр хэлбэл таван зуун сая шахам болно. Зөвлөлт Холбоот улсаар толгойлуулсан ардчилсан лагерийн хүн амын тоо одоо хэд болов? Зөвлөлт Холбоот улсаар толгойлуулсан арчилдсан улсуудын хүн амын тоо одоо 1952 онд найман зуун сая орчим болов. Өөрөөр хэлбэл бүх дэлхийн хүн амын гурван нэг хувь орчим болох юм. Одоо хэдэн зуугаад сая хүмүүс энх тайвны төлөө тэмцэж байна. Ардчиллын хүч өдөр ирэх тутам нэмэгдэж байна.

Явал сайн сурах вэ? Багшийн заасан хичээлийг анхааралтайгаар сонсоод, товч тэмдэглэл хийж аваад, өдөр бүр давтлага хийж байвал онц сайн сурч болно. Өдөр бүр давтлага хийвэл зохино. Маргааш эрт босвол зохино. Оюутан бүхэн онц сайн сурвал зохино.

Бид энд хоёр цаг хагас суув. Одоо бид гэртээ харина. Би хувцсаа өмсөв. Миний өрөөсөн бээлий хаа байна? Чиний өрөөсөн бээлий энэ байна. За, явъя.

1. Яарвал даарна.
2. Эхэлбэл дуусах хэрэгтэй, Эрвэл олох хэрэгтэй.

## С л о в а

**тоо(н)** число, цифра  
**бодох** *зд.* вычислять, решать  
**арван** нэг одинадцать  
**хорь (хорин)** двадцать  
**нэмэх** прибавить  
**гуч(ин)** тридцать  
**дөч(ин)** сорок  
**хасах** вычитать, отнимать  
**үлдэх** останется  
**үржүүлэх** умножить  
**тавь (тавин)** пятьдесят  
**жар(ан)** шестьдесят  
**хуваах** делить, разделить  
**нэжээд** по одному  
**хошоод** по два  
**гурваад** по три  
**дөрвөөд** по четыре  
**уншлагын танхим** читальный зал  
**зуугаад** около ста  
**барагцаалбал** приблизительно  
**дөрвөний нэг** одна четвертая  
**хувь** *зд.* часть  
**цөөн** мало, малочисленно  
**гурвуул** втроем  
**наймуул** восьмером  
**ер(эн)** девяносто  
**ная(н)** восемьдесят  
**хэддүгээр** который (по счёту)  
**наймдахь** восьмой  
**нэгдэх** первый

**мандах** *зд.* совершиться  
**мянга (н)** тысяча  
**Бүгд Найрамдах Хятад Ард Улс**  
Китайская Народная Республика  
**хүн ам(ан)** население  
**дал(ан)** семьдесят  
**гаруй** свыше  
**өөрөөр хэлбэл** иначе говоря  
**шахам** почти  
**толгойлуулсан** возглавляемый  
**ардчилсан** демократический  
**улс** государство  
**орчим** около  
**зуугаад сая** сотни миллионов  
**гурваны нэг** одна треть  
**хүмүүс** люди  
**энх тайван(г)** мир; мирный  
**ардчилал** демократия  
**хүч(ин)** сила  
**өдөр ирэх тутам** с каждым днём  
**нэмэгдэх** расти, увеличиваться  
**зохино** необходимо, должно  
**хагас** половина  
**бээлий** рукавицы, перчатки, варежки  
**өрөөсөн** один из пары  
**яарах** спешить  
**даарах** мёрзнуть, зябнуть  
**эрэх** искать  
**бүр** каждый

## ГРАММАТИКА

1. Условное деепричастие (болзлыг үзүүлэх төлөв) выражает действие, которое является условием другого действия, например:

Цас *орвол*, хүйтэн болно.

Дулаан *болбол*, бид цэцэрлэгт явна.

Өглөө долоон цагт *босвол* сургуульд есөн цагт ирнэ.

*Если пойдет* снег, то будет холодно.

*Если будет* тепло, [то] мы пойдем в парк.

*Если встанут* в семь часов утра, [то] в школу придут в девять часов.

2. Условно-деепричастный оборот всегда находится в начале предложения, между тем как соответствующее ему условно-придаточное предложение в русском языке может находиться и в конце предложения, т. е. после главной части последнего, например:

*Тэр замаар явбал, гэртээ эрт хүрч болно.* Домой можно прийти рано, *если пойти по той дороге = если пойти по той дороге, [то] домой можно прийти рано.*

3. Условное деепричастие соответствует русскому неопределенному наклонению, если оно управляется глаголом **ЗОХИНО** в значении «необходимо» и выражает действие, подлежащее неуклонному исполнению, например:

*Энэ даалгавар гүйцэтгэвэл зохино.* Это задание необходимо *выполнить.*  
*Шалгалтын дүнг удалгүй гаргавал зохино.* Необходимо поскорее *подвести* итоги экзаменов.

4. Окончаниями условного деепричастия являются:

1) **-бал, -бол, -бөл, -бэл**, если основа глагола оканчивается на согласные **в, л, м**, например:

**ав + бал = авбал** если взять  
**бол + бол = болбол** если будет  
**ол + бол = олбол** если найдет  
**нэм + бэл = нэмбэл** если прибавить

2) **-вал, -вол, -вөл, -вэл**, если основа глагола оканчивается на любой гласный или согласный (кроме **в, л, м**), например:

**хэвлэ + вэл = хэвлэвэл** если напечатать  
**нүү + вэл = нүүвэл** если перекочевать  
**суу + вал = суувал** если сесть  
**ир + вэл = ирвэл** если прибудет  
**бос + вол = босвол** если встать  
**үз + вэл = үзвэл** если посмотреть  
**өргө + вөл = өргөвөл** если поднять

5. В монгольском языке имеются следующие числительные (тооны үг):

<b>нэг(-эн)</b>	один	<b>зургаа(-н)</b>	шесть
<b>хоёр</b>	два	<b>долоо(-н)</b>	семь
<b>гурав (гурван)</b>	три	<b>найм(-ан)</b>	восемь
<b>дөрөв (дөрвөн)</b>	четыре	<b>ес(-өн)</b>	девять
<b>тав(-ан)</b>	пять	<b>арав (арван)</b>	десять

<b>хорь (хорин)</b>	двадцать	<b>жар(-ан)</b>	шестьдесят
<b>гуч (-ин)</b>	тридцать	<b>дал(-ан)</b>	семьдесят
<b>дөч (-ин)</b>	сорок	<b>ная(-н)</b>	восемьдесят
<b>тавь (тавин)</b>	пятьдесят	<b>ер(-эн)</b>	девяносто
	<b>зуу(-н)</b>	сто	
	<b>мянга(-н)</b>	тысяча	
	<b>сая</b>	миллион	

Кроме того, имеются малоупотребительные теперь числительные:

<b>түмэн</b>	десять тысяч	<b>жаваа</b>	десять миллионов
<b>бум(-ан)</b>	сто тысяч	<b>дүнчүүр</b>	сто миллионов

После революции в монгольском языке стало употребительно (заимствованное через русский язык) интернациональное числительное «миллиард».

Двузначные числительные составляются из сочетания соответствующих десятков и единиц, например:

<b>арван хоёр</b>	двенадцать
<b>хорин гурав</b>	двадцать три
<b>гучин дөрөв</b>	тридцать четыре
<b>дөчин тав</b>	сорок пять
<b>тавин зургаа</b>	пятьдесят шесть
<b>жаран долоо</b>	шестьдесят семь
<b>далан найм</b>	семьдесят восемь
<b>наян ес</b>	восемьдесят девять
<b>эрэн нэг</b>	девяносто один

Сотни от двухсот до девятисот образуются путем сочетания **зуун** с определительными единицами, например:

<b>хоёр зуу(-н)</b>	двести	<b>зургаан зуу(-н)</b>	шестьсот
<b>гурван зуу(-н)</b>	триста	<b>долоон зуу(-н)</b>	семьсот
<b>дөрвөн зуу(-н)</b>	четыреста	<b>найман зуу(-н)</b>	восемьсот
<b>таван зуу(-н)</b>	пятьсот	<b>есөн зуу(-н)</b>	девятьсот

Таким же путем образуются числительные от **мянга(-н)** — тысяча, например:

<b>хоёр мянга(н)</b>	две тысячи
<b>долоон мянга(н)</b>	семь тысяч
<b>хорин мянга(н)</b>	двадцать тысяч
<b>гурван зуун арван таван мянга(н)</b>	триста пятнадцать тысяч

Как видно из примеров, в сложных числительных те из них, которые содержат скрытый **н**, восстанавливают его (арав — десять, но: арван хоёр — двенадцать). Этот же скрытый **н** восстанавливается и в тех случаях, когда соответствующие числи-

тельные оказываются либо определениями, либо даны в родительном, дательном-местном или исходном падеже, например:

ДОЛОО	семь
ДОЛООН харандаа	семь карандашей
ДОЛООНЫ	семи
ДОЛООНД	в семь, к семи
ДОЛООНООС	от семи

6. Порядковые числительные (дэс тоо) образуются от описанных выше количественных (үндсэн тоо) при помощи суффикса **-дугаар (-дүгээр)**, например:

нэг + дүгээр = нэгдүгээр первый  
ес + дүгээр = есдүгээр девятый  
арван долоо + дугаар = арван долоодугаар семнадцатый  
хоёр + дугаар = хоёрдугаар второй

В устной речи суффикс **-дугаар (-дүгээр)** иногда заменяется другим — **дахь**, например:

найм + дахь = наймдахь восьмой  
хоёр + дахь = хоёрдахь второй  
ес + дэх = есдэх девятый

7. Разделительные числительные (түгээл ба тойм тоо — распределительные и приблизительные числительные) образуются при помощи суффикса **-аад** или (после долгих гласных) **-гаад** и обозначают, с одной стороны, равное количество предметов (до десяти) и, с другой, — приблизительное (десятки и выше), например:

гурав + аад = гурваад по три  
долоо + гоод = долоогоод по семь  
ес + өөд = есөөд по девять  
арав + аад = арваад около десяти  
хорь + иод = хориод около двадцати  
зуу + гад = зуугаад около ста  
мянга + аад = мянгаад около тысячи

Примечания. а) В разделительной форме числительные **нэг** и **хоёр** изменяют свою основу, например, **нэгжээд** — по одному, **хошоод** — по два.

б) Десятки, сотни и тысячи в описываемой форме могут по смыслу предложения иметь и разделительное значение, например: хүн бүрд **зуугаад** ном өгөв — каждому человеку дали *по сто* книг; хороо бүр **мянгаад** цэрэг байв — в каждом полку было *по тысяче* солдат.

в) Формы **арваад**, **зуугаад**, **мянгаад** перед большими цифрами имеют соответственно значения: *десятки, сотни, тысячи*, например: **арваад мянга** — десятки тысяч, **зуугаад сая** — сотни миллионов и т. д.

8. Дробные числительные (бутархай тоо) составляются из числителя и знаменателя, из коих последний всегда находится в форме родительного падежа, например:

гурваны нэг	одна треть
арваны хоёр	две десятых
дөрвөний гурав	три четверти
зууны долоо	семь сотых
мянганы арав	десять тысячных

Таким образом, в монгольском языке особых слов со значением «треть» или «четверть» нет.

Половина — **хагас**, например: **хагас жил** — полгода, **хоёр цаг хагас** — два с половиной часа, **гурван жил хагас** (нельзя: гурван хагас жил!) — три с половиной года.

Когда речь идет об одном из парных предметов (*глаза, уши, ноги, руки, рукавицы, сапоги* и т. д.), то употребляется слово **өрөөсөн**, например: **өрөөсөн гутал** — один сапог.

## У П Р А Ж Н Е Н И Я

### 1. Переведите на монгольский язык:

1) Если сегодня приедет мой младший брат, то мы втроем пойдём в кино. 2) Если ты принесешь тридцать тетрадей, то мы распределим по три. 3) Если ты хочешь хорошо знать географию Китайской Народной Республики, то прочти эту книгу. 4) Если ты принесешь мне интересную книгу, то я тебе дам эту книгу. 5) Если я закончу этот перевод до 6 часов вечера, то я поеду к бабушке. 6) Если завтра будет холодно, то оденешь теплую одежду.

### 2. Ответьте на следующие вопросы:

1) Долоог долоогоор үржүүлбэл хэд болно? 2) Наян хоёроос жаран есийг хасвал хэд үлдэх вэ? 3) Зууг тавд хуваавал хэд болно? 4) Яавал монгол хэлийг сайнаар сурч болно? 5) Жаран хоёр дээр наян гурвыг нэмбэл хэд болох вэ? 6) Өнөөдөр орой юу хийвэл зохино? 7) Оюутан нар гэртээ эрт ирвэл юу хийдэг вэ? 8) Оюутан нарын гурваны нэг хуралд ирвэл хурал эхлэх үү? 9) Эхэлсэн ажлыг яавал зохино? 10) Онц сайнаар сурах гэвэл яах хэрэгтэй вэ? 11) Чи номын санд очвол ямар ном авах вэ?

### 3. Составьте рассказ на тему «Моя учеба», используя числительные и условные дееспричастия.

## ЗАЛУУЧУУДЫН ЗОРИЛГО

Зөвлөлтийн залуучууд бол бүх дэлхий дээр хамгийн жаргалант залуучууд юм. Манай залуучууд бол сурах, хөдөлмөрлөх, амрах бүрэн эрхтэй юм. Коммунист нам ба агуу их Сталин бол манай залуучуудыг коммунизмын идэвхтэй байгуулагчид болгохоор хүмүүжүүлж байна. Коммунист нам бол манай залуучуудыг Маркс, Энгельс, Ленин, Сталины тэргүүний онолоор зэвсэглүүлж байна. Нам бол залуучуудыг эх оронч ба интернационализмын суртлаар хүмүүжүүлж байна. Агуу их Сталин ба коммунист нам бол манай залуучуудыг коммунист хүмүүжлээр хүмүүжүүлж байна.

Залуучууд бол «Хүн төрөлхтний бүтээн өгсөн бүх баялгийн мэдлэгээр өөрийгөө баяжуулбал сая коммунист болж болно» гэж агуу их Ленин сургажээ. Иймд манай оюутан нар өөрсдийнхөө сурлагыг улам сайжруулахын төлөө тэмцэх ёстой. Манай прээдүйн зам бол тунгалаг өдөр шиг саруул тод гэрэлтэж байна.

Агуу их Сталин бол манай жаргалант ард түмнийг коммунизмд хүргэх шулуун замаар удирдан давшуулж явна. Манай Зөвлөлтийн ард түмэн бол коммунист нам ба агуу их Сталины удирдлагын дор эх орны агуу их дайнд германы фашизм ба японы империалистүүдийг бут цохиод, одоо эх орныхоо улам чинээлэг баясгалант маргашийг ирүүлэх гэж ариун цагаан хөдөлмөрөө өрнүүлж байна. Бид онц сайнаар сураад ард түмэнтэйгээ коммунизмын төлөө тэмцэх болно.

Хүмүүжсэн залуучууд бол хөгшид ба ахлах хүмүүсийг хүндэтгэж, тэдний мэдлэг чадварын туршлагыг эзэмших ёстой байна. Бид бол боловсон шударга зан харьцаатай байх ёстой. Бид бол аливаад үнэнч шударга, эелдэг байх ёстой. Манай улсад хүний чадвар ба түүний хөдөлмөрөөр хүний чанарыг мэддэг юм. Бид бол ололт амжилтандаа тайвшрах ёсгүй юм.

Чи багшийнхаа даалгаврыг биелүүлэв үү? Би багшийнхаа даалгаврыг биелүүлэв. Чи хэнээс захидал авав? Би ахаасаа захидал авав. Захидалдаа юу бичив? Миний ах захидалдаа: «Бид сайн байна, бид сайн хөдөлмөрлөж байна» гэж бичив. Чи хэнд захидал бичив? Би нөхөртөө захидал бичив. Чи өнөөдөр сургуулиаа хаа явах вэ? Би сургуулиаа нөхрийндөө явна. Тэндээс аавындаа очно.

«Сур, сур, бас сур» гэж агуу их Ленин заасан юм. Бид үүнийг биелүүлж байна.

залуучууд молодежь  
 хамгийн самый  
 жаргалант счастливый  
 хөдөлмөрлөх трудиться  
 амрах отдыхать  
 бүрэн полный  
 эрх право  
 идэвхтэй активный  
 байгуулагчид строители  
 болгох сделать, превратить  
 тэргүүний передовой  
 эх оронч патриот  
 суртал учение, мировоззрение  
 хүн төрөлхтөн человечество  
 бүтээн өгөх создавать  
 баялаг богатство  
 өөрийгөө себя  
 баяжуулах обогащать  
 сая эд. только тогда  
 болж болох может стать  
 ирээдүй будущее  
 тунгалаг светлый, ясный  
 шиг подобно, как  
 тод ясный  
 гэрэлтэх светить, сверкать  
 хүргэх эд. довести  
 шулуун прямой  
 удирдан давшуулах руководить,  
 вести

дайн война  
 эх орон родина  
 бут цохих разгромить, разбить  
 баясгалант радостный, счастливый  
 ирүүлэх приблизить, принести  
 ариун цагаан священный  
 хөдөлмөр труд  
 өрнүүлэх развивать, развернуть  
 хөгшид старики, пожилые люди  
 ахлах старший  
 хүндэтгэх уважать, почитать  
 чадвар умение  
 туршлага опыт  
 эзэмших овладевать  
 боловсон күүлгүрний  
 шударга честный, бескорыстный  
 зан харьцаа(н) отношение к людям,  
 обращение с людьми  
 олон нийт общественность  
 аливаад во всем  
 үнэнч шударга честный, бескорыст-  
 ный  
 эелдэг вежливый  
 чанар эд. достоинство  
 ололт завоевания  
 тайвшрах успокаиваться  
 ёсгүй не должен

## ГРАММАТИКА

1. Возвратное или безличное притяжание (хамаа-дахын нөхцөлтэй тийн ялгал) показывает, что какой-либо предмет, обозначенный второстепенным членом предложения, принадлежит предмету, обозначенному в подлежащем. Таким образом, во-первых, само подлежащее никогда не может иметь окончание возвратного притяжания и, во-вторых, это притяжание обычно переводится на русский язык возвратным местоимением «свой», например:

Энэ сурагч *харандаагаа гаргав.*

Сурагчид *сургуульдаа* явав.

Сурагчид *сургуулийнхаа* дэргэд тоглоно.

Багш *сургуулиасаа* номын санд явав.

Багш *сурагчидтайгаа* цэцэрлэгт явав.

Тэр *замаараа* яв!

*Харандаагаараа* бичнэ.

Этот ученик достал *свой карандаш.*

Ученики пошли *в свою школу.*

Ученики играют *возле своей школы.*

Учитель *из своей школы* пошел в библиотеку.

Учитель *со своими учениками* отправился в сад.

Иди *той же дорогой* (буквально: своей дорогой), т. е. по той, по которой идешь (или шел раньше)!

Пишет *своим карандашом.*

2. Окончаниями возвратного притяжания, которые наращаются на падежные окончания, являются:

1) при родительном падеже **-хаа, -хээ, -хоо, -хөө**, например:

**малын** + **хаа** = **малынхаа** своего скота  
**үхрийн** + **хээ** = **үхрийнхээ** своего рогатого скота  
**морины** + **хоо** = **мориныхоо** своей лошади  
**өврийн** + **хөө** = **өврийнхөө** своей пазухи

2) при совместном падеже **-гаа, -гээ, -гоо, -гөө**, например:

**ахтай** + **гаа** = **ахтайгаа** со своим старшим братом  
**эхтэй** + **гээ** = **эхтэйгээ** со своей матерью  
**нөхөртэй** + **гөө** = **нөхөртэйгөө** со своим товарищем  
**моритой** + **гоо** = **моритойгоо** со своим конем

3) при прочих падежах **-аа, -ээ, -оо, -өө**, например:

**малыг** + **аа** = **малыгаа** свой скот  
**малаар** + **аа** = **малаараа** своим скотом  
**малаас** + **аа** = **малаасаа** от своего скота  
**малд** + **аа** = **малдаа** своему скоту  
**бэхийг** + **ээ** = **бэхийгээ** свои чернила  
**бэхээр** + **ээ** = **бэхээрээ** своими чернилами  
**бэхээс** + **ээ** = **бэхээсээ** от своих чернил  
**бэхэд** + **ээ** = **бэхдээ** к своим чернилам  
**нөхрийг** + **өө** = **нөхрийгөө** своего товарища  
**нөхрөөр** + **өө** = **нөхрөөрөө** своим товарищем  
**нөхрөөс** + **өө** = **нөхрөөсөө** от своего товарища  
**морь** + **оо** = **морио** свою лошадь  
**мориор** + **оо** = **мориороо** на своей лошади  
**мориноос** + **оо** = **мориноосоо** от своей лошади  
**моринд** + **оо** = **мориндоо** своей лошади

4) при наличии окончания возвратного притяжания окончание винительного падежа чаще всего опускается; так, например:

вместо:

**малыгаа**  
**бэхийгээ**  
**нөхрийгөө**  
**морийгоо**  
**гэрийгээ**  
**улсыгаа**

говорят:

**малаа** свой скот  
**бэхээ** свои чернила  
**нөхрөө** своего товарища  
**морио** свою лошадь  
**гэрээ** свою юрту  
**улсаа** свою страну

## УПРАЖНЕНИЯ

### 1. Переведите на монгольский язык:

1) Товарищ Доржи со своим младшим братом ушел в большой зал, чтобы слушать доклад о коммунистическом воспитании советской молодежи. 2) Наш советский народ под руководством коммунистической партии борется за дальнейшие успехи своей великой родины. 3) Я со своими товарищами изучаю основы марксизма-ленинизма. 4) Каждая советская школа воспитывает своих учеников в духе советского патриотизма. 5) Дети Самдана уважают своих преподавателей, своих старших. 6) Я принес эту книгу, чтобы отдать ее своей сестре. 7) Я получил письмо от своего дедушки. 8) Он в своем письме пишет, что живет хорошо. 9) В выходной день я собираюсь сходить к своему товарищу. 10) Я жду своего преподавателя.

### 2. Ответьте на следующие вопросы:

1) Чи сургуульдаа юугаар ирдэг вэ? 2) Чи сургуулиа төгсгөөд юу хийх гэж байна? 3) Чи өөрийнхөө зорилгыг сайн мэднэ үү? 4) Чи номоо хэнд өгөв? 5) Манай залуучууд ард түмэндээ ямар байх ёстой вэ? 6) Олсон амжилтандаа тайвширч болохгүй гэж хэн сургадаг байна? 7) Чи ахаасаа захидал авдаг уу? 8) Чи аавдаа ном худалдаж авав уу? 9) Чи нөхөртэйгөө хэзээ уулзав? 10) Чиний нөхөр дээд сургуулиа хэзээ төгсгөх вэ? 11) Чи өвөг аавындаа юугаар очоод ирдэг вэ? 12) Чи өвөг аавдаа юу өгөв?

## 13 АРВАН ГУРАВДУГААР ХИЧЭЭЛ

---

### МАНАЙ ЭХ ОРОН

Бид өнөөдөр амарч байна. Би ах дүү нартайгаа эх орныхоо газрын зураг үзэх гэж байна. Манайд нөхөр Дамдин ирэв. Та хаанаас ирэв? Би гэртээсээ ирэв. Таны хойноос хэн ирж явна? Миний хойноос нөхөр Дорж ирж явна. Тэр бол оюутан нартай уулзав. Тэд оюутан нар одоо хаа байна? Тэд номын санд очив. Одоо Дорж энд ирэв. Тэд оюутан нар бол чамд баярыг хургээрэй гэв. Та нар юу хийх гэж байна? Бид СССР улсынхаа газрын зураг үзэх гэж байна.

За, эх орныхоо газрын зургийг узье. Манай дэргэдэх ширээн дээр СССР-ийн газрын зураг байна. Чиний дэргэд Иванов суух юм. Би ярьа. Та миний дараа яриарай.

Одоо манай эх орон бол газар дэвсгэрээрээ бүх дэлхий дээр хамгийн их улс юм. Манай улсын газар дэвсгэр бол Балтийн тэнгэсийн өмнөх эргээс Номхон далай хүртэл үргэлжилнэ. Номхон далайн баруун талд манай улсын Курилийн арлууд оршино. Мөн манай улсын газар дэвсгэр бол Умарт Мөсөн далайгаас Памирын уулс хүртэл үргэлжилнэ.

Дэлхийн хоёрдугаар дайнаас өмнө манай Зөвлөлт Холбоот Улсыг хүрээлж байсан айл хөрш улсуудаас ганц Бүгд Найрамдах Монгол Ард Улс бол манай найрамдалт нөхөрсөг улс байсан юм. Бусад улсууд бол Зөвлөлт Холбоот Улсыг дайсагнаж байсан юм.

Одоо манай Зөвлөлт Холбоот Улс бол манай найрамдалт агуу их Бүгд Найрамдах Хятад Ард Улстай ба ардын ардчилсан бусад найрамдалт улсуудтай хил залгаж байна. Эдгээр улсууд бол манай СССР улсын нөхөрлөг улсууд юм.

Манай СССР улсын газар дэвсгэр бол ашигт малтмалаар ба байгалийн баялгаар бүх дэлхий дээр нэгдүгээр суурийг эзэлнэ. Манай улс бол хамгийн баялаг улс юм.

Манай улсын хөдөлмөрчид бол бүх дэлхий дээр хамгийн жаргалант хөдөлмөрчид юм. Тэдний аж амьдрал бол өдөр ирэх тутам сайжирч байна. Манай улс бол олон үндэстнүүдтэй улс юм. Манай улсын олон үндэстнүүдийг коммунист нам ба агуу их Сталин бол интернационализмын үзлээр хүмүүжүүлэв. Үүний ач үрээр манай улсын олон үндэстнүүд бол эвдэршгүй найрамдал нөхөрлөлөөр гагнагдав.

Манай хайрт эх орон бол хүчит хүнд үйлдвэр хөгжсөн бөгөөд хамтралуудын хөдөө аж ахуй хөгжсөн гүрэн юм. Одоо манай Зөвлөлт Холбоот Улс шиг бат бэх улс бүх дэлхий дээр байхгүй юм. Одоо зөвлөлтийн ард түмэн, түүний үр хүүхэд өөрийн жаргалант эх орныг коммунизмд хүргэх шулуун замаар СССР-ийн Коммунист нам ба агуу их Сталины удирдлагаар давшиж явна.

Танд СССР-ийн газрын зураг байна уу? Надад СССР-ийн газрын зураг бий. Таны дүү газрын зураг үздэг үү? Тиймээ, миний дүү өдөр бүр сонин уншаад, газрын зураг үздэг юм. Чиний дүү ямар сонин уншдаг вэ? Миний дүү «Правда» гэдэг сонин уншдаг юм.

Таны тасалгаанд байгаа газрын зураг бол эдний тасалгаанд байгаа газрын зургаас ямар байна? Манай тасалгаанд байгаа газрын зураг бол эдний тасалгаанд байгаа газрын зургаас шинэ юм. Таны хичээл хийдэг тасалгаанд ямар улсын газрын зураг байна? Бидний хичээл хийдэг тасалгаанд СССР-ийн газрын зураг байна.

### С л о в а

газрын зураг географическая карта  
чамд тебе  
дамжуулах передавать  
газар дэвсгэр территория

тэнгэс море  
эрэг берег  
Номхон далай Тихий океан

**үргэлжлэх** продолжаться, тянуться  
**баруун** запад, западный  
**тал** эд. часть  
**арлууд** острова  
**умарт** северный  
**Мөсөн далай** Ледовитый океан  
**хүрээлэх**, **окружать**  
**айл хөрш** сосед; соседний  
**ганц** единственный  
**дайсагнах** быть враждебным  
**найрамдалт нөхөрлөг** дружествен-  
 ный  
**ардын ардчилсан** народно-демокра-  
 тический  
**хил залгах** граничить  
**ашигт малтмал** ископаемые богат-  
 ства, полезные ископаемые  
**байгаль** природа  
**суурь** место

**эзлэх** занимать  
**баялаг** богатый; богатство  
**хөдөлмөрчид** трудящиеся  
**сайжрах** улучшаться  
**үндэстэн** нация, национальность  
**ач үрээр** благодаря  
**эвдэршгүй** нерушимый  
**гагнагдах** быть сжатым  
**хүчит** мощный  
**хүнд үйлдвэр** индустрия  
**гүрэн** держава  
**бат бэх** прочный  
**байхгүй** нет, не существует  
**үр хүүхэд** дети  
**улс** государство  
**уулс** горы  
**уул** гора  
**тиймээ** да

## ГРАММАТИКА

1. Местоимения (төлөөний үг) в монгольском языке склоняются иначе, нежели все прочие имена. Если имена вообще для всех падежей имеют одну общую основу, то местоимения (особенно личные — биеийн төлөөний үг) имеют особую форму для именительного падежа, первую основу — для родительного, вторую и даже третью — для прочих падежей. Сказанное особенно касается личных местоимений первого и второго лиц единственного числа.

Ниже даны местоимения в формах именительного и родительного падежей:

<b>би</b>	я	<b>чи</b>	ты
<b>миний</b>	меня	<b>чиний</b>	тебя
<b>бид</b>	мы	<b>та</b>	вы
<b>маны</b>	наш	<b>таны</b>	ваш
<b>манай</b>	наш	<b>танай</b>	ваш
<b>энэ</b>	это	<b>тэр</b>	тот
<b>үүний</b>	этого	<b>түүний</b>	того
<b>эд</b>	эти	<b>тэд</b>	те
<b>эдний</b>	этих	<b>тэдний</b>	тех

2. В монгольском языке нет личных местоимений третьего лица и вместо них употребляются указательные местоимения (заах төлөөний үг):

**энэ** — это, этот; он, она, оно (говорится о предметах, расположенных здесь, близко);

**тэр** — то, тот; он, она, оно (говорится о предметах, расположенных там, вдали).

3. В монгольском языке нет притяжательных местоимений, вместо них употребляются формы родительного падежа личных и указательных местоимений, например:

<i>миний</i> гэр	<i>моя</i> юрта
<i>чиний</i> ном	<i>твоя</i> книга
<i>манай</i> багш	<i>наш</i> учитель
<i>танай</i> нөхөр	<i>ваш</i> товарищ
<i>үүний</i> дэвтэр	<i>его</i> тетрадь ( <i>этого</i> )
<i>түүний</i> дэвтэр	<i>его</i> тетрадь ( <i>того</i> )
<i>эдний</i> байшин	<i>их</i> дом ( <i>этих</i> )
<i>тэдний</i> байшин	<i>их</i> дом ( <i>тех</i> )

4. Если местоимения в форме родительного падежа в положении определения, т. е. находясь перед именами, переводятся на русский язык притяжательными местоимениями, как это показано в приведенных выше примерах, то в сочетании с послелогами они переводятся в форме родительного же или иных падежей, например:

<i>миний</i> дараа	после <i>меня</i>
<i>чиний</i> дэргэд	возле <i>тебя</i>
<i>таны</i> хойноос	за <i>вами</i>
<i>маны</i> өмнө	перед <i>нами</i> , до <i>нас</i>
<i>үүний</i> төлөө	за <i>это</i> , для <i>этого</i>
<i>түүний</i> тухай	о <i>нем</i> , насчет <i>того</i>

5. Местоимения **манай**, или **маны**, и **бидний** когда-то различались в монгольском языке очень строго:

1) форма **манай** или **маны** представляла собою форму и с к л ю ч а ю щ е г о местоимения (исключались собеседники второго лица; таким образом, **маны газар** означало место, которое принадлежало только нам, но не нам и вам);

2) форма **бидний** представляла собою форму в к л ю ч а ю щ е г о местоимения (включались и лица, к которым вообще обращались; таким образом, **бидний газар** означало место, которое принадлежит не только нам, но и вам).

Указанное различие уже давно стерлось почти бесследно.

## У П Р А Ж Н Е Н И Я

### 1. Переведите на монгольский язык:

1) С какими государствами граничит СССР? 2) Есть ли у вас географическая карта? 3) У меня есть географическая карта. 4) Чем богата наша страна? 5) Мой старший брат передает вам привет. 6) Кого ты видел на берегу моря? 7) Где вы слушали доклад о странах народной демократии? 8) Есть у тебя книга о

Курильских островах? 9) Я прочитал книгу о дружественных нам странах. 10) Мы знаем об ископаемых богатствах нашей родины.

## 2. Ответьте на следующие вопросы:

1) Чамайг хүнд үйлдвэрийн тухай илтгэл хий гэж хэн хэлэв? 2) Манай улсад хэдэн үндэстэн бий юм бэ? 3) Манай Зөвлөлтийн ард түмнийг ямар нам удирдана? 4) Чи манай улсын газар дэвсгэрийг сайн мэдэх үү? 5) Та манай хайрт эх орны тухай ямар ном уншив? 6) Манай улсын олон үндэстэн бол ямар эв найрамдалтай байна?

## 3. Напишите сочинение на тему «Наша родина».

# 14 АРВАН ДӨРӨВДҮГЭЭР ХИЧЭЭЛ

---

## ШАЛГАЛТЫН ӨМНӨ

Удахгүй өвлийн шалгалт эхэлнэ. Оюутан бүхэн бол шалгалтанд сайнаар бэлтгэж, онц сайнар шалгуулах ёстой. Оюутан бүхэн бол сурлагын онц сайн дүн гаргахын төлөө тэмцэх ёстой. Цаг тухайд нь шалгалтанд бэлтгэж эхэлбэл сурлагын өндөр амжилтыг олж болно.

Манай нам засаг, агуу их Сталин бол манай улсын сурагчид, оюутан нарыг эх орноо цэцэглүүлэн хөгжүүлэх эрдэмтэй болгохын төлөө бүх бололцоог бий болгов.

Ийм учраас оюутан нар бол онц сайн сурлага, нарийн нямбай ажиллагаагаараа нам засгийн их ачийг хариулах ёстой байна. Хичээлийг идэвхтэй сайнаар давтаж, анхааралтай суудаг, гэрийн даалгаврыг цаг тухайд нь гүйцэтгэдэг оюутан бүхэн онц сайн сурлагын өндөр амжилтыг олж чадна.

Багш, өнөөдөр орой давтлага болно гэж надад хэлэв. Чи давтлага болох тухай мэднэ үү? Би давтлага болох тухай багшаас мэдэв. Чи түүнд юу гэж хариулав? Би бол бид заавал давтлаганд ирнэ гэж хариулав.

Чи давтлаганд очих гэж байна уу? Тиймээ, би давтлаганд очих гэж байна. Та давтлаганд очих уу? Тэгнээ би давтлаганд очно. Чи намайг хүлээгээрэй. За, би чамайг хүлээнэ. Чи надаас ямар номуудыг авсан билээ? Би чамаас сурах бичиг авсан билээ. Одоо нэг оюутан ирэв. Багш чамайг дуудаад ир гэж намайг явуулав.

За, бид давтлаганд явна. Та нар бидэнтэй хамт давтлаганд очих уу? Тэгнээ, бид та нартай хамт давтлаганд очно. Бид

бүгдээрээ давтлаганд ирэв. Биднээс урьд хэдэн оюутан нар энд ирсэн байв. Давтлага эхлэв. Манай багш бидэнд өвлийн шалгалтын тухай ярив. Тэгээд бид түүнээс асуудлуудыг асуув. Манай багш бидний асуудлуудад тодорхой тайлбар хариу хэлэв.

Үргэлжид ба шалгалтын урьд сайтар давтлага хийж байвал онц сайн сураад, шалгалтанд онц сайн тэмдэг ба сайн үнэлэлт авч болно. Шалгалтын урьд давтлагаа дуусаад нэг хоног сайн амрах хэрэгтэй. Энэ үед тэшүүрээр гулгаж, цэвэр агаарт зугаацаад, ший, кино үзээд, долоо — найман цаг унтах хэрэгтэй.

Чиний аав чамар сонин уншуулдаг уу? Тиймээ, миший аав надаар сонин уншуулдаг юм. Бас надаар захидал бичүүлдэг юм.

Өнөөдөр манай багш надад номоо уншуулав. Би бол чиний нөхөрт монгол сонинг уншуулав. Өчигдөр манай багш намайг дуудаад ном уншуулав. Таны багш хэнийг дуудаж самбар дээр бичүүлэв? Манай багш оюутан Дамдиныг дуудаад, самбар дээр бичүүлэв.

Та давтлагын дараа хэнийд очоод ирэв? Би давтлагын дараа багшийндаа очоод ирэв. Манай багшийнд гурван шүүгээгээр дүүрэн номууд байна. Чи маргааш хэнийд очих гэж байна? Би өвгөн аавындаа очно. Одоо танайд хэн байна? Одоо манайд нөхөр Самдан байна.

Чи одоо юу хийх гэж байна? Би одоо сонин уншина. Нөхөр Дорж юу хийж байна? Нөхөр Дорж давтлага хийж байна. Тэр бол өдөр бүр давтлага хийдэг юм. Бид бол түүн шиг байх ёстой. Чи гудамжинд хэнийг үзэв? Би бол гудамжинд чам шиг хүнийг үзэв. Над шиг хүнийг үзэв үү? Тэглээ, чам шиг хүнийг үзэв.

## С л о в а

**шалгалт(ан)** экзамен, зачет  
өвөл зима  
**шалгуулах** сдавать экзамен, зачёт  
**цаг тухайд** своевременно  
**засаг** власть, правительство  
**цэцэглэх** извести  
**эрдэмтэй** образованный  
**бололцоо(н)** условие, возможность  
**бий болгох** создать  
**ийм учраас** поэтому  
**нарийн нямбай** эд. прилежный; ак-  
куратный  
**ажиллагаа(н)** работа, деятельность  
**ачийг хариулах** отблагодарить  
**гүйцэтгэх** выполнить  
**чадах** мочь, уметь  
**дуудах** вызывать, звать  
**явуулах** отправив, послать  
**хамт** вместе

**бүгдээрээ** все  
**тодорхой** ясный, подробный  
**тайлбар** разъяснение  
**үргэлжид** постоянно, регулярно, си-  
стематически  
**тэмдэг** отметка  
**үнэлэлт** оценка  
**тэгнээ** да  
**хоног** сутки  
**үе** период  
**агаар** воздух  
**унтах** спать  
**дүүрэн** полный, наполненный  
**уншуулах** просить читать (*после сло-  
ва в орудном надеже*), позволить  
читать (*после дательного-местного  
надежа*), заставить читать (*после  
винительного надежа*).

## ГРАММАТИКА

1. Личное местоимение первого лица единственного числа имеет следующие основы:

1) **нам-** для винительного падежа, например, **намайг**—меня; эта основа не имеет самостоятельного употребления;

2) **над-**— для дательного-местного, исходного, орудного и совместного падежей, например:

<b>надад</b>	(употребляется в сокращенной форме — <b>над</b> )	мне, у меня
<b>надаас</b>	от меня	
<b>надаар</b>	мною	
<b>надтай</b>	со мною	

Эта основа имеет и самостоятельное употребление (с послелогами), например:

**над шиг**      вроде меня

2. Личное местоимение второго лица единственного числа для винительного, дательного-местного, исходного, орудного и совместного падежей имеет основу **чам-**, например:

<b>чамайг</b>	тебя
<b>чамд</b>	тебе, у тебя
<b>чамаас</b>	от тебя
<b>чамаар</b>	тобою
<b>чамтай</b>	с тобою

Эта основа имеет и самостоятельное употребление (с послелогами), например, **чам шиг** вроде тебя.

3. Указательные местоимения **энэ** — это и **тэр** — тот имеют соответственно следующие основы:

<b>үүн-</b>		<b>түүн-</b>	
<b>үүнийг</b>	это, его	<b>түүнийг</b>	то, его
<b>үүнд</b>	этому, ему	<b>түүнд</b>	тому, ему
<b>үүнээс</b>	от этого, от него	<b>түүнээс</b>	от того, от него
<b>үүгээр</b>	этим, им	<b>түүгээр</b>	тем, им
<b>үүнтэй</b>	с этим, с ним	<b>түүнтэй</b>	с тем, с ним

4. Личное местоимение первого лица множественного числа имеет следующие основы, ныне употребляемые на равных правах:

<b>ман-</b>	<b>бидэн-</b>	
<b>маньг</b>	<b>биднийг</b>	нас
<b>манд</b>	<b>бидэнд</b>	нам, у нас
<b>манаас</b>	<b>биднээс</b>	от нас
<b>манаар</b>	<b>биднээр</b>	нами
<b>мантай</b>	<b>бидэнтэй</b>	с нами

Надо заметить, что вторая основа (бидэн-) употребляется чаще и почти вытесняет из речи первую (ман-), которая употребляется преимущественно для образования формы родительного падежа (см. в предыдущем уроке).

5. Личное местоимение второго лица множественного числа имеет основу **тан-**:

<b>таныг</b>	вас	<b>танаар</b>	вами
<b>танд</b>	вам, у вас	<b>тантай</b>	с вами
<b>танаас</b>	от вас		

6. Указательные местоимения множественного числа **эд** — эти и **тэд** — те имеют следующие основы:

<b>эдэн-</b>		<b>тэдэн-</b>	
<b>эднийг</b>	этих	<b>тэднийг</b>	тех
<b>эдэнд</b>	этим	<b>тэдэнд</b>	тем
<b>эднээс</b>	от этих	<b>тэднээс</b>	от тех
<b>эднээр</b>	этим	<b>тэднээр</b>	теми
<b>эдэнтэй</b>	с этими	<b>тэдэнтэй</b>	с теми

7. Все изложенное относительно склонения местоимений схематически можно изобразить в следующем виде:

Формы падежей		Основы для падежей				
Именит.	Родит.	Випит.	Дат.-местн.	Исходн.	Орудн.	Совместн.
би я	миний	нам-	над-			
чи ты	чиний	чам-				
бид мы	бидний	бидн-	бидэн-	бидн-	бидэн-	
ба мы (ныне не употр.)	манай мань	ман-				
та вы	танай таны	тан-				
энэ это	үүний	үүн-			үү-	үүн-
тэр тот	түүний	түүн-			түү-	түүн-
эд эти	эдний	эдн-	эдэн-	эдн-		эдэн-
тэд те	тэдний	тэдн-	тэдэн-	тэдн-		тэдэн-

## У П Р А Ж Н Е Н И Я

### 1. Переведите на монгольский язык:

1) Как вы готовитесь к зимним экзаменам? 2) По каким предметам будете сдавать экзамены? 3) С кем ты повторяешь уроки? 4) Своевременно ли вы начали подготовку к экзаменам? 5) У нас созданы все условия для подготовки к экзаменам. 6) Каждый студент должен прилежно работать и сдавать свои экзамены на «хорошо» и «отлично». 7) Кто тебе дал читать эту книгу? 8) Моя бабушка каждый день просит, чтобы я прочитал ей газету. 9) Мой преподаватель вызвал меня к доске и попросил написать это слово. 10) Мой отец позволил мне читать его книгу.

### 2. Ответьте на следующие вопросы:

1) Манай нам засаг бол оюутан нарыг ямар хүмүүс болгох зорилго тавив? 2) Оюутан нар үүний ачийг юугаар хариулах ёстой вэ? 3) Чамайг хэн дуудав? 4) Хэн надаас өнөөдрийн сонин авав? 5) Чиний өвгөн аав чамаар юу уншуулдаг вэ? 6) Та надаар яах гэв? 7) Өчигдөр та хэнтэй хамт хичээл давтав? 8) Энэ номыг танд хэн уншуулав? 9) Багш чамайг дуудаад юу бичүүлэв?

### 3. Приготовьте рассказ на тему «Как я готовлюсь к экзаменам», используя личные местоимения.

## 15 АРВАН ТАВДУГААР ХИЧЭЭЛ

---

### ДЭЛГҮҮРТ

Өчигдөр аав минь цалингаа авав. Аав минь цалингаа ээжид минь өгөв. Би өнөөдөр ээжтэйгээ барааны дэлгүүрт очих гэж байна. Аав минь дүнс худалдаж аваарай гэж захив. Эгч минь торгон оймс захив.

Бид дэлгүүрт очив. Энэ дэлгүүр бол таван давхар том байшингийн нэгдүгээр ба хоёрдугаар давхарт нь оршино. Энэ дэлгүүрт янз бүрийн бараа худалдаж байна. Энд ард олны хэрэгцээт бараа товар дүүрэн байна. Энд нэн тэргүүний хэрэгцээт бараа хүрэлцээтэй байна. Энд олон худалдагчид янз бүрийн бараа худалдаж байна.

Коммунист нам ба агуу их Сталины анхаарлын ачаар манай ард түмний аж амьдралын хэмжээ өдөр ирэх тутам улам дээшлэж байна. Манай Зөвлөлтийн ард түмэн бол чинээлэг болов. Иймд манай ард түмэн бол яс чанар сайнтай бараа худалдаж авдаг болов. СССР улсад барааны үнэ улам хямдарч байна. Саяхан Коммунист намын Төв Хороо ба СССР-ийн Сайд нарын Зөвлөлийн

тогтоолоор барааны үнийг тавдугаар удаа нэлээд ихээр хямдруулав. Цаашид ч барааны үнийг хямдруулах төлөвлөгөөтэй юм. Иймд манай зөвлөлтийн ард түмэн бол хамгийн жаргалант ард түмэн юм.

Одоо капиталист орнуудад эдийн засгийн кризисийн шинж тэмдгүүд улам дэлгэрч байна. Одоо капиталист орнуудад ажилгүйчүүд ба хагас ажилтай хүмүүсийн тоо 45 саяас доошгүй тоонд хүрэв. Эдгээр улсуудад барааны үнэ улам нэмэгдэж байна. Одоо Америк ба маршаллчлагдсан орнуудад хөдөлмөрчин олон түмний аж амьдралын хэмжээ өдөр ирэх тутам зогсолтгүй унаж, гуйлинчин байдалд орж байна. Иймд капиталист орнуудын байдал улам муудаж байна.

Бид бол энэ сайхан дэлгүүрт ороод манай улс ба капиталист орнуудын ялгаварын тухай ярилцав.

Ээж минь: «Аавд чинь дүнс худалдаж авъя» гэв. Бид дүнс худалдаж авав. Тэгээд дүүд минь дээл хийхийн тул цэмбэ худалдаж авав. Бас дүүд минь өмд хийх даавуу худалдаж авав. Тэгээд дотуур хувцас оёулахын тул бид цагаан даавуу худалдаж авав. Ээж минь надад нэг хос савхин гутал худалдаж авав. Бас бид ээжийн минь эгчид нь цамцны торго худалдаж авав. Мөн бид энэ дэлгүүрээс гарахын өмнө нүүр гарын ба барааны саван, торгон оймс худалдаж авав. Бид эндээс гараад хүнсний зүйлийг худалдах дэлгүүрт очив. Тэнд чихэр, талх, цөцгийн тос зэргийн хүнсний зүйлүүдийг худалдаж байна. Бид гурил, давс ба цай худалдаж авав.

Бид дэлгүүрээс гараад трамвайд сууж гэртээ ирэв. Биднийг эгч минь угтав. Эгч минь: «Манайд нөхөр чинь ирээд байна» гэж надад хэлэв. Гэрт маань дулаан байна. Аав минь ирээд, худалдаж авсан бараагийг маань цөмийг үзэв. Тэгээд аав минь: «Та нарын худалдаж авсан бараа яс чанараараа маш сайн байна» гэж хэлэв. Аав минь дэлгүүрийн тухай асуув. Бид хариулав. Эгч минь ээжийгээс: «Энэ савхин гутлыг надад худалдаж авав уу?» гэж асуув. Ээж минь: «Чамд биш, дүүд чинь худалдаж авав» гэж хариулав.

Ээжийн минь эгч нь ирэв. Би ээжийнхээ эгчид нь худалдаж авсан торгоо өгөв. Ээжийн минь эгч нь: «баярлалаа» гэж хэлэв. Тэгээд би нөхөртэйгөө яриу. Тэр бол: «Эгч чинь оюутан уу?» гэж асуув. «Оюутан биш, албан хаагч юм» гэж би хариулав.

## С л о в а

цалин (г) зарплата  
барааны эд. промтоварный  
дүнс(эн) дунс (табак)  
захих заказать  
торго(н) шелк  
торгон шелковый  
оймс(он) чулки, носки  
давхар этаж

худалдах продавать  
бараа(н) товар  
ард олны хэрэгцээт массового потребления  
нэн тэргүүний хэрэгцээт первой необходимости  
хүрэлцээтэй в достаточном количестве

**худалдагчид** продавцы  
**хэмжээ(н)** уровень  
**дээшлэх** повышаться  
**яс чанар** качество  
**хямд** дешевый; дешево  
**саяхан** недавно  
**Төв хороо(н)** центральный комитет  
**Сайд нарын Зөвлөл** Совет Министров  
**хямдруулах** удешевлять, снижать [цены]  
**удаа** раз  
**нэлээд** значительно  
**төлөвлөгөө** план, проект  
**ертөнц** зд. мир  
**орон** страна  
**эдийн засаг** экономика  
**шинж тэмдэг** признак, симптом  
**ажилгүйчүүд** безработные  
**доошгүй** не менее  
**олон түмэн** массы  
**унах** падать, понижаться  
**гуйлинчин** нищий  
**муудах** ухудшаться  
**ялгавар** разница, отличие  
**дээл дэл** (пальто, шуба)

**оёх** шить  
**даалимба** далемба (род хлопчатобумажной ткани)  
**өмд(өн)** брюки  
**цэмбэ** сукно  
**дотуур хувцас(ан)** нижнее белье  
**оёулах** отдавать в пошивку  
**хөвөн(г)** хлопок; хлопчатобумажный  
**даавуу** ткань  
**хос** пара  
**савхин гутал** кожаные сапоги  
**цамц** рубашка, сорочка, кофточка, гимнастерка  
**нүүр гарын саван(г)** туалетное мыло  
**барааны саван(г)** хозяйственное мыло  
**хүнсний** продовольственный  
**чихэр** сахар  
**талх** хлеб (печеный)  
**цэцгийн тос(он)** сливочное масло  
**зэргийн** и другие  
**зүйл** вещь, предмет  
**гурил** мука  
**давс(ан)** соль  
**цай** чай  
**дэлгэрэх** расширяться, нарастать

## ГРАММАТИКА

1. Выше мы видели, что принадлежность предмета тому или иному лицу выражается формой родительного падежа личных местоимений, например:

<i>миний</i> ном	<i>моя</i> книга	<i>үүний</i> ном	<i>его (этого)</i> книга
<i>чиний</i> ном	<i>твоя</i> книга	<i>туүүний</i> ном	<i>его (того)</i> книга
<i>манай</i> ном	<i>наша</i> книга	<i>эдний</i> ном	<i>их (этих)</i> книга
<i>танай</i> ном	<i>ваша</i> книга	<i>тэдний</i> ном	<i>их (тех)</i> книга

Но подобные обороты, в которых личные местоимения в форме родительного падежа являются притяжательными определениями, могут быть заменены другими, в которых определяемые будут иметь не эти притяжательные определения (впереди себя), а лично-притяжательные частицы, ставящиеся после них, определяемых, и представляющие собой усеченные формы тех же личных местоимений в форме того же родительного падежа, например, ном *минь* — книга *моя*, номд *минь* — в книге *моей* и т. д.

2. В монгольском языке имеются следующие лично-притяжательные частицы:

<b>МИНЬ</b>	для 1-го лица единственного числа
<b>ЧИНЬ</b>	для 2-го лица единственного числа
<b>МААНЬ</b>	для 1-го лица множественного лица
<b>НЬ</b>	для 3-го лица обоих чисел

Для второго лица множественного числа лично-притяжательной частицы нет, хотя в отдельных говорах монгольского языка она имеется (**тань**; например, моринд *тань* — лошади *вашей*).

Примеры:

морь	<i>чинь</i>	лошадь <i>твоя</i>
мориор	<i>чинь</i>	на лошади <i>твоей</i>
ах	<i>минь</i>	старший брат <i>мой</i>
ахаас	<i>минь</i>	от старшего брата <i>моего</i>
гэр	<i>маань</i>	юрта <i>наша</i>
гэрт	<i>маань</i>	в юрте <i>нашей</i>
ном	<i>нь</i>	<i>его</i> или <i>их</i> книга
номд	<i>нь</i>	в книге <i>его</i> или <i>их</i>

3. Лично-притяжательные частицы, как видно из примеров, ставятся после определяемого слова, включая падежные окончания последнего. Однако, при наличии лично-притяжательных частиц, в оформлении окончаний винительного падежа происходят следующие изменения:

а) если слово в своей основе оканчивается на краткий гласный или согласный, то в окончании винительного падежа выпадает согласный **г**, например:

арга — <i>аргы</i>	минь	мой <i>способ</i>
ах — <i>ахы</i>	чинь	твоего <i>старшего брата</i>
ном — <i>номы</i>	нь	его, их <i>книгу</i>
гэр — <i>гэрий</i>	маань	нашу <i>юрту</i>
үнэ — <i>үний</i>	нь	его, их <i>цену</i>

б) если слово в своей основе оканчивается на дифтонг или долгий гласный, то к окончанию винительного падежа — **-г** — наращивается еще долгий **-и**, например:

нохой — <i>нохойгий</i>	минь	мою <i>собаку</i>
гахай — <i>гахайгий</i>	чинь	твою <i>свинью</i>
буу — <i>буугий</i>	маань	наше <i>ружье</i>
жороо — <i>жороогий</i>	нь	его, их <i>иноходца</i>
сүү — <i>сүүгий</i>	чинь	твое <i>молоко</i>

Во всех этих примерах соответственно нельзя сказать или написать:

<b>аргыг</b>	минь	<b>нохойг</b>	минь
<b>ахыг</b>	чинь	<b>гахайг</b>	чинь
<b>номыг</b>	нь	<b>бууг</b>	маань
<b>гэрийг</b>	маань	<b>жороог</b>	нь
<b>үнийг</b>	нь	<b>сүүг</b>	чинь

4. Таким образом, принадлежность предмета какому-нибудь лицу в монгольском языке выражается двумя способами: 1) при

помощи родительного падежа личных местоимений или 2) посредством лично-притяжательных частиц. Первый способ условно можно назвать полным притяжением, поскольку личные местоимения не «усекаются», а второй — частичным притяжением, поскольку последнее осуществляется при помощи частиц.

Теперь спрашивается, какая же разница в употреблении полного или частичного притяжений, поскольку, например, **МИНИЙ НОМ** и **НОМ МИНЬ** на русский язык одинаково переводится как *моя книга*? Разница заключается в том, что при полном притяжении логическое ударение падает на определение (**МИНИЙ** ном — *моя* книга, [а не — *твоя* или *ваша*]), тогда как при частичном притяжении — на определяемое (ном **МИНЬ** — *моя книга*, [а не *тетрадь* или *газета*]).

5. В монгольском языке **биш** (иногда **бус**) является противопоставительным словом или относительным отрицанием послеслового характера (ставится после соответствующего слова, а не впереди, как в русском языке) и переводится на русский язык «не . . . , а . . . », например:

Энэ — ном *биш*, дэвтэр.

Энд *биш*, тэнд.

Би тэнд дэмий талаар яваад ирсэн *биш*, энэ сонирхолтой ном сэтгүүлүүдийг авчирсан шүү!

Явсан *биш*, ирсэн.

Гэртээ явсан *биш*, сургуульдаа очсон.

Миний гэрт болсон *биш*, чиний гэрт болов.

Ахад минь өгсөн *биш*, дүүд минь өгөв.

Это *не* книга, а тетрадь.

*Не* здесь, а там.

Я *не* зря сходил туда, а принес эти интересные книги и журналы.

*Не* ушел, а пришел.

*Не* домой пошел, а в школу отправился.

Случилось [это] *не* в моей юрте, а в твоей.

Дал [что-то] моему *не* старшему брату, а младшему.

Последние два примера говорят о том, что по-монгольски при противопоставлении глаголы дублируются в обеих частях предложения.

## У П Р А Ж Н Е Н И Я

### 1. Переведите на монгольский язык:

1) Моя сестра прочитала нам постановление ЦК партии и Совета Министров о снижении цен на товары. 2) Отец мой сказал, что с каждым днем повышается жизненный уровень нашего советского народа. 3) Моя мать сегодня купила в магазине много разных вещей. 4) Твой отец сказал, что качество продукции их завода с каждым днем улучшается. 5) Мой старший брат сказал, что он завтра получит свою зарплату.

## 2. Ответьте на следующие вопросы:

1) Хэн чинь дэлгүүрээс бараа худалдаж авдаг вэ? 2) Аав минь ямар дэлгүүрт очив? 3) Багш маань юу ярив? 4) Нөхрийн чинь ах юу захив? 5) Ээж чинь өдөр бүр хэдэн кило талх худалдаж авдаг вэ? 6) Ард түмний маань аж амьдралын хэмжээ нь ямар болж байна? 7) Нөхөр минь юу худалдаж авав? 8) Аав чинь чамд ямар бэлэг өгөв? 9) Дамдины ах нь ямар бараа худалдаж авав? 10) Дүү чинь юу захив? 11) Энэ бол миний савхин гутал уу? 12) Харандаагаар чинь хэн бичив? 13) Худалдаж авсан бараагийн чинь хэн үзэв? 14) Цайгий чинь хэн уув? 15) Капиталист ертөнцийн орнуудын хөдөлмөрчин олны аж амьдралын нь хэмжээ ямар болж байна? 16) Одоо капиталист орнуудад ажилгүйчүүдийн тоо хэд болов? 17) Энд сууж байгаа нөхөр албан хаагч уу? 18) Энэ сурах бичиг үү? 19) Энэ чиний ах уу?

3. Напишите рассказ на тему «Что мы купим к празднику», используя слова 15-го урока.

## 16 АРВАН ЗУРГААДУГААР ХИЧЭЭЛ

---

### ЛЕНИНИЙ СУРГААЛ МӨНХ БӨГӨӨД ЯЛАГДАШГҮЙ

В. И. Лениний нас нөгцсөний 28 жилийн ойд зориулсан дурсгалын хуралдаан Улаанбаатарт болов. В. И. Лениний нас нөгцсөний 28 жилийн ойн дурсгалын хуралдаан энэ нэгдүгээр сарын 21-ний орой, улсын хөгжимт драматик театрт болов.

Улсын хөгжимт драматик театрын тайзны гүнд их Лениний хөргийг тавьж, түүний хоёр талд нь «1924—1952» он гэсэн тоог томоор бичиж амьд цэцэг, улаан тугуудаар жавхлантай чимэглэжээ.

Цуглагсад их багш Лениний зураг өөд ширтэн, түүний бүтээсэн гайхамшигт их үйл явдлыг бодон, сэтгэлийнхээ гүнд дурсан байдалтай сууцгааж байлаа.

Дурсгалын хуралдааны тэргүүлэгчдийн байранд нам засгийн удирдагчид ба Зөвлөлт Холбоот Улсаас тус Бүгд Найрамдах Монгол Ард Улсад суугаа онц бүрэн эрхт элчин сайд ба бусад нөхөд гарч ирэв.

Хуралдагсад бол эдгээр нөхдийг суудлаасаа босож алга ташиж угтав.

Монгол Ардын Хувьсгалт Намын Төв Хороо, М. А. Х. Намын Улаанбаатар хотын хороо, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Их Хурлын Тэргүүлэгчдийн газар, Монголын Хувьсгалт Залуучуудын Эвлэлийн Төв Хороо, Б. Н. М. А. Улсын үйлдвэрчний Эвлэлүү-

дийн Төв Зөвлөл, Улаанбаатар хотын хөдөлмөрчдийн бага хурлын тэргүүлэгчид, нийслэлийн хөдөлмөрчид, нам, олон нийтийн байгууллага, ардын хувьсгалт армийн төлөөлөгчдийн хамтран хийсэн дурсгалын хуралдаан эхлэв.

Хуралдааныг даргалагчаас:

«Дэлхийн хөдөлмөрчдийн суут жолоодогч, мэргэн багш, большевикуудын их нам ба Зөвлөлт улсыг үндэслэн байгуулагч Владимир Ильич Лениний зүрх цохихоо болиод 28 жил болов» гээд, «Владимир Ильич Лениний дурсгалыг босч хүндэтгэе» гэв. Бүгдээрээ босч чимээ аниргүй зогсов.

Тэгээд дурсгалын хуралдааныг нээв.

Дэлхийн хөдөлмөрчдийн мэргэн жолоодогч, большевикуудын нам ба Зөвлөлт улсыг үндэслэн байгуулагч В. И. Лениний нас нөгцсөний 28 жилийн ой ба түүний гайхамшигт их үйл явдлын тухай дэлгэрэнгүй илтгэлийг намын Төв Хорооны нарийн бичгийн дарга хийв. Хуралдагсад илтгэгчийн үг бүрийг маш анхааралтай сонсцогоов.

Агуу их Ленин нас нөгцсөн боловч, түүний үйл хэрэг мөнх, Ленин бү амьдралаа хөдөлмөрчин хүн төрөлхтнийг хөрөнгөтний дарлалаас чөлөөлөх, улс түмний тусгаар тогтнол, эрх чөлөөний төлөө, коммунизмыг байгуулах хэргийн төлөөний тэмцэлд зориулсан юм. Лениний нэр бол бүх шударга хүн бүхэнд дотно байдаг.

Ленин Сталин нарын үндэслэн байгуулсан Зөвлөлт Холбоот Улс бол дэлхийн тэргүүний хөгжилтэй гүрэн болов. Ленинизмийн туяа дэлхий дахинд сацраад, дэлхийн ардчилал, социализмын лагерь улам бүр батжин өсөж түүний эгнээнд одоо 800 сая гаруй хүн нэгдэв. Их Лениний мөнхийн үйл хэргийг их Сталин үргэлжлүүлж байна!

Монголын ард түмнийг эрх чөлөөгөө олж авах явдалд В. И. Ленин их анхаарлыг тавьсан билээ.

Монгол Ардын хувьсгалт нам бол марксизм-ленинизмийг удирдлага болгодог бөгөөд Лениний заасан замаар Зөвлөлт Холбоот Улсын тусламжтайгаар, нөхөр Чойбалсангийн жолоодлогоор явж их ялалтыг хийсэн байна. Лениний сургаал мөнх бөгөөд ялагдашгүй.

## С л о в а

**сургаал** учение

**мөнх** вечно; вечный, бессмертный

**ялагдашгүй** непобедимо; непобедимый

**нас нөгцөх** умереть

**ой эд.** годовщина, юбилей

**дурсгал** память

**хуралдаан** заседание, собрание

**тайз(ан)** сцена

**гол эд.** центр, середина

**хөрөг** портрет

**гашуудал** траур

**туг** знамя

**жавхлантай** великолепный; величественный

**чимэглэх** украшать

**цуглагсад** собравшиеся

**өөд эд.** на, в сторону, к

**ширтэн (харах)** устремить глаза, всматриваться

**бүтээх** сделать, созидать

**гайхамшигт** замечательный, прекрасный

**үйл** явдал дела

сэтгэл мысль, душа  
 гүнд в (о) глубине  
 дурсах вспоминать  
 удирдагчид руководители  
 тус эд. данный  
 онц эд. чрезвычайный  
 бүрэн эрхт полномочный  
 элчин посланник, посол  
 суудал место, сиденье  
 алга таших аплодировать  
 угтах встречать  
 нийслэл столица  
 байгууллага организация  
 төлөөлөгчид эд. представители  
 хамтран хийсэн совместный; совме-  
 сто проведенный  
 даргалагч председательствующий  
 суут гениальный  
 жолоодогч вождь  
 мэргэн мудрый  
 үндэслэн байгуулагч основатель  
 зүрх(эн) сердце  
 цохихоо болих перестать биться  
 чимээ аниргүй молча, без звука  
 эмгэнэх скорбеть, горевать, быть в  
 трауре

зогсох вставать, стоять  
 дэлгэрэнгүй подробный, обстоятель-  
 ный  
 дарлал угнетение  
 хөрөнгөтөн капиталист(ы)  
 тусгаар тогтнол независимость  
 чөлөөлөх освободить  
 эрх чөлөө(н) свобода  
 хэрэг дело  
 зориулах посвящать  
 дотно близко; близкий  
 хөгжилтэй развитый  
 туяа(н) луч; сияние  
 сацрах светить  
 батжин өсөх расти, укрепляться  
 эгнээ(н) ряды  
 удирдлага руководство  
 тусламж помощь  
 тэргүүлэгчид президиум  
 Их Хурал эд. Великий хурал  
 үйлдвэрчний эвлэл профсоюз  
 хувьсгалт залуучууд революцион-  
 ная молодежь  
 эвлэл союз  
 дотнын нөхөр соратник  
 урагшаа давшья вперед

## ГРАММАТИКА

1. а) Уступительное деепричастие (дутагдах төлөв) обозначает действие или состояние, несмотря на наличие которого происходит другое действие или имеет место другое состояние; на русский язык это деепричастие обычно переводится оборотом «хотя» или «несмотря на то, что...», например:

Цас оровч, гадаа хүйтэн биш. *Хотя и выпал снег, на дворе не холодно.*  
 Орой босовч, сургуульдаа цаг тухайд ирэв. *Пришел в школу своевременно, несмотря на то, что встал поздно.*

б) Окончанием уступительного деепричастия является **-вч** (если основа глагола оканчивается на гласный) или **-авч, -эвч, -овч, -өвч** (если основа глагола оканчивается на согласный), например:

ир + эвч = ирэвч	хотя и пришел
яв + эвч = явавч	хотя и ушел
ол + овч = оловч	хотя и нашел
өс + өвч = өсөвч	хотя и вырос
хаа + вч = хаавч	хотя и закрыл
нээ + вч = нээвч	хотя и открыл

суу + вч = суувч хотя и сел  
 нүү + вч = нүүвч хотя и перекочевал

в) В речи, однако, глаголы в форме уступительного деепричастия употребляются очень редко, ибо уступительный оборот образуется посредством сочетания имени или причастия с **болозч** или (иногда) **байвч**, представляющими собою формы данного деепричастия от глаголов **болох** — стать и **байх** — быть и переводимыми на русский язык как «хотя», например:

дуулах боловч	хотя и будет петь
дуулсан боловч	хотя и пел
дуулж байгаа боловч	хотя и поет
дулаан байвч	хотя и тепло
дулаан боловч	хотя и стало тепло

2. а) Слитное деепричастие (нийлүүлэх төлөв) по своему употреблению и значению почти ничем не отличается от соединительного деепричастия: все небольшое отличие этого деепричастия от последнего сводится к тому, что оно чаще всего обозначает действие, сливающееся с другим или определяющее последующее, например:

ширтэн харав	смотрел <i>вглядываясь</i> (внимательно)
гайхан үзнэ	рассматривает <i>удивляясь</i> (с удивлением)
суудласаа босон, үг хэлэв	<i>встав</i> с места, произнес речь.

б) Слитное деепричастие очень часто служит для образования сложных или составных глаголов, например:

зохион байгуулах	организовать
үндэслэн байгуулах	основать
хянан байцаах	контролировать, ревизовать

в) Окончанием слитного деепричастия является **-н** (если основа глагола оканчивается на гласный) или **-ан, -эн, -он, -өн, -ин** (если основа глагола оканчивается на согласный), например:

суу + н = суун	сидя
тэмдэглэ + н = тэмдэглэн	отмечая
гар + ан = гаран	выходя
ор + он = орон	входя
бич + ин = бичин	пиша
ир + эн = ирэн	приходя
өс + өн = өсөн	вырастая

3. Кроме известной нам первой изъявительной формы прошедшего времени (с окончанием **-в** или **-ав**), в монгольском языке

имеются еще вторая (достоверная или прежде известная) и третья (нечаянная) изъявительные формы прошедшего времени (өнгөрсөн цагийг хоёр ба гурав). Эти формы имеют некоторое отличие от первой:

а) при помощи второй формы обозначается действие, о котором говорящий лишь напоминает слушающему и которое, следовательно, уже известно последнему\*, например:

өглөө ирлээ      иршил [ведь, как известно] утром

б) при помощи третьей формы обозначается действие, которое стало известным внезапно и которого не ждали, например:

өглөө иржээ      иршил [оказывается] утром

Но в речи эти оттенки фактически соблюдаются очень редко.

4. Окончанием второй изъявительной формы прошедшего времени являются **-лаа, -лоо, -лөө, -лээ**, например:

яв + лаа = явлаа пошел  
ор + лоо = орлоо вошел  
өс + лөө = өслөө вырос  
нүү + лээ = нүүлээ перекочевал

5. Окончаниями третьей изъявительной формы прошедшего времени являются:

а) **-жээ** (если основа глагола оканчивается на гласный или любой согласный, кроме **с, р, в** без скрытого конечного краткого гласного), например:

бич + жээ = бичжээ написал  
суу + жээ = суужээ сел  
ол + жээ = олжээ нашел  
хас + жээ = хасжээ сократил  
хар + жээ = харжээ увидел  
яв + жээ = явжээ пошел

б) **-чээ** (если основа глагола оканчивается на согласные **с, р, в** без скрытого конечного краткого гласного), например:

бос + чээ = босчээ встал  
гар + чээ = гарчээ вышел  
ав + чээ = авчээ взял

Примечания. а) Эти окончания — **-жээ** и **-чээ** — не подчиняются закону гармонии гласных, что и видно из представленных примеров. б) При

---

\* Эта форма очень часто передает действие, совершить которое собирается говорящий, например: **за, би явлаа** — ну, я пошел (т. е. пойду)

глаголах **хас** — сократить, **хар** — увидеть, **яв** — итти и им подобных мы видим окончание не **-чээ**, а **-жээ** потому, что они, эти глаголы, в своей основе оканчиваются на краткие гласные, которые на письме не обозначаются (глаголы же: **бос** — вставать, **гар** — выходить, **ав** — взять и им подобные в своей основе не имеют скрытого конечного краткого гласного).

## У П Р А Ж Н Е Н И Я

### 1. Переведите на монгольский язык:

- 1) Дело своего учителя продолжает его верный ученик и друг.
- 2) Советские учителя воспитывают своих учеников в духе коммунизма.
- 3) Самдан является близким другом нашего учителя.
- 4) Наш учитель организовал кружок по изучению монгольского языка.
- 5) Собравшиеся бурными аплодисментами встретили сообщение о награждении нашего учителя орденом Трудового Красного Знамени.
- 6) Наш учитель уже приехал из деревни.
- 7) На недавно состоявшемся собрании коллектива нашего института доклад сделал директор института.
- 8) Мы читали книгу о молодежи Монголии.
- 9) Он сидел, пристально глядя на портрет.
- 10) Я ведь экзамен сдал.
- 11) Он, оказывается, вчера уехал.
- 12) Несмотря на то, что вернулся домой рано, спать лег поздно.
- 13) Хотя и закрыл окно, но в комнате холодно.

### 2: Ответьте на следующие вопросы:

- 1) Одоо ямар улсууд социализмын замаар хөгжиж байна?
- 2) Та монголын залуучуудын тухай ямар ном уншив? 3) Саяхан танай дээд сургуулийнханы хурал дээр хэн илтгэл хийв? 4) Та одоо ямар ажлыг зохион байгуулж байна? 5) Чиний дэргэд суугаа нөхөр юу уншиж байна? 6) Хичээл тарсан боловч сурагчид дээд сургуульдаа юу хийх гэж үлддэг байна?

### 3. Образуйте форму слитного деепричастия от следующих глаголов:

Чимэглэх, ширтэх, бүтээх, дурсах, алга таших, угтах, болих, эмгэнэх, зогсох, чөлөөлөх, зориулах, сацрах, өсөх.

### Повторительное упражнение

#### Переведите на монгольский язык:

- 1) Несмотря на то, что я пришел домой поздно, буду читать сегодняшнюю газету.
- 2) Товарищ Дамдин приезжает в институт очень рано, хотя он живет отсюда довольно далеко.
- 3) Наши студенты уходят домой поздно, хотя занятия кончаются рано.
- 4) Сегодня на улице тепло, хотя утром выпал снег.
- 5) Сегодня Доржи пришел в теплой одежде, хотя на улице тепло.
- 6) Мои товарищи пошли в кино, хотя идет снег.

## АГУУ ИХ СТАЛИНЫ 70 НАСНЫ ОЙД ЗОРИУЛСАН БАЯРЫН ХУРАЛДААН УЛААНБААТАРТ БОЛОВ

Дэлхий дахины хөдөлмөрчдийн хайрт мэргэн жолоодогч, багш, хүн төрөлхтний суут нөхөр Иосиф Виссарионович Сталины 70 насны ойд зориулан Улаанбаатар хотын намын хороо, Улаанбаатар хотын бага хурлын тэргүүлэгчид, нийслэлийн олон нийтийн байгууллага, хөдөлмөрчид, монгол ардын хувьсгалт армийн ангиудын хамтарсан баярын хуралдаан улсын хөгжимт драматик театрт 1949 оны 12 дугаар сарын 21-нд болов.

Чимэглэлт тайзны гүнд нь Иосиф Виссарионович Сталины том хөрөг, хоёр талд нь «1879—1949» гэсэн тоо байв.

Оройн 7 цаг боллоо. Нөхөр И. В. Сталины 70 насны ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг эрхэлсэн засгийн газрын комиссын дарга, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын ерөнхий сайд Маршал Чойбалсан ба бусад нөхөд хурлын тэргүүлэгчдийн байранд гарч ирлээ.

Баярын хуралдааныхан, нам засгийнхаа удирдагч нарыг дотноор угтав.

Энэ баярын хуралдаанд СССР-ээс Бүгд Найрамдах Монгол Ард Улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд, СССР-ийн элчний яамны ба СССР-ийн худалдааны төлөөлөгчийн газрын хариуцлагатай ажилтан нар байлцав.

Нөхөр Чойбалсан баярын хуралдааныг нээж үг хэлэхдээ: «И. В. Сталины 70 насны ойн энэ гайхамшигт өдрийг бүх шударга хүн төрөлхтөн, бүх гүрнүүдийн хөдөлмөрчид, дэлхий дахины ардчилал социализмын их жолоодогч багш нөхөр Сталиндаа маш их халамжтайгаа илэрхийлэн, газрын бөмбөрцгийн өнцөг булан бүрд угтаж байна» гэж хэлэв.

Нөхөр Чойбалсангаас цааш нь хэлэхдээ, «бид энэ өдөр их Сталины зүг их баяртайгаар хандан ширтэж, манай хайрт багш ханьдаа өөрийн халуун баяр, зүрхний мэндчиллэгийг бүх ард нийтийн талархлын хамт хүрэгье.

Хайрт Иосиф Виссарионович, Та, бүх дэлхийн хөдөлмөрчдийн баяр баясгалан, бүх шударга хүн төрөлхтний сайн сайхны төлөө олон он жил урт удаан насалж, мандан бадарч байгтун гэдэг ерөөлийг зүрхний угаас, сэтгэлийн гүнээсээ дэвшүүлэн хүрэгье!» гэв.

Нөхөр Чойбалсангаас үг хэлж байхад их Сталины яруу алд-рыг ерөөж нижигнэтэл алга ташиж байлаа.

Үг хэлж дуусахад нь бүгдээрээ босцогоон, нөхөр Сталинд зориулан удтал алга ташив. «Их Сталин мандтугай!», «Их Сталины яруу алдар бадартугай!» гэж цууриатав. Зөвлөлт Холбоот Улсын төрийн дууллыг хөгжимд эгшиглэв.

Дэлхий дахины хөдөлмөрчдийн агуу их жолоодогч, багш, Монголын ард түмний шилдэг хань нөхөр И. В. Сталины амьдрал, үйл ажиллагааны тухай илтгэлийг Монгол Улсын их сургуулийн ректор нөхөр Ширэндэв хийв.

Баярын хуралдаанаас дэлхий дахины хөдөлмөрчдийн их мэргэн жолоодогч багш бөгөөд агуу их Лениний мөнхийн үйл хэргийг суут мэргэнээр үргэлжлүүлэгч Иосиф Виссарионович Сталинд явуулах баярын илэрхийлэлтийг нэг дуугаар нижигнэтэл алга ташин маш их хөгжилтэй батлав.

Баярын хуралдааны дараа нь нийслэлийн театр, уран сайхны газрын жүжигчдээс нөхөр И. В. Сталины 70 насны ойд зориулсан концерт тавив.

## С л о в а

**баярын торжественный**  
**хайрт** любимый, дорогой  
**суут** гениальный; гений  
**ангиуд** эд. части  
**өнгөрүүлэх** проводить  
**эрхлэх** заниматься, ведать  
**ерөнхий сайд** премьер-министр  
**элчний яам(ан)** посольство, миссия  
**төлөөлөгчийн газар** представитель-  
ство  
**хариуцлагатай** ответственный  
**ажилтан** работник  
**байлцах** присутствовать  
**халамжтай** преданный, любящий  
**илэрхийлэх** подтвердить, заверить,  
выражать  
**бөмбөрцөг шар**  
**газар** земля  
**өнцөг булан** угол, концы  
**зүг** сторона, направление  
**хандах** направиться, устремиться  
**талархал** эд. поздравление; призна-  
тельность

**урт удаан наслах** долго, долго жить  
(*пожелание*)  
**мандан бадрах** эд. здравствовать  
**зүрхний угаас** эд. от глубины сердца,  
души  
**яруу алдар** слава  
**нижигнэтэл** бурно, громко, шумно  
**удтал** долго  
**цууриатах** нестись, раздаваться  
**төрийн дуулал** государственный гимн  
**эгшиглэх** (*музык.*) исполнять  
**шилдэг** лучший  
**их сургууль** университет  
**баярын илэрхийлэлт** приветственное  
письмо  
**нэг дуугаар** единодушно, единогласно  
**хөгжилтэй(гөөр)** с подъемом, с воо-  
душевлением  
**батлах** эд. принять, утвердить  
**уран сайхан** искусство  
**жүжигчид** артисты  
**хэлэхдээ...** в своей речи сказал...  
**дуулах** эд. узнать, услышать

## ГРАММАТИКА

1. Будущее причастие в форме дательного-местного падежа чаще всего обозначает действие, в момент совершения которого имеет место другое действие или состояние, например:

*Энд хурал болж байхад* та юу хийж байв?

Что вы делали, когда здесь происходило собрание?

*Намар бороо ороход* гадаа их чийгтэй болдог

*Өглөөний есөн цагт хичээл эхлэхэд* сурагчид бүгдээрээ хичээлийнхээ тасалгаанд байдаг.

*Багшийн ороход (орж ирэхэд)* нь бид бүгдээрээ босдог.

*Когда осенью идет дождь,* на улице становится сыро.

*Когда в девять часов утра начинаются занятия,* учащиеся в полном составе сидят в своей аудитории.

*При входе учителя* мы все встаем.

Как видно из примеров, будущее причастие в форме дательного-местного падежа с зависящими от него словами (дательный-местный причастный оборот) переводится на русский язык придаточно-подчиненным предложением (когда...) или отглагольным-именным оборотом обстоятельства времени (при...).

2. а) Повелительная форма второго лица множественного числа (захирах төлөв, хоёрдугаар биеийн олон тоо) выражает обращение ко многим или, вежливо, к одному лицу, например:

Гэрт *орогтун!*

Үүнийг *бичигтун!*

Эндээ *байгтун!*

*Заходите* в юрту!

*Напишите* это!

Здесь и *оставайтесь!*

б) Окончанием повелительной формы второго лица множественного числа является **-гтун** или **-гтүн** (по гармонии гласных), например:

**суу + гтун = суугтун!** сидите!

**ажилла + гтун = ажиллагтун!** работайте!

**хий + гтүн = хийгтүн!** сделайте!

в) Если основа оканчивается на согласный, то вставляется соединительная гласная, например:

**гар + а + гтун = гарагтун!** выходите!

**ор + о + гтун = орогтун!** входите!

**ир + э + гтүн = ирэгтүн!** придите!

**төл + ө + гтүн = төлөгтүн!** платите!

**бич + и + гтүн = бичигтүн!** пишите!

**унш + и + гтун = уншигтун!** прочтите!

г) Если основа глагола оканчивается на мягкий согласный (с обозначением ь), то мягкий знак заменяется гласной **и**, например:

**харь + гтун = харигтун!** идите домой!

**соль + гтун = солигтун!** меняйте!

3. Наименование членов какого-либо коллектива обозначается при помощи суффикса **-хан** (**-хэн**, **-хон**, **-хөн**), наращиваемого

к форме родительного падежа соответствующего имени, например:

хуралдаан + ы + хан = хуралдааныхан	участники собрания
сургуул + ийн + хан = сургуулийнхан	коллектив школы (учителя, ученики)
завод + ын + хан = заводынхан	коллектив, личный состав завода (рабочие и служащие)
Дамдин + ы + хан = дамдиныхан	дамдиновцы, Дамдиновы (члены семьи Дамдина)
Иван + ы + хан = иваныхан	ивановцы, Ивановы

## У П Р А Ж Н Е Н И Я

### 1. Переведите на монгольский язык:

1) В Советском Союзе построен социализм и ныне успешно решаются задачи строительства коммунизма. 2) Когда за столом президиума появляются руководители партии и правительства, собравшиеся встают и бурно аплодируют. 3) Когда товарищ Дамдин пришел на собрание, то в зале было много студентов. 4) Когда в солнечное утро мы пришли в парк, там играли дети. 5) Когда начался дождь, мы были в кино. 6) При входе преподавателя учащиеся встают и приветствуют его. 7) Когда он пришел, мы повторяли урок. 8) Когда коллектив нашего института проходил через Красную площадь, играла музыка. 9) Напишите это предложение. 10) Пойдите в большой зал! 11) Прочитайте эту книгу. 12) В конце занятий преподаватель сказал, чтобы завтра мы принесли словари.

### 2. Ответьте на следующие вопросы:

1) Баярын концертыг радиогоор нэвтрүүлэхэд та сонсдог уу? 2) Танай дээд сургуулийнханы хурлууд хаа болдог вэ? 3) Намайг өцөгдөр танайд ирэхэд та хаа байв? 4) Хүйтэн болоход хүмүүс ямар хувцсаа өмсдөг билээ? 5) Та зуны амралтанд байхдаа ямар номуудыг уншив? 6) «Энэ даалгаврыг биелүүлэгтүн!» гэж хэн хэлэв? 7) «Энэ тасалгаанд орогтун!» гэж хэн хэлсэн билээ? 8) «Энэ ажлыг зохион байгуулагтун!» гэж хэн даалгаврыг өгөв? 9) «Энэ номыг уншигтун» гэж хэн хэлэв?

### 3. Переведите устно на монгольский язык:

1) Когда начался дождь, мы были в кино. 2) При входе преподавателя учащиеся встают и приветствуют его. 3) Когда он пришел, мы повторяли урок.

**1. Переведите на монгольский язык:**

1) В следующий выходной день я собираюсь пойти в театр. 2) Товарищ Ламдин сказал, что завтра будет заседание нашей комиссии. 3) Сейчас мы пойдем в читальный зал, чтобы прочитать сегодняшнюю газету. 4) Мой младший брат собирается приехать в Москву. 5) Товарищ Доржи сказал, что звонок прозвенел. 6) Мы приехали, чтобы слушать ваш доклад.

**2. Ответьте на следующие вопросы:**

1) Энэ долоон хоногт манай оюутан нарын хурал болох гэж хэн хэлэв? 2) Эдгээр нөхөд илтгэл сонсох гэж манай дээд сургуульд ирэв гэж та хэнээс мэдэв? 3) Өнөөдөр хичээлээс хойш танай ангийн оюутан нар юу хийх гэж байна? 4) Та бол юу хийх гэж хотын төвд очдог вэ? 5) «Давтлага бол сурлагын эх мөн» гэж хэн хэлэв? 6) «Сур, сур, бас сур!» гэж хэн хэлсэн билээ?

## 18 АРВАН НАЙМДУГААР ХИЧЭЭЛ

---

### ДЭЛХИЙН ХӨДӨЛМӨРЧИН ОЛНЫ МЭРГЭН БАГШ АГУУ ИХ ЖОЛООДОГЧ ИОСИФ ВИССАРИОНОВИЧ ТАНАА

*Хайрт Иосиф Виссарионовичаа!*

Таны 70 насны алдарт ойн баярын өдөр Улаанбаатар Хотын Намын Хороо, Хотын Бага Хурал, нийслэл хотын олон найтийн байгууллага, Монгол ардын хувьсгалт цэргийн ангиуд болон хөдөлмөрчин ард олны төлөөлөгчидтэй хамтран хуралдсан баярын хуралд цугларсан бид нар Монголын бүх ард түмний хүсэл эрмэлзлэлийг илэрхийлж, агуу их Лениний үйл хэргийг суут үргэлжлүүлэгч дэлхийн хөдөлмөрчин олны мэргэн жолоодогч багш, Монголын ард түмний шилдэг хань танд хамгийн эрхэм сайныг хүсэж, гүн их талархлаа илчилсэн чин сэтгэлийнхээ халуун баярыг хүрэгье.

Хайрт Иосиф Виссарионович таны нэрийг дэлхийн бүх улс үндэстний хэл дээр газар болгонд хамгийн их баяр, бахдал, итгэл найдвартайгаар нэрлэж байна.

Их Зөвлөлт Холбоот улсын бүх ард түмэн, орон бүхний бүх хөдөлмөрчид бол мэргэн багш, хайрт жолоодогч танд хязгааргүй үнэнч шударга ба их хайртай бөгөөд бүхнийг ялагч марксизм-ленинизмийн үзэл санаа ба Ленин-Сталины үлэмжийн их хэргийн бүрэн ялалтын төлөө тэмцлийн их хэрэгт бүх хүчээ зориулах зориг шийдвэр төгөлдөр байгаагаа илчилсэн бүх ард түмний жинхэнэ баярлалын үед таны 70 насны ойн баяр өнгөрч байна.

Та, агуу их Лениний хамт шинэ маягийн нам болсон алдарт большевик намыг байгуулж, түүнийг хамгийн тэргүүний хувьсгалт онолоор зэвсэглэн, байлдаанд хатуужуулсан байна.

Та, агуу их Лениний хамт Оросын баатар ард түмнийг жолоодон, хүн төрөлхтний түүхэнд шинэ үеийг нээсэн Октябрийн ялалтад хүрэгсэн юм. Та, агуу их Лениний хамт ажилчин, тариачны зөвлөлт социалист төрийг дэлхий дээр анх удаа байгуулжээ.

Та, их Лениний нас нөгцсөний дараа түүний ялагдашгүй тугийг өндөр мандуулж, бахтайгаар барьж явна. Та, нам ба ард түмнийг эсэргүүцсэн олон тооны дайсантай ширүүн тулалдааныг хийж, Лениний сургаалыг хиргүй тунгалгаар хамгаалан, түүнийг баяжуулан хөгжүүлж, большевик нам, Зөвлөлтийн бүх ард түмнийг социализмын ялалтад хөтлөн жолоодов.

Таны мэргэн жолоодлогоор Агуу их Зөвлөлт Холбоот Улс, үйлдвэр, хамтын аж ахуйн хүчирхэг гүрэн, социализмын бат хэрэм бөгөөд дэлхийн хөдөлмөрчдийн зүрхийг бадруулан гэрэлтүүлэгч болжээ.

Зөвлөлтийн ард түмэн, таны суут удирдлагаар германы фашизм, японы империализмыг бут цохин дэлхий дахины түүхт ялалтыг хийж, хүн төрөлхтнийг фашизмын дөнгөөс аварчээ.

Зөвлөлтийн ард түмэн Ленин-Сталины тугийн дор таны мэргэн жолоодлогоор, Сталины үндсэн хуулийн нарны элчийн ивээлд социалист шинэ нийгмийг байгуулаад, коммунизмын бүрэн ялалтын зүг итгэлтэйгээр давшиж байна.

Хайрт Иосиф Виссарионович таны нэр болон танаас энх тайван, ардчилал, давшлын төлөө явуулсан бадрангуй эрхэм сайхан тэмцэл чинь дэлхий дахины бүх шударга хүмүүс, хэдэн зуун сая хөдөлмөрчдийг, шинэ дайн өдөөгчдийг эсэргүүцсэн бөгөөд ардчилал, энх тайван, социализмын төлөө тэмцэлд зоригжуулан нягтруулж байна.

Хайрт Иосиф Виссарионович та, их Лениний хамт манай Монголын ард түмэнд эрх чөлөө, тусгаар тогтнолыг байлдан олоход туслаад, их Оросын ард түмэнтэй ах дүүгийн холбоотойгоор феодализмээс социализм өөд хөгжих манай хөгжлийн гагц зөв замыг бидэнд зааж өгөв.

Зөвлөлтийн ард түмний ах дүүгийн тусламж ба манай хайрт Иосиф Виссарионович таны эцэг ёсны үргэлжийн хайр халамж, дэмжлэгээр Монголын ард түмэн эх орноо хөгжүүлэн цэцэглүүлэх хэрэгт ихээхэн амжилтыг олоод, өөрийн Монгол Ардын Хувьсгалт Намын удирдлагаар Ленин, Сталины их тугийн дор социализмд орох замаар итгэлтэй давжиш байна.

Хайрт Иосиф Виссарионович таны 70 насны ойн өдөр, манай ард түмний бүх хүсэл эрмэлзлэл, манай их нөхөр, багш, жолоодогч таны зүг улам бур чиглэн хандаж байна.

Таны алдарт ой бол манай бүх ард түмний хамгийн гэрэлт баяр юм.

Монголын бүх ард түмэн өөрсдийн хамгийн халуун хайр сэтгэл, баяр талархлаа, манай эх орны 640 мянга гаруй хөдөлмөрчид

гарын үсэг зурж танд явуулсан баярын бичигтээ улам хурцаар тодруулан илэрхийлсэн билээ.

Өөрсдийн энэхүү халуун хайр, баяр талархал үнэнч сэтгэлээ Монголын ард түмэн, танд өдөр бүхэн, бүх зүрх сэтгэл, бүх хөдөлмөрөөрөө, Ленин-Сталины их үзэл санаанд шантаршгүй үнэнч байгаагаа өөрсдийн итгэлээр илэрхийлж байдаг юм.

Хайрт мэргэн Иосиф Виссарионович маань, бүх давшилтат хүн төрөлхтний баяр жаргалын төлөө, манай ард түмний баяр жаргалын төлөө урт удаан наслахыг ерөөе.

Баярын хурлын тэргүүлэгчид. 1949 оны 12 дугаар сарын 21.

«Үнэн», № 296, 22. XII. 1949.

### Слова

**алдарт** славный  
**цэргийн** воинский; армии  
**хүсэл эрмэлзлэл** желание, стремление, чаяние  
**эрхэм** лучший, наилучший. хороший  
**илчлэх** выражать, подтверждать  
**чин сэтгэлийн** чистосердечный  
**халуун эд.** горячий  
**бахдал** восторг, радость  
**итгэл найдвар** вера, надежда  
**нэрлэх** называть  
**хязгааргүй** беспредельно, безгранично  
**бүхнийг ялагч** всепобеждающий  
**үзэл санаа(н)** идея  
**үлэмжийн их эд.** величайший, исплинский  
**зориг шийдвэр** воля, решимость  
**төгөлдөр** полно; полный  
**жинхэнэ** настоящий, подлинный, действительный  
**маяг** форма  
**байлдаан** бой, сражение  
**хатуужуулах** закалять  
**оросын** русский  
**баатар** героический; герой; богатырь  
**жолоодох** вести  
**төр** государство, строй  
**байгуулах** построить, организовать  
**бахтайгаар** замечательно; достойно  
**барьж явах** нести  
**эсэргүүцэх** сопротивляться, итти против  
**дайсан** враг  
**ширүүн** жестокий, суровый  
**тулалдаан** сражение, борьба  
**хиргүй тунгалаг** чистый, незапятнанный  
**хөтлөх** вести  
**хүчирхэг** мощный  
**хэрэм** крепость

**зүрхийг бадруулах** вдохновлять, воодушевлять  
**суут** гениальный  
**дөнгө** ярмо  
**аврах** спасти  
**үндсэн хууль** конституция  
**элчийн ивээл** живительные лучи  
**нийгэм(лэг)** общество  
**давших** продвигаться вперед; наступать  
**энх тайван** мир; мирный  
**бадрангуй** вдохновенный, пламенный  
**өдөөгчид** поджигатели  
**байлдан олох** завоевать  
**туслах** помогать  
**холбоо(н)** связь  
**гагц** единственный  
**эцэг ёсны** отеческий  
**дэмжлэг** поддержка  
**гарын үсэг зурах** подписаться, расписаться  
**бичиг** письмо  
**хурц** острый; ясный  
**шантаршгүй** непоколебимый; непоколебимо  
**давшилтат** прогрессивный  
**зоригжуулах** воодушевлять, вдохновлять  
**нягтруулах** сплачивать  
**анх** первый; впервые  
**нас нөгцөх** умереть  
**зэвсэглэх** вооружить(ся)  
**энэхүү** это  
**газар болгон** повсеместно, всюду  
**болон** и  
**болсон** являющийся  
**мандуулах эд.** поднимать  
**жирийн хүмүүс** простые люди  
**түгээх** раздавать  
**болоод** через

## ГРАММАТИКА

1. Причастия в форме винительного падежа обозначают действие или состояние, являющееся объектом другого действия, например:

Нөхөр маань, замдаа сайн явж <i>ирэхийг</i> ерөөе!	Пожелаем, <i>чтобы</i> наш товарищ <i>съездил</i> хорошо (т. е. пожелаем нашему товарищу счастливого пути)!
Гадаа бороо орж <i>байгааг</i> чи мэднэ үү?	Знаешь ли ты, <i>что</i> на дворе <i>идет</i> дождь?
Өцөгдөр үдэш хурал <i>болсныг</i> чи хэнээс мэдэв?	От кого ты узнал, <i>что</i> вчера вечером <i>состоялось</i> собрание?
Энэ самбарт <i>бичсэнийг</i> хэн уншина?	Кто прочтет то, <i>что написано</i> на этой доске?

2. Причастия в форме винительного падежа с зависящими от них словами (дополнительный причастный оборот) на русский язык, как это видно из представленных примеров, переводятся дополнительными придаточно-подчиненными предложениями. Очень часто дополнительный причастный оборот на русский язык переводится также дополнительным именным оборотом, например:

Багшийн маргааш тосгонд <i>явахыг</i> чи мэдэв үү?	Узнал ли ты <i>о</i> завтрашнем <i>отъезде</i> учителя в деревню?
Намайг тосгоноос <i>ирснийг</i> чи хэнээс дуулав?	От кого ты слышал <i>о</i> моем <i>прибытии</i> из деревни?
Энэ ажил <i>зохион байгуулахыг</i> нөхөр Дамдинд даалгав.	<i>Организацию</i> этой работы поручили товарищу Дамдину.

## УПРАЖНЕНИЯ

### 1. Переведите на монгольский язык:

1) В адрес съезда поступило очень много приветствий от братских партий. 2) Мы полны решимости построить коммунистическое общество. 3) Наши студенты изучают конституцию МНР. 4) Знаете ли Вы, что сегодня вечером состоится общее собрание коллектива нашего института, посвященное окончанию учебного года? 5) Товарищ Дамдин читает то, что написано в этой книге. 6) Я знаю, что сейчас придет тов. Доржи. 7) Кому поручили организацию этой работы? 8) От кого ты слышал об отъезде учителя? 9) От кого ты узнал, что вчера занятия не состоялись? 10) Я знаю, что преподаватель завтра придет. 11) Я прочту то, что написано на доске. 12) Знаете ли Вы, что в этом

зале будет собрание? 13) От кого ты слышал, что в будущий выходной день в нашем институте будет концерт? 14) Пожелаем нашему другу счастливого пути. 15) Когда ты приходил ко мне, я был на занятиях в институте. 16) Я знаю, где работает ваш старший брат. 17) Где вы были, когда начался дождь? 18) Когда он пришел, мы слушали по радио праздничный концерт. 19) Товарищ Иванов сказал, что он купил словарь. 20) Он пошел не в институт, а в библиотеку.

## 2. Ответьте на следующие вопросы:

1) Багшийн бичснийг хэн уншив? 2) Намайг энд ирснийг чи хэнээс сонсов? 3) Одоо энэ танхимд хурал болж байгааг та хэнээс мэдэв? 4) Энэ ажлыг зохион байгуулахыг танд хэн даалгав? 5) Чиний онц сайн тэмдэг авсныг эх эцэг чинь мэдэв үү? 6) Ирэх бүтэн сайн өдөр үдэшлэг болохыг бүх сурагчид мэднэ үү? 7) Миний аавын хаа ажилладгийг чи мэдэж байна уу? 8) Одоо үед Монгол улсад их хүйтэн байгааг чи хэнээс дуулав? 9) Маргааш ямар хичээл болохыг та нар мэднэ үү? 10) Ханын сонин гаргасныг та уншив уу? 11) Өцөгдөр хэн хуралдааныг нээв?

## 3. Приготовьте рассказ на тему «Под знаменем Ленина, под водительством Сталина советский народ уверенно идет вперед, к коммунизму».

### Повторительные упражнения

#### 1. Переведите на монгольский язык:

1) Если мы закончим повторение этого урока до пяти часов, то пойдем в кино. 2) Если сейчас придет мой младший брат, то мы втроем пойдем в парк. 3) Если регулярно будете повторять уроки, то сможете учиться хорошо. 4) Историческая победа великого китайского народа еще более усилила лагерь мира и демократии, возглавляемый Советским Союзом. 5) Студент раздал нам по десять тетрадей. 6) Одна треть наших студентов учатся на «отлично». 7) Через два с половиной часа я поеду домой.

#### 2. Ответьте на следующие вопросы:

1) Есийг таваар үржүүлбэл хэд болох вэ? 2) Жаран хоёроос хорин наймыг хасвал хэд үлдэнэ? 3) Арван ес дээр гучин наймыг нэмбэл хэд болно? 4) Бүгд Найрамдах Хятад Ард Улс хэзээ байгуулагдсан билээ? 5) Явал онц сайн сурч болно? 6) Хэдүүл давлага хийвэл сайн байна? 7) Хүйтэн болбол ямар хувцас өмсөх хэрэгтэй вэ? 8) Дулаан байвал ямар хувцас өмсвөл зохино?

## ТЭРГҮҮНИЙ МАЛЧДЫН ЖИШЭЭГЭЭР МАЛАА ӨСГӨЕ!

Манай малчин ард түмэн, энэ жил мал сүргээ өсгөх талаар ноднингоос үлэмжхэн их амжилтыг олов. Манай орон даяар явуулсан мал тооллогын дүн нь үүнийг баталж байна. Эдгээр амжилтыг олох явдалд манай улсын 9 дүгээр их хурлаас «Ардын аж ахуйтанд малаа өсгөх төлөвлөгөөг тогтоох тухай ба ардын аж ахуйтнаас улсын төлөвлөгөөг давуулан өсгөсөн бүх малыг албан татвараас болон ноос, мах зэргийн бусад үйлдэхүүнийг албан журмаар нийлүүлэх оногдлоос чөлөөлөх тухай» гаргасан түүхт хууль нь шийдвэрлэх ролийг гүйцэтгэсэн юм.

Маршал Чойбалсан бол, мал, хөдөө аж ахуйн тэргүүний сайчуулын 3 — дугаар зөвлөлгөөн дээр үг хэлэхдээ: «Ардын аж ахуй бүрд төлөвлөгөөг тогтоон өх явдал бол малын тоог өсгөхийн төлөөнөө санаагаа зовдоггүй юм уу, эсхүл аж ахуй нь өсөхгүй нэг хэвийн байдалд зогсож байгаа тийм аж ахуйтнуудыг, юмыг бодож дээш нь ахиж дөхөхийг шаардан түлхэх болно.

Төлөвлөгөө бол малын тоог цааш олшруулах талаар эдгээр аж ахуйнуудад зарим талаар түлхцийг өх ба ойрын хугацаанд мал аж ахуйн хэдэн мянган тэргүүнчүүдийг шинээр нэмэгдүүлэн гаргах болно» гэж хэлсэн билээ. Манай ард түмний жолоодогч, хайрт багшийн хэлсэн энэ үг нь ажил дээр амжилттай биелэгдэж байгаа явдлыг малчин ард бүхэн одоо нүдээрээ үзэж байна. Жил тутам мал сүргийг өсгөх улсын төлөвлөгөөг ардын аж ахуйтан бүхэнд хүргэж байх явдал бол нам засгаас манай орны эдийн засгийн үндсэн салаа болсон мал аж ахуйг цаашид хөгжүүлэн, манай ард түмний аж амьдралын байдлыг бүх аргаар сайжруулахад зориулсан ихээхэн арга хэмжээний нэг мөн юм.

Манай ард түмнээс мал аж ахуйг хөгжүүлэх талаар таван жилийн төлөвлөгөөний зорилгуудыг амжилттай бөгөөд давуулан биелүүлэхийн төлөө тэмцэж байгаа тэмцэлд энэ хууль нь дайчлагч, зохион байгуулагч их ролийг гүйцэтгэж байгаа нь малчин ардын хөдөлмөрөөр бүрэн нотлогдов. Үүнд, мал сүргээ өсгөх төлөвлөгөөг биелүүлсэн ба давуулан биелүүлсэн аймаг, сум, баг, ардын аж ахуйнууд энэ жил улам олон болов. Өмнөговь, Дундговь аймгууд ноднин жил мал өсгөх төлөвлөгөөгөө давуулан биелүүлээд, улмаар энэ жил малаа өсгөх улсын төлөвлөгөөг амжилттай биелүүлэв. Эдгээр аймгийн малчид, нам, улсын байгууллагууд, олсон амжилтаа улам бэхжүүлж, мал аж ахуйг хөгжүүлэх талаар ирэх жил улам сайн дүн үзүүлэхийг чармайж байна.

Сүхбаатар аймаг мал өсгөх талаар ноднин жил бусад аймгаас хоцорч байв. Тус аймаг энэ жил малаа өсгөж, улсын төлөвлөгөөг

биелүүлэх талаар тэргүүний аймгийн тоонд орсон явдлыг онцлон тэмдэглэвэл зохино. Энэ жил Сүхбаатар аймгийн сум бүхэн нь малаа өсгөх төлөвлөгөөг давуулан биелүүлсний ачаар тус аймаг нь мал өсгөх улсын төлөвлөгөөг 8,4 хувиар давуулан биелүүлээд, хээлтэгч малын тоог ноднин жилийнхээс 5,4 хувиар нэмэгдүүлжээ. Сүхбаатар аймгийн малчдаас ийм сайхан ололт гаргасан явдал нь тус аймгийн нам, улсын байгууллагуудаас мал аж ахуйн талаар ноднин жил гаргасан дутагдлаа анхаарч, түүнийг дахин гаргахгүй болоод, ард олноо хөдөлмөрт сайн зохион байгуулж, мал сургийг өсгөх улсын төлөвлөгөөг биелүүлээд улмаар давуулан биелүүлэх явдалд зоригжуулж чадсаны үр мөн. Үүнд, мал өсгөх талаар бүх арга хэмжээг цаг тухайд нь чанартай сайн биелүүлэхийн төлөө уралдааныг малчин ардын дунд өргөн дэлгэрүүлжээ. Энэ уралдааны манлайд нь нам, эвлэлийн гишүүн малчид явж ажиллажээ. Тэд, ардын аж ахуй бүрд байгаа бололцоог чадвартай ашиглаж мал өсгөх улсын төлөвлөгөөг давуулан биелүүлэхийн тул хэрхэн ажиллавал зохихыг өөрийн үлгэр жишээгээр малчин ардуудад үзүүлж байжээ.

Манай улсын мал аж ахуйн тэргүүний сайчуулын 3 дугаар зөвлөлгөөн дээр нөхөр Чойбалсангаас хэлэхдээ: «Ардын аж ахуй бүрд төлөвлөгөө өгснөөр манай ажил төгсөх биш, харин түүгээр эхлэх юм. Төлөвлөгөөний биелэлтийг хангахын тул аж ахуй бүр чармайлттай ажиллах хэрэгтэй юм» гэсэн билээ.

Гэтэл зарим аймаг, сум, багийн удирдагчид, үүнийг мартсан нь харамсалтай байна. Тэд, мал өсгөх улсын төлөвлөгөөг ардын аж ахуй бүхэнд хүрэгснээрээ хязгаарлаад, аж ахуй бүрээс энэ төлөвлөгөөг амжилттай биелүүлэх талаар зохих анхаарал санаачлагыг гаргаагүй байна. Орон нутгуудын зарим удирдагчдаас ийнхүү муу ажилласны улмаас, мал өсгөх төлөвлөгөөг биелүүлсэнгүй. Гэтэл эдгээр аймагт мал сүргээ өсгөх үүргийг нилээд сайнаар давуулан биелүүлсэн ардын аж ахуй, бүхэл сумд олон гарчээ. Тухайлбал, Завхан аймагт мал өсгөх төлөвлөгөө нь бүхэлдээ биелэгдээгүй байхад тус аймгийн Баянуул, Жавхлант, Цагаанхайрхан зэрэг сум нь мал өсгөх төлөвлөгөөгөө давуулан биелүүлжээ. Мал өсгөх төлөвлөгөөгөө биелүүлээгүй бусад аймагт ч иймэрхүү байдал үзэгдэж байна. Үүнээс үзвэл эдгээр аймагт мал өсгөх төлөвлөгөөг амжилттай биелүүлэх бололцоо байсан нь илэрхий юм. Иймд эдгээр аймгийн эрх баригчид болон тэдний хоцрогдож яваа сум, багийн удирдагчид, мал аж ахуйг хөгжүүлэх талаар муу ажиллаж, ерөнхий яриагаар ажлаа бараад, мал аж ахуйг хөгжүүлэх талаар тодорхой удирдлага өхгүй нь ил байна.

Тэргүүний малчин, баг, сум, аймгийн жишээгээр малаа өсгөх нь одоо хоцорч байгаа аймаг, сум, баг, малчдын чухал үүрэг мөн. Үүнд, мал сүргээ өсгөж, таван жилийн төлөвлөгөөг биелүүлэхээр барахгүй, урьд дутагдалтай ажилласан зүйлээ нөхөн гүйцэтгэхийн ба мал аж ахуйгаа цаашид улам хөгжүүлэх бүх нөхцөлийг бүрэлдүүлэх нь чухал боллоо.

По материалам «Үнэн».

**малчид** скотоводы  
**жишээ** пример  
**мал** скот  
**өсгөх** выращивать  
**сүрэг** стадо  
**үдэмжхэн** значительно  
**даяар** весь, вся  
**тооллого** перепись  
**тоглох** зд. разработать; установить  
**ардын аж ахуй** аратское хозяйство  
**давуулан өсгөх** перевыполнить  
**албан татвар** налог  
**ноос (он)** шерсть  
**мах** мясо  
**үйлдэхүүн** продукция  
**албан журмаар** по закону, в обяза-  
 тельном порядке  
**нийлүүлэх** поставлять  
**оногдол** обложение  
**хууль** закон  
**шийдвэрлэх** решающий; решать  
**хөдөө аж ахуй** сельское хозяйство  
**сайчуул** передовики  
**зөвлөлгөөн** совещание  
**санаа (гаа)** зовох беспокоиться  
**эсхүл** или; если нет  
**нэг хэв** без изменения  
**тийм** такой  
**дээш ахих** повышаться  
**дөхөх** приближаться  
**шаардах** требовать  
**түлхэх** толкать  
**олшруулах** количественно увеличить  
**зарим** некоторый

**түлхэц** толчок; стимул  
**хугацаа(н)** срок  
**нүд(эн)** глаз(а)  
**үндсэн** основной  
**салаа(н)** отрасль  
**бүх аргаар** всемерно  
**арга хэмжээ** меры  
**дайчлагч** мобилизующий  
**ногтох** доказать  
**улмаар** зд. затем  
**бэхжүүлэх** закрепить  
**чармайх** стараться  
**онцлон** особо  
**ачаар** благодаря  
**харамсалтай** достойно сожаления, к  
 сожалению  
**хязгаарлах** ограничить(ся)  
**зохих** соответствующий  
**санаачлага** инициатива  
**бүхэл** целый  
**иймэрхүү** такой, подобный  
**илэрхий** ясно; ясный  
**эрх баригчид** руководители  
**ерөнхий** общий  
**барах** кончать, исчерпать  
**барахгүй** с орудным падежом не  
 только  
**дутагдал** недостатки  
**нөхөх** наверстывать  
**бүрэлдүүлэх** обеспечить; восполнить  
**нөхцөл** условия  
**чухал** важно; важный  
**талаар** по линии, в области  
**үзэн** ядах ненавидеть

## ГРАММАТИКА

1. Причастия в форме родительного падежа чаще всего употребляются с послелогоми и переводятся на русский язык в соответствии с тем, какого падежа или какого оборота требуют соответствующие русские предлоги (эквиваленты монгольских послелогов), например:

<b>ачаар</b>	в результате того, что...
<b>дараа</b>	после того, как...
<b>төлөө</b>	для того, чтобы...
<b>тул</b>	для того, чтобы...

Ажлаа амжилттайгаар явуул-  
 сны ачаар үлэмжхэн тооны  
 мал өсгөв.

В результате того, что с успе-  
 хом провели свою работу (в  
 результате успешного прове-  
 дения своей работы), выра-  
 стили значительное количест-  
 во скота.

Малаа сайн *өсгөхийн төлөө* ид-  
эвхтэйгээр ажиллах хэрэгтэй.

Хичээл *төгссөний дараа* бид  
уншлагын газарт очив.

Зөвлөлт Холбоот Улсаас ах дү-  
үгийн тусламж *хүргэсний*  
*ачаар* манай Монгол улс хө-  
рөнгөтний бус замаар амжилт-  
тайгаар хөгжин давшиж  
байна.

2. Подлежащее очень часто сопровождается особыми показателями, которые на русский язык не переводятся, таковы: **бол** (или иногда **болбол**) и **нь**, например:

*Малчид бол* малаа амжилттай-  
гаар өсгөж байна.

Манай сургуулийн *байшин нь*  
хотын төвд байна.

Для того, чтобы хорошо *вы-*  
*рашивать* скот, необходи-  
мо энергично работать (для  
успешного выращивания сво-  
его скота...).

Мы пошли в читальню *после*  
*того*, как кончилось занятие  
(т. е. после окончания заня-  
тия...).

Наша Монголия успешно разви-  
вается по некапиталистиче-  
скому пути *благодаря тому*  
*что* Советский Союз *оказыва-*  
*ет* братскую помощь (т. е.  
благодаря братской помощи  
Советского Союза).

3. Если подлежащее обозначает людей, социальные группы, организации и их органы, то оно очень часто дается в исходном падеже, например:

*Малчдаас* ийм их ололт гарга-  
сан явдал нь...

То, что *скотоводы* добились та-  
ких больших достижений...

4. Отглагольное имя **явдал** — дело — в сочетании с причастиями на русский язык часто переводится отглагольными именами существительными или оборотом «то (того, тому, тем и т. д.), что...», например:

Хашаа *барих явдал*.

Ажил *зохион байгуулах явдал*.  
Ханын сониныг гаргасан *явдалд*.

Малчдаас хүрэлцээтэйгээр өвс  
*бэлтгэсэн явдалд* бид баясав.

*Строительство* хашанов (сара-  
ев).

*Организация* работы.

*В выпуске* стенной газеты (в  
деле выпуска стенной газе-  
ты).

Мы радовались *тому, что* ара-  
ты в достаточном количестве  
*заготовили* сено.

## У П Р А Ж Н Е Н И Я

### 1. Переведите на монгольский язык:

1) Сталинская забота о дальнейшем подъеме сельского хозяйства вдохновляет колхозное крестьянство на борьбу за новые победы социалистического сельского хозяйства, за дальнейшее укрепление могущества социалистической Родины. 2) В этом постановлении подведены итоги развития животноводства в истекшем году и намечены задачи борьбы за дальнейший подъем этой важнейшей отрасли сельского хозяйства. 3) Всемирное развитие этой отрасли сельского хозяйства является теперь центральной задачей в области сельского хозяйства. 4) Благодаря тому, что партия и правительство уделяют большое внимание развитию животноводства, наши колхозы и совхозы (зөвлөлт сангийн аж ахуй) добились больших успехов в этой области.

### 2. Ответьте на следующие вопросы:

1) Манай улсын мал аж ахуйн ба хөдөө аж ахуйн сайчуул бол ямар жишээ үзүүлж байна? 2) Мал аж ахуйг улам түргэнээр хөгжүүлэхийн тул ямар арга хэмжээнүүдийг авах хэрэгтэй вэ? 3) Мал аж ахуйгаас гардаг мах, ноос зэргийн зүйлүүдийг улам нэмэгдүүлэхийн төлөө юу хийх хэрэгтэй вэ? 4) Юуны тул мал тооллого явуулдаг юм бэ? 5) Юуны төлөө мал өсгөх төлөвлөгөөг тогтоодог вэ? 6) Мал аж ахуйг хөгжүүлэх төлөвлөгөөг тогтоосны дараа ямар ажил явуулах хэрэгтэй байна? 7) Малынхаа тоог олшруулсны ачаар ард түмний маань аж амьдралын хэмжээ ямар болов? 8) Тэргүүний малчдын жишээгээр манай орны малчид бол юу хийж байна? 9) Мал аж ахуйг хөгжүүлэх явдалд нам засгаас ямар анхаарал тавьж байна? 10) Манай малчид бол мал сүргээ өсгөх талаар ямар амжилтыг олов?

### Повторительные упражнения

#### 1. Переведите на монгольский язык:

1) Я не опоздал на занятие, несмотря на то, что сегодня выехал из дома поздно. 2) Товарищ Дамдин учится хорошо, несмотря на то, что выполняет большую общественную работу. 3) Сегодня на дворе тепло, хотя и выпал снег. 4) Товарищ Доржи приезжает в институт очень рано, хотя живет отсюда довольно далеко. 5) Студенты Дамдин и Доржи уходят домой поздно, хотя занятия кончаются довольно рано.

#### 2. Ответьте на следующие вопросы:

1) Өнөөдөр цас оровч, гадаа ямар байна? 2) Онцчууд бол олон нийтийн ажилд идэвхтэйгээр оролцдог онц сайн сурдаг боловч, гэж үнэн үү? 3) Таны бүлгийн оюутан нараас хэн бол зохион байгуулах ажлыг чадвартайгаар хийдэг вэ? 4) Монгол Ардын Хувьсгалт Нам бол хэзээ үндэслэн байгуулагдав? 5) Маны ард түмэн бол ямар хүмүүсийг үзэн яддаг байна?

## МАЛЫН САЙН ХАШАА ОЛНЫГ БАРЬЯ

Энэ жил олон мянган ардын аж ахуй, мал сүргээ өсгөх явдалд шинэ сайхан амжилтыг гаргаж, мал өсгөх улсын төлөвлөгөөг давуулан биелүүлжээ. Мал аж ахуйн тэргүүний сайчуул, ноднин жил малаа тарган, дулаан өвөлжүүлэхээр бэлтгэхдээ, малын хашаа хороог шинээр барих, хуучныг сэлбэн засварлах ажилд онц их анхаарлыг тавьсан явдал нь энэ их амжилтад ихээхэн тус дөхөм болсон байна. Тэд, малдаа найдвартай сайн дулаан хашаа байртай байсан учраас мал сүргээ тавтай, сайн өвөлжүүлж, малаа аятай төллүүлж, төл малыг хорогдолгүй бойжуулж чадсан байна. Иймд тэргүүний сайн малчдаас малын хашаа барихад гаргасан их хөдөлмөр нь дэмий хоосон болсонгүй. Харин баясгалант үр дүн үзүүлжээ.

Монгол Ардын Хувьсгалт Намын 11-дүгээр их хурал ба Бүгд Найрамдах Монгол Ард Улсын 9-дүгээр их хурлаас тавьсан зорилгыг үлгэртэй сайн биелүүлэхийн төлөөний тэмцэлд орон нутгийн нам, улсын байгууллагуудаас малчин ардын ажиллаганд зохих удирдлагыг өгч тэднийг дайчлав. Үүнд, мал аж ахуйг цааш нь хөгжүүлэхэд малын хашаа хороо барих явдал хичнээн их ач холбогдолтойг ард түмэнд өргөн таниулж, хашаа хороо барих энэ жилийн төлөвлөгөөг биелүүлэх ба давуулан биелүүлэхийн төлөө хувьсгалт уралдааныг тэдний дунд өрнүүлэх хэрэгтэй болов.

Энэ зорилгыг амжилттай биелүүлснээрээ, манай бүх ард түмний аж амьдралыг дээшлүүлэхийн гол эх булаг болсон мал аж ахуйг хөгжүүлэх явдалд ирэх жил шинэ амжилт гаргахын нэг чухал нөхцөлийг бий болгохыг мартаж болохгүй.

Шинэ хашаа барих улсын төлөвлөгөөг бүрэн биелүүлээд, улмаар төлөвлөгөөнөөс давуулан хашаа барих ажлыг зориг бадрангүй хийхийнхээ хамт хуучин хашаа хороог сэлбэн дулаалж байгаа ардын аж ахуйнууд ба бүхэл бүтэн баг сум ч олон байна. Нам, засгаас хөдөлмөрчин ардын аж амьдрал, соёлын хэмжээг дээшлүүлэхийн төлөө цуцалтгүй санаа тавьдаг явдал нь малчдын зорилгыг бадруулж, хайрт эх орноо цэцэглүүлэх хөдөлмөрт тэдний хүч чадлыг улам нэмэгдүүлж байна.

Хэнтий, Баян-өлгий аймагууд малын хашаа барих жилийн төлөвлөгөөг бүрэн биелүүлэхэд ойртож байна. Хэнтий аймагт боловсон хашаа барих үүргийг 80 хувь, суурьшилтай хашаа барих үүргийг 95 хувиар гүйцэтгэжээ. Эдгээр аймгийн удирдах байгууллагууд, малын хашааг хамтын хүчээр барих аргыг өргөн дэлгэрүүлж, ардуудаас малаа дулаан өвөлжүүлэх ажлыг хангах явдалд нь туслалцаа үзүүлж байна. Энэ аймгуудад чанар сайтай олон

хашаа барих талаар ард олны тэмцлийн манлайд намын жинхэнэ, орлогч гишүүн малчид явж байна. Тэд малаа тавтай сайхан өвөлжүүлэх ажлыг зохиох явдал дээр гишүүн бус малчдад үлгэр жишээ үзүүлэн байна. Гэвч, малын хашаа барих ажлыг газар бүхэнд жигд сайн зохиохгүй байна. Зарим сум, багууд хашаа барих төлөвлөгөөг тун хангалтгүй биелүүлж байна. Үүний гол шалтгаан нь эдгээр сум, багуудын байгууллагуудаас, малчин ардуудаас хашаа барих ажлыг шуурхай удирддаггүйд оршиж байна. Энэ сум, багуудад улс ардын аж ахуйн энэ чухал кампанийн биелэлтийг урсгалаар нь тавьжээ.

Удахгүй өвөл болно. Малчид өвлийн бэлтгэлийг бүрэн сайн хийж, мал сүргээ тавтай сайхан өвөлжүүлэх ажлыг хангаж, таван жилийн гуравдугаар жилд мал төллөлтийн ба төл малыг бүрэн өсгөж бойжуулах кампанийг амжилттай гүйцэтгэх бүх чухал нөхцөлийг хангах ёстой болов.

Иймд малын хашаа барих явдалд оршиж байгаа дутагдлуудыг түргэн арилгаж, өвлийн хүйтэн болохын наана баг, сум, аймаг, ардын аж ахуй бүр малын хашаа хороо барих төлөвлөгөөг тоо, чанарын талаар бүрэн сайн биелүүлбэл зохино.

Шинэ хашаа барих ажлыг хүчтэй болгохын хамт хуучин хашааны засварын явцыг бас хурдатгах хэрэгтэй. Орон нутгийн нам улсын байгууллагууд өвөл хаврын улиралд малыг онд оруулахад чухал болох сайн чанарын хашаа хороог байгуулах ёстой. Энэ ажилд бүх бололцоог бүрэн ашиглах явдалд ард олныг дайчилж, шинэ хашаа хороо барих, хуучныг сэлбэн засах хэрэгт хамтын ажиллагааны аргыг дэлгэрүүлж, малчдын дунд өвлийн бэлтгэлийг үлгэртэй сайн хийхийн төлөө хувьсгалт уралдааныг өргөн дэлгэрүүлбэл зохино.

Малын сайн хашаа хороог олноор барья! Баг, сум, аймаг бүрийн хашаа хороо барих төлөвлөгөөг биелүүлэх ба давуулан биелүүлье!

Өвөл, хаврын цагт малыг үхүүлэхгүй ба малын ашиг шимийг бууруулахгүйгээр онд сайн оруулагтун!

Боловсон хашаа саравчийг барихад орон нутгийн материалыг өргөн ашиглах ба ардын аж ахуйтан бүрийг өөртөө хүрэлцэх хэмжээний дулаан хашаа, саравч, пүнзтэй болгогтун!

Мал аж ахуйн сайчуул бол онц сайнаар ажилласнаараа мал өсгөх төлөвлөгөөг давуулан биелүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэв.

По материалам «Үнэн».

### С л о в а

**хашаа(н)** изгородь; загон, двор; хашан  
**гарган** жирный, откормленный, упитанный  
**өвөлжүүлэх** организовать зимовку  
**хороо** зд. изгородь, ограда  
**барих** строить

**хуучин** старый  
**сэлбэн засварлах** ремонтировать; восстановить  
**тавих** зд. уделять, обращать [внимание]  
**тус дөхөм** зд. помощь, содействие

**найдартай** надежный  
**учраас** из-за, по причине  
**тавтай** хорошо, удобно, как следует  
**аятай** благополучно, хорошо  
**төл** молодой, приплод  
**төллүүлэх** принимать приплод, принимать молодой  
**хорогдолгүй** без потерь  
**бойжуулах** выращивать, растить  
**иймд** поэтому  
**дэмий хоосон** зря, даром; попусту  
**үр дүн(г)** результат; плоды  
**их хурал** Великий хурал; съезд  
**орон нутгийн** местный  
**ажиллагаа(н)** работа, деятельность  
**дайчлах** мобилизовать  
**хэчнээн** сколько, насколько  
**ач холбогдол** значение  
**өргөн** широко, широкий  
**таниулах** ознакомить, разъяснить  
**уралдаан** соревнование  
**эх булаг** источник, родник  
**дулаалах** утеплять  
**бүтэн** целый  
**соёлын хэмжээ** культурный уровень  
**цуцалтгүй** неустанно  
**хүч чадал** сила, энергия  
**ойртох** приближаться  
**хувь** часть, процент  
**суурьшилтай** осёдлый, недвижимый  
**арга** способ, метод

**дэлгэрүүлэх** распространить  
**хангах** обеспечить  
**манлай** авангард, глава  
**жинхэнэ гишүүн** член  
**орлогч гишүүн** кандидат  
**дагуулах** вести за собой  
**жигд эд.** ровно, одинаково  
**тун** очень  
**хангалтгүй** неудовлетворительно  
**шалтгаан** причина  
**шуурхай** гибко; деятельно  
**улс ардын аж ахуй** народное хозяйство  
**урсгалаар эд.** самотеком  
**түргэн** быстро  
**арилгах** устранить  
**наана эд.** до  
**явц** ход, темп  
**хурдатгах** ускорить  
**улирал** сезон; квартал  
**хавар** весна  
**онд оруулах** сохранить в зимне-весенний период (*о скоте*)  
**үхүүлэхгүй** не допускать падежа, гибели  
**ашиг шим** продуктивность; польза  
**бууруулахгүй** не допускать снижения  
**саравч** навес; сарай  
**пүнз** хлев, помещение для скота  
**үүнд эд.** при этом

## ГРАММАТИКА

1. Будущее причастие в форме орудного падежа чаще всего обозначает действие, ради которого совершается другое. Таким образом, это причастие в указанном падеже с зависящими от него словами образует целевой причастный оборот, соответствующий русским придаточно-подчиненным предложениям цели или именным оборотам цели, например:

Малчин ардууд бол хашаагаа  
*сэлбэн засварлахаар* бэлтгэл  
хийж байна.

Малаа онд сайн *оруулахаар*  
дулаан хашаа бэлтгэх хэрэг-  
тэй.

Араты-скотоводы проводят под-  
готовку *для того, чтобы*  
*отремонтировать* свои ха-  
шаны.

*Для сохранения* своего скота  
в зимне-весенний период (*для*  
*того, чтобы сохранить* свой  
скот...) необходимо подгото-  
вить теплые хашаны.

2. Прошедшее причастие в форме орудного падежа чаще всего обозначает действие, в результате которого имеет место

другое действие или состояние. Это причастие в форме указанного падежа с зависящими от него словами составляет причинный причастный оборот, переводимый на русский язык словами: *в результате...* или *вследствие...*, например:

Дулаан хашаа *бэлтгэснээр* ма-  
лаа онд сайн оруулав.

*В результате* того, что *подготовили* теплые хашаны, хорошо сохранили свой скот в зимне-весенний период.

Хувьсгалт уралдааныг өргөнөөр  
*дэлгэрүүлснээр* төлөвлөгө-  
өгөө хугацаанаас өмнө би-  
елүүлэв.

*Вследствие* того, что широко *развернули* революционное соревнование (*вследствие широкого развертывания...*), свой план выполнили досрочно.

## У П Р А Ж Н Е Н И Я

### 1. Переведите на монгольский язык:

1) Осуществляя поставленные партией и правительством задачи по развитию животноводства, колхозы и совхозы в этом году добились значительного увеличения численности поголовья и повышения продуктивности скота. 2) За истекший год построено большое количество новых помещений для скота. 3) Выполняя указания партии и правительства, местные органы добились значительных успехов в деле развития животноводства. 4) Важная задача местных органов — обеспечить одновременно (зэрэгцээгээр) с дальнейшим ростом поголовья повышение продуктивности скота. 5) Выполняя постановление партии и правительства, необходимо улучшить руководство социалистическим соревнованием за успешное выполнение и перевыполнение плана увеличения поголовья скота. 6) Во всех колхозах и совхозах ведется большая борьба за сохранение каждой единицы молодняка. 7) Передовики животноводства неустанно борются за дальнейшее развитие животноводства.

### 2. Ответьте на следующие вопросы:

1) Юуны тул малын хашаа, хороо олныг барих хэрэгтэй вэ? 2) Явал төл малыг хорогдолгүй бойжуулж болно? 3) Монгол Ардын Хувьсгалт Намын 11 дүгээр их хурал бол мал аж ахуйг хөгжүүлэх тухай ямар зорилго тавьсан байна? 4) Хашаа хороо барих төлөвлөгөөг биелүүлэх ба давуулан биелүүлэхийн төлөө ямар арга хэмжээ авах хэрэгтэй вэ? 5) Мал аж ахуйг улам хөгжүүлэх явдал бол ямар ач холбогдолтой байна? 6) Намын жинхэнэ ба орлогч гишүүд бол ард түмэнд ямар жишээ үзүүлэх ёстой байна? 7) Мал аж ахуйг хөгжүүлэх явдлыг урсгалаар нь

тавивал юу болно? 8) Шинэ хашаа барихын зэрэгцээгээр ямар ажил явуулах хэрэгтэй байна? 9) Малаа онд сайн оруулахаар бэлтгэхдээ нэн тэргүүн юу хийх ёстой байна? 10) Тус улсын мал аж ахуйн сайчуул бол малаа амжилттай олшруулснаараа ард түмний аж амьдралыг ямар болгоно? 11) Манай Зөвлөлт Холбоот Улс бол ямар төлөвлөгөөнүүдийг биелуулснээрэ аж үйлдвэр ба хөдөө аж ахуйн талаар хамгийн хүчирхэг улс болов?

### Повторительные упражнения

#### 1. Переведите на монгольский язык:

1) Здание нашего института больше и лучше, чем это здание. 2) Эта картина красивее и дороже, чем та картина. 3) Сегодня теплее, чем вчера. 4) Около театра есть большой промтоварный магазин. 5) Около моего товарища сидит его старший брат. 6) Около библиотеки нашего института находится читальный зал. 7) Около шкафа висит карта СССР. 8) У карты стоит студент Самдан. 9) Эта карта лучше, чем та карта.

#### 2. Ответьте на следующие вопросы:

1) Энэ ном тэр номоос сонирхолтой гэж хэн хэлэв? 2) Энэ тасалгаа тэр тасалгаанаас ямар байна? 3) Таны суудаг байшингийн дэргэд ямар театр байна? 4) Хичээл дээр таны дэргэд хэн суудаг вэ? 5) Таны үзэг миний үзгээс ямар байна? 6) Өнөөдөр багшийн дэргэд хэн суув? 7) Манай дээд сургуулийн дэргэд ямар цэцэрлэг байна? 8) Москва хотод Москвагийн их сургуулийн шинэ байшингаас сайхан байшин бий юу?

## 21 ХОРИН НЭГДҮГЭЭР ХИЧЭЭЛ

### ГОВИЙНХОН, МАЛ ӨСГӨХ УЛСЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ САЙШААН ХҮЛЭЭЖ АВАВ

Аймгийн бага хурлын гишүүн нөхөр Дамба үг хэлэхдээ: «Улсын 9 дүгээр Их Хурлын түүхт шийдвэр гаргасан нь манай орны хөдөлмөрчин олон түмний хөдөлмөрийн баясгалант идэвх сонирхолыг хязгааргүй ихээр өрнүүлж, хайрт эх орныхоо төлөө зориг бадрангуй хөдөлмөрлөх үйл бүтээлийн санаачлагыг улам нээж байна.

Маршал Чойбалсангийн таван жилийн төлөвлөгөөний анхны жилд малаа улсын төлөвлөгөөгөөр манай аймаг хоёр бүтэн арваны ес, манай сум хоёр бүтэн арваны зургаа, манай баг 10 хувиар тус тус өсгөсөн билээ.

Би 1947 онд малаа 19 хувь, 1948 онд 21 хувиар тус тус өсгөн нэмэгдүүлэв. Энэ жил би, малаа өсгөх төлөвлөгөөг 52 малаар давуулан биелүүлж чадна.

Мал өсгөх хууль гаргасан нь малчин ард бидний идэвхийг улам зоригжуулж байна. Орон нутгийн байгууллагууд, мал өсгөх тэмцэлд малчин ард биднийг улам нарийн нямбай зохион байгуулж удирдахын хамт, гүйцэтгэлийг шалгах журмыг тодорхой болгон, төлөвлөгөөт үүргийг сайн ойлгуулж эзэмшүүлэх ажлыг сайн зохиох хэрэгтэй болов гэж хэлэв.

Баян-овдо сумын дарга нөхөр Батжаваас шүүмжлэхдээ: «Ардын аж ахуйтанд малаа өсгөх төлөвлөгөөг тогтоох тухай ба ардын аж ахуйтнаас улсын төлөвлөгөөг давуулан өсгөсөн бүх малыг албан татвараас болон ноос, мах зэргийн бусад үйлдэхүүнийг албан журмаар нийлүүлэх оногдлоос чөлөөлөх тухай хууль гаргасан нь манай ард түмний мал аж ахуйг хөгжүүлэх идэвх сонирхолыг дээшлүүлж, тэдний аж амьдралыг сайжруулахад ихээхэн ач холбогдолтой хууль юм. Би 1948 онд байсан 327 мал дээрээ уг хуулийн ёсоор 29 малыг нэмэгдүүлээд улмаар 15 малаар давуулан өсгөнө. Бас 1950 онд төлөвлөгөө ёсоор 31 малыг нэмэгдүүлээд 27 малыг илүү өсгөх бололцоотой байна.

Энэ чуулган дээр шүүмжилсэн бусад нөхдөөс хэлэхдээ, мал өсгөх улсын төлөвлөгөөг амжилттай биелүүлэхийн тул худаг усыг олшруулж, усгүй билчээрт өрөмдмөл худаг гаргаж, ус тойром тогтоох нь чухал байна. Тэрчлэн хуучин худгийн онгоц ховоог засаж сэлбэх, шинэчлэх, нүүдлийн хашааг олшруулах, худаг гаргахад хэрэглэх ёотуу, царил зэргийн багажийг олшруулах нь чухал байна гэж тэмдэглэв.

1949 оны 3 дугаар сарын хоринд Өмнөговь аймгийн Цогтцэций сумын 3 дугаар багийн ардын хурал болов. Тус хуралд Ерөнхий сайдын орлогч ба Өмнөговь аймгийн бага хурлын тэргүүлэгчдийн дарга нар суулцав.

Тус хурал дээр өрх нэг бүрд оногдох төлөвлөгөөний хуудсыг багийн захиргаанаас малчдад гардуулж өгөв. Мал өсгөх төлөвлөгөөний хуудсыг ардууд нь баясгалантай хүлээн аваад энэ төлөвлөгөөний үндсэн дээр малаа өсгөж аж амьдралаа улам элбэг дэлбэг болгохын төлөө чармайн ажиллана гэж нам, засгийнхаа өмнө зориг бадрангуй илэрхийлж байлаа.

Баянхонгор аймгийн Бууцагаан сумын 4 дүгээр багийн хөдөлмөрчид хуралдаж, Улсын 9 дүгээр Их Хурлын шийдвэрийг биелүүлэх зорилгын тухай хөгжилтэйгөөр хэлэлцэв.

Энэ багийн малчин, малаа төлөвлөгөөнөөс давуулан өсгөхийн хамт малаас гарах ашиг шимийг дээшлүүлэх талаар ажил хэргийн чанартай сайхан саналыг өргөн гаргав.

Малчин өвгөн Намжаа, малынхаа арчлагааг сайжруулан малынхаа төлийг бүрэн бойжуулахын хамт малдаа дулаан хашаа хороо, өвс тэжээлтэй байхын чухлыг дурдсан саналыг гаргахад цөм баяртай дэмжин авав. Бас малын эмнэлгийн ажлыг эрс сайжруулахыг шаардав.

По материалам «Үнэн», 1949.

говийнхон гобийцы, жители гобийских районов  
 сайшаах одобрять  
 хүлээж авах принять, встретить  
 идэвх активность  
 сонирхол интерес, заинтересованность  
 тус тус каждый в отдельности  
 шалгах зд. проверить  
 гүйцэтгэл выполнение  
 журам зд. порядок, правило  
 шүүмжлэх критиковать, выступить в прениях  
 уг зд. данный, это  
 ёсоор согласно, по  
 чуулган сессия  
 худг (ус) колодец  
 билчээр пастбище  
 өрөмдмөл худаг артезианский колодец  
 ус тойром пруд, водоем  
 тэрчлэн также  
 онгоц ховоо(н) колодезное корыто

шинэчлэх обновить  
 нүүдлийн кочевой; передвижной  
 ётуу кайло  
 царил лом  
 багаж инструмент  
 өрх зд. двор, хозяйство  
 хуудас (хуудсан) лист  
 гардуулж өгөх вручить  
 үндсэн дээр на основе, на базе  
 элбэг дэлбэг обилие, изобилие  
 хуралдах собираться, проводить собрание  
 шийдвэр решение  
 хэлэлцэх обсуждать  
 ажил хэргийн чанартай деловой  
 арчлагаа(н) уход  
 өвс(өн) сено  
 тэжээл корм  
 дэмжих поддерживать  
 малын эмнэлэг ветеринария  
 шаардах требовать  
 тарих посадить, сеять

## ГРАММАТИКА

Причастие в именительном падеже, чаще всего сопровождаемое лично-притяжательной частицей **нь**, в предложении является подлежащим и на русский язык переводится отглагольным именем существительным или оборотом «то [обстоятельство], что...», например:

*Ирсэн нь сайн.*

*Тоглож байгаа нь* харагдана.

Хорошо [то], что пришла.

Видно, что [как] играют.

Причастие-подлежащее с зависящими от него словами образует развернутое подлежащее, соответствующее русским придаточным предложениям-подлежащим или подлежащим, которые выражены отглагольными именными оборотами, например:

Намар дулаан хашаа бэлтгэсэн нь малаа онд сайн оруулахын нөхцөл болсон байв.

*То, что* осенью *приготовили* теплые хашаны (*подготовка* осенью теплых хашанов), явилось условием хорошего сохранения скота в зимне-весенний период.

Хувьсгалт уралдааныг өргөнөөр дэлгэрүүлж байгаа нь манай байгууллагын ажлаа сайнаар явуулсныг гэрчилнэ.

*То, что* широко *развертывают* революционное соревнование, свидетельствует о хорошей работе нашей организации.

Чиний энд надтай ажил хийсэн  
чинь над их тус дөхөм болов.

Үүнийг хийх нь — бага хэрэг  
биш.

Энд юу болсон нь сая мэдэгдэж  
байна.

Хичнээн хашаа сэлбэн засвар-  
ласан нь чиний илтгэлээс ил-  
рэв.

То, что ты работал здесь вме-  
сте со мною, оказалось для  
меня весьма кстати.

Сделать это — не малое дело.

Что здесь случилось, становит-  
ся известным теперь.

Из твоего доклада выясняется,  
сколько хашанов отремонти-  
ровано.

## У П Р А Ж Н Е Н И Я

### 1. Переведите на монгольский язык:

1) В нашей стране под руководством партии и правительства осуществляется великий сталинский план преобразования природы. 2) По этому плану проводится посадка леса, строительство прудов и водоемов. 3) Принятие этого постановления имеет историческое значение. 4) Этот план борьбы с засухой встретил широкую поддержку народа. 5) Задания 1951 года значительно перевыполнены, посеяно и посажено леса больше, чем в предыдущем году. 6) Этот план будет выполнен и перевыполнен. 7) Для обеспечения хорошей зимовки скота скотоводы заготавливают много сена и других кормов. 8) В гобийских аймаках проводится рытье колодцев. 9) Хорошая организация зимовки скота имеет очень важное значение. 10) Обеспечение скота достаточным количеством сена и других кормов является важнейшим условием организации хорошей зимовки скота. 11) Своевременное обсуждение этого вопроса помогло найти правильное решение, что способствовало выполнению и перевыполнению плана развития скотоводства. 12) То, что расширяется ветеринарная помощь, имеет большое значение для развития скотоводства.

### 2. Ответьте на следующие вопросы:

1) Улсын 9 дүгээр Их Хурлын түүхт шийдвэрийг говийнхон ямраар угтан хүлээв? 2) Улсын 9 дүгээр Их Хурал бол мал аж ахуйг хөгжүүлэх тухай ямар хууль гаргав? 3) Юуны тул худаг гаргах ба ус тойром тогтоох хэрэгтэй вэ? 4) Малынхаа арчлагааг сайжруулахын хамт ямар ажил явуулах хэрэгтэй вэ? 5) Малын төлийг бүрэн бойжуулах явдал бол ямар ач холбогдолтой вэ? 6) Малчин ардууд бол малын эмнэлгийн тухай ямар санал гаргаж байна? 7) Малын тоог олшруулах нь бүх ард түмэнд ямар ач холбогдолтой байна? 8) Улсын 9 дүгээр Их Хурлаас мал аж ахуйн тухай шийдвэр гаргасан нь ард түмний аж амьдралыг сайжруулах зорилготой ямар холбогдолтой юм бэ? 9) Говийн аймгуу-

дад ямар малууд бол бүх малын олонхи нь болно? 10) Говийн-хон бол ямар учраас тэмээ өсгөдөг байна?

## Повторительные упражнения

### 1. Переведите на монгольский язык:

1) В прошлый выходной день я съездил к своему дедушке. 2) Мой младший брат собирается съездить в колхоз. 3) Сейчас мой товарищ переводит с русского языка на монгольский. 4) Мы сначала переведем, а затем будем разговаривать. 5) Товарищи студенты, будем учиться на «хорошо» и «отлично»! 6) Товарищ Доржи, завтра приезжай к нам. 7) Сейчас придет наш преподаватель. 8) Мы будем повторять уроки. 9) Выполним и перевыполним наши планы. 10) Приближается весенняя экзаменационная сессия.

### 2. Ответьте на следующие вопросы:

1) Саяхан танайд хэн ирээд очив? 2) Таны дүү ирэх болов уу? 3) Онц сайн сурахын тул юу хийх хэрэгтэй вэ? 4) Өдөр бүр давтлага хийж байвал ямар ашигтай байна? 5) Чамайг «манайд ирээрэй» гэж хэн урив? 6) Чи долоон хоног бүрд өвгөн аавындаа хэдэн удаа очдог вэ?

## 22 ХОРИН ХОЁРДУГААР ХИЧЭЭЛ

### ХУДАГ ГАРГАХ БА АШИГЛАХ АЖЛЫГ ЖУРАМТАЙ БОЛГОХ ТУХАЙ

Монгол Ардын Хувьсгалт Намын Төв Хорооны бүгд хурал дээр нөхөр Чойбалсангаас 1950 оны 1-дүгээр сарын 25-нд тавьсан илтгэлдээ худаг гаргах ба ашиглах ажлыг журамтай болгох тухай хэлэв.

Билчээрийг усаар хангах явдал бол мал аж ахуйг хөгжүүлэх хэрэгт их ач холбогдолтой юм. Иймээс энэ асуудалд чухал анхаарлыг тавих хэрэгтэй.

Одоо Бүгд Найрамдах Монгол Ард Улсад жил бүр олон тооны худгийг ухаж гаргах ба засварлахаар төлөвлөж түүнийгээ жил бүр биелүүлж байгаа боловч зарим аймгуудад энэ ажлыг ёс төдий болгон явуулж байна.

Зарим нөхөд бол билчээрүүдийг усаар хангах ажил сайн явж байна гэж бодож магадгүй. Улсын Төлөвлөгөөний Комист байгаа тоонд итгэх юм бол манай улсад олон худаг барьсан тоотой байна. Үнэн хэрэг дээрээ энэ нь тийм бус юм.

Усаар хангах явдал одоо 5 жилийн өмнө байсны адил туйлын хангалтгүй муу хэвээрээ байна. Одоо 30 сая орчим гектар билчээр, усгүй байж байна.

Энэ ажлын хангалтгүй байгаагийн учир түүнийг ёс төдий болгон явуулж байгаад оршино. Энэ тухай нөхөр Чойбалсан дор дурдсан зүйлүүдийг хэлэв.

Усаар хангах явдал ийм муу байгаагийн шалтгаан юунд оршиж байгаа вэ? гэвэл:

Нэгдүгээрт. Сум, багийн захиргаадад худгийн тодорхой бүртгэл байдаггүй ба тэд нар нь худгуудын байдлыг мэдэж, тэдгээрийг сайн байлгах тухай хяналтыг тавьдаггүй байгаагаас гадна худгийг ардын аж ахуйтнуудад тодорхойгоор эзэмшүүлэн өгөөгүй учраас, түүний бүрэн бүтэн байхыг анхаарч түүнийг харж хамгаалж байх эзэнгүй байна.

Хоёрдугаарт. Ихэнхдээ худгийг хэрэгтэй газар нь гаргадаггүй, харин тэр газартаа хэрэгцээгүй боловч гаргахад хялбар газарт ухаж гаргадаг байна.

Гуравдугаарт. Худгийг хаана ч гэсэн голдуу дулаалдаггүй бөгөөд таглаагүй учраас өвлийн цагт хөлдөж, ашиглаж болохгүй болдог байна.

Дээр дурдсаныг батлахын тулд би хэд хэдэн жишээ дурдъя: Үүнээс 2 жилийн өмнө Орхоны аж ахуйд артезиан худаг 2-ыг гаргасан бөгөөд уул худгуудыг энэ 2 жилийн дотор огт ашиглаагүй байснаар барахгүй, харин балмадаар эвдэж сүйтгэсээр байна.

Хэрэв эдгээр худаг нь хэрэггүй байсан юм бол мөнгөн хөрөнгийг хий зарцуулж, уул худгуудыг байгуулсны хэрэг юу байсан юм бэ? гэдэг асуулт аяндаа гарна. Хэрэв эдгээр худаг хэрэгцээтэй байвал нь түүнийг ашиглах хэрэгтэй байна.

Хоёрдугаар жишээ: намар болохтой зэрэг зарим аймгаас хар зуд болов гэдэг гомдлыг гаргадаг байна. Үүнд, худаг гаргах ажлыг зөвөөр хуваарлаж, түүнийг цаг тухайд нь засварлан дулаалж байх юм бол хар зудын аюулыг амархан арилгаж болох байна.

1950 онд 4150 худгийг шинээр гаргах, 4200 худгийг засварлахаар төлөвлөж байна.

Одоо аймгийн байгууллагуудын зорилго бол худгийг чухам хэрэгцээтэй газарт нь гаргах, мөн тоо бөглөхийн тулд бус, харин олон жил ашигтайгаар хэрэглэж болохуйц жинхэнэ сайн чанартай худаг гаргах явдал мөн.

Худгуудыг тодорхой бүртгэлтэй болгож, худгуудын байдал ямар байгааг үргэлжид хянаж, тэдгээрийг сайн байлгах үүргийг сум, багийн захиргаадад хариуцуулан ажиллуулах ба одоо бэлхэн байгаа худгуудыг ардын аж ахуйтнуудад хариуцуулан эзэмшүүлэх нь энэ талаар тавих аймгийн удирдах хүмүүсийн хоёрдугаар сүрхий зорилго мөн юм.

Энэ ажлыг ор нэр болгон хийх бус, харин бэлхэн байгаа худаг бүрийг ардын аж ахуйтнуудад хариуцуулан эзэмшүүлж, түүнийг арчлан хамгаалах, намар өвлийн улиралд засварлах, дулаалах талаар цаг тухайд нь арга хэмжээ авахуулж байх хэрэгтэй.

Өвөл зуны цагт усгүй байх явдал манай мал аж ахуйд ихээхэн хор хөнөөл учруулж байгааг бид ойлгох хэрэгтэй.

Зуны улиралд усгүйгээс болж, бид сайн билчээрийг ашиглаж чадахгүй байна. Тэрчлэн өвлийн улиралд ус цас хүрэлцээгүй байх явдал мал аж ахуйн байдалд муугаар нөлөөлдөг байна.

## С л о в а

**бүгд хурал пленум**  
**журамтай болгох** упорядочить  
**анхаарах** обратить внимание  
**ухах** копать, рыть  
**магадгүй** может быть, возможно  
**хамаг** все  
**ёс төдий** для вида, для отвода глаз  
**оршино** *з*д. заключается  
**итгэх** верить  
**захиргаа(н)** управление  
**бүртгэл** учет, сведения  
**хяналт** контроль  
**харж хамгаалах** охранять  
**эзэн** хозяин  
**ихэнх** большинство  
**хэрэгцээгүй** без надобности, без потребности  
**хялбар** легко, не трудно  
**голдуу** в основном  
**таглаа(н)** пробка, крышка  
**хөлдөх** замерзать  
**батлах** *з*д. подтвердить

**уул** *з*д. указанный; это  
**балмадаар** *з*д. преступно  
**эвдэх** ломать, разрушить  
**сүйтгэх** разрушить, погубить  
**мөнгөн хөрөнгө** денежные средства  
**хий** *з*д. попусту  
**зарцуулах** расходовать  
**аяндаа** само по себе, невольное  
**хар зуд** бесснежие и отсутствие воды  
**гомдол** жалоба  
**чухам** именно  
**бөглөх** затыкать, закрыть  
**болохуйц** чтобы можно было  
**бэлхэн** готовый, имеющийся  
**сүрхий** серьезный  
**ор нэр** пустое название; на бумаге  
**арчлах** *з*д. защищать, охранять  
**зун** лето  
**хор хөнөөл** вред  
**учруулах** причинить  
**нөлөөлөх** влиять

## ГРАММАТИКА

1. Причастие возможности обозначает, что данное действие является возможным или необходимым, например:

Энэ замаар *явмаар* байна.

Үүнд арга хэмжээ *авмаар* байна.

Бороо *ормоор* байна.

Урлах дархлахыг сурч *болмоор*.

По этой дороге *проехать можно*.

В отношении него *необходимо принять* меры.

*Будет* дождь (есть признаки того, что будет дождь).

*Мастерить* и *кузничить* научиться *можно*.

2. Окончанием причастия возможности является *-маар (-мээр, -моор, -мөөр)*, например:

**гар** + **маар** = **гармаар** можно выйти

**ир** + **мээр** = **ирмээр** можно прибыть

**ол** + **моор** = **олмоор** можно найти

**хөгж** + **мөөр** = **хөгжмөөр** может развиваться

3. Будущее причастие в форме дательного-местного падежа перед качественными именами, соответствующими русским наречиям образа действия, переводится на русский язык неопределенным наклонением или оборотом «для...», например:

Өнөөдөр явахад сайн.

Сегодня *итти* хорошо.

Үүнийг хийхэд амархан биш.

Сделать это нелегко.

Мал билчээрлүүлэхэд дөхөмтэй газар олох хэрэгтэй.

Нужно найти место, удобное для пастбы скота.

## У П Р А Ж Н Е Н И Я

### 1. Переведите на монгольский язык:

1) Наши колхозы и совхозы борются за выполнение плана дальнейшего развития животноводства и повышения его продуктивности. 2) Повышение продуктивности животноводства обеспечит изобилие продовольствия. 3) Необходимо заготовить сено и корма. 4) В настоящее время в гобийских и других аймаках развертывается работа по рытью колодцев и по строительству прудов и водоемов. 5) Но необходимо утеплять и охранять имеющиеся колодцы. 6) Также необходимо провести ремонт старых колодцев. 7) Тогда можно ли будет считать, что созданы все необходимые условия для зимовки скота? 8) Мне кажется, что здесь можно построить скотный двор и вырыть колодец. 9) Этот план можно выполнить и перевыполнить. 10) Необходимо упорядочить эту работу. 11) Нужно обратить особое внимание на заготовку кормов для скота и обеспечение пастбищ водой. 12) Отдыхать в этом саду очень хорошо. 13) Работать здесь очень хорошо, ибо здесь созданы все условия для работы. 14) Понимать это легко.

### 2. Ответьте на следующие вопросы:

1) Монгол улсын ямар аймгуудад худаг гаргах хэрэгтэй гэж үзмээр байна? 2) Билчээр дээр оршиж байгаа худгуудыг дулаалдаг байна уу? 3) Худгийг ямар газарт гаргавал сайн байна? 4) Монгол улсад артезиан худгуудыг гаргадаг уу? 5) Бүгд Найрамдах Монгол Ард Улсад худгууд бол ямар ач холбогдолтой байна? 6) Боловсон мал аж ахуйг хөгжүүлэхийн тул ямар ямар ажлуудыг явуулах хэрэгтэй вэ? 7) Билчээр дээр оршиж байгаа худгуудыг хэн хамгаалах ёстой вэ? 8) Мал аж ахуйг өвс тэжээлээр хангах явдал ямар ач холбогдолтой байна? 9) Худаг гаргахад ямар багаж хэрэгтэй вэ? 10) Худгийн тоог хүрэлцээтэй болгоход мал аж ахуйд ямраар нөлөөлдөг байна? 11) Худаг гаргамаар газрыг яаж олдог юм бэ? 12) Энэ тасалгаанд хичээл хийхэд ямар байна?

**1. Переведите на монгольский язык:**

1) Когда в театре происходило торжественное заседание, я со своими братьями и сестрами слушал радиопередачу. 2) Когда закончится наше собрание, тогда мы поедем к нам. 3) Когда прозвонит звонок, тогда ты приходи в читальный зал. 4) При подготовке к экзаменам необходимо прочесть эту книгу. 5) Когда приедете к нам, привезите учебник монгольского языка. 6) Товарищи, садитесь! 7) Сначала прочитайте урок, а затем переведите его на русский язык. 8) Коллектив нашего института успешно готовится к экзаменам. 9) Коллектив этого завода досрочно выполнил свой производственный план.

**2. Ответьте на следующие вопросы:**

1) Өнөөдөр хичээл болж байхад хэн ороод гарсан байна? 2) Өглөөний есөн цагт хичээл эхлэхэд бүх оюутан нар хичээлийнхээ тасалгаанд байсан уу? 3) Таны бүлгийнхэн ямар сурч байна? 4) Таны бүлгийнхний сахилга бат ямар байна? 5) Онц сайн сурагтун! гэж хэн уриалав?

## 23 ХОРИН ГУРАВДУГААР ХИЧЭЭЛ

---

### ХӨДӨЛМӨРИЙН БАДРАНГУЙ БҮТЭЭЛ

Маршал Чойбалсангийн нэрэмжит аж үйлдвэрийн комбинатын алтан гадас одонт эсгий ба эсгий гутлын фабрикийнхан, энэ оны 3 дугаар сард болох тус комбинатын 15 жилийн ойг угтсан хувьсгалт уралдаанд 1949 оны төлөвлөгөөг хугацаанаас нь өмнө 120 хувь биелүүлэх эрхэм үүргийг авсан билээ.

Тус фабрикийнхан, энэ үүргээ нэр төртэй биелүүлэхийн тул хөдөлмөрийн бүтээлийг дээшлүүлэн, үйлдвэрийн ажиллагааг тасаг, бригад, ээлж, ажилчин бүр дээр нарийн зохион байгуулж, үйлдэхүүний чанарыг сайжруулахын төлөө тэмцлийг өрнүүлэн ажиллаж эхлэв.

Фабрикийн захиргаа, намын байгууллага нь тасаг, бригад, ээлж, ажилчин бүрийн уралдааныг таван хоног тутам тогтмол дүгнэхийн хамт, төлөвлөгөөгөө давуулан биелүүлдэг тэргүүний тасаг, сайчуулын ажлын туршлагыг нийт тасаг, ажилчдын дотор дэлгэрүүлэн, уралдааны шилжин явдаг туг, баярын бичгийг шилжүүлэх зэргээр нийт ажилчны идэвх зоригийг бадруулан ажилласан бөгөөд үүн дээр нам, эвлэлийн гишүүд, түүний нэрэмжит бригадууд манлайлж, хөдөлмөрийн бадрангуй гялалзсан сайхан жишээг үзүүлэв. Тэд, хувьсгалт уралдаанд их бүтээлийг гаргахын төлөө биеэ хайрлалгүй хөдөлмөрлөж, авсан үүргээ үлгэртэй сайн биелүүлэхэд ажилчин олон нийтийг дагуулсаар байна.

Б. Н. М. А. Улсын Бага Хурлын гишүүн, улсын ударник нөхөр Пунцагийн удирдсан намын нэрэмжит бригадынхан, ээлжийнхээ төлөвлөгөөг бүтэн хагасаас хоёр дахин биелүүлж ирэв. Нөхөр Пунцагийн удирдсан энэ бригадынхан нэг ээлжинд 300 эсгий гутлыг нойтон дамжлагаар боловсруулан гаргахаас 600 гаруйг гаргаж байв. Энэ бригадын ажилчин бүхэн, өдөр тутмынхаа нормыг 120-иос дээш хувиар гүйцэтгэж байна. Улсын ударник нөхөр Пунцаг, ээлжийнхээ нормыг 90-ээс дээш хувиар биелүүлдэггүй байсан ажилчин нөхөр Хуужийг нойтон дамжлагын бүх ажилд дэс дараалан сургаж, ажлын туршлагатай болгон, нормоо 120-иос дээш хувиар биелүүлдэг болгов.

Тус фабрик дээр эвлэлийн нэрэмжит залуучуудын 4 бригад ажиллаж байна. Эдгээр бригад нь энэ он гарсаар ээлжийнхээ нормыг байнга давуулан биелүүлсээр ирэв. Эвлэлийн гишүүн, улсын ударник Жамъяншарав даргатай эсгий гутлын хуурай тасгийн эвлэлийн нэрэмжит бригад, ээлжийнхээ нормыг 140-өөс дээш хувиар биелүүлж, бусдаасаа түрүүлж явна.

Энэ фабрикийн намын байгууллага, ажилчин олныг зохион байгуулж зоригжуулагч гол штаб нь болов. Тус фабрикийн нам, эвлэлийн гишүүдийн олонхи нь нормоо 200 ба түүнээс дээш хувиар биелүүлж, ажилчин олноо манлайлсаар байна.

Намын байгууллагаас ажилчдын дотор хүмүүжлийн ажлыг өдөр тутам зохиож байна. Тус үүрийн ухуулагч нараас манай анхдугаар таван жилийн төлөвлөгөөгөөр үйлдвэрийн өмнө тавигдсан зорилго, Улсын 9 дүгээр Их Хурлын шийдвэрийг ажилчин олонд тайлбарлахын хамт фабрикийн ажилчдын тэргүүний туршлагыг тайлбарлан таниулж, тэдний хөдөлмөрийн идэвх зоригийг улам хөгжүүлсээр байна. Энэ бүх ажиллагааны үрээр тус фабрикийнхан, нэгдүгээр улирлынхаа төлөвлөгөөг энэ 3 дугаар сарын 10-нд 105,7 хувиар биелүүлж, хөдөлмөрийн бүтээлийг нэмэгдүүлээд, уралдаант ажил дээрээ сайхан бүтээлийг гаргав.

Тус фабрикийн олонхи тасгууд нь 1-2 дугаар сарын ба 3 дугаар сарын эхний 10 хоногийн төлөвлөгөөгөө давуулан биелүүлсний дотор, намын гишүүн Мягмаржав даргатай эсгийн тасаг нь улирлынхаа төлөвлөгөөг 131 хувиар биелүүлж, бусдынхаа түрүүнд нь оров. Энэ фабрикийн ажилчдын дотроос ажил таслах, ажлаас хожимдох явдал эрс багасаж, ажилчин бүхний хөдөлмөрийн бүтээл эрс дээшилж ирсэн учир, энэ оны эхний хоёр сард бүх ажилчид өдөр тутмын нормоо биелүүлсэн ба давуулан биелүүлжээ.

По материалам «Үнэн», 1949.

### С л о в а

**хөдөлмөрийн бүтээл** производительность труда  
**нэрэмжит иمني**  
**аж үйлдвэр** промышленность  
**алтан гадас** полярная звезда

**одон орден**  
**эсгий войлок**  
**эсгий гутал** валенки  
**үүрэг эд.** обязательство  
**нэр төртэй (гөөр)** с честью

**тасаг** эд. цех, отдел  
**өөлж** эд. смена  
**тогтмол** постоянно, регулярно  
**дүгнэх** подытожить  
**шилжин явдаг туг** переходящее зна-  
 мя.  
**шилжүүлэх** передавать  
**гялалзсан** блестящий  
**биеэ хайрлалгүй** самоотверженно  
**бүтэн хагас** полтора  
**нойтон** мокрый, влажный  
**дамжлага(н)** передача, перевалка  
**боловсруулах** обработать  
**дэс дараалан** по порядку, последо-  
 вательно  
**дээш** выше

**байнга** постоянно  
**түрүүлэх** итти впереди  
**олонхи** большинство  
**нарийн** тонкий; тонко  
**нийт** весь  
**үзүүлэх** показать  
**эвлэл** сюз; эд. ревсомол  
**зохион байгуулах** организовать  
**манлайлах** возглавлять  
**ухуулагч** агитатор, пропагандист  
**тайлбарлах** разъяснить, растолковать  
**таслах** эд. пропускать, не являться  
**хожимох** опаздывать  
**эрс** резко решительно  
**багасах** уменьшаться

## ГРАММАТИКА

1. Обобщительные местоимения со значением «каждый» — **бүр**, **бүхэн** и **тутам** характерны тем, что они располагаются не перед определяемым, а после определяемого слова, например:

<b>өдөр бүр</b>	<i>каждый</i> день, ежедневно
<b>сар тутам</b>	<i>каждый</i> месяц, ежемесячно
<b>хүн бүхэн</b>	<i>каждый</i> человек, все люди

2. При склонении падежное окончание принимает не определяемое слово, а определение, выраженное одним из обобщительных местоимений, например:

<b>өдөр бүрийн</b>	ежедневный
<b>сар тутмын</b>	ежемесячный
<b>хүн бүхэнд</b>	каждому человеку, всем

3. Обобщительное местоимение **бүхэн** отличается тем, что оно употребляется лишь при обозначении людей и некоторых других понятий (например: Орон *бүхний* пролетари нар нэгдэгтүн! — Пролетарии *ьсех* стран, соединяйтесь!).

## У П Р А Ж Н Е Н И Я

1. Переведите на монгольский язык:

1) Партийные и профсоюзные организации организуют социалистическое соревнование трудящихся и постоянно руководят им, направляя его на скорейшее выполнение хозяйственных планов. 2) Участники социалистического соревнования неуклонно повышают производительность труда, увеличивают выпуск продукции и повышают ее качество. 3) Работать сегодня лучше, чем вчера,

а завтра лучше, чем сегодня,— так воспитаны советские люди. 4) Под руководством коммунистической партии советский народ достиг огромных успехов в борьбе за выполнение и перевыполнение послевоенной сталинской пятилетки. 5) В каждой отрасли народного хозяйства имеются известные всей стране передовики. 6) Все соревнующиеся работают по примеру передовиков. 7) Каждый участник социалистического соревнования борется за выполнение и перевыполнение своего ежедневного и ежемесячного плана. 8) Каждый студент ежедневно повторяет уроки.

## 2. Ответьте на следующие вопросы:

1) Чойбалсангийн нэрэмжит аж үйлдвэрийн комбинатын алтан гадас одонт эсгий ба эсгий гутлын фабрикийнхан уралдаанд ямар үүргийг авсан байна? 2) Үйлдвэрийн сайчуулын ажлын туршлага бол бусад ажилчид бүрд ямар ач холбогдолтой байна? 3) Тус фабрикийнхан энэ үүргээ нэр төртэй биелүүлэхийн тул юу хийх ёстой байна? 4) Тус үйлдвэрийн намын байгууллага бол ажилчдын дотор өдөр тутам ямар ажлыг зохиож байна? 5) Ухуулагч нар бол ажилчин бүхэнд юу тайлбарлаж байна? 6) Хэн бол юу хайрлалгүй ажиллаж байна? 7) Бүгд Найрамдах Монгол Ард Улсад хувьсгалаас урьд аж үйлдвэр байсан уу? 8) Бүгд Найрамдах Монгол Ард Улсын аж үйлдвэр байгуулах ба түүнийг хөгжүүлэх явдалд ямар улс тусалсан ба одоо тусалж байна? 9) Одоо Улаанбаатар хотод ямар аж үйлдвэрүүд байна? 10) Үйлдвэрийн сайчуул бол ямар жишээ үзүүлж байна?

## Повторительные упражнения

### 1. Переведите на монгольский язык:

1) Кто знает, о чем написано в этой книге? 2) Я знаю, о чем написано в этой книге. 3) От кого ты узнал, что вчера вечером приехал мой младший брат? 4) Знаешь ли ты, что сейчас происходит собрание студентов второго курса? 5) Знаешь ли ты о завтрашнем отъезде Дамдина в деревню? 6) Все ли студенты знают о завтрашнем собрании нашей группы? 7) Все студенты знают о завтрашнем собрании.

### 2. Ответьте на следующие вопросы:

1) Маргааш хэн энд ирэхийг та мэднэ үү? 2) Одоо уншлагын тасалгаанд хэдэн хүмүүс сууж байгааг та мэднэ үү? 3) Энэ тасалгаанд монгол хэлний хичээлээс урьд ямар хичээл болсныг хэн мэднэ? 4) Өнөөдөр орой энд юу болохыг та мэднэ үү? 5) Одоо гадаа ямар байгааг та мэднэ үү? 6) Та, миний дүүгийн ямар сурч байгааг мэднэ үү? 7) Та, миний дүүгийн хэдэн настайг хэнээс мэдэв? 8) Өнөөдөр орой манай дээд сургуульд юу болохыг та мэднэ үү?

ҮЙЛДВЭРИЙН САЙЧУУЛЫН ТУРШЛАГЫГ  
СУДАЛЖ ӨРГӨН ДЭЛГЭРҮҮЛЬЕ

Хөдөлмөрийн бүтээлийг дээшлүүлэн, үйлдэхүүний чанарыг сайжруулж эдийн өөрийн өртгийг хямдруулахын хамт түүхий эд, материалыг арвилан хэмнэж, төлөвлөгөөнөөс илүү ашгийг хуримтлуулах явдал бол манай аж үйлдвэрийн ажилчин олон нийтээс таван жилийн төлөвлөгөөг бүрэн биелүүлж, улмаар давуулан биелүүлэхийн төлөө тэмцэх тэмцлийн хамгийн чухал зорилго мөн билээ.

Үйлдвэрийн газрын тэргүүний сайчуулын ажлын туршлагыг гүн судалж, өргөнөөр дэлгэрүүлэх нь нийт ажилчин олны хөдөлмөрийн бүтээлийг дээшлүүлж, тус орны аж ахуй, соёлыг хөгжүүлэх таван жилийн төлөвлөгөөгөөр аж үйлдвэрийн газрын өмнө нам, засгаас тазьсан их зорилгыг амжилттай биелүүлэх тэмцлийн чухал замын нэг нь мөн. Манай үйлдвэрийн салаа мөчир бүхэнд хөдөлмөрийн аргыг байнга судалж, техникийг чанартай сайн ашиглахын хамт хөдөлмөрийн бүтээлийг дээшлүүлэн сайн чанартай үйлдэхүүнийг гаргаж, түүхий эд, материалыг арвилан хэмнэж чаддаг болсон тэргүүний сайн ажилчин, мастер олон байна.

Үйлдвэрийн газар ба үйлдвэрчний байгууллагын удирдагчдаас үйлдвэрийн шинэ санаачлагатанд элдэв тусламжийг үзүүлж, тэдний ажлын туршлагыг тогтмол сонирхон судалж нэгтгэх ба түүнийг бүх эрэгтэй, эмэгтэй ажилчны дунд дэлгэрүүлэх арга хэмжээг авч байвал зохино.

Аж үйлдвэрийн комбинатын гутлын фабрикийн олон эсгүүрчин олон мянган дөрвөлжин метр булигаарыг хэмнэжээ. Мөн комбинатын эсгийлэх фабрикийн нэг бригад, мөн улиралд эдийг тогтоосон нормоос нь 3400 төгрөгөөр хэмнэжээ. Тэднээс ажлынхаа аргыг өдөр тутам улам сайжруулан боловсруулж байдаг учраас ийм амжилтыг олж байна. Эдгээр үйлдвэрийн газрын удирдагчид, нам, үйлдвэрчний эвлэлийн байгууллагуудаас үйлдвэрийн сайчуулын бригадын ажлын туршлагыг улс нийтийн ба үйлдвэрийн ашиг тусын үүднээс аль болохоор дэлгэрүүлж, энэ шинэ санаачлагатны ажлын туршлагыг ажилчин бүхэнд хүртээл болгох нь чухал байна. Үйлдвэрчний эвлэлийн Төв Зөвлөл ба Гар Үйлдвэрийн зөвлөлөөс эдгээр үйлдвэрийн сайчуулын ажлын туршлагыг гутлын артелийн ажилчин нараас судлан эзэмшихэд нь туслах талаар анхаарлаа тавивал зохино.

Барилгын хэрэг эрхлэх газрын харьяа модны тэргүүний заводынхан шинэ санаачлагыг зоригтой гаргаад, түүнийгээ биелүүлэ-

хийн төлөө шургуу сайн хөдөлмөрлөсөн учраас хар тос нэрэх ажлын зохион байгуулалтыг амжилттай өөрчлөх бололцоотой болоод, тосыг 4 дахин илүү гаргахын хамт өртгийг 50 хувиар хямдруулжээ.

Манай үйлдвэрийн газар бүхэн, улам их үйлдэхүүнийг гаргаж, өртгийг хямдруулах талаар улс нийтийн чанартай санаачлагыг тавьж байвал зохино. Үүнд, үйлдвэрийн газрын санаачлагатныг аль болохоор хөгжүүлэн, тэдний саналыг зоригтой дэмжин авч биелүүлэх ба ашиг тустай зүйлийг ажил дээр шургуу нэвтрүүлэн, өргөн олонд дэлгэрүүлэх нь чухал юм.

Зөвлөлт Улсын үйлдвэр дээр стахановч ажилчны хөдөлмөрийн туршлагыг судалж, улмаар үйлдвэрт гүнээ нэвтрүүлэхийн тул хичээлийг өргөн зохиож байдаг байна. Энэ ашигтай сайн арга хэмжээг манай аж үйлдвэр дээр ч биелүүлж болох билээ. Гэтэл Үйлдвэрчний Эвлэлийн Төв Зөвлөл ба зохих яамдын удирдагчид нь үйлдвэрийн тэргүүний сайчуулын туршлагыг судалж, олон нийтэд дэлгэрүүлэх талаар үйлдвэрийн мэрэгжлийн хичээлийг зохиох, шинэ санаачлагатны дугуйланг байгуулах тухай зохих анхаарлыг тавьдаггүй байна. Энэ чухал арга хэмжээг биелүүлэх явдал бол үйлдвэрийн ажилчин олон нийтээс хөдөлмөрийн бүтээлийг цаашид дээшлүүлэхийн төлөө тэмцэлд ихээхэн чухал алхам болох ёстой юм.

Үйлдвэрийн тэргүүний сайчуулын туршлагыг судалж, үйлдвэрийн ажилчин нийтэд нэвтрүүлэх талаар зохиох ажлын арга маяг олон янз байдаг тул тэр бүхнийг зөв ашиглаж, ажилчин олноос тэргүүний сайчуулын туршлагыг түргэн судлахад нь өдөр тутмын тусламжийг үзүүлэх нь зохих яам, үйлдвэрийн газар, нам, үйлдвэрчний байгууллагуудын удирдагч нарын нэр төрийн хэрэг мөн.

По материалам «Үнэн», 1949.

## С л о в а

судлах изучать  
эд товар  
өөрийн өртөг себестоимость  
арвилан хэмнэх экономить, беречь  
хуримтлуулах накапливать  
гүн глубокий; глубоко  
салаа мөчир отрасль  
түүхий эд сырье  
санаачлагатан инициатор(ы)  
элдэв разный  
эрэгтэй ажилчин рабочий  
эмэгтэй ажилчин работница  
эсгүүрчин закройщик  
дөрвөлжин квадратный

булигаар юфть, хром  
хэмнэх эд. экономить  
аль болохоор всячески, всемерно  
хүртээл болгох сделать достоянием  
барилга строительство  
эрхлэх руководить; заниматься  
харьяа подведомственный  
хар тос(он) деготь  
нэрэх перегонять, гнать  
өөрчлөх изменить  
шургуу упорный; упорно  
нэвтрүүлэх внедрить  
алхам шаг

В монгольском языке имеются прямой, побудительный, страдательный, совместный и взаимный залого.

1. Прямой залог обозначает, что в предложении выражено лишь отношение между подлежащим и сказуемым; он соответствует русским действительному и среднему залогам. Этот залог, в отличие от остальных, не имеет специальных формативов и в своей основе служит базой для образования всех прочих залогов.

2. а) Побудительный залог (бүтээхийг бусдад даалгасан үйл үг) обозначает действие, совершить которое повелевается или разрешается. Поэтому глагол в форме этого залога переводится на русский язык оборотами «позволить» или «заставить сделать то-то», а также каким-либо другим глаголом, передающим данное комплексное понятие (например *выгнать, исключить* вместо «заставить выйти» или *выпустить* вместо «разрешить выйти» и т. д.), например:

<b>ирэх</b> прибыть;	<b>ирүүлэх</b> заставить прибыть, вызвать; позволить прибыть
<b>явах</b> итти;	<b>явуулах</b> заставить итти, отправить; позволить итти, пустить; проводить (работу)
<b>уух</b> сидеть;	<b>суулгах</b> заставить (или: позволить) сесть, посадить
<b>уух</b> пить;	<b>уулгах</b> заставить (или: позволить) пить, напоить
<b>нүүх</b> кочевать;	<b>нүүлгэх</b> заставить (или: позволить) кочевать; перевозить, переселить кого-л.

б) Во многих случаях посредством побудительного залога от непереходного глагола (пассивного значения) образуется переходный глагол, например:

<b>хатах</b> сохнуть;	<b>хатаах</b> сушить (но: <b>хатаалгах</b> заставить [или: позволить] кому-л. что-л. сушить);
<b>ноцох</b> разгореться;	<b>ноцоох</b> зажигать (об освещении, но: <b>ноцоолгах</b> заставить кого-л. зажигать).

Иногда побудительный залог употребляется со значением страдательного залога, например:

<b>удирдах</b> руководить;	<b>удирдуулах</b> быть руководимым
<b>заах</b> учить;	<b>заалгах</b> быть обучаемым

в) Если первичная основа глагола оканчивается на дифтонг или долгий гласный, то побудительный залог образуется посредством суффикса *-лга* (*-лгэ, -лго, -лгө*), например:

<b>нүү</b> кочевать;	<b>нүүлгэ</b> переселить
<b>суу</b> сидеть;	<b>суулга</b> посадить

<b>бай</b>	быть;	<b>байлга</b>	оставить
<b>хороо</b>	сократить;	<b>хороолго</b>	заставить сократить
<b>хөө</b>	гнать;	<b>хөөлгө</b>	заставить гнать
<b>гүй</b>	бежать;	<b>гүйлгэ</b>	заставить бежать

г) Если первичная основа глагола оканчивается на **с** или **д**, то при образовании побудительного залога употребляется суффикс **-га (-гэ, -го, -гө)**, причем согласный **д** переходит в **т**, например:

<b>бос</b>	вставать;	<b>босго</b>	поднимать
<b>өс</b>	расти;	<b>өсгө</b>	выращивать
<b>багад</b>	уменьшаться;	<b>багатга</b>	уменьшать
<b>өвд</b>	болеть;	<b>өвтгө</b>	причинить боль

д) Если основа глагола оканчивается на краткий гласный (как обозначаемый на письме, так и необозначаемый), то суффиксом побудительного залога является **-уул (-үүл)**, например:

<b>гарга</b>	выводить;	<b>гаргуул</b>	заставить выводить
<b>эвлэ</b>	соединиться;	<b>эвлүүл</b>	соединить
<b>ор</b>	войти;	<b>оруул</b>	впустить, заставить (или: позволить) войти

е) Как уже было сказано, некоторые непереходные глаголы (пассивного значения, соответствующие русским средним глаголам) при помощи суффикса побудительного залога становятся переходными. Это чаще всего глаголы, в своей первичной основе оканчивающиеся на согласный, после которого иногда следует необозначаемый на письме краткий гласный, например:

<b>хат(а)</b>	сохнуть	<b>сөнө</b>	гибнуть
<b>хор(о)</b>	сокращаться	<b>шингэ</b>	впитываться

От подобного рода непереходных глаголов при помощи наращенного долгого гласного, в данном случае условно считающегося суффиксом побудительного залога, образуются переходные глаголы, например:

<b>хат</b> + <b>аа</b> = <b>хатаа</b>	сушить	<b>сөнө</b> + <b>өө</b> = <b>сөнөө</b>	уничтожать
<b>хор</b> + <b>со</b> = <b>хороо</b>	сокращать	<b>шингэ</b> + <b>ээ</b> = <b>шингээ</b>	впитывать

Примечание. В монголоведении пассивными глаголами называются непереходные глаголы типа **хат** — сохнуть, **урга** — расти (о растениях), **өс** — расти (в смысле «размножаться») и т. п., которые обозначают действие или состояние, независимое, так сказать, от воли субъекта, выраженного в подлежащем. Этим пассивным глаголам в других языках соответствуют глаголы среднего залога, отсутствующего в монгольском языке. Активными глаголами называются все переходные глаголы, а также непереходные типа **яв** — итти, **ир** — пригги, **суу** — сидеть и т. д., обозначающие действия, совершение которых зависит от воли субъекта.

## У П Р А Ж Н Е Н И Я

### 1. Переведите на монгольский язык:

1) Передовые промышленные предприятия нашей страны с огромным подъемом выполняют свои обязательства по досрочному завершению производственных планов и выпуску продукции сверх плана, по снижению себестоимости и дальнейшему улучшению качества выпускаемой продукции. 2) Высокая трудовая активность позволила коллективу этого завода выполнить свое обязательство. 3) Социалистическое соревнование позволяет поднять производительность труда, увеличить выпуск продукции, выполнить и перевыполнить производственный план. 4) Вчера мы выпустили стенную газету. 5) Необходимо впустить этих студентов в зал. 6) Необходимо пропагандировать и распространять опыт передовиков промышленности. 7) Необходимо улучшить качество выпускаемой продукции. 8) Каждый студент должен бороться за дальнейшее улучшение своей учебы и за поднятие дисциплины в своей группе. 9) Солнце освещает нашу комнату.

### 2. Ответьте на следующие вопросы:

1) Та дээд сургуулиа хэзээ төгсгөх вэ? 2) Энэ хичээлийг хэн уншуулав? 3) Та нар хэзээ ханын сонин гаргах гэж байна? 4) Энэ ажлыг хэн явуулж байна? 5) Дотуур хувцсыг хаа хатаахад сайн байна? 6) Энэ ширээг хэн энд оруулав? 7) Үйлдэхүүний чанарыг сайжруулж, эдийн өөрийн өртгийг хямдруулахад ард түмний аж амьдралын хэмжээ ямар болно? 8) Үйлдвэрийн сайчуулын туршлагыг өргөн дэлгэрүүлэхэд ямар ач холбогдолтой юм бэ? 9) Үйлдвэрийн сайчуулын туршлага бол юу үзүүлж байна? 10) Үйлдвэрийн тэргүүний хүмүүсийн туршлагыг ямар аргаар дэлгэрүүлэх хэрэгтэй вэ?

## Повторительные упражнения

### 1. Переведите на монгольский язык:

1) Для того, чтобы учиться хорошо, необходимо ежедневно повторять уроки и своевременно выполнять домашние задания. 2) Чтобы хорошо сдать экзамены, необходимо своевременно начать подготовку к ним. 3) В результате победы социализма в нашей стране упрочилась дружба народов. 4) Наши студенты сдали экзамены на «хорошо» и «отлично» благодаря тому, что они всегда повторяли уроки и своевременно начали подготовку к экзаменам. 5) Мы пойдем в кино после того как кончатся занятия. 6) Строительство новых домов имеет очень большое значение. 7) Об успехах передовиков животноводства узнали все скотоводы.

### 2. Ответьте на следующие вопросы:

1) Малчдаас дулаан хашаа барих төлөвлөгөөгөө давуулан биелүүлсний ачаар мал онд ямар оров? 2) Хурал тарсны дараа та хаа явах гэж байна? 3) Малаа онд сайн оруулахын тул ямар арга хэмжээ авах хэрэгтэй вэ? 4) Малдаа хүрэлцээтэйгээр өвс ба бусад тэжээл бэлтгэх явдал, ямар ач холбогдолтой юм бэ?

## ҮЙЛДВЭР ДЭЭР БОЛОВСОН БАЙДЛЫН ТӨЛӨӨ ТЭМЦЬЕ!

Хөдөлмөр дээр боловсон ажиллагаатай болох явдал бол үйлдвэрүүдээс төлөвлөгөөгөө амжилттай биелүүлж, сайн чанарын үйлдэхүүнийг бүтээж гаргахын нэг нөхцөл мөн. Үйлдвэрийн ажлын салаа мөчир бүхэнд өдөр тутмын төлөвлөгөөг гаргаж, ажиллагааны журмыг нарийн чанга сахих, хөдөлмөрийг зөв зохион байгуулж, үйлдвэрийн байранд эмх цэгцтэй байлгах, эд материалыг ямагт арвилан хэмнэх, машин техникийг хайрлан зөвөөр ашиглах нь үйлдвэрийн боловсон байдлын чухал зүйлүүд мөн билээ. Эд бүхнийг харилцан нягтаар хослон биелүүлэх явдал бол манай үйлдвэрийн нийт ажилчин болон ажилчин тус бүрээс хөдөлмөрийн бүтээлийг дээшлүүлэн, боловсруулан гаргах, үйлдэхүүний яс чанарыг сайжруулж, улмаар түүний өөрийн өртгийг хорогдуулахын төлөө явуулах тэмцлийн чухал шижим мөн юм.

Манай эх орны нийт хөдөлмөрчдөөс таван жилийн төлөвлөгөөг биелүүлэхийн тул зориг бадрангуй хөдөлмөрлөж, тус орны эдийн засаг, соёлыг цааш нь цэцэглүүлэх дайчин программыг амжилттай бөгөөд давуулан гүйцэтгэх явдалд манай бүх бололцоог бүрэн ашиглах нь чухал болж байгаа энэ үед хөдөлмөрийн боловсон байдлыг дээшлүүлэх асуудал онц их ач тустай болж байна. Иймд үйлдвэрийн газруудын удирдагчид, инженер, техникч ажилтан, нам, үйлдвэрчний байгууллагууд, өдөр тутамд энэ талаар онц анхаарал тавивал зохино.

Манай үйлдвэрийн олон зуун тэргүүний хүмүүс нормоо өдрөөс өдөрт 200—300 хувь буюу түүнээс дээш хувиар биелүүлсээр байна. Ийм гавшгайчууд, үйлдвэр бүхэн дээр байгаа бөгөөд тэднээс хөдөлмөр дээрээ өндөр бүтээлийг гаргаж яваа явдал бол манай тэргүүний хүмүүс өөрсдийн ажлын техникийг сайнаар судалж, үр бүтээлтэй боловсноор ажиллаж сурсныг хамгийн түрүүнд үзүүлж байна. Эдгээр хүмүүс, маргааш юу хийхээ урьд өдөр нь нарийн тодорхой мэдээд хэрэглэх материалаа мастераас хүлээн аваад, машин техник, хэрэглэл багажаа нарийн сайн шалгаж бэлтгэдэг юм. Тэд аар саар дутагдал байвал дор нь засаж арилгах буюу чадахгүй зүйлээ мастертаа уламжлан түүний заавар туслалцаагаар засдаг байна. Үүнд, ажлынхаа байрыг хэдий сайн засаж, чухал материал, багажийг хэчнээн сайн бэлтгэж авсан байвал хөдөлмөрийн бүтээл нь төдий чинээ их болдгийг ударник бүхэн ажлынхаа туршлагаас олж мэдсэн билээ.

Тэргүүний хүмүүсийн туршлагыг үйлдвэрийн ажилчин олон түмэнд нэвтрүүлэх нь үйлдвэр дээр боловсон байдлыг дээшлүү-

лэх тэмцлийн хамгийн зөв чиглэлт мөн юм. Иймийн тул манай удирдах, инженер, техникийн шинэ хүчнүүд тэргүүний хүмүүсийн ололт туршлагыг цуцалтгүй судалж, түүнийг нэгтгэн дүгнээд бүх ажилчдын дунд өдөр тутам дэлгэрүүлж байвал зохино. Үүний зэрэгцээгээр үйлдвэр бүхэн дээр ажилчин болон бүх инженер, техникч, ажилтны мэрэгжлийг байнга дээшлүүлж байх нь чухал. Гэтэл одоо хүргэл олонхи үйлдвэр дээр ийм хичээл огт явсангүй нь харамсалтай юм. Жишээ нь: Улаанбаатар хотын гар үйлдвэрийн хоршооллын артелиудад тэртээ өвлийн эхээр техникийн дугуйлангуудыг зохиох шийдвэр гаргасан боловч одоо хавар болчихоод байхад тэр дугуйлангууд зохиогдоогүй байгаагаар барахгүй, хотын холбооноос түүний программыг ч боловсруулж өгсөнгүй байна.

Үйлдвэрийн газар болон түүний байрын дотоодод аж ахуйч үлгэр жишээтэй байдлыг тогтоох нь үйлдвэрийн нийт боловсон байдлын салшгүй хэсэг мөн. Иймд үйлдвэрийн яамны харьяа үйлдвэрийн газар болон орон байр нь хэтэрхий их хог новшид дарагдаж бохир байдалтай байгаа үйлдвэрүүд үүнийг онц их анхаарч ажиллавал зохино.

Үйлдвэрийн газруудын бүх ажилчдаас уралдааны аргаар таван жилийн төлөвлөгөөг биелүүлэхийн үүднээс хөдөлмөрийн шинэ амжилтуудыг гаргаж, үйлдвэрийн боловсон байдлыг дээшлүүлэхийн төлөө өдөр тутмын тэмцлийг явуулах нь чухал болов.

По материалам «Үнэн», 1948/49.

## С л о в а

**үйлдвэр** промышленное производство, предприятие  
**чанга** твердо, крепко; громко; громкий  
**сахих** соблюдать, придерживаться  
**үйлдвэрийн байр** рабочее место  
**эмх цэгцтэй** в порядке; налаженный  
**нягтаар** аккуратно, четко  
**ямагт** всегда  
**харилцан** взаимно связывая  
**хослох** проводить параллельно, согласованно  
**хорогдуулах** сокращать, снижать  
**шижим эд.** фактор, условие  
**дайчин** боевой  
**үйлдвэрийн газар** промышленное предприятие  
**техникч** техник; технический  
**гавшгайчууд эд.** ударники  
**үр бүтэлтэй** плодотворно  
**аар саар** небольшие, незначительные  
**дор нь** сразу, здесь же  
**засах** исправить; устранить

**буюу** или  
**заавар** указание  
**уламжлах** передавать; связываться  
**тусалцаа(н)** помощь  
**төдий чинээ(н)** настолько, столько  
**чиглэлт** направление  
**шинэ хүчнүүд** кадры  
**нэгтгэх** объединить  
**зэрэгцээгээр** наряду  
**огт** совсем  
**гар үйлдвэрийн** кустарно-промышленный  
**хоршоолол** кооперация  
**тэртээ** то; на той стороне; еще тогда  
**дотоод** внутренний  
**аж ахуйч** хозяйственник; хозяйственный  
**салшгүй** неразрывный, неотделимый  
**хэсэг** часть  
**хэтэрхий** чересчур, очень  
**хог новш** сор, хлам, отбросы  
**дарагдах эд.** быть покрытым  
**бохир** грязный; запущенный.

## ГРАММАТИКА

1. Страдательный залог (биедээ даасан үйл үг) обозначает действие, претерпеваемое предметом, например:

<b>олох</b>	найти;	<b>олдох</b>	быть найденным
<b>батлах</b>	утверждать;	<b>батлагдах</b>	быть утвержденным
<b>байгуулах</b>	организовать	<b>байгуулагдах</b>	быть организованным
<b>барих</b>	поймать	<b>баригдах</b>	быть пойманным
<b>харах</b>	видеть	<b>харагдах</b>	быть видимым

2. Суффиксами страдательного залога являются:

а) **-д**, если основа односложного глагола оканчивается на согласный **л** без необозначаемого на письме конечного краткого гласного, например:

**ол** + **д** = **олдох** быть найденным  
**сонс** + **д** = **сонсдох** быть услышанным

б) **т**, если основа производного глагола оканчивается на согласные **в, г, р, с** без необозначаемого на письме конечного краткого гласного, например:

**ав** + **т** = **автах** быть взятым  
**өг** + **т** = **өгтөх** быть данным  
**гар** + **т** = **гартах** быть обогнанным

в) **-гд**, если основа глагола оканчивается на гласный или согласный, кроме случаев, оговоренных выше, например:

**барь** + **гд** = **баригдах** быть пойманным  
**ал** + **гд** = **алагдах** быть убитым  
**биеүүл** + **гд** = **биелүүлэгдэх** быть реализованным  
**орчуул** + **гд** = **орчуулагдах** быть переведенным  
**ид** + **гд** = **идэгдэх** быть съеденным  
**хороо** + **гд** = **хороогдох** быть сокращенным

## УПРАЖНЕНИЯ

1. Переведите на монгольский язык:

- 1) Коммунистическая партия и Советское правительство всегда придавали и придают огромное значение вопросам улучшения качества продукции и снижения ее себестоимости.
- 2) Борьбу за всемерное улучшение качества выпускаемой продукции советские люди неразрывно связывают с борьбой за

бережливое, экономное расходование сырья и материалов, за повышение производительности труда. 3) На всех предприятиях ведется борьба за повышение культуры производства. 4) В нашей стране начинания передовиков поддерживаются и принимаются меры к внедрению этих начинаний на всех предприятиях. 5) Долг партийных и хозяйственных организаций, профсоюзов и комсомола — всегда быть во главе социалистического соревнования масс. 6) Массовое соревнование за отличное качество продукции дало значительные результаты. 7) Шире размах социалистического соревнования за досрочное выполнение и перевыполнение пятилетнего плана развития народного хозяйства и культуры!

## 2. Ответьте на следующие вопросы:

1) Чойбалсангийн нэрэмжит аж үйлдвэрийн комбинат хэзээ байгуулагдсан билээ? 2) Үйлдвэрийн бүтээлийг нэмэгдүүлэхийн тул ямар арга хэмжээ авах хэрэгтэй вэ? 3) Үйлдвэрийн газрууд бол боловсруулагдан батлагдсан төлөвлөгөөгөө биелүүлэхийн ба давуулан биелүүлэхийн тул юу хийдэг байна? 4) Одоо эндээс үзэгдэж байгаа байшин хэзээ баригдсан билээ? 5) Өглөө ба үдэш бүр төрийн дуулал эгшиглэхэд танайд сонсдог уу? 6) Одоо явуулагдаж байгаа уралдаанд та ямар үүрэг авсан билээ? 7) Манай ханын сонин хэзээ гаргагдах вэ? 8) Үйлдвэр дээр боловсон байдлыг байгуулах нь ямар ач холбогдолтой байна? 9) Үйлдвэр бүхэнд боловсон байдлыг байгуулах явдлыг хэн буюу ямар байгууллага удирдах ёстой вэ? 10) Таван жилийн төлөвлөөг биелүүлэх ба давуулан биелүүлэхийн тул юу хийвэл зохино?

## Повторительные упражнения

### 1. Переведите на монгольский язык:

1) Гобийцы готовятся отремонтировать и утеплить старые колодцы. 2) Для сохранения скота в холодное время года необходимо построить теплые хашаны и заготовить корма. 3) В результате того, что скотоводы хорошо подготовились к зиме, они полностью сохранили свой скот. 4) Необходимо каждый день повторять уроки. 5) Если студенты будут своевременно выполнять домашние задания, то они смогут учиться хорошо.

### 2. Ответьте на следующие вопросы:

1) Эдгээр оюутан нар бол юу хийхээр бэлтгэж байна? 2) Энэ нөхөд бол яаснаараа сайн шалгуулав? 3) Мань малчид ба ажилчид ямар арга хэмжээ авснаараа үйлдвэрийнхээ төлөвлөгөөг биелүүлж ба давуулан биелүүлж байна? 4) Хувьсгалт уралдааныг өргөнөөр дэлгэрүүлбэл ямар ач холбогдолтой байна? 5) Ямар арга хэмжээнүүдийг авбал мал аж ахуйг улам хөгжүүлж болно?

## ҮЙЛДВЭРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХУГАЦААНААС НЬ ӨМНӨ БИЕЛҮҮЛЖ ХУРИМТЛАЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХИЙН ТӨЛӨӨ

Дорноговь аймгийн хөдөлмөрчдөөс таван жилийн төлөвлөгөөний хоёр дахь жилийн төлөвлөгөөг хугацаанаас нь өмнө биелүүлж, эх орныхоо эдийн засаг, соёлын байгуулалтын бүх салаа мөчирт их амжилт гаргахаар манай орны бүх хөдөлмөрчдийг хувьсгалт уралдаанд дуудсан халуун уриа нь малчин ард түмэн, үйлдвэрийн ажилчин олны дунд өрнөн дэлгэрч, тэдний дэмжлэгийг олсоор байна.

Манай орны мянга түмэн малчин, мал өсгөх улсын төлөвлөгөөг давуулан биелүүлэхийн төлөө шургуу тэмцэж, амжилт гаргасаар байна. Үйлдвэрийн ажилчид, жилийн программаа хугацаанаас нь өмнө биелүүлэн үйлдвэрийн ажлын гүйцэтгэлийн чанарыг сайжруулах талаар шинэ үүргийг нэмэн авч байна.

Аж үйлдвэрийн комбинатын ажилчин олон нийтээс монголын ард түмний хайрт удирдагч маршал Чойбалсанд бичсэн бөгөөд 6 дугаар сарын 5-нд «Үнэн» сонинд нийтлэгдсэн илэрхийлэлт нь үүний яруу сайхан жишээ болж байна. Аж үйлдвэрийн комбинатынхан, энэ жилийн үйлдвэрийн программаа давуулан биелүүлж үйлдэхүүний чанарыг сайжруулахын хамт эдийн өөрийн өртгийг хямдруулж улам их амжилт гаргахын тул их анхаарал тавьсаар байна.

Аж үйлдвэрийн комбинатын үйлдвэрүүд хөдөлмөрийн бүтээлээ дээшлүүлэн, үйлдэхүүний өөрийн өртгийг хямдруулан, түүхий эд материал, цахилгаан хүчийг хэмнэж чадсаны үрээр энэ оны 1 дүгээр улиралд улсдаа 411 мянган төгрөгийг төлөвлөгөөнөөс гадуур хуримтлуулж өгөв.

Манай эх орны тэргүүний үйлдвэрийн ажилчид хөдөлмөрийн шинэ амжилтыг гаргаж, улсынхаа 28 жилийн ойг нэр төртэй угтаад, улмаар жилийнхээ төлөвлөгөөг давуулан биелүүлэхийн төлөө хувьсгалт уралдааныг өрнүүлж байна.

Тэднээс маршал Чойбалсанд барьсан илэрхийлэлтдээ: «Бид таван жилийн төлөвлөгөөний 2 дахь жилийн үйлдвэрийн программыг 1949 оны 12 дугаар сарын 10-ны дотор биелүүлэх үүргийг тус комбинатын 15 жилийн ойн баярын өдөр авсан билээ. Үүнд бид, энэ оны эхний 4 сарын ажлын дүн ба Бүгд Найрамдах Монгол Ард Улсын 28 жилийн ойг угтсан хувьсгалт уралдаанд гарч байгаа хөдөлмөрийн шинэ өрнөлтийг харгалзан Дорноговь аймгийн хөдөлмөрчдийн уриалгын хариу болгож нам, засаг, эх орныхоо өмнө хайрт удирдагч таны өмнө шинэ өндөр үүрэг авлаа» гэсэн билээ.

Аж үйлдвэрийн комбинатынхан эхний хагас жилийн үйлдвэрийн төлөвлөгөөг 113 хувиар биелүүлээд, жилийнхээ төлөвлөгөөг 12 дугаар сарын 5-ны наана гүйцэтгэхийн хамт жилийн эцэс хүртэл 2340 мянган төгрөгийн үйлдэхүүнийг төлөвлөсөн дээрээ илүүгээр үйлдвэрлэн гаргана гэж илэрхийлсний дээр хөдөлмөрийн бүтээлийг улам дээшлүүлэх, үйлдэхүүний чанарыг сайжруулах, өөрийн өртгийг хямдруулах, түүхий эд материалыг арвилан хэмнэх, төлөвлөгөөнөөс 1500 мянган төгрөгийн илүү хуримтлалыг олох талаар өдий төдий чухал үүргийг хүлээн авсан билээ.

Аж үйлдвэрийн комбинатынхан хүлээн авсан бүх үүргээ нэр төртэй биелүүлж улмаар давуулан биелүүлэхийг тул улам шургуу сайн ажиллах хэрэгтэй боллоо. Тэд, үйлдэхүүнийхээ төлөвлөгөөг тооны талаар биелүүлэх ажлаа, үйлдэхүүний чанарыг сайжруулах, өөрийн өртгийг хямдруулах, түүнчлэн аж үйлдвэрийн комбинатын зарим үйлдвэр дээр өнгөрсөн жил гарч байсан бөгөөд одоо ч гэсэн үзэгдсээр байгаа аж ахуйч бус байдлыг эрс устгах ажилтай нягт хослон биелүүлэх нь чухал юм.

Аж үйлдвэрийн комбинатынхны энэ жилийн гаргаж байгаа амжилт, сайхан санаачлага нь манай бүх үйлдвэр, ялангуяа одоо болтол хоцрогдсоор байгаа авто механик заводын зэрэг үйлдвэрээс таван жилийн төлөвлөгөөний 2 дахь жилийн төлөвлөгөөг амжилттай биелүүлж улмаар давуулан биелүүлэхийн бололцоотой байгааг яруу тод үзүүлж байна.

Иймд үйлдвэрийн дотоод бололцоог бүрэн ашиглаж, үйлдвэрийн тоноглол хэрэглэлийг дүүрэн эзэмшихийн хамт аж ахуйн салаа бүхэнд эдийг арвилан хэмнэж төлөвлөгөөнөөс илүү хуримтлалыг нэмэгдүүлэх хийгээд төлөвлөгөө давуулан биелүүлэхийн төлөө ажилчин олон түмний идэвхтэй тэмцлийг оргилуулан, тэдний хөдөлмөрийн санаачлагыг улам өрнүүлж, үйлдэхүүний чанарыг сайжруулан, хөдөлмөрийн бүтээлийг цаашид их хэмжээгээр нэмэгдүүлэх нь эрхэм зорилго мөн билээ.

По материалам «Үнэн», 1949.

### С л о в а

хуримтлал накопление  
уриа призыв  
нийтлэгдэх быть опубликованным  
яруу сайхан замечательный, пре-  
красный  
цахилгаан электричество; электри-  
ческий  
хүч(ин) сила, энергия  
гадуур вне  
барих эд. преподнести  
эх (эн) начало  
харгалзах принимать во внимание  
өцэс конец  
өдий төдий эд. несколько, некоторый

түүнчлэн также, подобно этому  
устгах устраничь; уничтожить  
нягт тесно  
ялангуяа особенно  
тоноглол оборудование, снаряжение  
хийгээд и  
оргилуулах вызвать подъем  
Дорноговь Восточно-гобийский  
түм(эн) десять тысяч  
дуудах призывать  
илэрхийлэлт эд. рапорт, письмо  
одоо ч гэсэн и теперь; и ныне  
яруу тод ясно, наглядно

## ГРАММАТИКА

1. Употребление имени в форме множественного числа (олон тоо) не является обязательным, если оно имеет какое-либо количественное определение, например:

<b>хоёр багш</b>	два учителя
<b>долоон гэр</b>	семь юрт

При отсутствии же количественных определений употребление формы множественного числа является необходимым, и имя в форме единственного числа (ганц тоо) оставаться не может.

2. Наиболее употребительными суффиксами множественного числа являются **-д**, **-ууд** (или **-үүд**), **-с**, **-чууд** (**-чүүд**), **-цуул** (**-чүүл**), **-нууд** (**-нүүд**), нар.

1) Суффикс **-д** употребляется в тех случаях, когда имя в единственном числе оканчивается на согласный **-н**, который при этом выпадает или является скрытым, а также на имяобразующий суффикс **-гч**, например:

<b>ажилчин</b>	рабочий	<b>ажилчид</b>	рабочие
<b>малчин</b>	скотовод	<b>малчид</b>	скотоводы
<b>дархан</b>	кузнец, мастер	<b>дархад</b>	кузницы
<b>морь (морин)</b>	конь	<b>мориэ</b>	кони
<b>хонь (хонин)</b>	овца	<b>хониэ</b>	овцы
<b>сурагч</b>	ученик	<b>сурагчид</b>	ученики
<b>ухуулагч</b>	пропагандист	<b>ухуулагчид</b>	пропагандисты

Некоторые немногие слова образуют форму множественного числа путем замены своих конечных согласных на тот же **-д**, например:

<b>түшмэл</b>	чиновник	<b>түшмэд</b>	чиновники
<b>тугал</b>	теленек	<b>тугад</b>	телята

2) Суффикс **-ууд** (или **-үүд**) употребляется, главным образом, в тех случаях, когда имя в единственном числе оканчивается на согласные, кроме **н**, и гласные, например:

<b>бичиг</b>	письмо	<b>бичгүүд</b>	письма
<b>ном</b>	книга	<b>номууд</b>	книги
<b>ард</b>	арат	<b>ардууд</b>	араты
<b>улс</b>	государство	<b>улсууд</b>	государства
<b>байгууллага</b>	организация	<b>байгууллагууд</b>	организации
<b>үйлдвэр</b>	предприятие	<b>үйлдвэрүүд</b>	предприятия

3) Суффикс **-с** употребляется в тех случаях, когда некоторые имена оканчиваются на краткий гласный, который может быть

скрытым, или дифтонг, причем в этом случае гласный **й** в составе последнего выпадает, например:

<b>үйл</b>	дело	<b>үйлс</b>	дела
<b>үг</b>	слово	<b>үгс</b>	слова
<b>уул</b>	гора	<b>уулс</b>	горы
<b>нохой</b>	собака	<b>нохос</b>	собаки
<b>гахай</b>	свинья	<b>гахас</b>	свиньи
<b>их</b>	большой	<b>ихэс</b>	большие

4) Суффикс **-чууд (-чүүд)** и **-чуул (-чүүл)** употребляются для образования слов собирательного значения, обозначающих только людей, например:

<b>бага</b>	малый	<b>багачууд</b>	дети
<b>залуу</b>	молодой	<b>залуучууд</b>	молодежь
<b>сайн</b>	хороший	<b>сайчуул</b>	передовики
<b>монгол</b>	монгол	<b>монголчууд</b>	монголы

5) Суффикс **-нууд (-нүүд)**, встречающийся сравнительно редко, употребляется в тех случаях, когда имя в единственном числе оканчивается на гласный, например:

<b>хэрээ</b>	ворон	<b>хэрээнүүд</b>	вороны
<b>даага</b>	жеребенок	<b>дааганууд</b>	жеребята
<b>сүх(э)</b>	топор	<b>сүхнүүд</b>	топоры

6) Частица **нар** употребляется только при именах, обозначающих людей, а после собственных имен имеет значение «и другие», например:

<b>багш</b>	учитель	<b>багш нар</b>	учителя
<b>ах</b>	старший брат	<b>ах нар</b>	старшие братья
<b>Сүхбаатар</b>	Сухэбатор	<b>Сүхбаатар нар</b>	Сухэбатор и другие

Примечание: Имяобразующий суффикс **-тан (-тэн, -тон, -төн)** всегда содержит в себе значение множественности (аналогичным суффиксом со значением единственности является **-т**), например:

<b>эрдэмтэн</b>	ученые	<b>эрдэмт</b>	ученый
<b>жигүүртэн</b>	пернатые	<b>жигүүрт</b>	пернатый
<b>морьтон</b>	конные	<b>морьт</b>	конный

## У П Р А Ж Н Е Н И Я

1. Переведите на монгольский язык:

1) Отличники учебы повторяют уроки. 2) В прениях выступили преподаватели и студенты. 3) Передовики промышленности и сельского хозяйства систематически выполняют и перевыпол-

няют свои производственные планы. 4) В этом кружке занимаются члены и кандидаты в члены коммунистической партии. 5) Из года в год поднимается жизненный уровень наших рабочих, крестьян и интеллигенции (сэхээтэн). 6) Улучшается учебно-воспитательная работа в наших начальных и средних школах. 7) Из года в год увеличивается число учащихся наших начальных, средних и высших школ. 8) Староста нашей группы принес нам тетради и карандаши. 9) Мой отец купил мне интересные книги.

## 2. Ответьте на следующие вопросы:

1) Таны ангид олон хүмүүс сурч байна уу? 2) Одоо уншлагын танхимд олон оюутан нар байна уу? 3) Та нарт хэдэн багш нар хичээл заадаг вэ? 4) Таны ах дүү нар ба эгч дүү нар сурч байна уу? 5) Та нар энэ хавар олон хичээлүүдээр шалгуулах уу? 6) Та, энэ жил ямар номуудыг уншив? 7) Манай орны ажилчид ба тариачид, хэзээнээс эрх чөлөөтэй болов? 8) Чиний нөхөд ямар ажил хийдэг вэ? 9) Маны орны залуучуудын зорилго нь юунд оршино? 10) Манай орны үйлдвэр ба хөдөө аж ахуйн сайчуулын туршлагыг дэлгэрүүлэх явдал бол ямар ач холбогдолтой байна? 11) Сургуулийн насанд хүрээгүй багачуудыг ямар газрууд хүмүүжүүлдэг юм бэ? 12) Монголчууд, голдуу ямар малыг өсгөдөг вэ? 13) Говийн малчид, зудаас малаа арчлахын тул ямар арга хэмжээ авдаг билээ? 14) Үгсийг сайн тогтоохын тул юу хийх хэрэгтэй вэ? 15) Аж үйлдвэрийн ба хөдөө аж ахуйн сайчуулын сайн туршлагыг яаж дэлгэрүүлдэг байна?

## Повторительные упражнения

### 1. Переведите на монгольский язык:

1) Отсюда видно, что около театра играют дети. 2) Хорошо, что он приехал. 3) То, что рабочие перевыполнили производственный план завода, является результатом соревнования. 4) То, что ты повторил урок вместе со мною, оказалось для меня весьма полезным. 5) Из газеты я узнал, что коллектив этого завода работает очень хорошо.

### 2. Ответьте на следующие вопросы:

1) Өнөөдөр илтгэл болсон нь сайн байна уу? 2) Өнгөрсөн зун өвс их бэлтгэсэн нь малаа онд сайн оруулах явдалд ямар тус хүргэв? 3) Хавар болоход цаг уурын байдал ямар болдог байна? 4) Хаврын шалгалтанд хэзээнээс бэлтгэж эхлэх хэрэгтэй вэ? 5) Шалгалтанд сайн бэлтгэвэл сайн шалгуулж, сайн ба онц сайн тэмдэг авч болох гэдгийг та мэднэ үү?

## БАГШИЙНД ОЧДОГ

Дорж багш минь чи манайхаар очиж байгаарай гэж надад хэлдэг юм. Би бол сайн өдөр бүр Дорж багшийнд очдог болов.

Дорж багшийнд байгаа шүүгээ бүрд янз бүрийн номуудыг эмхтэйгээр тавьсан байдаг. Багш минь надад элдэв сонирхолтой ном, сэтгүүлүүдийг үзүүлдэг юм. Бас ном зааж, сонирхолтой юм ярьж өгдөг. Дорж багшийн ярихад би анхааралтайгаар сонсон суудаг юм.

Дорж багш минь: «танайх хувьсгалаас урьд Цэнд тайжийнд зарцлагдаж зовж байсан юм» гэж хэлэв.

Одоогийн сайхан цагийг хувьсгалын өмнөх үетэй зэрэгцүүлэн үзэхэд огт өөр юм гэж Дорж багш хэлдэг.

Хувьсгалаас урьд ардууд уранхай хар урцан гэртэй, олон хүүхэдтэй, өмсөх идэхээр дутмаг байж, хүйтэнд даарж, халуунд шарагдаж явсан юм гэнэ.

Ардын хувьсгалаас хойш манай ардууд эрх чөлөөтэй болж жаргалтайгаар аж амьдарч байгаа бөгөөд тэдний хүүхдүүд бага, дунд, дээд сургуульд суралцаж, Монгол ардын хувьсгалт намын удирдлагын дор хүмүүжин сайн малчин, тэргүүний ажилчин, ардын сэхээтэн болоод улс орноо цаашид цэцэглүүлэхийн төлөө тэмцэж байгаа юм гэж багш минь хэлдэг.

Манай ард түмний жаргалтай аж амьдрал бол манай Монгол ардын хувьсгалт нам, засаг, Зөвлөлт Холбоот Улсын агуу их тусламжийн үр юм гэж багш минь хэлдэг.

Багшийнхаа хэлсэн юм цөмийг би ухамсартайгаар сонсож авдаг юм. Монголын ард түмэн бол өөрийн ололтуудыг ялж дийлсэн пролетарийн орны тусламжтайгаар олсон юм. Бид бол эрх чөлөөт шинэ аж амьдралаа амжилттайгаар байгуулж, жинхэнэ тэргүүний соёлыг хөгжүүлж байгаа бөгөөд эдгээр түүхт ололтуудаа баттайгаар сахин хамгаалж, их Зөвлөлт Холбоот Улсаар толгойлуулсан энх тайван ба ардчиллын лагерийн эгнээнд тэмцэх шийдвэр төгс төгөлдөр байна.

Би бол багшийн хувгүүнтэй найртайгаар тоглодог байна. Бид завтай цагаа баяртайгаар өнгөрүүлдэг юм.

Би одоо сургуульдаа түргэн очоод ирье. Чи намайг түр хүлээж байгаарай. Тэгээд бид хоёулаа манайд очно. Манайхаас гараад хоёулан баярын чимэглэл ба нийслэл хотынхоо шинэ шинэ ордон барилгыг үзье гэж миний хэлэхэд нөхөр минь «за» гэж толгой дохин зөвшөөрөв.

Сургуулиасаа ирээд, би багшийнхаа хувгүүнтэй манайд хүрээд, хотынхоо чимэглэл ба шинэ шинэ ордон барилгуудыг бахдан үзэв.

Биднийг гэр гэртээ буцах гэж байхад нэг өвгөн ирээд бидэнтэй ярилцав. Нийслэл хотынхоо ийм сайхан барилгатайг би мэдсэнгүй шүү гэж тэр өвгөн хэлэв. Тэр өвгөн бол өндөр настайгаас хотынхоо шинэ шинэ ордон барилгуудыг мэдэхгүй байгаа биз.

Бид маргааш хичээлтэйгээс удаан зугаацалгүй гэр гэртээ харив.

Би гэртээ хариж явахдаа бас нэг нөхөртэйгөө уулзав. Нөхөр минь, би танайд очиж явна гэв. Би түүнтэй гэртээ ирээд хичээлээ давтав.

## С л о в а

**сайн өдөр** выходной день, праздничный день

**эмхтэйгээр** складно, аккуратно

**тайж** тайджи (князь)

**зарцлагдах** батрачить

**зовох** страдать, испытывать бедствие

**зэрэгцүүлэх** сравнивать

**уранхай** рваный, обветшалый

**урцан гэр** лачуга

**дутмаг** нехватка, недостаток

**хөрөх** замерзать, коченеть

**шарагдах** жариться; испытывать жару

**гэнэ** говорит; говорят

**аж амьдрах** жить

**Монгол ардын хувьсгалт нам** Монгольская Народно-революционная партия

**ач гавьяа** заслуга

**дийлэх** победить

**баттайгаар** крепко, твердо, надежно  
**сахин хамгаалах** *эд.* защищать, отстаивать

**соёл** культура

**төгс** полный

**төгөлдөр** полный

**хүвгүүн** сын, мальчик

**найртай (гаар)** дружно

**манайхаас** от нас, от нашего дома

**хоёул(ан)** вдвоем

**чимэглэл** украшение

**орд(он)** дворец; здание

**толгой** голова

**дохих** кивать

**за ну, ладно**

**хүрэх** *эд.* зайти, заглянуть

**зөвшөөрөх** соглашаться

**удаан** долго

**биз** вероятно, наверное

## ГРАММАТИКА

1. Суть двойного склонения заключается в том, что некоторые падежные формы образуются не только от основы имен, но еще также и от других падежных форм. Таким образом, склоняемыми оказываются и некоторые падежные формы, формы родительного и совместного падежей.

2. От формы родительного падежа получается, путем наращивания окончания дательного-местного падежа, родительного-дательного-местный падеж, отвечающий на вопрос **хэнийд?** — у кого?; к кому?. При этом имеется в виду лишь жилище или квартира лица, обозначаемого в основе склоняемого имени.

Примеры:

**ах** старший брат

**ахын** старшего брата

**ахынд** у старшего брата, к старшему брату [на квартиру]

**багш** учитель

**багшийн** учителя

**багшийнд** у учителя, к учителю [на квартиру]

**та** вы

**таны** вас (*родит. падеж*)

**таныд, танайд** к вам, у вас [на квартире].

3. От формы родительного падежа получаются, путем наращивания частицы **-х** или **-хан**, особые притяжательно-субстантивные имена, которые обозначают принадлежность одного предмета другому предмету и могут склоняться по всем падежам на общих основаниях.

Примеры:

**фронт** фронт

**фронтын** фронта

**фронтынхон** фронтовики

**фронтынхонтой** с фронтовиками

д.чи ты

**чиний** твой

**чинийх** твой (*при опущенном определяемом*)

4. От формы совместного падежа получаются, путем наращивания окончаний соответствующих падежей, совместно-орудный, совместно-винительный и, иногда, совместно-исходный двойные падежи.

1) Форма совместно-орудного падежа чаще всего выражает обстоятельство образа действия, например:

**анхаарал** внимание

**анхааралтай** внимательный

**анхааралтайгаар** со вниманием, внимательно

**амжилт** успех

**амжилттай** успешный, имеющий успех

**амжилттайгаар** с успехом, успешно

2) Форма совместно-винительного падежа чаще всего обозначает предмет, оказавшийся объектом действия вместе с каким-либо другим предметом, например:

**багш** учитель

**багштай** с учителем

**багштайг** [кого-то] вместе с учителем: тэдгээрийг *багштайг* нь хамт урив — их пригласили *месте* с их *учителем* (т. е. и *учителя*)

**арьс** шкура

**арьстай** со шкурой

**арьстайг** вместе со шкурой; нечто, имеющее шкуру

5. Совместно-исходный падеж обозначает причинность, являющуюся следствием обладания чем-либо, например:

Өвчин	болезнь
Өвчтэй	больной; имеющий болезнь
Өвчтэйгөөс	по болезни; так как болен
Хичээл	урок, занятие
Хичээлтэй	имеет урок
Хичээлтэйгээс	так как имеет урок или занят

## У П Р А Ж Н Е Н И Я

1. Переведите на монгольский язык следующие предложения:

1) Придя к моему другу [на квартиру], я прочитал статью о Пушкине. 2) Закончив свою работу, я поеду к вам. 3) Пригласите того из них, у кого есть книга. 4) Мы закончили эту работу с помощью учеников. 5) Наш учитель сказал: «Если вы успешно сдадите экзамены, поедете в Крым». 6) Мой отец поговорил с учителем, пришедшим к нам. 7) Ввиду занятости я не могу сегодня пойти в театр. 8) Мы внимательно слушали доклад о Монгольской Народной Республике. 9) Мой товарищ в этом месяце пропустил одно занятие вследствие болезни. 10) Мы беседовали с фронтовиком.

2. Ответьте на следующие вопросы:

1) Та манайхаас гараад хаа явах гэж байна? 2) Төлөвлөгөөгөө амжилттайгаар биелүүлсэн хүмүүс одоо хаа байна? 3) Танайд ирсэн зочид хэзээ мордоно? 4) Аавындаа ирсэн охин ямар бэлэг авчрав? 5) Манайхаар ирдэг сурагч ямар сурч байна? 6) Та ямар ажилтайгаас өчигдрийн хуралд ирсэнгүй вэ? 7) Та манай сургуулийн номын сантайг мэдсэн үү? 8) Та бол таны нөхрийн хэдэн настайг мэднэ үү? 9) Та өчигдөр хэнийд очоод ирэв? 10) Танайд ирсэн оюутны эх эцэг нь хаа сууж байна?

## 28 ХОРИН НАЙМДУГААР ХИЧЭЭЛ

### БАЯРЫН ОРОЙ

Хорь орчим насны залуу багш тодхон гэрэлтэй тунгалаг тасалгааны дотор бичгийн ширээний дэргэд сууж хичээлийн контекстыг хийнэ. Түүний бичгийн ширээг хүрэн цэмбээр бүтээж, лээр нь урлаг хийцтэй чулуун хэрэглэл, төрөл бүрийн номыг эмхтэйгээр тавьжээ.

Бичгийн хэрэглэлийн дэргэд чулуун жаазтай залуу эмэгтэйн зураг эгц харж байгааг Гочоо их л ухамсартайгаар харж, хайрт түүнтэйгээ уулзах болзоот өдрөө санана.

Энэ бүсгүй бол багш Гочоогийн янаг сэтгэлт залуу бүсгүй Буян ажээ.

Гочоо бол 1941 онд багш болж 3 жил хөдөө ажиллаад одоо хотод багшилж байгаа хүн юм. Гочоо Буян хоёр 4 жилийн өмнө хотод хамт суралцаж байхдаа танилцжээ. Гочоо өнгөрсөн жилийн найман сард хотод ирэхэд нь Буян сургуулиа төгсгөөд хөдөө ажиллахаар явсан байжээ. Гочоо, Буянг чухам хаа явсныг сураглавал Өвөрхангай аймагт явсан гэдгийг түүний үерхдэг бүсгүйгээс нь дуулжээ.

Гочоо конспект хийж гүйцсэний дараагаар оросын алдарт зохиолч Толстойн бичсэн Хаджи Мурат гэдэг зохиолыг уншиж суртал байшингийн хаалга нээгдэж үеийн нөхөр Дамдин орж ирлээ.

Гочоо Дамдин нар харилцан найртайгаар уулзаж цайлсны дараа өөрсдийн уншсан сонин сайхан номуудыг харилцан ярилцаж, баяр хөгжөөнийг дэгдээн шөнийн 2 цаг хүртэл сууцгаасны дараа сая тус тусын гэртээ харьцгаав.

Маргааш нь тэнгэр цэлмэг, огторгуйд үүлгүй, намрын урихан салхи салхилна. Гочоо хичээлээ зааж төгссөний дараагаар гэртээ ирж шинэ хийлгэсэн хар даавуу костюмоо өмсөж тохитой цэврээр хувцаслаад Буянтайгаа уулзахаар гарлаа. Орой тэнгэр бүрхэж салхи шуугин гандмал газрын зөөлөн шороо хийсч, цагаан тоос бужигнасаар их л тавгүй боллоо.

Гочоо хэлэлцсэн газартаа ирж Буяныгаа хүлээж байтал яг долоон цагт Буян хүрч ирлээ.

Энэ үед салхи улам ширүүсч, нүд чихгүй шороо босч харилцан бие биеэ хүсэн мөрөөдсөн янаг хоёр залуугийн тавтай сайхан уулзаж сэтгэлийнхээ үгийг зөвлөн хэлэлцэхэд зав чөлөө өгсөнгүй. Дараагийн бүтэн сайн өдөр уулзахаар хэлэлцэж салахын үед Буяны хэлэх нь:

Би хэрэв чухал ажил гараад, ирж чадахгүй бол энэ чулуунд тэмдэг хийгээд явна шүү гэж хашааны булан дахь цагаан чулууг заав.

Гочоо, за тэгье гэж толгой дохин хэлээд гэр гэртээ харихаар явлаа.

(Төгсөөдүй)

### С л о в а

**түүвэр зохиол** избранные произведения

**тодхон эд.** ясный, яркий

**бичгийн** письменный

**хүрэн** коричневый; бордо

**бүтээх эд.** покрыть, укрыть

**урлаг хийцтэй** художественно вы-

полненный; тонко сделанный

**чулуун** каменный

**хэрэглэл** прибор, принадлежность

**төрөл бүрийн** разный, разнообразный

**эмхтэйгээр** складно, аккуратно

**жааз** рама

**эгц** прямо

**ухамсартайгаар** понимающе, проик-

новенно; сознательно

**болзоот** условленное, назначенное

**санах** вспомнить

**бүсгүй** женщина, девушка

**янаг сэтгэлт** любимый, сердечный

**сураглах** справляться, наводить справки  
**үерхэх** дружить  
**дуулах** зд. узнать, услышать  
**нээгдэх** открываться, раскрываться  
**найртайгаар** дружно, дружелюбно  
**цайлах** пить чай  
**баяр хөгжөөн** веселье, оживление  
**дэгдээх** зд. поднимать  
**сая** зд. только, после того как . . .  
**тус тусын** свои .  
**огторгуй** небо  
**үүл** облако  
**ури(ха)н** теплый; ласковый, мягкий  
**тохитой** хорошо, удобно; благоустроенный  
**хувцаслах** одеваться  
**бүрхэх** заволакиваться облаками; мрачнеть

**шуугих** шуметь, свистеть  
**гандмал** высохший; засушливый  
**зөөлөн** мягкий  
**шороо** земля, пыль  
**хийсэх** лететь, разноситься  
**тоос** пыль  
**бужгинах** подниматься  
**тавгүй** неудобно, нехорошо  
**хэлэлцсэн** зд. условленный  
**яг** ровно  
**хүрч ирэх** прийти, приехать, прибыть  
**ширүүсэх** усиливаться  
**нүд чихгүй** непроницаемый, густой  
**мөрөөдөх** желать, стремиться  
**сэтгэлийнхээ** задушевный, сокровенный  
**салах** расставаться  
**булан** угол

## ГРАММАТИКА

1. Деепричастие предела, называемое иногда совместным, обозначает действие, до момента наступления или совершения которого имеет место другое действие. Окончания: **-тал, -тэл, -тол, -төл.**

Примеры:

**ир** приходиться

**иртэл** до прихода; до тех пор, пока не придет (не пришел)

**гар** выходить

**гартал** до выхода; до тех пор, пока не выйдет (не вышел)

**ор** входить

**ортол** пока не войдет; до тех пор, пока не вошел.

2. Целевое деепричастие по существу представляет собой форму будущего причастия в форме орудного падежа и обозначает действие, являющееся целью другого действия, например:

<b>явах</b>	имеющий итти	<b>бичих</b>	имеющий писать
<b>явахгаар</b>	чтобы итти	<b>бичихээр</b>	чтобы писать

## УПРАЖНЕНИЯ

1. Переведите на монгольский язык следующие предложения:

1) Мы будем работать в библиотеке до тех пор, пока не расставим аккуратно все книги. 2) Я буду ждать тебя до 5 часов вечера в условленном месте. 3) До твоего приезда я буду чи-

тать роман «Молодая гвардия». 4) Когда мы сидели, ожидая тебя, начал идти дождь и усилился ветер. 5) Я пришел к тебе, чтобы вместе с тобою готовиться к экзаменам. 6) Мой товарищ ушел в институт, чтобы встретиться с преподавателем истории Монголии. 7) Преподаватель сказал, что каждый студент должен готовиться к экзаменам до тех пор, пока он не будет хорошо знать весь пройденный материал. 8) После того как мы выпьем чай, отправимся в читальный зал, чтобы прочитать сегодняшние газеты и новые журналы. 9) До приезда преподавателя мы будем повторять 27-й урок. 10) До наступления холодов кочевники живут на осеннем стойбище (намаржаа[н]).

## 2. Ответьте на следующие вопросы:

1) Чиний юу хийж байтал хайрт нөхөр чинь хүрч ирэв? 2) Та шөнө орой болтол юу хийдэг вэ? 3) Та одоо хүртэл оросын алдарт зохиолч Л. Н. Толстойн бичсэн ямар зохиолуудыг уншсан бэ? 4) Таны нөхөр өвлийн амралтын үед хаа явахаар байна? 5) Одоо та юу хийхээр байна? 6) Та манай дээд сургуульд орлоо хаа сурсан билээ? 7) Та нар өдөр бүр хэдэн цаг хүртэл хичээллэдэг юм бэ? 8) Та гэртээ хүртэл юугаар явдаг вэ? 9) Та энэ жилийг дуустал ямар ямар уран зохиолуудыг уншихаар төлөвлөж байна? 10) Монгол хэлийг сайн судлахаар юу хийвэл зохино?

# 29 ХОРИН ЕСДҮГЭЭР ХИЧЭЭЛ

## БАЯРЫН ОРОЙ

(Төгсгөл)

Бүтэн сайн өдрийн еглөө Гочоо эрт босож өөрийнхөө ангийн сурагчдыг цуглуулж, төрөл бүрийн үзүүлэн таниулах зураг зэргийг хадаж дууссаны дараагаар ангийнхаа сурагчдад сонирхолтой яриа ярьж, зарим сул сурлагатай сурагчдын хичээлийг давтуулсаар байгаад цагаа харвал таван цаг болжээ. Гочоо Буянтай дөрвөн цагт уулзах гэснээ санаж, тэр даруйдаа явж, болзсон газраа ирвэл юу ч үгүй ганц цагаан чулуу толбо мэт гялалзан харагдана.

Гочоо чи үнэхээр үнэнч бус хэрэг гаргав гэж бодоод чулууны дэргэд очиж үзвэл нандин гэгчийн жижиг боодолтой бичиг гарав. Гочоо бичгийг яаралтайгаар задлан үзвэл Буян хорины ардын гэрээр орж ухуулга хийхээр явсан байжээ. Гочоо Буяндаа худал хэлж хэлэлцсэн цагт очоогүйдээ ихэд гэмшиж байсан нь завшаан тохиолдож, Буян нь ажилтай болоод явсан болохоор сэтгэл нь тайвшрав. Гочоо гэртээ ирж, маргааш заах хичээлийнхээ кон-

спектыг хийж, үзүүлэн таниулах зураг зурсаар шөнө орой болтол суув.

Гочоо торгон хөнжилдөө орж тавтай сайхан унтаж сэртэл үүрийн тунгалаг туяа шилэн цонхоор нэвт тусан гийгүүлж, радиогоор: «Сонсогтун! сонсогтун!» гэж эвлэг цээл дуугаар хэлэх нь: «Гитлерийн фашистууд бууж өгөөд Зөвлөлтийн ард түмний эх орны дайн манай ялалтаар төгсөв» гэж цог жавхлан бадруулсан баярын сайхан мэдээ сонсмогц Гочоо түргэн босч гэрийн хүмүүс аав ээжтэйгээ их баярын мэдээг ярилцаж, сурагчиддаа дуулгахаар сургуулийн зүг явав.

Үүлгүй цэнхэр тэнгэр мэлтийж, түг түмэн хүний баяр хөгжлийг ивээсэн, цэлмэг сайхан өглөө, хаврын урихан салхи үлээж, тогтуухан долгионоор радиогийн хүнгэнэх дуун сонсдож, 5-дугаар сарын 9-ний өдрийг Гитлерийн Германыг бутниргэж устгасан Улаан Армийн түүхт ялалтын баярын өдөр болгосугай гэж СССР-ийн Дээд Зөвлөлийн Тэргүүлэгчдийн хүндэт зарлигийг сонсгов.

Гочоогийн сэтгэл булаг мэт оргилон баясч хайрт амраг Буянтайгаа хэчнээн их баяртайгаар уулзах болов гэж баясч явав.

Энэ өдөр Сүхбаатарын өргөн чөлөөнд баярын митинг болж оройн 7 цагт Гочоо Буянтай уулзахаар ирэхэд баярын индрийг чийдэнгийн гэрэл гийгүүлж, радиогоор баярын дуун хосолж их чөлөөнд ёслолын их буунууд ярайж сүртэй сайхан харагдаад олон хүмүүс ийш тийш сэлгүүцэн баяр хөгжил болсоор байна.

Гочоо, эртээд Буян бид хоёрыг уулзахад чухам ямар өдөр байлаа, өнөөдөр дайснаа дарсан ялалтын саруул тунгалаг өдөр байна.

Буян минь надад өнөө орой лав нэг баяртай үг хэлж өх байх гэж ихэд сэтгэл хөдлөн бодоод Буянгийн ирэх зүгийг ширтэн харж байлаа.

Удалгүй залуу бүсгүй болзоотой газраа хүрч ирлээ. Гочоо Буян хоёр урьд урьдаас илүү баясгалантайгаар уулзаж найртай сайхнаар хөтөлдөн явж, индрийн талбай дээр иртэл ёслолын их буу нижигнэн өнгө бүрийн сацралт гэрэл туяаран, Сүхбаатарын өргөн чөлөөг гийгүүлэхэд Гочоо Буян хоёр харилцан дурласан баярын цогт нүүрээ ширтэлцэн, сэтгэлийн үгээ зөвлөлдөн, Гочоо Буянгийн олон жил хэлэлгүй хадгалсан үнэнч үгийг нь сонсож хос хоёр залуу амьдралын алтан жолоог холбов.

Энэ үгүүллэгээс үзвэл Гочоо Буян хоёр танилцсаар нилээд удаж гэр бүл болсон юм байна.

По рассказу П. Хорло.

### С л о в а

**үзүүлэн таниулах** наглядный  
**хадах эд.** прибить; повесить  
**гэр даруйдаа** тотчас же  
**толбо** пятно, кружок  
**гялалзах** блестять, сверкать

**үнэхээр** действительно, истинно  
**нандин** священный  
**боодолтой** свернутый, завернутый  
**задлах** распечатать, раскрыть  
**ухуулга** агитация

гэмших расквашиваться, сожалеть  
завшаан удобный случай; удача;  
счастье  
хөнжил одеяло  
худал вранье, неправда, ложь  
сэрэх проснуться  
шилэн стеклянный  
нэвт тусах проникать насквозь  
эвлэг цээл четкий; звонкий; прият-  
ный  
бууж өгөх капитулировать  
цог жавхлан (г) великолепие, красота  
бадруулах вдохновлять  
мэдээ(н) весть, сообщение  
цэнхэр голубой  
мэлтийх блестять  
түг түмэн тысячи и тысячи; очень  
много  
ивээх покровительствовать, защищать  
тогтуухан спокойный  
хүнгэнэх греметь; говорить басом  
булаг ключ, источник, родник  
мэт подобно  
амраг любимый

хэчнээн сколько  
чөлөөн зд. площадь  
чийдэн электрическая лампа  
хослох спариваться; происходить од-  
новременно  
ёслол зд. салют  
их буу орудие, пушка  
ярайх стоять рядами  
сүртэй сайхан величавый  
ийш тийш туда-сюда  
сэлгүүцэх сновать  
эртээд в предыдущий раз, в тот раз  
лав наверняка; по всей вероятности  
сэтгэл хөдлөх волноваться; растро-  
гаться  
урьд урьдаас илүү как никогда луч-  
ше  
хөтөлдөх итти, держась рука об руку  
индэр трибуна  
нижигнэх греметь; ухать  
цогт зд. жизнерадостный, радостный  
хадгалах хранить  
алтан золотой  
жолоо поводья

## ГРАММАТИКА

Продолжительное деепричастие, образуемое при помощи окончания **-саар, -сээр, -соор, -сөөр**, в сочетании со связкой **байх** — «быть», обозначает продолжительность действия («продолжает делать то-то», «все еще делает то-то»), а в сочетании с другими глаголами — действие, с момента совершения которого продолжается другое действие («с тех пор, как...» или «как сделал то-то...»), например:

**яв** итти

**явсаар байна** продолжает итти, все еще идет

**гар** выходить

**гарсаар явав** как вышел, так сразу же пошел

**ор** входить

*Орсоор* гурван сар болов. *С тех пор, как вошел*, прошло три месяца.

## УПРАЖНЕНИЯ

1. Переведите на монгольский язык следующие предложения:

1) Когда я в выходной день рано приехал к своему товарищу, он продолжал еще спать. 2) С отстающими учениками мы продолжаем повторение пройденных уроков. 3) С тех пор как мы

познакомились, прошло 3 года. 4) С тех пор как капитулировала гитлеровская Германия, прошло много лет. 5) В парке продолжает играть музыка. 6) Тов. Найдан все еще продолжает писать книгу. 7) На улице все еще идет снег. 8) Дамдин как вошел в юрту, так сразу же узнал меня. 9) Доржи все еще находится в пути (едет).

## 2. Ответьте на следующие вопросы:

1) Таны нөхөр багшилж эхэлсээр хэдэн жил болов? 2) Гитлерийн Герман бууж өгсөөр хэдэн жил болов? 3) Та ямар сургуульд сурсаар байна? 4) Баярын ёслолд их буугаар бууддаг болсоор хэдэн жил өнгөрөв? 5) Та энэ дээд сургуульд орсоор хэдэн жил болов? 6) Та эндээс гарсаар хаа явна? 7) Манай дээд сургууль байгуулагдсаар хэдэн жил болов?

# 30 ГУЧДУГААР ХИЧЭЭЛ

---

## ШИНЭ ТӨМӨР ЗАМТАЙ БОЛСОНDOO БАЯРЛАЖ БАЙНА

Хэдэн жилийн өмнө нас барсан өвгөн аавтай минь айл аймаг нутаглаж, хамт ан гөрөө хийж явсан өвгөн Дэмчигийг хармагц хайрт өвгөн аавын минь хүрэн бор царай нь бүрэлзэн үзэгдэх шиг болоод, сэтгэл минь их л хөдлөв.

Ардын хувьсгал үүсмэгц миний хэдэн хүүхэд ардын сургууль, цэргээр хүмүүжээд одоо зарим нь цэргийн дарга, зарим нь сайн малчин, зарим нь дээд сургуульд сурч байна гэж Дэмчиг гуай хэлэв.

...Төдөлгүй цайвар хөх утаа цэнхэр огторгуй өөд оргилж галт тэрэгний айсуу нь харагдав. Төдөлгүй ойртон ирэв. Галт тэрэгний тэргүүний эгнээн дээрх их Сталин, маршал Чойбалсангийн зураг тодхон болсоор, жагсаалын дундуур орж ирмэгц угтсан олон цөм хөгжилдөн дайчин хөдөлмөрийн баатар тулалдаанд хатуужсан ах дүү Зөвлөлтийн ард түмний үнэнч хүвгүүд охидод баярыг хүргэн, харилцан хоёр талаасаа гар гараа барилцан мөндөлцгээж: «Их Сталинд ура!» «Маршал Чойбалсанд ура!» гэж тасралтгүй ура хашгиралдах нь галт тэрэгний урт цуурайтай хосолж байв. Шинэ төмөр замыг хүлээн авах баярын хурлыг нээж Зөвлөлт Холбоот Улсын ард түмэнд ба их Сталинд чин сэтгэлийн баярыг хүргэхэд ёслолын их буу нижигнэж хэдэн мянган хүний баяр жавхлангийн долгионыг улам сүртэй болгов.

Нөхөр Цэдэнбалаас баярын хурал дээр «Манай их түшиг Зөвлөлт Холбоот Улсаас их Сталины санаачлага заавраар энэ төмөр замыг манай оронд тавьсан явдал бол манай орныг хөгжүүлэх хэрэгт маш чухал үнэхээрийн үнэлж баршгүй их ач холбогдолтой бөгөөд Зөвлөлт Холбоот улсаас Монголын ард түмэнд

ах дүүгийн чин үнэнч тусламжийг харамгүй үзүүлж байгаа явдлын шинэ эрхэм алхам мөн юм гэж яруу сайхнаар дүгнэн хэлсэн үгийг би өөрийнхөө дэвтэрт тэмдглэж авав.

Өвгөн Дэмчиг энэ үгийг надаар дахин дахин хэлүүлж сайтар тогтоон аваад:

— Нутагтаа очоод айл аймгийн хүмүүст хэлж өгье гэж байв.

Өвгөн Дэмчиг бид хоёр хурал дуусмагц галт тэрэгний урт цувааг эргэн тойрон үзэж явтал төмөр замын ажилчин нэгэн эмэгтэй биднийг ах дүүгийн ёсоор хүндэтгэн уулзаад галт тэрэгний ажиллагааны тухай тодорхой сайхан ярьж өгөв. Тэгэхлээр нь өвгөн Дэмчиг жирийн нэгэн ажилч бүсгүйн эелдэг сайхан аашийг магтаж Зөвлөлтийн хүний нөхөрсөг чанарт хязгааргүй баярлав.

Бид харилцан салах болсонд өвгөн Дэмчиг тэр бүсгүйн гарыг барьж «Та бид хоёр ах дүү байна, дараа давхар баяртай уулзъя» гэж хэлсэнд тэр эмэгтэй хариу баярыг хүргээд салан явлаа. Тэр эмэгтэйн явахлаар өвгөн бид хоёр галт тэрэгний буудлаас гэрийн зүг буцаж явав. Энэ завсар өвгөнөөс: — Шинэ зам бол манай ардын мал сүргийг олон болгоход их тусыг хүргэхээр барахгүй, ардын жин тээвэрт их хөнгөлтийг үзүүлж байна. Галт тэрэг нэг ирэхдээ манай сумын нэг жилд тэмээн жингээр авчирдаг бараанаас илүү юмыг түргэн хугацаанд авчрах юм. Энэ бол Зөвлөлт Улс, Их Сталин, манай нам засаг, маршал Чойбалсангийн ач юм. Шинэ төмөр замтай болсондоо үнэхээр баярлаж байна. Энэ бол манай ард түмний баяр юм гэж ярьж явтал бидний өмнөөс Төгс угтан ирэв. Өвгөн Дэмчиг хайрт хүүтэйгээ баясгалантай уулзав.

По очерку П. Хорло.

### Слова

**найруулал** очерк; сочинение  
**айл аймаг** сосед; по соседству  
**нутаглах** жить, обитать  
**ан гөрөө хийх** охотиться  
**хүрэн бор** смуглый, загорелый  
**царай** цвет лица; облик  
**бүрэлзэх** мерещиться  
**гуай** вежливое обращение к старшим по возрасту или по положению

**төдөлгүй** вскоре  
**цайвар** беловатый  
**хөх синий**  
**утаа дым**  
**цэнхэр** голубой  
**галт тэрэг** поезд; паровоз  
**жагсаал** ряд, строй; демонстрация  
**хөгжилдөх** шуметь, веселиться  
**хатуужих** закаляться  
**үнэнч** верный, честный  
**хүвгүүд** сыновья, сыны  
**барилцах** держать, пожать  
**хашгирах** кричать; провозгласить

**цуурай** эхо; шум  
**нижигнэх** греметь  
**сүртэй** величавый; могучий  
**үнэхээрийн** действительно; действительный  
**харамгүй** щедро; щедрый; не скупясь

**тогтоон авах** запомнить  
**урт** длинный  
**цуваа(н)** колонна; эшелон  
**эргэн тойрон** кругом, вокруг  
**тэгэхлээр** когда так сделал  
**ааш** поведение; поступок  
**магтах** хвалить  
**нөхөрсөг** дружеский  
**жин тээвэр** перевозка грузов; транспорт  
**хөнгөлөлт** облегчение; льгота  
**сум(ан) эд. сомон** (административная единица)  
**тэмээн жин** караван верблюдов  
**ач** заслуга; воздаяние.

## ГРАММАТИКА

1. Предварительное деепричастие, образуемое при помощи окончания **-магц, -мэгц, -могц, -мөгц**, выражает действие, после совершения которого сразу же наступает другое («как только случилось то-то, так сразу же...»), например:

**гар** выходить

**гармагц** как только вышел

Нар **гармагц** бид явна. Мы отправимся *как только* *взойдет* солнце.

**ор** входить

**ормогц** как только вошел

Багшийн **ормогц** сурагчид *Как только* учитель *вошел*,  
босов. ученики встали.

2. Последовательное деепричастие, образуемое при помощи окончания **-ахлаар, -эхлээр, -охлоор, -эхлөөр**, обозначает действие, с момента совершения которого происходит другое (по значению это деепричастие довольно близко предварительному), например:

**гар** выходить

**гарахлаар** с выходом, как только вышел

Нар **гарахлаар** явав. Отправился *с восходом* солнца  
(*как только* *взошло* солнце).

**ир** приходить

**ирэхлээр** как только пришел, с приходом

Чамайг **ирэхлээр** би явна. *Как только* ты *придешь*, я  
пойду.

## УПРАЖНЕНИЯ

1. Переведите на монгольский язык следующие предложения:

1) Как только окончатся занятия, я пойду в читальный зал и буду там работать до вечера. 2) С восходом солнца мы выехали из города и направились в горы. 3) Как только закончу эту работу, я пойду в библиотеку. 4) Как только он ко мне пришел, мы отправились с ним в кино. 5) Мы отправимся сразу же после занятий.

## 2. Переведите устно:

1) Как только увидите голубой дым, ждите, что скоро придет поезд. 2) Как только закончим эту работу, пойдем на станцию железной дороги. 3) Сразу же после окончания торжественного собрания я вернусь домой. 4) Когда придет с собрания твой младший брат, приходите вместе с ним к нам.

## 3. Ответьте на следующие вопросы:

1) Та хичээл дуусмагц юу хийх гэж бодож байна? 2) Танай дүү дунд сургууль төгсгөмөгц ямар дээд сургуульд орох гэж байна? 3) Та нар хичээлийн тасалгаанд багшийнхаа орж ирэхлээр яадаг вэ? 4) Та хань нөхөртэйгөө уулзаад гар гараа барилцан мэндэлцгээмэгц хамгийн урьд юуны тухай ярьдаг вэ? 5) Октябрийн хувьсгал үүсмэгц манай орны ажилчин тариачны аж амьдрал ямар болсон байна? 6) Наушки — Улаанбаатар хоёрын хоорондох төмөр замын барилга төгсгөмөгц юу болсон байна?

## 3. Повторно прочитайте урок и подготовьте пересказ.

# 31 ГУЧИН НЭГДҮГЭЭР ХИЧЭЭЛ

---

## БАРИМТ

Бямба гаригийн орой билээ. «Улаан шугам» дээрх онгоцнууд далавчаа сэрийлгэн сүртэйгээр жагсжээ. Онгоцноос нилээн цаана нисэх сургуулийн сурагчдын байрын гэгээн цонхнууд гялалзан үзэгдэнэ. Түүний хажуугийн клубээс хөгжмийн дуу сонсдож байв. Энд саяхан «жинхэнэ хүний тууж» гэдэг кино гарчээ. Киног тарсны дараа сурагчдын зарим нь клубтээ үлдэж танц хийв. Зарим нь ном уншихаар уншлагын танхимд оров. Бас зарим нь унтахаар байрдаа хүрч ирлээ. Хагас сайн өдрийн орой сурагчдад нэг зэрэг унтах шаардлага өхгүй тул цэргийн чанд дэглэмт энэ байр энгийн байдалтай үзэгдэв.

Сурагч Даваасамбуу саяынхаа үзсэн киноны тухай бодолхийлж явсаар гэртээ ирэв. Түрүүлж ирсэн нөхдийн зарим нь хөнжилдөө орцгоож, зарим нь сууж, зарим нь цонх түшин зогсоод ярилцаж байв. — За та нар чинь юун тухай зөвлөлгөөг нээчихээ вэ? — гэж Даваасамбуу нөхөддөө хэлээд, хариугий нь сонсолгүй үргэлжлүүлэн: «Жинхэнэ хүний тууж» гэдэг чинь яасан сайхан кино вэ. Энэ кинод гарч байгаа нисэгч Мересьев бол ёстой хүн — зөвлөлтийн хүн юм. Сталины бүргэд ёстой мөн юм. Би эх орныхоо төлөө тэмцэхдээ Мересьевийн баатарлаг сайхан үлгэр дууриаллыг мөрдөнө гэв.

Тэгээд тэд Мересьевийн баатарлаг үйл явдлын тухай ярилцав.

Тэдний яриаг сонсож суусан түрүүч Шарав төв бөгөөд шингэвтэр дуугаар:

— Мересьев хоёр хөлгүй болоход түүний эх оронч, сталинч өндөр ухамсар нь хөл болж, Мересьев дахин байлдахаар байлдаанд орж, агаарт амжилт олж байсныг энэ кино үзүүлж байна.

Ер нь зориг, баатарлаг явдал нь хүний биеийн том жижиг, бяр чадлаас болдог биш, эх оронч, улс төрийн өндөр ухамсраас гардаг байна гэхэд, нэг сурагч үгүүлрүүн:

— Нээрээн тийм шүү. Жишээ нь манай багш нисэгч нөхөр Нямаа бол жижигхэн биетэй, тургүй хүн, гэтэл 1945 оны байлдаанд их мундаг байлдсан шүү дээ гэв. Хөнжлөө нөмөрч нүдээ аниад, нөхдийнхөө яриаг чагнаж хэвтсэн сурагч Бат:

— Би нэг зүйлийг асууя гэж нөхдийнхөө анхаарлыг татах гэсэн боловч нөхөд нь яриандаа болоод анзаарсангүй. Бат өндийж ирээд:

— Нөхдөө би нэг зүйлийг асууя, энэ бол багш нисэгч Нямаагийн тухай юм. Нямаа багшийг бурханд сүсэглэдэг гэж зарим хүн ярьдаг. Энэ үнэн үү? гэв. Энэ асуулт гарахад цөм чимээгүй болов. Даваасамбуу босож Бат руу хараад:

— Цаадахь чинь зүүдэлж байх шив дээ гэж нөхөддөө хэлээд: өвгөөн сэр! — гэж Батыг дуудав. Гэтэл өөр нэг сурагч үгүүлрүүн:

— Багш нисэгч Нямааг шүтлэгтэй гэж би бас дуулсан юм байна гэхэд, бас нэг сурагч:

— Би бас ч бас тэгэж боддог гэж хэлэв. Цонх түшин зогссон нэг сурагч толгой сэгсрэн: — Багш нисэгч Нямаа, манай эвлэлийн дугуйланд СССР-ийн Коммунист намын түүх заадаг. Тэгээд ер нь шүтлэгтэй гэж үзэх аргагүй хүн байгаа юм. Би л хувьдаа итгэхгүй байна гэв.

Даваасамбуу үгүүлрүүн:

— Зүйтэй. Би ч бас итгэхгүй байна. Нямаа багш байтугай, түүний ээж жар шахсан авгай бий. Тэр авгайтай би их танил юм. Нэр нь Дулмаа гэнэ. Дулмаа гуай, олон зүйлийн чухал юмыг над ярьж өгдөг юм. 1922 онд намд элссэн. Нийслэлийн нэг гар үйлдвэрт хорин долоон жил хөдөлмөрлөсөн тийм хүн. Хоёр одонтой гурван медальтай. Тэгээд яах аргагүй шударга, намч зарчимтай хүн билээ.

\* \* \*

Энэ хичээлийг сайн ойлгож тогтоохын тул хэдэн удаа давтаж унших хэрэгтэй. Ард түмнийхээ эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэгч эх оронч нар бүхэн «жинхэнэ хүний тууж» гэдэг кино сонирхон үзэв. Мересьевийн баатарлаг үйл хэргийг ойлгохын тул зөвлөлтийн эх оронч чанарыг мэдэх хэрэгтэй.

бямба суббота  
гариг день недели  
онгоц лодка, корабль, судно, пароход;  
    самолет  
далавч крыло  
сэрийлгэх приподнять; оттопырить  
цаана дальше; за, по ту сторону  
нисэх летать  
гялалзах сверкать, блестять  
хажуугийн находящийся рядом; бо-  
    ковой  
сонсдох доноситься; быть слышимым  
тууж повесть  
хагас сайн өдөр под выходной день,  
    субботный день  
чанд крепкий, твердый  
дэглэм режим; регламент; распорядок  
энгийн обычный, обыкновенный  
бодолхийлох думать  
түших опираться  
нээчих открывать  
нисэгч летчик  
бүргэд орел; сокол  
үлгэр дууриалал пример, подражание  
мөрдөх последовать; следовать  
түрүүч сержант  
шингэвтэр жидковатый; тошкий  
ухамсар сознание  
ер вообще  
эориг воля; смелость

бие тело, организм  
бяр чадал сила, мощь  
үгүүлрүүн сказал  
нээрээн действительно; на самом деле  
тургуй щуплый, тощий  
мундаг здорово  
нөмрөх укрываться, накидывать  
    (что-л.) на себя  
аних смыкать; закрывать [глаза]  
чагнах слушать  
анзаарах обращать внимание  
өндийх приподняться  
бурхан бурхан (изображение буддий-  
    ского божества)  
сүсэглэх верить, веровать  
руу *послелог* в, к, на  
цаадахь находящийся за..., по ту сто-  
    рону  
зүүдлэх видеть сон  
өвгөөн эд. дружнице  
шүтлэгтэй верующий  
сэгсрэх трясти  
хувьдаа лично  
зүйтэй верно, да, правильно  
шахах приближаться; почти  
авгай тетя  
танил знакомый  
элсэх вступить  
намч зарчим партийность  
тогтоох эд. запомнить; выучить

## ГРАММАТИКА

1. Деепричастия и причастия вместе с зависящими от них сло-  
вами образуют соответственно деепричастные и причастные обо-  
роты, значение которых в монгольском языке очень велико. Дело  
в том, что в монгольском языке эти обороты употребляются как  
бы вместо придаточных определительных и подчиненных предло-  
жений и именных оборотов, которых в этом языке нет (за исклю-  
чением некоторых отдельных типов построения фразы), например:

*Одоо энд сууж байга* багш ха-  
наас ирэв?

Откуда прибыл учитель, *кото-  
рый сидит здесь* (теперь здесь  
сидящий)?

В этом примере мы имеем причастно-определительный оборот,  
соответствующий русскому придаточно-определительному пред-  
ложению или причастному обособленному обороту.

*Одоо энд бороо орж байсныг*  
тэдгээр мэдэхгүй байх.

Они не знают о том, что *теперь  
здесь идет дождь*.

Здесь мы имеем такой причастный оборот, который соответ-  
ствует русскому придаточно-подчиненному предложению.

*Чиний хотоос ирснийг би энэ* О твоем прибытии из города  
багшаас мэдэв. (о том, что ты прибыл из го-  
рода) я узнал от этого учи-  
теля.

Здесь мы имеем такой причастный оборот, который соответствует русскому придаточно-подчиненному предложению или именному обороту.

*Маргааш цас орвол* маш их *Если завтра выпадет снег,* бу-  
хүйтэн болно. дет очень холодно.

В этом предложении мы находим условно-деепричастный оборот, соответствующий русскому условно-придаточному предложению или именному обороту условности.

2. Деепричастные и причастные обороты в монгольском языке строятся так же, как и предложения вообще в том смысле, что в составе своих оборотов деепричастия и причастия занимают последнее по порядку место. Характерной особенностью этих оборотов является то обстоятельство, что они имеют или могут иметь свои самостоятельные подлежащие, чего нет в подобных оборотах в русском языке. Подлежащие причастных и деепричастных оборотов в монгольском языке ставятся в родительном, винительном или иногда именительном падеже, например:

<i>чиний</i> (или <i>чамайг</i> ) ирвэл	если <i>ты</i> придешь (в случае твоего прихода)
<i>бороо</i> ороход	когда пойдет <i>дождь</i>
<i>нар</i> гарахад	когда взойдет <i>солнце</i> (при восходе солнца)
<i>чиний</i> явсан зам	дорога, по которой <i>ты</i> проходил ( <i>тобою</i> пройденная дорога)

Об употреблении падежей для оформления подлежащего причастных и деепричастных оборотов в самых общих чертах можно сказать следующее:

а) подлежащее причастного и деепричастного оборота ставится в форме именительного падежа, если оно выражается именем, обозначающим явления природы (дождь, снег, солнце, ветер и т. п.), например: *цас* их болбол — если *снега* будет много;

б) подлежащее причастного оборота ставится в форме родительного падежа, если такой оборот является определительным, например: *чиний* авсан ном — книга, которую взял *ты*;

в) если причастный или деепричастный оборот является в предложении обстоятельственным или дополнительным, то его подлежащее ставится в форме винительного падежа, например: *чамайг* ирэхэд — когда пришел *ты*;

г) если подлежащее определительного причастного оборота обозначает деятеля, то оно часто выражается именем в форме исходного падежа, например: *Чойбалсангаас* бичсэн зохиол — сочинение, написанное *Чойбалсаном*.

3. Если же исполнителем действий, выраженных как причастием, так и «главным» сказуемым является одно и то же лицо или предмет, т. е. если предложение с причастным оборотом имеет только одно подлежащее, а другое и не подразумевается, то такое подлежащее ставится в форме именительного падежа, но зато причастие сопровождается частицей безличного или возвратного притяжания, например:

Чи маргааш тосгонд *явахдаа* Энэ миний захиа бичиг авачна уу? Когда ты завтра *отправишься* в деревню, то не возьмешь ли вот это мое письмо?

Энэ багш хаа *явсн(ыг)аа* ярив. Этот учитель рассказал о том, где [он] *был*.

Важно при этом заметить, что если в русском языке подлежащее как бы «дублируется» (в первой части сложного предложения каким-нибудь именем, а во второй — местоимением «он»), то такое «дублирование» в монгольском языке не допускается, как это видно из приведенных примеров.

4. Причастный оборот, являющийся определительным, всегда ставится перед своим определяемым именем, например:

*чиний тосгоноос авчирсан* юм вещь, которую ты привез из *дерезни* (привезенная тобою из деревни)

*миний нөхрийн уншсан* ном книга, которую прочитал мой *товариц* (моим товарищем прочитанная)

*манай багшийн сууж байгаа* дом, в котором живет наш *байшин* *учитель*

5. Причастные и деепричастные обороты в предложении почти всегда располагаются впереди всей остальной части предложения и никогда не ставятся в конце всего предложения. Так как в предложениях с подобными оборотами «главное» подлежащее ставится перед последними, то в таких предложениях в самом начале очень часто находят сразу два подлежащих: первое, принадлежащее «главной» части предложения, а второе — причастному или деепричастному обороту. Сказанное можно пояснить следующим правилом перевода с русского языка на монгольский сложных предложений с придаточно-подчиненными предложениями:

- а) сначала перевести главное подлежащее с его определениями,
- б) затем перевести подлежащее придаточно-подчиненного предложения,
- в) потом перевести все придаточно-подчиненные предложения и, наконец,
- г) всю остальную часть главного предложения.

Пример:

Когда наш учитель прибыл из Бид багшийнгаа хотоос ирэхэд города, мы все вышли встречать. бүгдээрээ угтан гарав.

## УПРАЖНЕНИЯ

### 1. Переведите на монгольский язык следующие предложения:

1) Когда ты в субботу приедешь к нам, то привези мне интересную книгу. 2) Мой товарищ рассказал о том, что он сделал в выходной день. 3) Дом, в котором живем мы, построен в прошлом году. 4) Студент, который сидит около окна, приехал из Монгольской Народной Республики. 5) Когда я был в деревне, я прочитал эту книгу. 6) Когда я был в деревне, мой товарищ отдыхал в Крыму. 7) О твоём приезде из Крыма я узнал от твоего товарища. 8) Я прочитал книгу, написанную писателем М. Шолоховым. 9) Я приехал по той дороге, по которой обычно приезжаешь ты. 10) Дом, в котором будет торжественное заседание, находится в центре города.

### 2. Ответьте на следующие вопросы:

1) Одоо хичээлийн ангийн нарийн бичгийн даргатай ярьж байгаа хүн хаанаас ирэв? 2) Өчигдөр энд ямар хурал болсныг та мэднэ үү? 3) Өнөөдөр манай дээд сургуульд кино гарвал та үзэх үү? 4) Энд хурал болж байхад чи юу хийж байв? 5) Чи сургуульдаа ирж явахдаа юу үзэв? 6) Чамайг энд ирэхэд сургуулийн байшингийн дэргэд оюутан нар юу хийж байв? 7) Маргааш цас орвол чи цанаар явах уу? 8) Та зөвлөлтийн зохиолч А. Толстойн бичсэн ямар зохиолуудыг уншив? 9) Чи унтахдаа зүүдэлдэг үү? 10) Та бол сэрсээр босдог уу?

### 3. Приготовьте пересказ урока.

## БАРИМТ

*(Өмнөхийн үргэлжлэл)*

«Хүү минь чи шашны тухай ном дээрээс уншиж, хичээл, лекцээр сонссон. Гэвч шашин гэдэг юу вэ гэдгийг жинхэнэ биеэрээ амсаж мэдээгүй өсжээ. Би бол насныхаа тал хувийг бурханд мөргөж, ламд залбирч өнгөрүүлэв. Хонь малыг идчихдэг болохоор нь хүн, чоныг устгах гэж тэмцдэг. Чоно бол хонь малыг барьж иддэг дайсан юм гэдгийг мэддэггүй хүн байвал тэр хүнд чонотой тэмцэх ёстой занал төрөхгүй шүү дээ! Тиймийн тул шашин гэдэг юу байсан юм бэ гэдгийг арьс махан дээрээ туршиж үзсэн хүн — миний яриа чамд хэрэг болно» гээд Дулмаа гуай, шашны хор холбогдлын тухай олон зүйлийг над ярьж өгсөн юм.

Ийм эхийн хүмүүжүүлсэн хүүд мухар сүсгийн өчүүхэн ч гэсэн хэлтэрхий байна гэдэгт би итгэхгүй гэж хэлэв.

— Тийм юм, үнэхээр итгэхэд бэрхтэй зүйл байна гэж нэг сурагчийн хэлэхэд, бас нэг сурагч үгүүллрүүн:

Тийм нь ч тийм юм. Гэвч баримт бол арчигдашгүй зүйл байдаг... гэхэд, түүний яриаг таслан:

За ямар баримт байна? гэж Даваасамбуу яаран асуув. Нөгөө сурагч:

— Баримт байна. Жишээлбээл... гэтэл нь хаалга нээгдэж, намхан нуруутай, туранхайвтар боловч шалмаг маягийн нэг дэслэгч орж ирэв.

Дэслэгч:

— Сайхан амарцгааж байна уу? гэж бүгдэд мэндлээд,— За ямар баримтын тухай шуугилдав? Яриагаа үргэлжлүүлэхгүй юу? гээд, сурагчдынхаа тавьж өгсөн сандальд суув.

Энэ хүн бол тэдний саяын ярилцаж байсан багш нисэгч Нямаа мөн байжээ.

Сурагчид, багшийнхаа асуултад хариуг өгч чадахгүй хэдэн минут дуугүй суув. Гэтэл Даваасамбуу арга олж:

— Энд, саяын гардаг киноны тухай ярилцав. Баатарлаг явдал нь чухам юунаас гардгийг шүүмжлэн хэлэлцэв. Гэтэл манай нэг нөхөр «сүсэг бишрэлийн явдал нь хүнд зоригжлыг өгдөг учир байна уу?» гэдэг асуултыг тавив. Тэгээд бид, энэ асуултад зохистой хариугий нь өх гэж шуугилдаж байсан юм гэв.

Сурагч Даваасамбуугийн энэ товчхон яриа над руу чиглэж байна гэдгийг Нямаа өөрөө тэр дор нь мэдэв. Учир нь сурагчдын дотор өөрий нь сүсэг бишрэлтэй гэж эргэлзэн бодох явдал байна гэдгийг Нямаа өөрөө урьд өмнө нь гадарлаж явсан байжээ. Тэгээд Нямаа жаахан бодосхийснээ, үгүүллрүүн:

— Сүсэг бишрэл нь хүнд ямар нэг зоригжлыг өгч чадахгүй. Чадахгүйгээр ч барахгүй, мухар сүсэгтэй хүн нь бурхнаас өх хувь заяа гэдэгт итгэж найдаад, ямар ч тэмцэлгүй, үхээнц дорой амьтан болдог юм гэж хэлэв.

\* \* \*

Манай нисэгчид бол зөвлөлтийн эх оронч үзлээр хүмүүжигдсэн учир ялагдашгүй юм. Энэ учраас манай нисэгчид бол эх орны байлдаанд дайсны нисэгчдийг ялсан юм.

«Бид хүчтэй тул манай Оросын буу ялагдашгүй» гэсэн Суворовын гэрээсийг манай байлдагчид санаж явдаг.

Коммунист нам бол манай ард түмнийг зөвлөлтийн эх оронч үзлээр, коммунизмын үзлээр хүмүүжүүлдгээс Зөвлөлтийн хүмүүс бол эх орны байлдаанд ялсан бөгөөд одоо энх тайван үеийн бүтээн байгуулах хөдөлмөрт хамгийн сайхан үлгэр жишээ үзүүлж байна. Манай Зөвлөлтийн ард түмэн бол коммунист намын удирдлагын дор баатарлагаар ажиллаж байгаагаас бүх төлөвлөгөөгөө хугацаанаас нь урьд биелүүлдэг юм.

(Төгсөөдүй)

## С л о в а

**шашин** религия  
**амсах** зд. испытывать; попробовать, отведать  
**тал хувь** половина  
**мөргөх** зд. молиться  
**лам** лама (*буддийский монах*)  
**залбирах** молиться; веровать  
**идчих** скушать, съесть;  
**чоно** волк  
**занал** зд. мщение  
**төрөх** зд. появляться, возникать  
**арьс(ан)** кожа, шкура  
**турших** испытывать, пробовать  
**хор холбогдол** вред  
**мухар сүсэг** суеверие  
**өчүүхэн** ничтожный, незначительный, маленький  
**хэлтэрхий** осколок; крупинка  
**үнэхээр** действительно, истинно  
**баримт** данные; довод, доказательство, основание; факт  
**арчигдашгүй** неопровержимый; упрямый  
**таслах** зд. прервать  
**намхан** невысокий

негөө другой  
жишээлбэл например  
нуруу(н) спина; рост  
туранхай(втар) худой, худошавый  
шалмаг проворный  
дэслэгч лейтенант  
дуугүй молча, безмолвно  
сүсэг бишрэл вера, набожность  
зоригжил смелость, решимость  
асуулт вопрос  
зохистой подходящий  
хариу ответ  
чиглэх направляться  
эргэлзэх сомневаться; недоумевать  
гадарлах зд. догадываться  
жаахан зд. немного; недолго  
бодосхийх думать  
найдах надеяться, уповать  
үхээнц дорой беспомощный; забитый  
амьтан зд. существо  
үзлээр в духе  
буу ружье, оружие  
бүтээн байгуулах созидательный

## ГРАММАТИКА

1. Прошедшее причастие в исходном падеже выражает действие, оказавшееся причиной другого действия, причем такое причастие очень часто сопровождается глаголом **болж**, например:

Гадаа их цас *орсноос болж* зам Не стало видно дороги *из-за*  
харагдахгүй болов. *того, что* на улице *выпало*  
много снега.

Би одоо сониныг *уншсангүйгээсээ* тэнд юу *болж* байсныг *Так как* я сегодня *не читал*  
огт мэдэхгүй. газету, то не знаю, *что* там  
*происходит.*

2. Иногда причинность выражается формой дательного падежа, в которой ставится соответствующее причастие, например:

Чиний *ирсэнд* би их баярлав. Я очень обрадовался тому, *что*  
ты *приехал* (твоему приезду).

3. Если после причастия в форме исходного падежа имеются такие слова, как **урьд** — прежде, **хойш** — после, **гадна** — кроме и т. п., то причинность отсутствует, например:

хүйтэн болсноос *хойш* *после* наступления холодов  
тэр ном уншнаас *гадна* *кроме* чтения той книги

4. Если после причастия, данного в форме исходного падежа, следует какое-либо качественное имя, то оно обозначает действие, с которым качественно сравнивается какое-либо другое действие, например:

Уулаар *явснаас* голоор явсан *Лучше* итти по реке, *нежели*  
дээр. по горе.

## У П Р А Ж Н Е Н И Я

1. Переведите на монгольский язык следующие предложения:

1) Сегодня в читальном зале нашего института будет лекция о коммунистическом воспитании трудящихся. 2) Я прочитал статью о борьбе за мир, демократию и социализм. 3) Я очень обрадовался, увидев летчика, прилетевшего из Монголии. 4) Слушая радио осенью 1945 года, я узнал, что наши войска разгромили армию империалистической Японии. 5) Так как я сегодня не был в институте, я не знаю, на какое число назначено собрание. 6) Магазин, находящийся около нашего дома, закрыт вследствие ремонта. 7) Сегодня Дамдин не пришел на занятие из-за болезни. 8) Так как я сегодня приехал в институт рано, то не

купил сегодняшнюю газету. 9) Лучше заниматься в этой комнате, чем в 32-й аудитории. 10) Поезд опаздывает из-за снежных заносов. 11) Мне не выдали книгу потому, что я не вернул книгу, взятую раньше.

## 2. Ответьте на следующие вопросы:

1) Энэ сурагчид ямар учраас нисэгч Нямааг шүтлэгтэй гэж бодов? 2) Та ямар шалтгаанаас өнөөдөр хичээлд хожимдов? 3) Хувьсгалаас урьд ажилчин тариачны байдал ямар байснаас тэдний үр хүүхэд дээд сургуульд сурдаггүй байсан билээ? 4) Ямар учраас хүмүүс чоныг устгах гэж тэмцдэг билээ? 5) Таны дэргэд суудаг оюутан нар юунд ярьж суудгийг та мэднэ үү? 6) Сонирхолтой юм ярьж өгсөнд чинь би их баярлав гэж хэн хэлэв? 7) Дэмий ярьснаас сайн ном уншвал дээр гэж та мэднэ үү? 8) Ямар учир шалтгаанаас зарим оюутан нарын сурлага сул байна? 9) Юуны тул хичээл давтах хэрэгтэй вэ? 10) Их юм мэдэхийн тул яавал зохино?

## 3. Приготовьте пересказ урока.

# 33 ГУЧИН ГУРАВДУГААР ХИЧЭЭЛ

## БАРИМТ

*(Өмнөхийн үргэлжлэл)*

Дэслэгчийн яриаг зогсохын хамт нэг сурагч үгүүлрүүн:

— Би анх цэрэгт ирэхдээ багаасаа хэдүүлээ мордлоо. Гэтэл бидний нэг нөхрийн хүзүүнд даавуугаар бүрж шидсэн сахиус байсан юм. Бид түүнийг «сахиуст» гэж нэрлээд, мухар сүсэгтэй хүн гэж үздэг болов. Гэтэл тэр нь үнэндээ сүсэгтэн биш байжээ... гэтэл нь дэслэгч, түүний үгийг таслан:

— За тэгээд тэр сахиус нь ямар шүү юм байсан бэ? гэж асуугаад, хариугий нь сонсож амжилгүй, цамцныхаа өврөөс торгон эдээр боож шидсэн нэг зүйлийг гаргав. Тэр нь яг сүсэгтэн хүний зүүдэг сахиус шиг юм байв. Тэгээд дэслэгч: — Миний энүүн шиг л юм байсан уу? гэж асууж өнөөх зүйлээ сурагчдад үзүүлэв.

Сурагчид, дэслэгчийн гар дахь зүйлийг үзцэгээгээд, «баримт», «баримт» гэж шивнэлдэн, сэмхнээр бие биеэ нударцгаав.

Өнөөх сурагч дэслэгчийн асуултад баахан дүгдэрсхийж:

— Тиймээ... бараг... ер нь л иймэрхүү юм байсан гэж хариулав.

Иймэрхүү явдал тохиолдож болох юм. Би нэг явдлыг ярья гэж дэслэгчийн хэлэхэд, сурагчид сандлаа дэслэгчид ойртуулан

сууцгааж, унтахаар хэвтсэн нь өндийж чагнав. Дэслэгч үгүү-  
лрүүн:

— 1945 оны байлдааны үе билээ. Нэг өдөр би агаарын байл-  
даанд дайсны нэг онгоцыг сөнөөгөөд, байлдаж явтал миний онгоц  
шатаж эхлэв. Доошоо үзээл, шатаж байгаа онгоцоо чиглүүлчих-  
мээр ашигтай зүйл үзэгдсэнгүй. Тэгээд би парашютаа хэрэглэн  
буув. Газарт буухтай минь зэрэг, чихний хажуугаар сум исгэрэн,  
буу тас хийв. Золигийн японууд буудаж байна. Японы хайгуулын  
хэдэн цэрэг миний буухыг хараад над руу давшжээ. Тэд зургуулаа.  
Бас хөнгөн пулемёттай. Би ганцаараа. За ингээд тулалдах болов.  
Тулалдаан хорин минут үргэлжлэхэд, би дайсны хоёр цэргийг  
устгав. Миний сум цөөрөв. Сум цөөрснийг минь мэдсэн юм шиг  
японууд над руу улам ширүүн галлав. Зүүн гар минь шархтав.  
Би, нэг аятайхан хонхорт хориглосон юм. Үлдсэн дөрвөн япон,  
намайг амьдаар барих гэж байгаа нь илэрхий болов. Тэд миний  
хориглосон хонхрыг тал дугуй маягтайгаар бүсэлж, бага багаар  
мөлхөн ахиж байна.

Шарх тэсгэлгүй өвдөж, бие чичирч эхэлсэн боловч дайсныг  
үзэн ядах хорсгол минь, түүнээс илүү намайг өвтгөв. Дайсны  
хөнгөн пулемёт аягүй л бол авчих гээд тун сүрхий галлаж байна.  
Би шүдээ зууж, шархаа боов. Сумаа тоолж үзвэл дөнгөж тавхан  
үлджээ. Хонхорт өнгийсөн бүхэнд нь нэг сум зарцуулна. Хэрэв  
болохгүй бол хутгаар байлдана гэж шийдээд, хутгаа гаргаж дэр-  
гэдээ тавив. Тэгээд сумкдээ байсан зүйлүүдийг шатааж устгав.  
Тэгээд эвлэлийн гишүүнийхээ батлахыг авахад гар минь чичирч  
байсан билээ. Эвлэлийн батлахтай минь хамт, анх мордоход ээ-  
жийн минь өгсөн энэ зүйл гарч ирэв гээд дэслэгч өнөөх торгонд  
боож шидсэн зүйлээ сурагчдад дахин үзүүлэв.

\* \* \*

Нисэгч Нямаагийн яриаг сонсон суулцаж байсан сурагчид  
чимээ аниргүй байв. 1945 оны байлдаанд биеэрээ оролцсон дэс-  
лэгчийн яриаг энд байлсан сурагчид их сонирхолтойгоор сонсов.

Чи номын сангаас ном авахдаа монгол сонин авалцаарай. Тэн-  
дээс ирээд чи надтай хичээл давталцаарай.

Бямба гаригт чи надтай кино үзэлцээрэй.

Та ханын сонин гаргалцаарай.

(Төгсөөдүй)

### С л о в а

**баг низовая административная еди-  
ница**

**хэдүүлээ** несколько (человек)

**мордох** отправиться в путь

**хүзүү(н)** шея

**бүрэх** обшивать

**шидэх** эд. пришивать, обшивать

**сахиус(ан)** талисман, амулет

**амжилгүй** эд. не дожидаясь

**өвөр** эд. карман; пазуха

**шивнэлдэх** шептаться; говорить шопотом

**нудрах** бить, ударить кулаком

**дүгдэрсхийх** запинаться

**өндийх** приподняться; поднимать голову  
**амьхнээр** тихо; крадучись  
**чагнах** слушать, внимать  
**сөнөөх** уничтожать, истреблять; сбить  
**шатах** гореть, сгорать; пылать  
**доошоо** вниз  
**чиглүүлчих (чиглүүлэх)** направлять  
**ашигтай** полезный; подходящий  
**буух** сойти; слезать; ниспадать, нисходить; спускаться, опускаться  
**сум(ан)** эд. пуля  
**исгэрэх** свистеть  
**тас хийх** трещать  
**золиг руг.** чорт, дьявол  
**буудах** стрелять  
**хайгуул** разведка, дозор  
**зургуулаа** вшестером  
**хөнгөн** легкий  
**ганцаараа(н)** один  
**тулалдах** сражаться  
**цөөрөх** уменьшаться (количественно)  
**галлах** открывать огонь, стрелять  
**зүүн** левый; восточный  
**шархтах** быть раненым  
**аятайхан** удобный

**хонхор** ложбина, овражек  
**хориглох** эд. укрыться, скрыться  
**амьдаар** живым, живьем  
**барих** эд. задержать, взять  
**тал дугуй** полукруг  
**бүслэх** окружать; оцеплять  
**мөлхөх** ползать  
**шарх(ан)** рана  
**тэсгэлгүй** невыносимо, нестерпимо  
**өвдөх** болеть; саднить  
**чичрэх** трепетать, дрожать  
**хорсгол** гнев, злоба  
**аягүй л бол** если допустить оплошность  
**авчих** взять; сразить  
**шүд(эн)** зуб  
**зуух** стиснуть  
**боох** перевязывать, забинтовывать, обвязывать, завязывать  
**тоолох** считать  
**дөнгөж** только всего, всего лишь  
**өнгийх** приподняться; поднимать голову  
**хутга** нож, ножик; кинжал  
**шийдэх** решать; решиться  
**батлах** эд. билет (членский)

## ГРАММАТИКА

1. Совместный залог обозначает действие, которое совершается кем-либо совместно с другим лицом, главным исполнителем или зачинателем данного действия, например:

**Би** чамтай тосгонд *гаралцана*. **Я** *отправляюсь* в деревню *вместе* с тобою.

**Чи** тэр тэргэнд *суулцаад* яв. **Подсядь** на ту телегу (подразумевается, что на той телеге кто-то уже сидит).

2. Иногда совместный залог показывает, что какое-либо действие совершается как бы попутно или одновременно с другим действием, например:

**Чи** гэдрэгээ *харалцаж* яв. **Посматривай** *и назад* (подразумевается: не только вперед).

3. Изредка совместный залог показывает, что попутным оказывается не какое-либо действие, как в предыдущем случае, а предмет, например:

**Тосгонд** явахдаа тэр ном *авалцаарай*. **Когда** поедешь в деревню, то *прихвати с собою* и ту книгу (подразумевается: наряду с другими вещами).

4. Суффиксом совместного залога является **-ли**, например:

**яв** итти  
**ор** войти

**явалиц** итти вместе с кем-л.  
**оролц** входить с кем-л.; участвовать

## У П Р А Ж Н Е Н И Я

1. Переведите на монгольский язык следующие предложения:

1) Лейтенант целый час рассказывал нам о боях и победах наших войск в 1945 году. 2) Монгольская Народно-революционная армия в 1945 году приняла активное участие в разгроме основных вооруженных сил империалистической Японии. 3) На этом собрании присутствовал директор нашего института. 4) Я поеду к вам вместе с тобою. 5) Ты помоги нам закончить эту работу. 6) Тебе нужно присутствовать на этом собрании. 7) Когда пойдешь в библиотеку, то прихвати эту книгу и сдай в библиотеку. 8) Сегодня будем обсуждать доклад товарища Дамдина. 9) Товарищ Доржи поедет в Крым вместе с учениками средней школы. 10) Дулма приехала к нам вместе с моей старшей сестрой.

2. Ответьте на следующие вопросы:

1) Өнөөдөр тантай хамт хэн ирэлцэв? 2) Оюутан нарын хуралд ямар асуудал хэлэлцэв? 3) Оюутан нарын хуралд хэн суулцав? 4) Чи надтай театрт оролцох уу? 5) Чи аавтайгаа тосгонд явалцах гэж байна уу? 6) Та нар эх эцгийнхээ ажилд тусалцаж уу? 7) Чи амралтанд явахдаа хавар намрын дээл авалцах уу? 8) Танай үдэшлэгт хэн байлцаж вэ?

3. Приготовьте пересказ урока.

# 34 ГУЧИН ДӨРӨВДҮГЭЭР ХИЧЭЭЛ

## БАРИМТ

(Төгсгөл)

— Ер нь хүний ухаан бодол нь агшин зуур мянган хэрэг, түмэн явдлыг бодож амждаг шүү дээ гээд дэслэгч үргэлжлэн ярьсан нь:

— За тэгээд, ээж минь бодогдов. Ээж минь намайг үдэх гэж аэродром дээр ирээд, уйлсан ч үгүй, харин их ууртай юм шиг ширүүн байдлаар надад хандаж: «Эх орон чинь, эх болсон би чинь чамайг энхрийлж, хайрлаж өсгөсөн. Аав чинь арван нэгэн

онд өнөөгийн жаргалант сайхан амьдралыг чамд олж өх гэж байлдан тэмцэж яваад нас барсан юм шүү. Эд бүгдийн ачийг харуулах цаг чинь одоо болжээ. Ямар хүүг өсгөснөө би үзье, чи үзүүл!» гэж хэлсэн нь санагдав. Ээж минь торгонд боож шидсэн энэ зүйлийг над өгч, зүү! гэхэд би, энэ чинь сахиус бурхан юм уу? Шал дэмий юм. Би энэ сахиус бурхнаар чинь яах юм бэ! гэж ээждээ хэлж байсан минь санагдав. Энэ үед нисэх дохио өгч, би онгоц руугаа гүйхэд, ээж минь миний хойноос гүйж ирээд кабин руу минь өнгийж, «үүнийг ав! Хүнд цагт чинь хэрэг болно. Ээжийнхээ сэтгэлийг бодож ав хүү минь» гээд энэ зүйлийг миний хүзүүнд зүүж, «За нис» гэж духы минь үнсэж байсан нь санагдав. Тэгээд би ээжийнхээ өгсөн зүйлийг задалж үзвэл, гээд дэслэгч өнөөх зүйлээ задалж дотроос нь Сталины нэг жижиг хөргийг гаргаж сурагчдад үзүүлээд:

— Энэ зураг байсан юм. Энэ зургийг үзээд миний дотор хачин сэтгэгдлүүд төрөв. Нөхөр Сталин над руу хараад «хувьсгалт орны нэг байлдагч бол империалистийн хөлсний арван солдатаас хол давуу юм. Чи ялна. Урагшаа!» гэж хэлэх мэт болов. Би энэ хонхорт ганцаар биш, ялагдашгүй баатар Сталинтайгаа хамт, Сталинар жолоодуулсан бүх ард түмэнтэйгээ хамт байлдаж байна гэдэг бодол надад төрөв. Тэгээд би довтлох гэж байгаа барс мэт бүх хүчээ хурааж гар буугаа гартаа чанга атгаад «Эх орны төлөө! Сталины төлөө!» гэж зоригтойгоор хашгиран босон харайж дайсны хөнгөн пулемётын наводчикийг гайгүй сайн шагайгаад буудав. Дайсны наводчик сөнөж, пулемёт нь хуцахаа болив. Намайг босон харайх үед дайсан хэд хэд дахин буудсан тул би хоёр дахь шархыг олов. Толгой минь эргээд доош унатал, ээжийн минь өгсөн энэ зураг дахин үзэгдэв. Сталин, гэгээн тунгалаг нүдээрээ намайг харж, «Чи ялна», «Би, дэргэд чинь байна, урагшаа!» гэж хэлэх шиг болов. Би бүх чадлаа шавхаж, «Сталины төлөө! Урагшаа!» гээд босон харайж дайсан руу дайрахад, хоёр япон миний өмнөөс гараа өргөн босож ирэв. Цааш ажиглавал, Сталины хүвгүүд — Зөвлөлтийн цэргүүд эргэн тойрон бүсэлсэн байлаа.

Агуу их Сталин бол манай байлдагчдын зоригийг бадруулагч дайчин туг нь мөн гэдгийг жинхэнэ үйл хэрэг дээр нь би ингэж үзсэн юм.

Ээжийн минь над өгсөн энэ зүйлийн учир ийм юм.

Агуу их Сталин бол монгол хүн бүрийн сэтгэл зүрхний итгэл найдвар нь мөн гэдгийн нэгэн баримт энэ юм гээд дэслэгч Нямаа яриагаа төгсгөв.

\* \* \*

Энэ дайны эхэлсэн өдөр манай цэргүүд, дайсны цэргүүдтэй их буугаар маш ширүүнээр буудалдсан юм. Энэ дайны турш манай олон нисэх онгоцнууд дайсны онгоцнуудтай мөргөлдөж сөнөөсөн юм. Энэ байлдааны үед дайсны солдатууд хоорондоо олон удаа зодолдож байсан билээ.

Манай баатарлаг хувгүүд, эх орондоо бөгөөд өөрийн ард түмэнд хязгааргүй үнэнч, шударгаар байлдаж дайснаа бутниргэсэн юм.

По рассказу Л. Бадарчи.

### Слова

<b>ер нь</b> вообще	<b>гар буу</b> пистолет, револьвер
<b>ухаан бодол ум, разум, сознание</b>	<b>атгах</b> пожать, сжимать (рукой)
<b>(а)гшин зуур</b> мгновенно	<b>харайх</b> скакать, прыгать
<b>амжих</b> успевать	<b>гайгүй</b> сносно, неплохо, как следует
<b>уйлах</b> плакать	<b>шагайх</b> прицеливаться
<b>ууртай</b> сердитый	<b>сөнөх</b> гибнуть, сгинуть
<b>энхрийлэх</b> ласкать, нежить; забобититься	<b>хуцах</b> лаять; издавать звук
<b>хайрлах</b> любить; ласкать; жалеть	<b>болих</b> перестать, прекратить
<b>өнөөгийн</b> теперешний	<b>эргэх</b> зд. кружиться
<b>зүүх</b> носить, надевать	<b>доош</b> вниз
<b>шал дэмий</b> зря; никчемный, ненужный	<b>чадал</b> сила, мощь
<b>дохио</b> сигнал, знак	<b>шавхах</b> зд. мобилизовать полностью
<b>хойноос</b> <i>послелог</i> за	<b>дайрах</b> нападать, атаковать
<b>дух</b> лоб	<b>цааш</b> дальше, за ним
<b>үнсэх</b> целовать	<b>ажиглах</b> наблюдать; приглядываться
<b>задлах</b> раскрывать, развязывать; вскрывать	<b>зоригийг бадруулагч</b> вдохновитель; вдохновляющий
<b>хачин</b> удивительный, странный	<b>сүйдсэн</b> разрушенный
<b>сэтгэгдлүүд</b> мысли; чувства	<b>эмэгтэй</b> женщина
<b>хөлсний</b> наемный	<b>ажиллагаа(н)</b> работа, деятельность
<b>мэт болов</b> показалось	<b>мөргөлдөх</b> зд. таранить; столкнуться
<b>жолоодуулсан</b> ведомый	<b>дайралдах</b> неожиданно встретиться, столкнуться
<b>барс</b> тигр	<b>үнээ(н)</b> корова
<b>барилдаа(н)</b> борьба	<b>зодолдох</b> драться
<b>хураах</b> собирать, мобилизовать	

### ГРАММАТИКА

1. Взаимный залог обозначает действие, которое направляется двумя сторонами друг на друга, например:

Тэр хоёр *барилдаж* байна.

Те двое *борются друг с другом* (как бы: *держат друг друга*, от *барь* — держать).

Замын дэргэд багачууд бөмбөг *шидэлдэж* тоглов.

У дороги дети играли, *бросая друг другу* мячик.

2. Суффиксом взаимного залога является *-лд*, например:

<b>бууд</b> стрелять	<b>буудалд</b> перестреливаться, стрелять друг в друга
<b>цохь</b> бить	<b>цохилд</b> биться

3. Во многих случаях совместный и взаимный залого употребляются просто для выражения вообще массового действия, в котором участвует большое количество людей, а иногда один из этих залогов употребляется вместо другого, например:

**буудалц** (вместо **буудалд**) стрелять друг в друга, перестреливаться

**дуулалд** распевать песню (о многих поющих)

**хэлэлц** обсуждать

4. Русским выражениям типа «там, где» в монгольском языке соответствует причастно-определительный оборот с определяемым **газар** — место, например:

*Там, где* прежде жил наш учитель, теперь живет врач. *Урьд мань багшийн суусан газар* одоо их эмч сууж байна.

Я прибыл *оттуда, где* пасется наш скот. Би бол манай малын *билчиж байгаа газраас* ирэв.

Ты пройдешь *туда, где* находится твоя лошадь. Чи *мориныхоо байгаа газарт* яв!

## У П Р А Ж Н Е Н И Я

**1. Переведите на монгольский язык следующие предложения:**

1) Около этого дома мальчишки каждый день дерутся друг с другом. 2) Мы столкнулись в дверях. 3) До начала атаки происходила сильная артиллерийская перестрелка. 4) Ежегодно в дни Надома на надомской площади близ г. Улан-Батора происходит борьба сильнейших борцов Монголии. 5) Местность, где провел отпуск мой младший брат, находится на берегу Черного моря. 6) Учреждение, где работает мой отец, находится в центре города. 7) Там, где прежде жил мой младший брат, теперь живет один летчик со своей семьей. 8) В местности, где пасется наш скот, есть колодец и хорошая трава.

**2. Ответьте на следующие вопросы:**

1) Хүүхдийн зодолдож байвал яах хэрэгтэй вэ? 2) Та өнгөрсөн бүтэн сайн өдөр хэнтэй дайралдав? 3) Бөхчүүд, юуны тул барилддаг билээ? 4) Танай амарсан газарт цэцэрлэг байна уу? 5) Чиний аавын ажиллаж байгаа албан газарт олон хүмүүс ажиллаж байна уу? 6) 1945 онд манай баатар хүвгүүдийн ялсан тухай ямар номд бичсэн билээ? 7) Энэ цонхоор харагдаж байгаа ой модны цаана юу байна? 8) Энд хичээл хийхэд ямар байна? 9) Та дээд сургуульдаа ирэхдээ ямар гудамжаар явдаг вэ? 10) Та манай дээд сургуульд орохоос урьд ямар сургуулийг төгсгөв?

**3. Приготовьте пересказ урока.**

## 35 ГУЧИН ТАВДУГААР ХИЧЭЭЛ

---

### ИХ СТАЛИН БОЛ МОНГОЛЫН АРД ТҮМНИЙ ШИЛДЭГ ХАЙРТ ХАНЬ МӨН

Монголын ард түмэн, эрх чөлөө тусгаар тогтнолоо байлдан олсон явдал ба түүний бүх амжилт нь нөхөр Сталины нэртэй салшгүй холбоотой учир манай бүх ард түмний сэтгэлд их Сталины алдар нэр хамгийн хайртай дотно байдаг юм.

Ленин-Сталины удирдлагаар ялсан Октябрийн Социалист Их Хувьсгалын ялалт, дорно дахины дарлагдсан хөдөлмөрч ард олныг олон зуун жил унтсан нойроос нь сэрээж дэлхийн империализмийн эсрэг тэмцэлд татан оруулсан юм.

Октябрийн хувьсгалын шууд нөлөөний дор манай орноо 1921 онд ардын хувьсгал ялжээ. Энэ хувьсгал бол колонийн улс түмэн, империалист дарлалаас хувьсгалт ёсоор чөлөөлөгдөх тухай ба улс түмний эрх чөлөө, тусгаар тогтнолын эрхийн тухай Ленин-Сталины их үзэл санааны тодорхой биелэл нь мөн.

Маршал Чойбалсангаас: «хөдөлмөрчдийн их жолоодогч Ленин-Сталин нараас монголын ард түмэнд империалист хүнд дарлагдлын гинжнээс тасран ангижрахад нь тусалсан ба Зөвлөлт улсын ялсан пролетари нартай холбоотой явж эрх чөлөө, энх жаргалант амьдралыг байгуулах ганцхан зөв замыг түүнд зааж өгсөн юм» гэжээ.

Манай ард түмэн Зөвлөлтийн ард түмэнтэй хувь заяагаа анх удаа холбогчдын нэг болсон явдлаа зол жавшаантай хэрэг гэж зүй ёсоор үзэж бахархдаг юм. Зөвлөлтийн ард түмэнтэй тогтоосон эвдэршгүй нөхөрлөлөө манай ард түмэн зүй ёсоор бахархан эрхэмлэж, Ленин-Сталины тогтоосон энэ нөхөрлөлийг цааш улам бэхжүүлэх явдлыг өөрийн ариун үүрэг гэж үздэг юм.

Монголын ард түмэн, Зөвлөлтийн ард түмэнтэй ах дүүгийн ёсоор 30 жил нөхөрлөхдөө, Зөвлөлтийн их ард түмний зүйл бүрийн дэмжлэг тусламжийг хүлээн авч ирсэн ба авсаар байна.

Их Сталинаас манай орныг цэцэглүүлэхийн төлөө эцэг ёсоор үргэлж анхаарч байдаг анхаарлыг бид, зөвлөлтийн ард түмний ах дүүгийн тусламжинд харж үзсээр байна.

Хортон дайсан-гадаадын боолчлогчдын эсрэг тэнцүүргүй хүнд бэрх тэмцлийг хийж, ардын хувьсгалыг явуулж байх уед Оросын пролетари нар манай ард түмэнд тусалж, колонийн дарлагдлаас үүрд ангижруулсан юм.

Улс түмний эрх чөлөө тэгш эрхийн тухай Ленинч-Сталинч үзлийн зарчмууд дээр бүх бодлогоо зохиосон Зөвлөлт засгийн газар, ардын залуу засгийн газрыг монгол дахь ганцхан хууль ёсны засгийн газар гэж хүлээн зөвшөөрснөөр манай бүгд найрамдах улс чөлөөтэйгөөр хөгжих нөхцөлийг олж авсан юм.

Хоцрогдсон орнууд капиталист бус замаар хөгжих бололцооны тухай Лениний сургаж, их Сталинаас цааш хөгжүүлэн, СССР-ийн олон үндэстний бүгд найрамдах улсуудын дотор биелүүлсэн сургаал нь манай ард түмний замыг гийгүүлж, хоцрогдсон орны ард түмэнд капитализмаас учруулдаг тэсвэрлэшгүй зовлон ба шаналалт мөхлөөс монголын ард түмнийг ангижруулах явдлыг хангасан юм.

Ленин-Сталины заасан ёсоор Монголын ард түмэн, капиталист бус хөгжлийн замаар явахдаа түүхийн асар богино хугацаанд феодализм, дундад зууны үеийн хоцрогдлыг устгаж, социализм өөд явж байна.

Байлдан олсон эрх чөлөөг бэхжүүлэх явдал ба манай орны эдийн засаг, соёлын ололтууд нь ганцхан Зөвлөлтийн ард түмний байнгын тусламж, их Сталинаас манай ард түмний төлөө анхаардаг өдөр тутмын анхаарал санаачлагын үрээр бүтсэн юм.

Монголын ард түмний хөгжлийн замд олон тооны саад тохиолдож байхад их Сталин, Зөвлөлтийн ард түмнээс бидэнд үргэлж тусалж байсан юм.

Японы империалистүүдээс манай эрх чөлөө тусгаар тогтнолыг аюул заналд учруулж байсан хүнд өдрүүдэд их Сталинаас дэлхий дахинд цууриатуулан зарласан нь «Хэрэв Японоос Бүгд Найрамдах Монгол Ард Улсыг дайран түүний тусгаар тогтнолд халдахыг шийдвэрлэвэл бид, Бүгд Найрамдах Монгол Ард Улсад туслах болно. Бид, Бүгд Найрамдах Монгол Ард Улсад 1921 онд хэрхэн тусалсны нэг адил тусална» гэсэн билээ.

(Төгсөөдүй)

## С л о в а

**алдар нэр** имя, слава  
**ялалт** победа  
**дорно дахины** восточный, востока  
**дарлагдсан** угнетенный  
**нойр** сон  
**сэрээх** будить, разбудить  
**эсрэг** против  
**татан оруулах** привлекать, вовлекать  
**шууд** прямой, непосредственный  
**нөлөө(н)** влияние  
**биелэл** реализация

хүнд тяжелый  
гинж цепь  
тасран ангижрах избавиться  
хувь заяа(н) судьба  
зол завшаан счастье, удача  
бахархах гордиться, радоваться  
зүй ёсоор искренне; законно, по праву  
эрхэмлэх придавать первостепенное значение  
ариун священный  
харах видеть

хортон злобный; заядлый  
боолчлогчид поработители  
тэнцүүргүй неравный; несравненный  
бэрх тяжелый  
үүрд навсегда, навеки  
ангижруулах избавить, освободить  
тэгш эрх равноправие  
зарчмууд принципы  
бодлого политика  
засгийн газар правительство  
хууль ёсны законный  
хүлээн зөвшөөрөх признать  
бус не  
бүгд найрамдах улс республика  
гийгүүлэх освещать

тэсвэрлэшгүй невыносимый, нестер-  
пимый  
зовлон мұка, страдание  
шаналал печаль  
мөхөл вымирание  
асар богино кратчайший  
дундад зууны үе средневековье  
саад тормоз, помеха  
тохиолдох встретиться  
аюул занал опасность, угроза  
цууриатуулан зарлах объявить во  
всеуслышание  
дайран халдах напасть  
адил эд. также; одинаково

## 36 ГУЧИН ЗУРГААДУГААР ХИЧЭЭЛ

### ИХ СТАЛИН БОЛ МОНГОЛЫН АРД ТҮМНИЙ ШИЛДЭГ ХАЙРТ ХАНЬ МӨН

*(Өмнөхийн үргэлжлэл)*

Манай эх оронд японы империалистүүдээс халдан довтлоход Зөвлөлтийн арми, их Сталины уриалгаар Халх голд японы самурай нарыг бут ниргэж, түүгээрээ манай эх орны цаашдын чөлөөт хөгжлийг хангасан юм. Сталины мэргэн гадаад бодлогын ачаар бид, тусгаар тогтнолоо бэхжүүлж, олон улсын өргөн харилцаанд орж чадах болсон юм. Нөхөр Сталины санаачлага ба байнгын тусламжийн үрээр манай ард түмэн, чөлөөт ардчилсан улсаа бэхжүүлэн хөгжүүлж, өөрийн эдийн засаг, соёлын талаар асар их амжилтыг олов.

Манай ард түмэн, ардын засаг төрийн жилүүдэд малынхаа тоог 1920 оныхоос 2 дахин илүү өсгөжээ. Энэ нь юуны өмнө Зөвлөлт улс, их Сталинаас бидэнд мал эмнэлгийн байгууллагуудыг байгуулах, түүнийг өргөтгөх, өвсний станцуудыг байгуулах, зоотехникийн тэргүүний аргыг өргөнөөр нэвтрүүлэх хэрэгт тусалж, малыг түргэн өсгөх, түүний шимийг дээшлүүлэх чухал нөхцөлийг бий болгож өгсөн юм.

Зөвлөлт Холбоот Улс ба нөхөр Сталины биет тусламжтайгаар маршал Чойбалсангийн нэрэмжит үйлдвэрийн комбинат, Налайхын нүүрсний уурхай, Махкомбинат, Төмрийн завод, Цахилгаан комбинат, Биокомбинат, тосны олон зуун завод хийгээд хоршооллын олон үйлдвэр байгуулагдан хөгжиж байна. Үүний үрээр шинэ нийгмийн анги-ажилчин анги манайд бий болов. Их Сталины асрамж тусламжийн ачаар одоо манай сронд авто машинын сай-

хан зам тээвэр, төмөр зам, агаарын ба усан харилцааны зам, телеграф ба телефоны өргөн харилцаатай болжээ.

Манай ард түмний энх аж байдал, эдийн засаг, соёлыг хөгжүүлэхийн төлөө их Сталины тавьсан хайр халамжийн шинэ илрэл бол нөхөр Сталины санаачлага заавраар зөвлөлтийн хүмүүсийн гараар бүтээгдсэн Улаанбаатарын төмөр зам мөн. Онцгой хоцрогдмол байсан манай орон, Зөвлөлтийн ард түмний ах дүүгийн зүйл бүрийн тусламж, их Сталины хайр халамжийн ачаар тэргүүний соёлт орон болон хувирчээ.

Манай эх оронд олон зуун бага, дунд сургууль, клуб, номын сан, хүн, малын эмнэлгийн газрууд бий болжээ. Дээд мэрэгжлийн шинэ хүчнүүдийг бэлтгэх хэдэн дээд сургууль бий болсон явдал бол манай улсын соёлын нэг чухал амжилт мөн юм.

Манайд ард олны зорилтод үйлчлэгч шинжлэх ухаан, урлаг амжилттай хөгжиж байна.

Манайд хөдөлмөрчин ард түмэнтэй үндсээрээ холбоотой бөгөөд Маркс-Энгельс-Ленин-Сталины сургаалаар зэвсэглэсэн шинэ сэхээтэн төрөв.

Маркс-Энгельс-Ленин-Сталины сургаал бол манай намын үзэл суртлын үндэс мөн бөгөөд манай нам, манай бүх ард түмний замыг гийгүүлж, социализмыг байгуулах тэмцэлд манай ард түмнийг үзэл суртлын талаар зэвсэглэн хатуужуулж байна.

Манай намын гишүүд, манай орны хөдөлмөрчдөөс судалж байгаа Ленин-Сталины баатарлаг амьдрал, зохиолууд нь ард түмний үйл хэрэг, коммунизмын үйл хэргийн төлөө хэрхэн зүтгэхийг бидэнд сургаж байна.

Маршал Чойбалсангийн санаачлагаар нөхөр Сталины зохиолуудыг монгол хэл дээр орчуулсаар байгаа явдал бол манай ард түмний үзэл суртлын хэмжээг дээд шатанд дэвшүүлэн гаргаж, хүн төрөлхтний нийгмийн хуулиудаар зэвсэглүүлэх шинэ шинэ их бололцоог өгч байна.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх, манай ард түмний бүх ололт ялалтад нөхөр Сталины тусламж ба роль агуу их юм.

Маршал Чойбалсан, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын 25 жилийн ойгоор тохиолдуулан нөхөр Сталинд манай ард түмний хайр талархлын сэтгэлийг илэрхийлэхдээ: «Манай ард түмэн өнгөрсөн замаа баяр баясгалантай харж байна. Түүний хараа, сайхан Москва, дэлхийн хөдөлмөрчдийн жолоодогч их Сталины зүг талархан ширтэж байна» гэсэн билээ.

Энэ учраас манай ард түмэн, бүх дэлхийн хөдөлмөрчдийн суут жолоодогч нөхөр Сталиныг өөрийн их багш, шилдэг хань, төрөлхийн эцэг гэж үздэг юм. Чухам энэ учраас манай уудам сайхан орны өнцөг булан бүрд нөхөр Сталины нэрийг баяр талархлын сэтгэлээр ярьж, түүнийг өөрийн амьдралын гэгээн наран, туг, манлай гэж зүй ёсоор нэрлэж дуу, зохиолдоо үргэлж дурсан дуулж ярьж байдаг юм.

(Төгсөөдүй)

халдан довтлох нападаты  
уриалга призыв  
бүт ниргэх разгромить  
хөгжил развитие  
чөлөөт свободный  
гадаад внешний  
асар их огромный, величайший  
юуны өмнө прежде всего, раньше  
всего  
өргөтгөх расширить  
шим зод. продуктивность  
биет реальный, конкретный  
нүүрс уголь  
уурхай шахта, бассейн  
асрамж тусламж помощь, забота  
энх аж байдал мирная жизнь  
хайр халамж забота  
илрэл проявление  
онцгой исключительный  
хоцрогдмол отсталый  
зүйл бүрийн всесторонний

хувирах измениться; превратиться  
дээд мэрэгжлийн высшей квалифи-  
кации  
зорилт цель; стремление, чаяние  
үйлчлэх служить, посвятить  
шинжлэх ухаан наука  
урлаг искусство  
үндсээрээ своими корнями  
төрөх родиться, появиться  
үзэл суртал мировоззрение, идеология  
баатарлаг геронческий  
амьдрал жизнь  
үйл хэрэг дело  
зүтгэх трудиться, стараться  
тохиолдуулах приурочить  
баяр баясгалантай с радостью  
хараа(н) взор  
эцэг отец  
уудам обширный  
гэгээн светлый, яркий  
дуу(н) песня  
дуулах петь, воспевать

## 37 ГУЧИН ДОЛООДУГААР ХИЧЭЭЛ

### ИХ СТАЛИН БОЛ МОНГОЛЫН АРД ТҮМНИЙ ШИЛДЭГ ХАЙРТ ХАНЬ МӨН

(Төгсгөл)

Ийм учраас нөхөр Сталины 70 насны ой бол манай бүх ард нийтийн их баяр мөн юм. Нөхөр Сталинд илэрхийлж байгаа манай ард түмний баяр баясгалангийн их долгион, хязгааргүй талархал, гүн хайр хүндэтгэл, хамаг сайн сайхныг хүссэн эрхэм ерөөл, энэ өдрүүдэд маш их эрчим хүчтэй оргилон гарч байна.

Манай бүх ард түмний их баярын энэ сэтгэл ба нөхөр Сталиныг талархсан манай ард түмний талархал нь манай орны малчид, ажилчид, цэрэг, сэхээтнүүдийн цуглаануудад илэрч байна. Энэ нь нөхөр Сталины 70 насны ойг тэмдэглэн өнгөрүүлэх комиссын нэр дээр манай бүх орны хөдөлмөрчдөөс тасралтгүй ирүүлж байгаа илэрхийлэлт, бэлэглэл, захидал, цахилгаануудаар илэрч байна. Энэ сэтгэл, манай улсын ард иргэдийн олон зуун мянган хүний гарын үсэгтэй бүх ард түмний захидалд илэрсэн юм.

Энэ сэтгэл, Улаанбаатар хотын ард түмнээс нөхөр Сталиныг манай нийслэл Улаанбаатар хотын хүндэт иргэнд сонгосноор илэрч байна. *(Нижигнэтэл алга ташив.)*

Нөхөр Сталинд Бүгд Найрамдах Монгол Ард Улсын баатар цолыг олгож, манай улсын хамгийн дээд шагнал-Сухбаатарын

одонгоор шагнах тухай Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн газрын зарлигийг манай орны ард түмэн их баяр баясгалантайгаар хүлээн авав.

Нөхөр Сталины санаачлагаар тавьсан Улаанбаатарын төмөр зам, мөн нөхөр Сталины санаачлагаар баригдсан Улаанбаатарын Махкомбинат, тэрчлэн Улсын төв номын сан, Улаанбаатарын гол гудамж, хязгаарын цэргийн 12 дугаар отряд болон төмөр замын буудлын талбайг Сталины нэрэмжит болгох тухай Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн Газраас гаргасан зарлигийг манай орны ард түмэн, туйлын их баяр баясгалантай хүлээн авсан нь нөхөр Сталинд талархаж байгаа манай орны хөдөлмөрчдийн сэтгэлийг илэрхийлж байна. *(Нижсигнэтэл алга ташив.)*

Энэ бүгд нь манай ард түмний хөдөлмөрийг шинэ хүчтэй өрнөлтөд оруулж байна.

Бид, их Сталины 70 насны ойн энэ өдөр нөхөр Сталинд манай ард түмний хайр талархлаа илэрхийлж, дэлхий дахины хөдөлмөрчдийн тусын тулд урт наслан үйлчлэхийг түүнд дахин ерөөнө. *(Нижсигнэтэл алга ташив.)*

Ард түмний хэрэг, Зөвлөлт, Монголын ард түмний нөхөрлөлийн хэрэг, социализмын хэргийн төлөө их Сталинаас биднийг сургадаг шиг, их Сталины хөдөлмөрлөдөг шиг, ажиллахад бэлхэн байгаа зориггоо бид, энэ өдөр илэрхийлнэ.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын 25 жилийн ойгоор тохиолдуулан маршал Чойбалсангийн нэр дээр ирүүлсэн халуун талархлын баярын бичигтээ, нөхөр Сталинаас манай аж ахуй ба соёл боловсролын цаашдын амжилтад талархлыг хүрэгсэн нь бид бүгдийн ба манай бүх ард түмний зоригийг бадруулж байна.

Манай ард түмэн ба Зөвлөлтийн ард түмний нөхөрлөлийг цааш нь бэхжүүлэх талаар манай нам, манай ард түмнийг Ленин-Сталины заасан замаар жолоодож байгаа манай ард түмний жолоодогч маршал Чойбалсангийн сургадаг шигээр ажиллацгаая.

Ленин-Сталины тугийн дор, Зөвлөлтийн ард түмний ах дүүгийн тусламжтайгаар, маршал Чойбалсангийн жолоодлогоор социализм өөд урагшаа!

Ленин-Сталин нарын гагнасан Зөвлөлт-Монголын ард түмний ах дүүгийн эвдэршгүй нөхөрлөл мандтугай! *(Нижсигнэтэл алга ташив.)*

Дэлхий дахины хөдөлмөрчдийн их жолоодогч, багш бөгөөд хань, манай төрөлхийн хайрт Сталины яруу алдар бадартугай! *(Нижсигнэтэл алга ташив.)*

Манай хайрт жолоодогч, багш их Сталин урт удаан наслах болтугай! *(Хуралдагчид цөм босож нижсигнэтэл алга ташив.)*

«Үнэн», № 297, 23.XII. 1949

Из доклада тов. Ширэндэб

на торжественном заседании в г. Улан-Баторе,  
посвященном 70-летию товарища Сталина.

долгион волна  
хайр хүндэтгэл уважение, почет  
ерөөл пожелание (блага)  
эрчим хүчтэй энергично; энергичный  
оргилох бурлить  
цуглаан собрание, митинг  
тасралтгүй непрерывно  
бэлэглэл подарки  
иргэд граждане  
хүндэт почетный, уважаемый  
цол звание  
олгох эд. присвоить

шагнал награда  
зарлиг указ  
хязгаарын цэрэг пограничные войска  
буудал станция, остановка  
талбай площадь  
туйлын эд. очень  
ажиллацгаах работагаь  
гагнах паять, спаивать  
мандтугай да здравствует  
яруу алдар бадартугай слава!, да  
здравствует!

## 38 ГУЧИН НАЙМДУГААР ХИЧЭЭЛ

### СТАЛИНЫ ӨВӨР ДЭЭРХ БЯЦХАН ОХИН

Намайг мэдээ орохын үед, манай гэрийн хойморт өндөр ширээн дээрх гүнгэрваан дотор гурав дөрвөн толгойтой арван хэдэн гартай, арзайж ярзайсан, харахаас айдас хүрмээр бурхан байдаг байсан нь нэг мэдэхэд алга болоод түүний оронд том улаан авдар дээр, өргөн сайхан гуун дотор Ленин-Сталин, Сүхбаатар-Чойбалсан нарын хөргийг тавьсан байсан билээ. Ингэж жил сар ирэх тутам манай гэрийн дотоод байдал өөр болж байлаа. Би багадаа элдвийн зургийг өлгөн хаддаг байсан билээ. Тэр зургуудын дотроос нэг зургийг би туйлын хайрлан үздэг байж билээ. Тэр зурагт их Сталин эцэг хүний энхрий хайраар мишээж баглаа цэцэг барьсан хар үстэй торомгор нүдтэй хачин хөөрхөн жаалхан охиныг хоёр гараараа өргөж энхрийлэн байгааг үзүүлсэн байжээ.

Би тэр зургийг байн байн харж энэ яасан азтай хүүхэд вэ? Хаанахын хэний хэн гэгчийн охин бол, би мөн цэцэг өгч их Сталинд өргүүлэх юмсан гэж боддог байв. Энэ бол арваад жилийн өмнөх хэрэг юм. Би тэр цагт Сталин коммунизмын их жолоодогч, дэлхийн олон сая хөдөлмөрчдийн их багш болохын жинхэнэ нарийн учрыг үнэндээ мэддэггүй байлаа. Гэвч Сталины мишээнгүй сайхан дүрийг хараад энэ хүн хүүхдэд яасан хайртай хүн бол, хүүхдийг хараад лав хоёр гараараа өргөж аваад энхрийлэн сайхан чихэр өгч, хүү минь ном сайн сураарай! Сайн хүн болоорой гэж хэлдэг байхдаа гэж боддогсон.

Монгол хүн өргөн талдаа өтгөн сүргээ маллаж эх орон, эрх чөлөө, эрхэм жаргалаа магтсан дуртай дуугаа чөлөөтэй дуулж явахад бүрэн эрхтэй байдаг, манай эсгий гэрүүдийн бүслүүрт хийморь гэдэг өгөрсөн цагаан даавуу салбаганан хийсэж байсан бол түүний оронд жаргалаа олохдоо барьж явсан улаан туг хий-

сэж байдаг болов. Сүндэрлэн боссон сайхан барилгуудын дотор жирийн ардын хүвгүүд охид сууж төрийн хэрэгт оролцож байдаг. Энэ бол тэр их ухаант хүн Сталины заасан, тусалснаар олдсон баяр жаргал эрх чөлөөний тэмдэг мөн гэж би мэддэг үздэг болов.

Одоо өнөө зургаа харахад эрх чөлөө эрдэм боловсролыг эрхэмлэсэн хэний ч охиныг Сталин өргөнө. Сталины заасан замаар явж Сталины сургасан бүгдээс нь мэдэж авах юм бол Сталин биднийг өргөж байгаатай адилаар би мэддэг боллоо.

Сталины өвөр дээр байгаа тэр охины зураг одоо их Сталин энх тайвныг энхрийлж байна. Их Сталин ирээдүйг минь зааж байна. Энэ үеийг минь баясуулж байгаа гэж хардаг боллоо. Хэрэв манай урьд үеийн өвгөд хөгшдийг босгож ирдэгсэн бол энэ ямар их жаргалт үе вэ? Ийм эрх чөлөөг хэн олгов? Яасан сайхан юм бэ? гэхсэн. Хэрэв өнөөдрийн Энэтхэг, Ираны дарлагдсан хүн, энэ хэний зам бэ? Энэ юуны гэгээн туяа вэ? Энэ эрхийг яаж олов гэж биднээс асуувал, энэ Сталины зам! Энэ Октябрийн мөхөшгүй туяа! Энэ эрхийг Сталин та бидэнд зааж өгсөн юм гэж би хариулна. Сталины өвөр дээр байгаа баяртай бяцхан охины зураг бол үнэхээр үнэн бодит амьдралын зураг, азтай нэг нь ч биш, ардчилал энх тайвны төлөө тэмцэгч бүхэн, ард түмэн бүхэн, Их Сталины өмөг түшиг байна. Их Сталин энэ бүхнийг тэр сайхан охин шиг өргөдөг. Монголын ард түмний жаргал хөгжил нь тэр цэцэг шиг дэлгэрч байна. Жирийн ард түмэн бүхэн их Сталиныг тэр охины адилаар хайрт эцэг, хайрт багш минь гэж байна.

Манай бяцхан хүвгүүд охид харийн дайсны бузар харгислаас ачит Сталины тусламжаар хамгаалагдсан, чөлөөт нутгийнхаа өндөр уул, өргөн талд ургадаг ариун сайхан цэцгээ, бат бөх иш дээрээ багсайн ургасан хонгор зулаа ачит эцэг багш Сталиндаа өргөж байна.

Бид саруул сайхан эх орныхоо хөгжил цэцэглэлийн төлөө, ариун шударгаар үйлчлэхдээ хүнд үйлдвэрт хүчит техникийг ажиллуулж давуу нормыг өгөгч цогтой залуу ажилчин ч, гурван есийн ид хүйтэн хангинасан цэвдэг хөлдүү өвөлд амьдралы минь үндэс мал сүргээ малласан алдарт малчид, гэрэлт чийдэнгийн хурц гэгээ бадарсан саруул сайхан танхимд шинжлэх ухааны эрдмийг судалж суугаа оюутан сурагч минь ч, манай үеийн ирээдүй болсон жаргалант үр хүүхдээ тэвэрч эвийлэн бүүвэлэн байхдаа ч эрхийг олгосон Сталин минь! Жаргалыг жолоодогч Сталин минь! Эрдмийн дээдийг олгогч багш Сталин минь! гэж царга их хадтай цаст өндөр уулын орой хүртэл жаргалын дуугаа цууриатуулдаг. Дуу дууны дээд баярт дуугаа Сталиндаа өргөж байдаг. Сталины үеийн эрх чөлөөг эзэмшигч баяр жаргалтай амьдарч байгаа манай хүвгүүд охид, их Сталины сургалыг судалж Сталины алсыг харсан эцэг хүний энэрэнгүй нүдээр зааж байгаа тэр замаар явж ихийг сурч, ихийг бүтээж эх орноо хөгжүүлнэ.

Их Сталинаар өмөг түшиг хийсэн монгол хүн бид цөм, өлгий болсон эх орон минь! ивээлт нам засаг минь! эцэг маршал Чойбалсан минь! Их жолоодогч багш Сталин минь! гэдэг. Их Сталины үеийн хөдөлмөрчид цөм, их Сталины өмөг түшигт бахдаж байна. Энх найрамдал, эрх чөлөө минь! Эх орны хөгжил минь! Сталины өвөр дээр байгаа баясгалант охин, түүний барьсан цэцэг шиг энхрийлэгдэж байна.

По рассказу С. У д в а л.

## С л о в а

**өвөр дээр** *зд.* на руках  
**бяцхан** маленький  
**мэдээ орох** *зд.* начинать воспринимать окружающий мир  
**хоймор** задняя часть юрты  
**гүнгэрваан** шкафчик  
**арзайж ярзайсан** скаливший зубы  
**айдас хүрмээр** вызывающий страх, страшный  
**бурхан** *зд.* изображение буддийского божества  
**алга болох** исчезать  
**оронд** *зд.* вместо  
**улаан** красный  
**авдар** сундук  
**гуун** рама  
**багадаа** в детстве  
**энхрий** ласковый, нежный  
**мишээх** улыбаться  
**баглаа цэцэг** букет цветов  
**үс(эн)** волосы  
**торомгор** блестящий, красивый  
**хөөрхөн** хорошенький, прелестный  
**жаалхан** маленький  
**аз(а)** счастье  
**хаанах?** откуда?, из каких мест?  
**хэн гэгчийн?** чей?  
**бол** *зд.* *вопросительная частица*  
**үнэн** правда  
**дүр** облик; вид  
**өтгөн** густой, тучный  
**маллах** ухаживать за скотом, пасти скот  
**жаргал** счастье  
**бүслүүр** *зд.* пояс  
**хийморь** «флажок счастья»  
**өгрөх** обветшать, устареть  
**салбаганан хийсэх** развеиваться  
**төрийн хэрэг** государственное дело

**ухаант хүн** мудрейший человек, умнейший человек  
**бүгд** все, всё  
**баясуулах** даровать радость  
**өвгөд хөгшид** старики и старушки; предки  
**Энэтхэг** Индия  
**мөхөшгүй** неугасимый  
**бодит** реальный, подлинный  
**тэмцэгч** борец  
**өмөг түшиг** опора, защитник  
**дэлгэрэх** распространяться; цвести  
**харийн** чужеземный, иноземный  
**бузар харгислал** захват, оккупация; оскорвление  
**ачит** благодетельный  
**бөх** *зд.* сильный, крепкий  
**иш** стебель  
**багсайх** расти пучком, расти густо  
**ургах** расти  
**зул** *зд.* тюльпаны  
**цэцэглэл** цветение, расцвет  
**гурван есийн ид хүйтэн** разгар холодов  
**хангинасан цэвдэг хөлдүү өвол** суровая зима, зима с трескучими морозами  
**гэгээ(н)** свет  
**бадрах** гореть  
**танхим** зал  
**тэврэх** обнимать  
**эвийлэн бүүвээлэх** баюкать  
**эрдмийн дээд** вершина науки, вершина знания  
**[царгиа]** их хадтай скалистый, с высокой скалой  
**алсыг харсан** дальновидный  
**энэрэнгүй** человекный; заботливый  
**өлгий** колыбель  
**ивээл** защита, покровительство

## СТАЛИНЫ ЗОХИОЛЫГ УНШСАН НЬ

Сургааг хашаан дотор цагаан даавуу бүрээстэй, их бага хоёр гэр байна. Том гэр нь аймгийн хүнсний комбинатын дарга намын гишүүн Зоригийн гэр ажээ.

Хүрэн өнгөтэй даавуу дээлтэй, торгон өнгөтэй үнэгэн лоовууз өмссөн хорь гаруй настай залуу, гэрийн гадна ирж малгай дээлээ засаад, хаалгыг тогшиж зөвшөөрөл аваад оров. Энэ хүн бол Ховд аймгийн гар үйлдвэрийн артелийн хувцасны тасгийн мастер Дондог гэдэг хүн байжээ.

Зориг, бичгийн ширээний дэргэд ном уншиж сууна. Түүний гэргий Жавзан, эвтэйхэн өнгөтэй улбар пансан цамцан дээр цэцэг хатгаж байна. Гурван настай хүү нь гэрийнхээ хойно янз бүрийн сонин сайхан зургийг дэлгэж, эрх дураараа тоглоно.

Дондог мэнд сайныг мэдэлцээд, Зоригийн хажуу дахь сандаль дээр суув.

Жавзан цай хийж, чихэр таваглав. Хаанаас ирэв? Ажил амжилттай байна уу? гэж Зоригийн асуухад Би шууд гэрээсээ ирлээ. Манай артелийн ажиллагаа нилээд сайн байна. Их Сталины 70 насны ойг угтаж явуулсан энэ сарын төлөвлөгөөт ажлыг манай тасаг, 150%-оор биелүүлж, артелийн хэмжээн дээр түрүүлсэн шүү! гэж Дондог их л хөгжилтэйгөөр хэлэв.

Зориг, ухамсартайгаар Дондогийн зүг хандаж,

Үйлдвэрийн төлөвлөгөөг чанартайгаар давуулан биелүүлнэ гэдэг чинь ажилчин хүний амьдралын хамгийн сайхан хэрэг шүү. Чи бол залуучуудын эвлэлийн гишүүн, улсын ударник мастер хүн юм. Ингэхээр үйлдвэрээ зөвөөр удирдаж, улам илүү бүтээл гаргах хэрэгтэй. Цааш биеэ боловсруулах хэрэгтэй гэж сургав.

Дондог биеэ боловсруулж орос хэлийг сурахсан гэж бодох юм. Гэвч санасандаа хүрч чадахгүй байна. Тэгээд чамтай уулзаж зөвлөлгөө авахаар өнөөдөр зориуд ирлээ.

Өчигдрийн чиний хийсэн лекц тун сайхан боллоо. Би бүгдийг ойлгож их Сталины амьдралтай танилцлаа шүү. Чи орос хэлийг сурснаа над сэтгэл харамгүй хэлж өгнө үү? Чи бид хоёр бол хоёр жилийн өмнө Манхан сумын төв дээр хамт ажиллаж байхдаа хоёулаа орос хэл мэдэхгүй байсан шүү. Гэтэл чи өнөөдөр орос хэлтэй болоод янз бүрийн сайхан юм, Ленин, Сталины зохиолыг уншдаг болжээ гэж хэлэхэд, Зориг жирийн хүний даруу зангаар үл мэдэг инээмсэглэж,

— Дондог оо! Чиний хүсэл бол одоогийн шинэ хүний хамгийн зөв хүсэл юм. Би ч ингэж боддог. Миний орос хэл сурах явдалд нэг сайхан жавшаан тохиолдсон юм.

Би түүнийгээ чамд хэлж өгье. Би хоёр жилийн өмнө сумын нарийн бичгийн дарга хийж байгаад намын хорооны шийдвэрээр аймгийн төвд ажиллахаар болж суман дээрээсээ мордож, Цагаан голын өртөөн дээр ирлээ. Энэ өртөөн дээр нэг орос нөхөртэй дайралдаж аймгийн төв ортол хамт явлаа.

Энэ хүн бол манай аймгийн малын их эмч байсан Виноградов гэдэг залуу юм. Энэ хүн бол Ленин Сталины коммунист залуучуудын эвлэлийн гишүүн, зөвлөлтийн дээд мэрэгжилтэн хүн юм. Энэ хүн одоо Улаанбаатар хотод эжиллаж байгаа Виноградов зан аашаар эелдэг, төлөв шударга, ямар ч хүнийг голдоггүй Зөвлөлтийн хүний онцгой шинжийг бүрэн хадгалсан хүн шүү.

Виноградов, намайг орос хэл мэддэг юм шиг өртөөний хооронд хэдэн цагийн турш юм ярьж билээ. Би түүний ярианаас юу ч ойлгоогүй. Хааяа нэг «Москва, Ленин, Сталин» гэдэг үгийг сонсоод, манай ах дүүгийн найрамдалт Зөвлөлт улсын их хөгжлийг ярьж байна даа гэж дотроо тааварлан бодоод, дэмий л ойлгосон хүн шиг толгой дохиж явж билээ. Виноградовыг хэчнээн сайхан юм ярьж байгаа бол түүнийг бүрэн мэдэх юмсан гэхээс зүрх цохилж, заримдаа биедээ гомдох шиг, заримдаа ичих шиг болж билээ.

Ингэсээр яваад бид аймгийн төвд ирж би Виноградовыг гэрт нь буулгаж өглөө. Үүнээс хойш Виноградов бид хоёр үргэлж уулздаг, уулзах бүрдээ надад янз бүрийн юмыг ярьдаг, би түүний асуусан байдал гаргахад, толгой дохиж зөвсгөрөөх хоёрын алиныг ч мэдэхгүй байлаа,

Нэг өдөр, Виноградов надтай уулзаад намайг гэртээ оч! гэж байгаа бололтой. Би дуртайгаар толгой дохиж зөвшөөрөөд, тэдний гэрт очлоо.

Байшингийн тасалгааны дотор цэвэр үзэмжтэй, таримал цэцгийн анхимал сайхан үнэр ханхалж шилэн шүүгээний дотор жигдхэн өрсөн алтан мөнгөн үсэгтэй сайхан, сайхан номууд давхарлан тавьсан нь: үнэхээр үзэсгэлэнтэй. Орос хэл түргэн сурч энэ сайхан номыг Виноградов шигээ уншихсан гэж бодохоос сэтгэл хөдөлж билээ. Виноградовын гэргий бас нэг сайхан ааштай залуу бүсгүй намайг учир тоймгүй хүндэтгэж ширээ сандаль засаж, янз бүрийн амтатнаар дайлав.

Би юм ярих гэхээс хэл мэдэхгүй, дэмий овоохой мэт суусандаа үнэхээр нүүрээ хийх газар олдсонгүй дэмий л гайхсандаа толгой дохиж суулаа. Би хэдэн цаг дуугүй суусны дараагаар явах болсонд Виноградов номын шүүгээг нээж гэрэлтсэн алтан үсэгтэй гялалзсан хүрэн өнгийн хавтастай номыг гаргаж ирээд нүүр дээр нь тодхон өнгийн цэвэр чернилээр юм бичээд надад өхдөө:

«Орос хэл сур! Би зааж өгнө» гэж байгаа бололтой нэг үгийг дахин давтан хэлээд миний гарыг чанга атгав. Би хязгааргүй баярлаж, тэдний гарыг бариад өөрийн сайхан мэддэг орос үгээр «Баярлав» гэж хэлээд гарав. Би, гадаа гараад номыг

нээж үзвэл их Сталины хүндэт хөрөг байхыг үзээд, Сталины тухай ном байжээ гэж тааварлан бодоод Виноградовын бичсэнийг унших гэсэн боловч оросоор бичсэн тул чадсангүй. Энэ лав учиртай үг байх, үүнийг заавал мэдэж авъя гэж бодоод улсын их сургуулийг энэ жил төгсгөж ирсэн, хүний их эмч Бадамынд хүрч очив.

(Төгсөөдүй)

## Слова

**сургааг** жердь  
**бүрээс(эн)** покрывало; обёртка  
**үнэгэн** лисий  
**лоовууз** шапка, головной убор  
**өмсөх** одевать  
**залуу** *эд.* юноша  
**зөвшөөрөл** разрешение, согласие  
**гэргий** жена  
**өвтэйхэн** *эд.* приятный  
**улбар** красноватый; розовый  
**пансан** шелковый  
**цэцэг хатгах** вышивать цветы  
**өрх дураараа** по своей воле  
**мэнд сайныг мэдэлцэх** здороваться  
**хажуу дахь** находящийся рядом, сбоку  
**таваглах** положить в тарелку  
**хаанаас** откуда  
**хэмжээн** *эд.* масштаб  
**хандаж** повернувшись; смотря, обращаясь  
**чанартайгаар** качественно, высококачественно  
**давуулан биелүүлэх** перевыполнить  
**ингэхээр** поэтому, следовательно  
**улам илүү** еще больше  
**биеэ боловсруулах** повышать свои знания, учиться  
**санасандаа хүрэх** осуществить свою мечту, добиться желаемого  
**зөвлөлгөө(н)** совет, указание; консультация  
**зориуд** специально  
**сэтгэл харамгүй** не скрывая, не скупясь; подробно  
**даруу зан** скромность  
**үл мэдэг** незаметно  
**инээмсэглэх** улыбаться  
**хүсэл** желание, стремление  
**жавшаан** счастье, удобный случай, удача

**өртөө(н)** *эд.* уртон (*почтово-ямская станция*)  
**дайралдах** встретиться  
**зан ааш** характер, нрав  
**төлөв** *эд.* вообще, всегда  
**голох** недооценивать; отвергать; браковать  
**шинж** признак; качество  
**хааяа** иногда, редко, изредка  
**найрамдал** дружба  
**тааварлах** догадываться, предполагать  
**дэмий л** *эд.* от нечего делать  
**цохилох** трепетать, биться  
**гомдох** *эд.* обижаться, досадовать  
**ичих** стыдиться  
**буулгах** высадить; провожать (до дому)  
**сэсрэх** *эд.* качать  
**дуртайгаар** охотно, с удовольствием  
**үзэмжтэй** привлекательный, красивый, приятный (на вид)  
**таримал** посаженный  
**анхимал сайхан үнэр** аромат, благоухание  
**ханхлах** пахнуть, издавать запах  
**алтан золотой**  
**мөнгөн** серебряный  
**үсэг** буква  
**давхарлах** ставить рядами, ставить один на другой  
**үзэсгэлэнтэй** прекрасный, красивый  
**үчир тоймгүй** очень, очень сильно  
**амттан** сладости  
**дайлах** угощать, устроить угощение  
**овоохой** шалаш, лачуга, балаган; *перен.* истукан  
**гайхсандаа** *эд.* от нечего делать  
**хавтас** переплет  
**учиртай** имеющий глубокий смысл

## СТАЛИНЫ ЗОХИОЛЫГ УНШСАН НЬ

(Төгсгөл)

Бадамыг урьд сайн таних учраас өөрийн явдлыг нуулгүй ярьж, Виноградовын өгсөн номыг үзүүлэхэд Бадамын хэлсэн нь:

«Энэ ном бол И. В. Сталины намтар гэдэг ном байна. Комсомолын гишүүн Виноградов ах дүү мэт сайн нөхөр Зоригтоо дурсгав. Чи, Маркс-Энгельс-Ленин-Сталины зохиолыг уншихын тулд орос хэл түргэн сур! Би чамд тусална. «Сурахдаа биднийг ба бидний бүдүүлэг хоцрогдсон байдлыг дайсан шоолно гэж айхгүйгээр шүдээ зууж, чармайн сурах хэрэгтэй. Бидний өмнө хэрэм байна. Энэ хэрмийг олон тооны салбар мэдлэг бүхий шинжлэх ухаан гэж нэрлэдэг юм. Энэ хэрмийг бид заавал авах ёстой гэж их Сталины сургасныг цаг үргэлж санаж яв!» гэж бичсэн байна гэж хэлэв. Миний сэтгэл үнэхээр долгион бадарч Сталины хэлсэн үгийг өврийн дэвтэрт бичиж аваад, гэртээ ирж хэд дахин уншиж учрыг тодорхой ойлгоод тэр өдрөөс эхлэн орос хэл заалгадаг болов. Үүнээс хойш, орой бүр Виноградовын гэрээр очиж орос хэл заалгадаг болов. Хоёр сар илүү заалгаж бага зэрэг сонин, номын гарчиг зэргийг уншиж мэддэг, Виноградовын ярьсан зүйлийн заримыг ойлгодог болов. Ингэхдээ их баярлаж одоо ч орос хэл сурах нь байна гэж бодов.

Нэг өдөр одоо ч Сталины зохиолыг унших болсон гэж бодод бүтэн хагас хуудсыг арван хэд уншаад юу ч ойлгосонгүйд бүр ч урам хугарч, орос хэлийг ч сурдаггүй юм байна гэж бодтол, гэнт Сталины «...шүдээ зууж чармайн сурах хэрэгтэй...» гэж сургасныг санахтай зэрэг улам хатуужил, зориг орж дахин дахин уншиж зарим мэдэхгүй үгээ толиос харж, тэмдэглээд сүүлийн удаа уншихдаа тэр хуудсанд хэлсний хагас хугасыг ойлгосондоо хязгааргүй баярласан, ингэж өглөөнөөс орой болтол уншиж санасандаа хүрч байсан юм.

Ийм явдал олон олон тохиолдож байсныг хэлж барахгүй. Би нэг өдөр номын худалдаанаас жижиг зохиол авчраад орчуулахаар оролдов. Хүнд байсан боловч орчуулахад Сталины хэлсэн үг намайг улмаар зоригжуулж, бас Виноградовоос тусламж авч гурван сар шахам оролдож байж орчуулав. Миний тэр орчуулсан жижигхэн үгүүлэгийг эвлэлийн сэтгүүлд хэвлэсэн байна билээ. Хойно нь үзэхэд бас л засмаар юм их байдаг шүү. Үүнээс хойш Виноградовтойгоо ойр зуурын юмыг ярих болсон.

Хоёулаа кинонд хамт очиж, киноныг үгийг Виноградовоороо тайлбарлуулан ойлгодог болсон. Залуу эмч Виноградов, надад хичээл заахдаа өдөр бүр шинэ шинэ номыг заадаг, заримдаа сайхан үлгэр ярьж өгдөг. Заримдаа зохиолоос уншиж өгдөг. Вино-

градов бид хоёр, хоёр жил шахам үргэлж хамт хичээллэсэн. Ер уурлахыг мэддэггүй сонин хүн шүү. Заримдаа чээж бичгийн хичээл хийгээд, намайг олон алдсан байвал хүүхэд айлгаж байгаа юм шиг болсноо тэр дороо инээд алдчихдаг байсан юм.

Виноградов, шувуу агнах их дуртай хүн шүү. Бид хоёр нэг өдөр шувуу агнахаар явлаа. Цагаан нуурын хөвөөнд очоод нэг нугас буудчихав. Нугас, усны давалгаанд хөвөж цаашаа явахад би түүнийг авахаар усанд орж явтал гэнт хөл алдаж сандрахад, Виноградов учиргүй айж загас мэт шумбаж ороод намайг уснаас татаж гаргасан юм. Виноградов намайг авраагүй бол тэр дороо загасны хоол болох байсан юм. Түүнээс хойш, Виноградов шувууны анд явахдаа намайг усанд ер оруулдаггүйсэн.

Ингэж сайн нөхөр Виноградовын ачаар орос хэлийг төсөөлөх болж Сталины зохиолыг унших юмсан гэдэг хүслийнхээ эхэнд хүрч байна. Миний туйлын санаа бол Маркс, Энгельс, Ленин, Сталины гайхамшигт зохиолуудыг бүрэн уншиж ойлгодог болохыг хүснэ. Үүнд хүрэхэд их хол байна гэвч, «зоригоор уулыг давж, зүрхээр далайг гатална» гэгчээр санасандаа заавал хүрнэ гэж боддог. Чи ч хүрэх хэрэгтэй. Би чамайг сургахын тулд бүрэн тусална. Орос хэл бол ганц орос үндэстний хэл биш, дэлхийн хөдөлмөрчдийн марксизмын шинжлэх ухааны хэл юм. Сталины сургаал бол бидний хайрт эх орныг социализмын их ялалтад дэвшүүлж байна. Бид цөм давших хэрэгтэй. Чи бид хоёрын ингэж ярьж байгаа өдөр бол жирийн нэг өдөр биш, их Сталины 70 насны ойн өдөр байна. Чи энэ өдрөөс эхлэн Сталины зохиолыг уншихын тул орос хэлийг сурахын төлөө тэмц! гэж ярьж байтал гаднаас аймгийн шуудангийн хорооны зарлага Жамба, цаасанд боолттой юм барьсан орж ирээд, Зоригийн яриаг завсарлуулав.

Жамба, хуучин танил нөхрийн ёсоор гэрийн хүмүүсийн мэндийг мэдээд, зоригийн зүг хандаж,

— Танд хотоос ирсэн захидал авчрав гэж цаасанд боолттой юмаа өгөв. Зориг, гадуур боолтыг тайлбал түүний дотроос их Сталины шинэ хэвлэгдсэн зохиол гарахад Зоригийн нүүрт дүүрэн баясгалан бадарч, цааш үзвэл түүний дотно нөхөр Виноградовын гараар бичсэн захидал гарав.

Зориг, захидлыг хөгжилтэйгөөр уншиж чин сэтгэлээсээ баясгалангийн цог жавхланг бадруулан, Сталины шинэ ботийн анхны хуудсыг нээтэл, зоригийн үргэлж зүрхэндээ санаж явдаг Сталины хүндэт сургаалын үг тэр хэвээрээ бичээстэй байв.

За Дондог минь, чи өврийнхөө дэвтрийг гаргаад, Сталины энэ сургамжийг бичиж ав! Энэ үгийг үйлдвэр дээрээ машин хөдөлгөхдөө ном унших, бүх ажилдаа марташгүй санаж яв! гээд хоолойгоо засаж, яруухнаар уншсан нь: «Сурахдаа, биднийг ба бидний бүдүүлэг хоцрогдсон байдлыг дайсан шоолно гэж айхгүйгээр шүдээ зууж чармайн сурах хэрэгтэй. Бидний өмнө хэрэм байна. Энэ хэрмийг олон тооны салбар мэдлэг бүхий шинжлэх ухаан гэж нэрлэдэг юм. Энэ хэрмийг бид заавал авах ёстой...»

Сталины энэ үг бол дэлхийн олон зуун мянган сая шударга хүн бүхний зүрхэнд шингэсэн, «эрээд олдоггүй эрдэнэ, сураад олдоггүй сувд шиг» ийм үнэтэй сургаал байгаа юм гэж Зоригийн чанга дуугаар хэлэхэд, Дондог Жавзан хоёр нэгэн зэрэг бичиж авлаа.

По рассказу П. Хорло.

### Слова

нуулгүй не скрывая  
намтар биография  
дурсгах подарить на память  
бүдүүлэг невежество  
шоолох зд. смеяться, зубоскалить  
айх бояться  
салбар мэдлэг отрасль знания  
цаг үргэлж постоянно  
санаж явах помнить  
долгилох волноваться  
өврийн дэвтэр блокнот  
гарчиг заглавие  
урам хугарах разочароваться  
хатуужил стойкость  
толь [бичиг] словарь  
сүүлийн последний  
хагас хугас половина  
худалдаа(н) торговля, магазин  
оролдох стараться, стремиться  
үгүүллэг рассказ; сочинение  
хэвлэх издавать; печатать  
ойр зуурын обиходный; минимальный  
уурлах злиться, сердиться  
чээж бичиг диктант  
айлгах пугать  
инээд алдчих засмеяться  
шувуу(н) птица  
агнах охотиться  
дуртай любящий, желающий (что-л. делать)  
нугас(ан) утка

буудчих выстрелить  
давалгаа(н) волна  
хөвөх плавать; плыть  
хөл алдах тонуть  
шумбах нырять  
төсөөлөх разбираться, знать  
гайхамшигт замечательный, прекрасный  
гатлах переправляться  
дэвшүүлэх звать; поднимать, продвигать  
шуудангийн хороо(н) почтовое отделение  
зарлага зд. почтальон, письмоносец  
боолт зд. пакет, сверток  
завсарлуулах прервать  
баясгалан(г) радость, удовольствие  
цог жавхлан(г) подъем, вдохновение  
боть том  
хэвээр так как было, в таком же порядке  
бичээстэй написано  
сургамж учение, поучение, наставление  
марташгүй незабвенный; не забывая  
хоолойгоо засах прочистить горло (откашляться)  
ярухнаар прекрасно, хорошо  
шингэх проникать, доходить  
эрдэнэ драгоценность  
сурах зд. осведомляться, искать  
сувд жемчуг

## 41 ДӨЧИН НЭГДҮГЭЭР ХИЧЭЭЛ

### СҮХБААТАРЫН ЗОРЬСОН ҮЙЛС МӨНХ

Монголын ард түмний агуу их жолоодогч, чин зоригт Сүхбаатар бол ард түмнийхээ эрх чөлөө, тусгаар тогтнол, энх жаргалын үйлсэд бүх ухамсарт амьдралаа зориулсан билээ. Сүхбаатар, Чойбалсан нар Монгол Ардын Хувьсгалт Намыг бойжуулан хувьсгалын тэмцэлд хатуужуулсан билээ.

Тус намын удирдлагаар, Октябрийн их хувьсгалын ялалтын нөлөөгөөр Монголын ард түмэн, 1921 онд хувьсгалт тэмцлийг өрнүүлэн, гадаадын түрэмгийлэгчдийг өөрийн орноос хөөн зайлуулж, хар, шар феодалуудын дарлалаас ангижирсан билээ.

Байлдан олсон эрх чөлөөгөө гадаадын империалистүүд, дотоодын феодалуудаас хамгаалахын тул ардын дайснуудтай хайр найргүй тэмцэж хувьсгалыг улам гүнзгийрүүлэгтүн гэж Монголын ард түмэнд Сүхбаатар гэрээсэлсэн юм. Монголын ард түмэн, ардын хувьсгалт нам ба маршал Чойбалсангийн удирдлагын дор Сүхбаатарын энэ гэрээсийг ариунаар биелүүлсэн билээ.

Сүхбаатар бол Монголын ард түмний хувь заяаг их Зөвлөлт орны ард түмэнтэй ах дүүгийн бат найрамдлын зангилгаагаар холбож, энэ найрамдлыг бэхжүүлэхэд манай ард түмний төр, эдийн засаг, соёлын байгуулалтын амжилт, манай эх орны эрх чөлөө, тусгаар тогтнолын баталгаа оршино гэж гэрээсэлсэн юм. Монголын ард түмэн, Сүхбаатарын энэ гэрээсийг ариунаар биелүүлсээр байна.

Их Сүхбаатар, Монгол ардын хувьсгалт намын нэгдлийг болд мэт бат болго гэж гэрээсэлсэн юм. Монгол ардын хувьсгалт намын гишүүд, Сүхбаатарын энэ гэрээсийг ариунаар биелүүлж байна.

Эх орныхоо батлан хамгаалах хүчийг зузаатга гэж Сүхбаатар гэрээсэлсэн юм. Монголын ард түмэн, ардын хувьсгалт намынхаа удирдлагын дор Сүхбаатарын энэ гэрээсийг ариунаар биелүүлсээр байна.

Жанжин Сүхбаатар, хөдөлмөрчин ардын засаг төрийг бататга гэж гэрээсэлсэн юм. Монголын ард түмэн, Сүхбаатарын энэ гэрээсийг ариунаар биелүүлж байна.

Монголын хөдөлмөрчин ард түмэн, Монгол ардын хувьсгалт намыг үүсгэн байгуулагч бөгөөд ардын хувьсгалыг зохион байгуулж удирдсан Сүхбаатарынхаа эрхэм гэрээсийг чин батаар дагаж гүйцэтгэж байгаагаар, улсын эдийн засаг, соёл боловсролын их хөгжил, ард улсынхаа бүтээн босгох агуу үйлсийн үлэмж амжилтаар батлан үзүүлж байна. Малчин ардын эрх чөлөөт баясгалант хөдөлмөр нь, ардын чинээлэг баялгийн үндэс сурвалж нь болж, монголын ард түмний төрийн хүчин чадлын сурвалж нь болжээ.

Монголын ард түмэн, германы фашизмтай байлдсан Зөвлөлтийн ард түмний эх орны их дайны үед Зөвлөлтийн арми ба Зөвлөлтийн ард түмнээс нийтийн дайсныг дарахад нь тусалснаараа Сүхбаатарын гэрээсэд хязгааргүй үнэнчээ үзүүлэв.

Монголын ард түмэн 29 жилийн туршид аймшиггүй эрэлхэг зоригт Сүхбаатарынхаа заасан замаар, түүний намын тугийн дор, түүний дотно нөхөр маршал Чойбалсангийн жолоодлогоор явж капиталист бус хөгжлийн зам, бүх дэлхийн хөдөлмөрчдийн суут жолоодогч Ленин-Сталин нарын заасан социализмд хүрэх хөгжлийн ганц зөв замаар давшин ирэв.

Аймшиггүй Сүхбаатарын зорьсон үйлс мөнх!

**зорих** стремиться; намереваться; иметь  
 цель  
**үйлс** дела  
**чин зоригт** смелый, волевой  
**энх жаргал** счастье  
**бойжуулах** эд. основать  
**хатуужуулах** закалять  
**түрэмгийлэгчид** захватчики  
**шар(а)** желтый  
**ангижрах** избавиться  
**хайр найргүй** беспощадно  
**гүнзгийрүүлэх** углублять  
**гэрээс** завещание  
**гэрээслэх** завещать  
**ариунаар** свято, свяшенно

**найрамдал** дружба  
**зангилгаа(н)** эд. узы; узел  
**нэгдэл эд.** единство, монолитность  
**болд** сталь  
**батлан хамгаалах хүч** оборонная  
 мощь  
**зузаатгах** укреплять  
**жанжин** командующий, полководец  
**хөдөлмөрчин** трудящийся  
**чин батаар** крепко  
**дагах** следовать  
**бүтээн босгох** созидать; созидатель-  
 ный  
**сурвалж** источник

## 42 ДӨЧИН ХОЁРДУГААР ХИЧЭЭЛ

### ХОРЛООГИЙН ЧОЙБАЛСАН

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын ерөнхий сайд, Монгол Ардын Хувьсгалт Намын Төв Хорооны Улс Төрийн Товчооны гишүүн, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Их Хурлын депутат, манай нам ба ард түмний жолоодогч, манай аврагч хамгаалагч бөгөөд түшиг тулгуур болсон Зөвлөлт Холбоот Улсын үнэнч хань Хорлоогийн Чойбалсан удтал хүндээр өвчилсний дараа 1 дүгээр сарын 26-нд нас барав.

Хорлоогийн Чойбалсан 1895 оны 2 дугаар сарын 8-нд ядуу ардын гэр бүлд төржээ.

Гадаадын боолчлогчдын тэсвэрлэшгүй хүнд дарлал ба балмад харгис явдлууд болон феодалуудын хатуу ширүүн мөлжлийг бага насандаа гаталж туулсан Чойбалсан өөрийн ард түмнийг гадаадын эзлэгчид ба феодалуудын дарлалаас чөлөөлөх үйл хэрэгт бүх амьдралаа зориулахаар эрс шийдвэрлэсэн юм.

Нөхөр Чойбалсан 1918 оны эцсээр хувьсгалт нууц бүлгэмийг байгуулав. Энэ бүлгэм нь удалгүй Сүхбаатарын удирдсан хувьсгалт нууц бүлгэмтэй нийлэв. Энэ үеэс Сүхбаатар-Чойбалсан хоёрын хамтарсан хувьсгалт үйл ажиллагаа ба чин үнэнч дотнын нөхөрлөл эхэлсэн юм.

Монголын ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөөний тэмцлийг манлайлан удирдсан Монгол Ардын Хувьсгалт Намыг Сүхбаатар, Чойбалсан нар 1921 онд байгуулав.

Сүхбаатар, Чойбалсан тэргүүтэй Монгол Ардын Хувьсгалт Намын удирдлагын дор Оросын пролетари нарын шийдвэрлэх

тусламжтайгаар Монголын ард түмэн, 1921 онд ардын хувьсгалыг мандуулж, гадаадын боолчлогчдыг өөрийн орноос хөөн зайлуулав.

Их Зөвлөлтийн ард түмэнтэй манай ард түмэн үүрд эвдэршгүй ах дүүгийн ёсоор найрамдахын үндсийг Сүхбаатар, Чойбалсан нар тавьсан юм. Сүхбаатар, Чойбалсан тэргүүтэй Монгол Ардын Хувьсгалт Нам, ардын ялалтат хувьсгалыг мандуулаад манай тусгаар тогтносон ардын төрийг байгуулж бэхжүүлэхэд шинэ ялалтууд өөд манай ард түмнийг жолоодов.

Аймшиггүй Сүхбаатар нас барсны дараа нам ба улсыг удирдах ажлын бүх хүнд хүчир нь нөхөр Чойбалсан дээр тохогдсон юм. Чойбалсан, хувьсгалын бүх дайснуудтай цогт хувьсгалч эвлэршгүй тэмцлийг хийж манай намыг цуцалтгүй бэхжүүлж, хатуужуулсан юм.

Манай нам, Ленин, Сталины сургаалыг баримтлан, Чойбалсангийн удирдлагын дор манай орныг капиталист биш замаар хөгжүүлэх ганц зөв бодлогыг сонгон авлаа.

Манай эх орон 30 гаруй жилийн турш эрх чөлөөтэй тусгаар тогтнон, хөгжиж цэцэглэхдээ олсон бүх гайхамшигт амжилтууд бол нөхөр Чойбалсангийн нэртэй шууд бөгөөд нягт холбоотой юм.

Нөхөр Чойбалсан хамгийн идэвхтэй оролцож, зоригжуулж, зохион байгуулаагүй ямар нэгэн чухал явдал манай нам ба улсын түүхэнд үнэхээр нэг ч байхгүй юм. Нөхөр Чойбалсангаас их Зөвлөлт Холбоот Улсын ард түмэнтэй манай ард түмний найрамдлыг бүх талаар бэхжүүлэн, хөгжүүлсэн бөгөөд энэ найрамдал бол манай улс эрх чөлөөтэй тусгаар тогтнон оршихын баталгаа, манай бүх амжилтын үндэс, социализмд орох замаар урагшаа явах манай амжилттай давшилтын баталгаа мөн юм.

Герман фашистын эзлэгчдийн эсрэг Зөвлөлтийн ард түмний эх орны дайны өдрүүдэд Монгол-Зөвлөлтийн ард түмнүүдийн агуу их найрамдал онц тод бөгөөд хүчтэй илэрсэн юм. Монгол Ардын Хувьсгалт Нам ба нөхөр Чойбалсан зоригжуулж удирдсан монголын ард түмэн, нийтийн дайсан германы фашизмыг ялах хэрэгт нь ах дүү Зөвлөлтийн ард түмэнд бүх чадлаараа туслах явдлыг өөрийн гол зорилт гэж эх орны их дайны анхны өдрүүдээс эхлэн үзсэн юм.

Манай ард түмэн, манай орны зэвсэгт хүчин, Монгол Ардын Хувьсгалт Нам ба нөхөр Чойбалсангийн удирдлагын дор, агуу их Зөвлөлтийн ард түмэнтэй ах дүү ёсоор хамтран найрамдаж, Зөвлөлтийн баатар армитай хөтөлцөн явж, японы империализмийг бутцоох хэрэгт бүх чадлаараа өөрийнхөө хувь нэмрийг оруулсан юм.

Нөхөр Чойбалсан, манай орны бүх хөдөлмөрчин олон түмэн-ардтай өргөн дотнын холбоотой байсан юм. Манай ард түмэн өөрийн жолоодогч эцэг бөгөөд хань нөхөр Чойбалсангаа хэзээд халуун дотноор хайрладаг юм. Манай эх орны тусын тулд ба цэцэглэлт, манай орны хөдөлмөрчид нэг бүрийн тусын тулд

зориулсан нөхөр Чойбалсангийн гайхамшигт хувьсгалч зүтгэлийг манай ард түмэн өндрөөр үнэлсэн юм.

Манай ард түмэн, аугаа их ач гавьяаг нь тэмдэглэн нөхөр Чойбалсандаа Бүгд Найрамдах Монгол Ард Улсын баатар гэдэг дээд цолыг хоёр удаа өргөмжлөн олгосон юм. Нөхөр Чойбалсан, Сүхбаатарын одонгууд, байлдааны улаан тугийн одонгууд, хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон, алтан гадас одон ба бусад медалиудаар шагнагдсан юм.

Монгол ба Зөвлөлтийн ард түмний аугаа их найрамдал ба хамтын нягт ажиллагааг бэхжүүлэх, эх орны их дайны өдрүүдэд Зөвлөлтийн ард түмэнд туслах ажлыг зохион байгуулсан ба японы империализмийг бутцоохихын төлөө тэмцэлд гарамгай гавьяа байгуулсныг тэмдэглэн СССР-ийн Дээд Зөвлөлийн Тэргүүлэгчдийн Газраас нөхөр Чойбалсанг Лениний одонгоор хоёр удаа улаан тугийн одонгоор хоёр удаа, Суворовын нэгдүгээр зэргийн, одон ба медалиудаар шагнасан юм.

Нөхөр Чойбалсангийн гайхамшигт бүх амьдрал ба үйл ажиллагаа бол манай намын гишүүд нэг бүрд, манай орны шударга хөдөлмөрчин нэг бүрд ард түмэндээ амь бие хайрлахгүй зүтгэх манай эх орны тусын тулд алдарт шинэ гавьяа байгуулахад биднийг уриалан дуудсан хурц жишээ юм.

Манай хайрт жолсодогч, манай хань бөгөөд дайчин нөхрөөсөө хагацсан явдалд бид хязгааргүй харамсан гашуудна.

БАЯР	ЛУВСАН	УДВАЛ
БУМЦЭНД	ЛХАМСҮРЭН	ЦЭДЭВ
ДАМБА	МАЙДАР	ЦЭДЭНБАЛ
ДАНГААСҮРЭН	НОРОВСАМБУУ	ШАРАВ
ЖАМБАЛДОРЖ	СОСОРБАРАМ	ШИРЭНДЭВ
ЛАМЖАВ	СҮРЭНЖАВ	

«Үнэн», № 23, 27. I. 1952 г.

### С л о в а

**аврагч** спаситель, защитник  
**түшиг** опора, оплот  
**удтал** долго  
**өвчлөх** болеть  
**нас барах** умереть  
**мөлжил** эксплуатация  
**бага нас(ан)** детство  
**гатлах** преодолеть, пройти  
**бүлгэм** кружок  
**нийлэх** слиться, соединиться  
**нөхөрлөл** дружба  
**ялалтат** победоносный  
**найрамдах** дружить  
**аймшиггүй** бесстрашный, неустрашимый, смелый  
**хүнд хүчир нь** тяжесть  
**тохогдох** быть возложенным  
**цогт** пламенный

**давшилт** наступление, продвижение  
вперед  
**эзлэгчид** захватчики, оккупанты  
**нийтийн** общий  
**хамтран найрамдах** сотрудничать  
**хөтөлцөн явах** итти рука об руку  
**хувь нэмэр(и)** вклад, лепта  
**хэзээд** всегда  
**хувьсгалч** зд. революционный  
**аугаа их** великий  
**өргөмжлөх** зд. присвоить  
**Дээд Зөвлөл** Верховный Совет  
**тэргүүлэгчдийн газар** президиум  
**зэрэг зд.** степень  
**амь бие хайрлахгүй** не щадя своей жизни  
**хагацах** расставаться  
**харамсах** сожалеть  
**гашуудах** скорбеть, быть в трауре

## ЭЦЭГ ХҮҮ ХОЁР

— Өвгөн гуай хайчих нь вэ? гэж асуухад,  
 — Өнөө сургууль уруу очье гэж өвгөн хариулав.  
 — Та хүүгийнхээ сургуулийг ганцаараа яваад олох юм уу?  
 — Ололгүй яхав, хүү минь, өчигдөр засмал замаар ирж явахад, арван жилийн сургууль энэ гэж хүүхдүүд зааж өгсөн юм.  
 Тэгээд сургууль тийш очиход нь замын хоёр талаар ажилдаа яарсан хүмүүс, хүүхдүүд, цэргийн залуучууд нааш цаашаа зөрж байна.

Дамдин хүүтэйгээ уулзав. Хүү нь асуув:

— За, Улаанбаатар маань ямар байна, ааваа?

— Ай даа, Улаанбаатар гэдэг минь, ёстой л баатар гэдэг нэр — тэйгээ тэнцсэн бардамнаж ханашгүй хот болж байгаа юм байна. Ямар сайхан зам, яасан олон сайхан байшин гэж байдаг юм бэ дээ.

— Тийм, хараач ааваа, энэ бас барьж байна. Тэр барьж байгаа бол манай шинэ театр, бас тэр бол киноны барилга, үүгээр сайхан цэцэг навчтай, түүн шиг цэцэрлэг босно гэж цэцэрлэгийг заав. Тэр хараач ааваа, ухаа хонгор морио унаад, Сүхбаатар жанжин маань урагшаа гэж заагаад өндөр бартааг давж харайлган яваа байдлыг илтгэн дууриалгасан хөшөө гэж заав.

Хөөрхий минь, Сүхбаатарынхаа хөшөөг аав нь очиж бүр тухтай үзнэ гээд эргэж, энэ бас сайхан барилга гэж хажууд нь сүндэрлэн босож байгаа барилгыг харна.

— Тиймээ, энэ бол Гадаад яамны барилга, наад нүүрэндээ 48 тулгуур том баганатай, гялалзсан сайхан чулуун шатуудыг тавина, одоо хоёулаа үзэх үү?

— Хүү минь яарамгүй бол үзье гээд явсаар хоёулаа барилгын гаднахь том хаалгаар оров. Өмнө нь лужир бүдүүн гол багана моднууд, чулуу болтол нь түлж өрсөн туйпуу бүдүүн нарийн, төмөр утсан хоолойнууд, ширхгий нь ялгасан элс, шохой зуурч бэлтгэсэн шавар зэрэг барилгын бүтээлд холбогдох элдэв материал харагдана. Барилгын үүдээр орж явахдаа,

— Энэ барилгын сүүрийн анхны чулууг, маршал Чойбалсан өөрийн гараар 1946 оны 4-дүгээр сарын 26-нд тавьсан юм. Энэ оны 10 дугаар сарын нэгэнд яг дуусаж жинхэнэ албан ажил эхлэхэд бэлхэн болох юм гэж хүү нь хэлэв.

— Мөн амархан босох нь ээ.

— Тэхгүй-ях вэ, аав минь, үүний чинь аль юугий нь хэдийд босгох, бүх юм нь төдийд бэлэн болно гэсэн айхтар нарийн төлөвлөгөөтэй юм шүү дээ. Тэгээд энэ бол сүүлийн үеийн барилгын нарийн нандин шинэ арга техник, их ажиллагаа орж байгаа юм гэж нэмж хүү нь хэлэв.

(Төгсөөдүй)

**хайчих** куда итти  
**өнөө** *эд.* тот самый  
**уруу** *послелог* в, к, в сторону  
**ололгүй яахав** как же не найти  
**ай даа** да; так, действительно  
**тэнцэх** быть равным; соответствовать  
**бардамнах** *эд.* гордиться  
**ханах** удовлетвориться  
**хараач** смотри же  
**үүгээр** здесь  
**навч** листья, лист, листва  
**цэцэг** цветок  
**уухаа хонгор** светложелтый, светло-  
 соловый, светлорыжий (*о масти лошадей*)  
**унах** *эд.* ездить верхом, сесть (на-  
 пример, на коня)  
**урагшаа** вперед  
**бартаа** скала, валуны; препятствия  
**харайлгах** скакать, пустить взапуски  
**илтгэн дууриалгах** показывать, ото-  
 бразить  
**хөшөө(н)** памятник  
**хөөрхий** *эд.* восклицание почтитель-  
 ности или изумления  
**тухтай** не спеша  
**хажууд** возле, около

**сүндэрлэх** возвышаться  
**наад** находящийся по эту сторону,  
 на этой стороне  
**нүүр(эн)** лицо; сторона, фасад  
**тулгуур** опора, подставка  
**багана** колонна  
**яарамгүй** не спеша  
**гаднахь** внешний, наружный  
**лужир** громадный, гигантский  
**бүдүүн** толстый  
**түлэх** обжигать  
**өрөх** *эд.* складывать, сложить  
**туйлуу** кирпич  
**хоолой** *эд.* труба  
**ширхэг** штука; крупинка  
**ялгах** отделять, сортировать  
**элс(эн)** песок  
**зуурах** месить  
**шавар** глина, штукатурка  
**холбогдох** быть связанным (*с ч.м.-л.*)  
**амархан** легко  
**тэхгүй яах вэ** конечно, как же иначе  
**аль** который  
**хэдийд** когда  
**төдийд** тогда  
**айх(ав)тар** очень, исключительно  
**нарийн нандин** точнейший, тончай-  
 ший

## 44 ДӨЧИН ДӨРӨВДҮГЭЭР ХИЧЭЭЛ

### ЭЦЭГ ХҮҮ ХОЁР

(Төгсгөл)

Эцэг хүү хоёр энд энэ барилгын суурийг анх малтах өдрөөс эхлэн ажилласан барилгын дарга Дүгэржавтай уулзав. Нөхөр Дүгэржав тэр хоёрыг дагуулан явж, дорд давхарт оров. Тэдний эгц өмнө нь нэг томоохон тасалгааны үүдэн дээр ирээд хоёр тийш очсон төв гудамжийг заав.

— За энэ багануудын толгойн гоёлол чимэг нь одоо хийгдэнэ. Энэ баруун тасалгаа бол зочдыг хүлээж авах өрөө юм. Бүх өрөөний тааз нь цөмөөр цэцгэн хээгээр чимэх юм гэж тэр чимгийн зүйлсийн заримыг үзүүлэв. Цаашлаад, энэ бол зочлогын өрөө, наад талаараа зэргэлдээ ийм гурван хаалгаар хэчнээн ч хүн чөлөөтэйгөөр нааш, цааш нь орж гарна гэв.

Ингээд дорд давхрын тасалгаа болгоноор явахад шил зүсэх, мод огтлох, цонхны рам мод тааруулах, хадах, зүйх, энд тэнд

хөрөөдөх, цавчих, угаах, будах, нүхлэх бүх ажил нь явж байгааг өвгөн их л бахдан хараад, дээд давхарт гарав. Нөхөр Дүгэржав энэ бол дээд давхрын төв гудамж нь юм. Энэ барилгын дээд дорд бүх өрөө нь модон шалтай байх юм. Ганцхан гал тогооны өрөөний шал нь өнгийн чулуугаар нүдэлж тавьсан чулуун шал байна гээд, тэр дуб модон шалыг ямар янзтай нүдлүүлэн зүйж тавихыг харуулав.

— Энэ нүхнүүд чинь ямар хэрэгтэй юм бэ гэж өвгөн гэнт сонирхож асуув.

— Энэ бол чийдэн, харилцаа, уурын зуухны элдэв бүдүүн нарийн утас хоолойнууд сүлжих юм гэж хүү нь хэлэв. Тэгээд тэд дээд дээвэр дээр нь гарав. Богд уулын ногоон хөндийн зүгээс урсан ирж байгаа зуны сэрүүн сайхан салхи тэдний нүүрийг илбэн таалж байна.

— Хот маань ямар шүү харагдаж байна, ааваа?

— Тун хачин сайхан байна. Хүү минь, ямар сайхан хот вэ? яасан сайхан хөгжил бэ гэж бодохоос илүү сайшааж хэлэх юм аавд нь олдохгүй л байна гэж, тойрон харахад хол баруун аймгийн буурал өвгөн, нутгийн уулын орой дээр гараад, тойрныг харахад өндөр өндөр цаст уулс, өргөн хээр тал, өвст ургамалт хөндийнүүд, багтаж ядан багширсан мал сүрэг нь харагддаг бол, хотын ерийн нэг өндөр барилга дээрээс тойрон харахад нутгийн өндөр өндөр уултай эн булаалдсан барилгууд, засмал зам, дурсгал хөшөө, цэцэрлэг, сургууль, үйлдвэр завод, хашаа, цагаан гэрүүд харагдана.

— Тэр хумбагар оройтой чинь ямар газар вэ?

— Тэр бол маршал Чойбалсангийн нэрэмжит улсын их сургууль, Монгол улсын маань соёл эрдмийн өв хуралдсан газар, тэр баруунтай байгаа маршал Чойбалсангийн нэрэмжит, манай арван жилийн сургууль, тэр Туул голын хөвөө дахь шинэ хүчний дээд сургууль, гэж хүү нь аавдаа хотын хөгжил бүхнийг заав. Тэндээсээ тэд, энэ барилгын дээврийн бүтээсэн хэсэг, одоо босож байгаа хэсэг барилгын дээврийн нуруу хэсгүүдийг үзээд доошоо бууж гадаад яамны ажилтны байрыг үзэв.

— Ай даа мөн сайхан юм үзлээ, эрдэм боловсролтой хүний ухаан гэдэг энэ дэлхий дээр юуг ч бүтээдгийг мэдлээ. Сайхан юм үзүүлсэн хүүдээ баярлав, гэж нөхөр Дүгэржавын гарыг атгаж өвгөн гадагшаа гарав.

Тэгээд эцэг хүү хоёр шууд жанжин Сүхбаатарын хөшөөг чиглэн явлаа.

По рассказу Б. Басто.

### С л о в а

**Малтах** копать, рыть; заложить  
**Дорд** нижний  
**Томоохон** большой  
**Тийш** *последлог* к, в, в сторону  
**Гудамж** *эд.* коридор  
**Гоёлол** украшение; наряд

**Зочид** гости  
**Өрөө** комната, зал  
**Цэцгэн хээ** узорный, узор из цветов  
**Цаашлах** итти дальше  
**Зэргэлдээ** соседний, стоящий рядом.  
**шил** стекло

зүсэх резать, разрезать  
огтлох резать ножом; рубить  
гааруулах подгонять; подбирать  
зүйх плести; пришивать; приладить  
хөрөөдөх пилить  
цавчих рубить  
угаах мыть  
будах красить  
нүхлэх [про]дыривить, делать отверстие

гал тогооны өрөө кухня  
чулуу(н) камень  
нүдэлж тавих сложить узорами  
гэнт вдруг, неожиданно  
чийдэн электролампочка  
уур пар  
уурын зуух батарея парового отопления  
зуух печь, печка  
сүлжих *зд.* сплетаться; перекрещиваться  
дээвэр крыша  
ногдон зеленый

хөндий долина  
урсах течь  
сэрүүн свежий, прохладный  
илбэн таалах ласкать  
хачин сайхан прекрасно, чудесно  
тойрон вокруг  
цаст снежный  
хээр тал(а) степь, поле, безлюдное место  
ургамал растение  
багтаж ядах вмещаться с трудом; тесниться  
багшрах тесниться, толпиться  
ерийн обычный, обыкновенный  
эн булаалдах *зд.* соревноваться  
хумбагар округлый  
эрдэм образование; знание, ученость  
өв сокровищница; наследие  
баруунтай на западе  
хөвөө(н) *зд.* берег  
нуруу(н) *зд.* гребень, самая вершина  
гадагшаа наружу, на двор

## 45 ДӨЧИН ТАВДУГААР ХИЧЭЭЛ

---

### СУРАГЧ

Дорж сандран гүйж ирсэн бололтой, амьсгаадан орж ирээд, суудалдаа суув. Төдхөн нөхөд нь ч ирцэгээв. Цэрмаа охин бодлого бодож эхлэв.

— Аяар! Би ном уншиж байна гэж Дорж хэлэв. Дорж ямархан нэг юм тогтоон чээжлэх бололтой аман дотроо шивнэнэ. Хоёрын А гэсэн нэртэй энэ ангид залуухан эмэгтэй орж ирмэгц, сурагчид босцогоов.

— Сайн байцгаана уу? гэж багш асуусанд,

— «Сайн» гэж нэг зэрэг хариулав. Өглөөний давтлага явагджээ. Дараа нь багш:

— Дорж, Очир, Гомбо нар их сайн давтсан байна. Сүрэн чи муухан байна шүү, хичээл сайн давтах хэрэгтэй шүү. Та нар одоо улам мэрийх цаг боллоо шүү. Хэд хоног үлдсэн билээ? Дорж! Дорж босон номхон зогсоод,

— Арван тав... гэж хариулав.

— Зүйтэй! Суу! Хагас сар л байна шүү дээ. Юу байх вэ дээ, гадаа ороод ирлээ. Манай ангийн сурагчид сайн сурч чадна гэсэн шүү дээ. Тэгээд та нар хэлсэн үгэндээ хүрч чадахгүй бол ичгүүртэй биз дээ. Намынхаа их хурлын төлөөлөгчдөд юугаа хэлэх

билээ? хэлэх үггүй шүү... та нар бас хожим том болоод намынхаа их хуралд очно шүү дээ. Тэхэд чинь нэг сургуулийн сурагчид муу сурчихсан байвал, уучлахгүй биз дээ. Яасан ичгүүртэй юм гэх болно биз дээ гэж тайлбарлан ярьж байна. Дорж гараа өргөж зөвшөөрөл аваад,

— Багшаа! Би хэдэн настайдаа, намын гишүүн болох вэ? гэж асуув.

— Арван найм хүрээд л орж болно доо гэж, багш инээмсэглэн хариулав.

— Найман жил болоод уу? бас удах нь байна даа... гэж аяархан хэлээд суув.

— Сурагчдаа! та нар бүгдээр намын гишүүн болох дуртай биз дээ? гэж багш нь туршин асуув.

— Дуртай! гэж олон янзын хоолойгоор ян хийтэл хариулцгаав.

— За тэгвэл хожим намдаа элсэхийн тулд эхлээд пионер болох хэрэгтэй. Тэгээд эвлэлийн гишүүн болж, дараа нь намын гишүүн болдог юм шүү дээ. Мэдэв үү?

— Мэдлээ! гэж бүгдээр урьд адил хэлэв. Дорж номынхоо савнаас дөрвөлжин эвхсэн цаас гаргаж багшдаа өхөөр сарвайж:

— Би пионер больё гэж хүссэн юмаа. Та намайг 2 дугаар бүлгийн удирдагч багшид хэлж өгөөч! гэж хэлэв. Түүнд бичсэн нь: пионерийн 3 дугаар дружинийн 2 дугаар бүлгийн удирдагч хүндэт багшаа! Би пионер болох гэсэн юмаа. Хожим намын гишүүн больё гэсэн юмаа. Нэгдүгээр улирлын шалгалтаар чээж бичигт нэг алдаж ганц хэл бичгээр сайн гарсан, одоо заавал бүх хичээлдээ онц сайн сурч чадна. Би бас пионерийн тангараг сайн мэднэ. Багш намайг шалгаж үзээрэй! Би намынхаа их хурлын төлөөлөгчдөд үзүүлнэ гэж алдарт нам гэдэг дуу сурсан. Улаан галстук гэдэг шүлэг чээжилсэн. Бас гурван танц хийж чаддаг болсон шүү. Намайг пионерт авна уу? Би сахилга баттай сайн пионер болж чадна. Сурагч Дорж гэжээ.

— Би бас пионер больё гэгцгээж хүвгүүд, охид гараа өрөгцгөөв.

— За... чимээгүй! та нарыг цөмий чинь пионер болгож болно. Харин пионер бүхэн онц сайн, сайн сурдаг юм шүү гэж багш нь хэлэв. Хичээл тараад Дорж харив.

— Ээжээ, ээжээ! би одоо пионер болно. Нөгөөдөр болно. Надад өнөөх улаан торгоороо галстук хийж өх үү? гэж асууна.

— Ээж нь: хийж өгөлгүй яах вэ. Маргааш оёод өгье гээд энхрийлэн, духан дээр нь үнсэнэ. Баярласан хүү эгч тийшээ очиж:

— Эгчээ! би одоо пионер болно. Та намайг энгийн хүн гэж хэлдэг билүү? Би одоо энгийн хүн биш! пионер хүн, ээж над торгоор сайхан галстук хийж өгнө л дөө гэж эгчдээ хэлэв.

— Тэгсэн ч гэсэн, чи бол зөвхөн пионер, би бол, эвлэлийн гишүүн. Ийм сайхан тэмдэг зүүдэг! гэж тэмдгээ арчиж дүүдээ үзүүлнэ.

— Би арван тав хүрээд эвлэлийн гишүүн болно л доо. Сайхан тэмдгий нь зүүнэ.

— Чи эвлэлийн гишүүн болсон ч гэсэн... намын гишүүн биш. Би бол намынхаа их хуралд очно. Ай бас сайхан байна даа гэж эгч нь улам хоры нь хөдөлгөнө.

— Би намын гишүүн болно шүү! Багш намайг найман жил болоод намд орно гэсэн юм... гээд тачгинатал инээж эгчийнхээ амыг бяцхан алгаараа таглаж үг хэлүүлэхгүйг чармайна. Ном уншиж байсан аав хүүгээ хараад,

— Миний хүү наашаа ир! Хүүгий минь битгий оролд! Миний хүү хожим намын гишүүн болоод намынхаа их хуралд очилгүй яах вэ. Миний хүү Чойбалсан шигээ эрдэмтэн баатар болох хэрэгтэй шүү гэж толгойг илж үнсэн таална.

Дорж дараа нь хичээлээ давтахаар өөрийнхөө ширээ тийшээ очив.

По рассказу М. Гадаамбы.

### С л о в а

гүйж ирэх прибежать  
амьсгаадах учащенно дышать  
төдхөн вскоре  
бодлого бодох решать задачу  
аяар тихо; тише  
чээжлэх учить, запоминать  
шивнэх шептать  
босцогоох вставлять  
нэг зэрэг одновременно, дружно  
мэрийх стараться, проявлять усердие  
зүйтэй верно, правильно  
гадаа ороод ирлээ остается небольшо-  
шой срок (до чего-л.)  
хэлсэн үгэндээ хүрэх сдержать свое  
слово  
ичгүүртэй стыдно  
хожим потом, после  
том болох вырасти, стать взрослым  
тэхэд тогда

уучлах извинять, прощать  
аяархан тихо; медленно  
хоолой эд. голос  
ян хийтэл четко, громко  
олон янзын разный  
элсэх вступить, поступить  
мэдлээ понял, понятно  
номын сав портфель  
эвхэх сложить  
сарвайх протягивать руку  
тангараг клятва, обещание  
шүлэг стих, стихотворение  
хоры нь хөдөлгөх дразнить  
тачгинатал громко, звонко  
алга(н) ладонь  
таглах закрыть, затыкать  
битгий оролд не обижай, не дразни  
илэх гладить  
таалах ласкать, нежить

## 46 ДӨЧИН ЗУРГААДУГААР ХИЧЭЭЛ

### БАГШ ЗАСЛАА

Гэрийн хойморт улаан дээлтэй, эсгий гуталтай, тавь орчим настай, буурал сахалтай өвгөн, нэг номын зургийг гайхаж байгаа маягтай харна.

Зүүн талд нь дөч хир настай авгай оёдлын машинаар юм оёж байснаа, цагаа харччаад, хийж байсан юмаа эмхлэн хурааж нэг шүүгээ онгойлгож хатуу хавтастай ном гаргаж ирээд хавтсыг нээв.

Зүүнтэй суусан авгай, багш минь цагаасаа ганц ч минут хожимддоггүйсэн Өнөө яасан юм бол, 5—6 минут өнгөрлөө гэтэл,  
— Ирнэ гэсэн хойно ирэлгүй хайчхав? Хоёулаа харин давтаж суух уу? гэж өвгөн хэлэв.

Өнөөдөр чинь, 33 дугаар хичээлийг шинээр заана. 32 дугаар хичээлээ сайн уншаад, цэвэрхэн хуулаад байгаарай гэсэн шүү дээ. Та хуулсан уу?

— Би, орой чамайг хорины хуралд очиход хуулчсан, харин нэг мэдэхгүй үг гараад байна.

— За ертөнц гэхэд «Т»-гийн дараа, «О» байх уу?, «Ө» байх уу?

— Ном дээр чинь аль нь байна?

— «О» байна.

— За тэгвэл «О» л байгаа биз.

— Арай ч ямар бол, миний санахад «Ө» баймаарсан.

— Мэддэг чинь хэтэрч эхэлжээ. Наад номыг чинь хийсэн хүн, чи бид хоёроос л дор байв гэж үү дээ.

— За чамд ямар хамаатай юм бэ? Эр нэг алддаг, эрэг нэг нурдаг гэдэг юм. Энд лав алдсан байна.

— За яагаад?

— Яагаад гэнээ! Харж байна уу? чи, урьдахь хичээлээсээ мартаж байгаа юм байна шүү дээ. Давт хөө, сайн давт!

— Үгүй та сайн давтсан яараа хэлээд орхи!

— Үгийн эхэнд «Е» үсгээр эхэлсэн бол, дараа нь «Ө» байх ёстой. Мэдэв үү?

— Жишээлбэл:

Аа чи асууж байгаад бүгдий нь хэлүүлж авах нь уу?

— Үгүй яахав мэддэг юм бол хэлээд орхи.

— Жишээлбэл үү? Өндөр, өргөн... Ертөнц гэхэд эхлээд «Ө» биш «Е» байна шүү дээ.

Үгүй тэгсэн ч гэсэн, «Е» -гийн дараа яагаад ч гэсэн «О» дагахгүй, заавал «Ө» дагана.

Тэнэг хүн тэг дундуур нь гэдэг, мань хүн одоо нэг багшид загнуулах нь, чи хэчнээн ч сураад ном өөрчилж чадахгүй. Хүү минь горьдохын зовлон,

— Харж байгаарай, «Ө» дагахгүй бол, би юу болох болдоо?

— «О» дагахгүй бол би яах болдоо гэж хоёулаа дахин, дахин маргалдаж, нэг, нэгэндээ уурлалцгааж, бараг номоороо шидэлцэх дөхтөл, гаднаас хашааны өвгөн Болд орж ирэв.

— За чи Болд гуайгаас асуудаа. Мань өвгөн, бид хоёрыг бодвол, мэднэ байх.

— За та хоёр яагаад час улаан болчоод, мэддэг, мэддэггүй-дээ хүрчээд сууцгааж байна вэ?

Юун дээрээс маргалдав.

— Болд гуай та энд бичээд орхи. Ертөнц гэхэд «Т» -гийн дараа «Ө» «О» хоёрын аль нь байх вэ?

— Ертөнц гэнэ үү? гэж Болд өвгөн баахан бодол бодсоор аман дотроо олон дахин давтсаар, ертөнц гэдэг үгийн нэг үсгийг,

1 минут шахам удаан бодсоор, гарцаагүй «Ө» байх юм, дүрэм ч тийм гэж батлав.

— Харин тийм байх ёстой. Ном дээр «О» байгаа юм. Ном алдсан байна, гэхэд цаадахь чинь «О» байна гэж надтай булаацалдаад ууралчаад сууж байгаа юм.

— За за ам нийлснээрээ та хоёр дийлээд багшаас их сайшаал дуулаарай гэж, тэр авгай бүр ч их уурлав.

Гаднаас хүрэн торгон дээлтэй, дугараг шар малгайтай улаан галстугтай бяцхан охин орж ирээд сайн байцгаана уу гээд хоймор очив.

— Сайн байна гээд гэрийн эзэгтэй авгай цай идээ авч өгөв.

— Багш яагаад хождов гэж хашааны өвгөн Болд асуув.

— Би пионерийн ажилтай байгаад хождов.

— За хичээлээ эхлэе. Би бас гэрийн даалгаврыг үзье.

— За эгчээ наашаа суу гэхэд: гэрийн эзэгтэй, багшаа, ертөнц гэдэг үгийн «Т» үсгийн дараа «Ө» «О» хоёрын аль нь байх вэ? гэхэд бяцхан багш шууд, «Ө» байна гээд шалтгааныг тодорхойлов. Дараа нь Болд гуайгаар «Миний нутаг» гэдэг шүлгийг ном дээрээс уншуулав.

— Багш, за буруу уншсан зүйл гарав уу?

— Эмэгтэй, ертөнц гэдгийн, «Т» -гийн дараа энд «О» байхад энэ чинь «Ө» -гөөр уншлаа гэв.

— Багш, ном дээр чинь алдаатай байна. Би засчъя гээд, цөмий нь ном дээр засав.

— Бичиг мэддэггүй хүнд ном нь алдаатай гардаг чинь жигтэйхэн аюултай хэрэг байна даа гээд гэрийн эзэгтэй жаахан дурамжхан сууж билээ.

По рассказу Б. Б а с т о.

### С л о в а

**сахал** борода; усы  
**гайхах** удивляться, дивиться, изумляться  
**оёлын машин** швейная машина  
**эмхлэх** сложить, собрать  
**онгойлгох** открывать, раскрывать, отворять  
**цэвэрхэн** чистый; чисто  
**хуулах** *зд.* переписать; снимать копию  
**хорин** *зд.* двадцатидворка  
**тэгэх** так делать  
**хамаатай** причастный, имеющий отношение; принадлежащий  
**алдах** *зд.* ошибаться, промахнуться  
**нурах** обвалиться, разрушаться  
**хөө возглас обращения** (например, друг!)  
**хэлээд орхи** скажи-ка  
**тэнэг** глупый  
**тэг дундуур** *букв.* через середину; *перен.* не стесняйся

**загнах** обругать; окрикнуть  
**горьдохын зовлон** нечего ожидать, не зачем надеяться  
**маргалдах** спорить  
**уурлах** злиться, сердиться, беситься  
**шидэлцэх** кидаться, бросаться  
**час улаан** яркочерный  
**дүрэм** правила; *зд.* правила орфографии  
**булаалдах** *зд.* спорить  
**ам нийлэх** сходиться, иметь одно мнение  
**дугараг** круглый, имеющий форму круга  
**эзэгтэй** хозяйка  
**идээ(н)** пища, кушание  
**хождо** опоздать  
**жигтэйхэн** странно  
**аюултай** *зд.* чревато последствиями  
**дурамжхан** *зд.* расстроенный; расстроено

## НАНДИН СЭТГЭЛ

Улсын их театр шинэ барилгадаа орж шинэ опер тавих тухай зарлалыг үзэгчид талбайг бүрхэв. Анхны нээлтэд шинэ опер аялгуут жүжиг үзэх хүмүүс багтахгүй байв. Тэр орой ганц илүү билет авсан хүн хамгийнхаа дотнын хүнд олдошгүй үнэт эрдэнэ өгсөн шиг болгож байв.

Улаанбаатарын өргөн талбарын дунд аймшиггүй эрэлхэг жанжин, монголын ард түмний их удирдагч Сүхбаатарын дурсгалын хөшөө харагдана. Хотын гудамжууд толь мэт гялалзан засагдсан баганад өдөр мэт болгогч чийдэнгүүд гэрэлтүүлж, цэцэглэсэн ногоон мод, барилгуудыг тойрон гудамжны хоёр талаар бүрхжээ. Эдгээр хээрийн сайхан ой тайгын анхимал үнэр хотын дотор тарж, төв театрын таван давхар шинэ барилга дээр улаан туг, зөөлөн салхинд намиран харагдана. Монгол хүн, хийсэн юмаа үзэж, өөрсдөө хөдөлмөрлөн шорой зөөж байсан хүн, мод тарьж байсан цагийг бодохдоо, одоо ямар болсныг хараад хөдөлмөрийн гал цогийг улам оргилуулна.

«Одоо ажил их байна. Цааш нь улам их хийх ч ёстой юм» гэдэг үг манай хөдөлмөрчний ариун үг юм. Саруул гудамжийн дундуур, хоёр хоёроороо залуучууд сэлгүүцэн хүүхдээ дагуулсан хүмүүс хотын цэцэрлэгийн дунд хүүхдээ зугаацуулан эрхлүүлж байна. Өргөн сайхан талбарт хөгжмийн эгшиг цууриатаж, хүмүүс бүжиг танц хийж байна. Би бас хожигдоогүй ирэв гэсэн шиг галт тэрэгний чимээ сонсогдоно. Шинэ кино театрын үүдэнд олон түмэн хүмүүс нааш цааш явах бөгөөд монгол зохиолчдын зохиосон, үлгэрийн шинэ киног үзэхээр багачууд цугларан байв. Өмнө харагдагч төвийн номын сангийн барилга сүндэрлэн гэрэлтэж, саруул, саруул тасалгааны дотор хэдэн зуун хүн, ном зураг үзэж сууна. Тэнд, монголын зохиолчдын анхдугаар 5 жилийн төлөвлөгөөний эхний жилүүдэд хийсэн роман, тууж, үлгэр, найргийн сайхан зохиолууд харагдана. Үй түмэн хүний гараар бүтсэн соёл хөдөлмөрийн ариун дагшин орон болсон нийслэлдээ монголын ард баялаг сайхан амьдралаа зохиож, шинэ гэрэл барилгуудаа хүлээж авч байгаа цаг.

Улсын их сургуулийн, одон орныг шинжлэх оргилоос өнгө өнгийн гэрэл сацарч байна. Шинэ хүчний дээд сургуулийн оюутнууд, их сургуулийн оюутнуудтай хамтран, сургууль дээрээ өргөн тоглоом үдэшлэг, бүжиг хийхээр сэтгэл хөдлөн бужигнаж байгаа цаг.

Улсын их сургууль ба шинэ хүчний дээд сургуулийг төгсгөгчид, «бид хуучин сурагчид, хайрт сургууль дээрээ очно» гэгцгээж явж байна. Залуу эрдэмтэн, багш, профессор нарын явах нь үзэгдэнэ.

Дэмчиг ч энд явж байна. Дэмчиг л ганцхан гаднын түмэн баясгалан хүрээлэвч, уйтгартай явна. Яагаад тэгсэн юм бол?

Энд залуу Замбага хүүхэн ч явж байна. Замбагыг ард түмний хайр хүндэтгэл хүрээлж, түүнийг түмэн сайхан баяр баясгалан угтан авч байв. Замбагад, их театраас тусгай хүндэтгэлийн урилга ирсэн байв. Замбага, саруул гудамжаар түмэн хүний дундуур үеийн олон нөхөддтэйгөө зэргэлэн алхалж, шинэ театрын зүг яарна. Шинэ театрын хаалганы хажууд Дэмчиг, бороонд цохигдсон ангаахай шиг үрчийгээд эрвийгээд, зогсож байхад нь Должин хүүхэн тохиолдов.

Дэмчиг:

— Хүүе Должин минь сайн байна уу гэж гар нь чичрэн салгалж очиход нь,

Должин:

— Та сайн байна уу гэв.

Дэмчиг:

— За хоёулаа цуг явах уу? ганцаараа эвгүй гэдэг чинь гэв.

Должин:

— Уучлаарай, та хүний нандин сэтгэлийг эвддэг хүн шүү дээ.

— Та тэр тийм сайхан сэтгэлтэй, тийм эрдэмтэй ажилтай хүнийг хаяж гомдоож байгаа хүн чинь, надад хань болно гэдэг худал хэрэг, уучлаарай би энд хүнтэй цуг явж байна. Баяртай гээд орчхов.

(Төгсөөдүй)

## С л о в а

нандин сэтгэл благородное сердце;  
верное чувство любви  
зарлал объявление, афиша  
нээлт открытие  
аялгуут жужиг музыкальная пьеса  
багтах поместиться, вписаться  
олдошгүй үнэт бесценный  
талбар площадь  
толь зеркало  
засагдсан убранный, украшенный  
ой тайга тайга  
намирах колыхаться, развеваться.  
тарих эд. посадить  
гал цог огонь, огонек  
эрхлүүлэх ласкать; баловать  
бүжиг пляска; танцы  
хожигдох опоздать  
нааш цааш явах сновать, ходить  
взад и вперед  
зохиолчид писатели  
найраг зохиол поэма  
үй түмэн множество; масса

ариун дагшин орон святыня  
одон орныг шинжлэх ухаан астро-  
номия  
оргил эд. вышка, обсерватория  
төгсгөгчид выпускники  
уйтгартай грустный, скучный; груст-  
но, скучно  
хүүхэн девушка  
хайр хүндэтгэл любовь и уважение  
урилга приглашение  
зэргэлэн рядом, в одном ряду  
алхлах шагать  
ангаахай пенчик; цыпленок  
үрчийх сморщиться, нахмуриться  
эрвийх скорчиться  
хүүе возглас обращения: эй!  
чичрэн салгалах дрожать, солдрогать-  
ся  
цуг вместе  
уучлаарай прости, извини  
хаях бросить  
гомдоох обидеть

## НАНДИН СЭТГЭЛ

(Төгсгөл)

Тэгээд гунирхан зовж, буцаад явтал замаар нэг олон хүүхэн зэргэлэн явахыг харав. Хаврын цэцэг шиг сайхан охид, яаралтай алхалж, намуухнаар нэг сайхан дуу аялах нь юутай ч зүйрлэшгүй сонсогдов. Яг дунд нь Замбага байгааг харав.

Урьдынхаасаа улам сайхан харагдана. Анх ханилсан цагаас нь хавьгүй сайхан харагдана. Түүний тунгалаг сайхан, хацар нь жимс шиг ягааран улайж, уруулы нь цаанаас дун цагаан шүд гялалзан харагдана. Тормолзсон нүдний урьхан харц нь цогтойгоор гялалзан харагдана.

Энгэр дээр нь хөдөлмөрийн гавьяаны одон, медаль хоёр гялалзаж байна. Сайхан тэнцүү махлагий нь 3—4 жил ханилахдаа мэдээгүй, харин энэ орой л олж харав. Ухаан алдатлаа дуралж Должингоос хэдэн хувь илүү харагдаж сэтгэл нь нэг л хачин эвгүй болчхов. Зүрх нь түг түг цохиж, чээжний хөндийд нь цахилгаан хонхны дохиур шиг чичрэн догдлов. Хүүхнүүд түүний хажуугаар дуулан өнгөрөхөд, Дэмчиг, биеийг сүрхий ихэд барьж:

— Замбагаа гэж дөнгөж дуудаж чадав. Хүүхнүүд зэрэг зогсов.

Замбага сочин эргэж харав. Хүүхнүүд эргэж харав.

Дэмчиг:

— Замбага гэж дахин сулхан бөгөөд чичирсэн хоолойгоор дуудав.

Замбага, хүүхнүүдийн дундаас гарч ирэхэд хүүхнүүд, хоёр хүний уулзахад саад болж магадгүй гэсэн шиг, цааш эргэж аяархан дуулан алхалцгаав.

Дэмчиг:

— Сайн байна уу? Хайрт минээ... гээд цааш юу ч хэлж чадсангүй, нүдэндээ нулимс бүрхүүлэн зогсов.

Замбага инээмсэглэн:

— Сайн байна. Та сайн байна уу? Дараа уулзъя. Одоо театрын нээлт болох гээд байна... гэж эмэгтэй хүний жижиг цагаа харав. Цаг бол, Дэмчигийн талд биш, харин Замбагыг түргэн яв гэж, 9 цагт 15 минут дутуу харагдав. Секундийн зүү нь над мэт хурдлан яваасай гэсэн мэт түргэлэн эргэж харагдав.

Дэмчиг:

— Би, бурууг хүлээе, уучилна уу! чамаас сайхан юм нэг ч алга санагдаж байна.

Замбага:

— Уучлаарай! би, хаанаас сайхан байх вэ? гологдсон юм чинь, тэгээд хэрэггүй юм биш үү? та жаалхан, гэр бүлийн талаар

тогтворгүй хүн юмаа! Бас шинэ эхнэрээ яасан бэ? хаясан уу? гэхэд, Дэмчиг:

— Үгүй... гэтэл Замбага тосож:

— Би, сайн сэтгэлээсээ нэг үг хэлье. Биеэ засаж аваарай. Тэгж биеэ засахгүй бол, танд сайн хань олдохоосоо өнгөрнө шүү! гэхэд.

Дэмчиг:

— Ёстой тийм, би чиний хэлсэн ёсоор биеэ засъя! гээд цааш нь эргэж суухыг үнэн сэтгэлээсээ гуйна! гэж ичгүүргүй хэлмээр санагдав.

Замбага инээмсэглэж:

— Уучлаарай та биеэ засахдаа, надтай суухын тулд биш, улсдаа сайн хүн болохын тул засах хэрэгтэй. Би урьд ханилж байсны хувьд баяртай үгээ хэлэхэд, би хөгжлөөс хоцрохгүйн тул, оролдсоор орос хэлтэй болоод, дунд сургуульд үзсэнээ сайн давтаж, цааш нь үзээд одоо Улсын их сургуулийн хэл бичгийн нэгдүгээр ангид орохоор сайн шалгагдсан нэг баяртай. Хоёрт монголынхоо нийслэлийг улам сайхан цэцэглүүлэн босгосон тухай алдарт дурсгалд нэрээ оруулсан нэг баяртай. За явъя баяртай гэж хэлээд явав. Хойноос нь дагаж, Дэмчигээс миний түмэн буруу, би дахиж хэрхэвч тийм дутагдал, муу муухай юм гаргахгүй гэж хэлэхийг завдсан боловч чадсангүй дараа уулзахыг хүсэв.

Дэмчиг, хуруугаа ноцолдуулан хойноос нь харсаар хоцров. Замбага шинэ театрын хаалгаар орохдоо нэг эргэж хараад түүнээс зугтаасан юм шиг түргэн цаашаа оров.

Замбага бол, эх орондоо үнэнч нандин сэтгэлийг тавьж, эрдэм ажил хоёроор биеийг чимээд, дэмий саваагүйтэхийн оронд, цагийг эрдэмд зориулснаас ийм болов гэж нэг юм, Дэмчигийн чихэнд шивгэнэсэн шиг бодогдуулав.

По рассказу Д. Даржа.

## Слова

**гунирах (гунихрах)** тосковать, печалиться

**нам/ухнаар** тихо

**зүйрлэшгүй** несравненный

**хавьгүй** несравнимо, значительно

**жимс** фрукт, ягода

**ягааран улайх** быть румяным, розовым

**уруул** губы

**дун цагаан** блейший

**тормолзох** блестять (о глазах)

**урьхан** теплый, ласковый

**харц** взгляд

**энгэр** лацканы, борта

**ягаан алдатлаа** безумно, очень сильно

**дурлах** любить

**түг түг цохих** стучать(ся), трепетать

**чээж** грудь, грудная полость

**хөндий** эд. полость

**дохиур** барабанная палочка, молоточек

**догдлох** колебаться, трепетать

**сочих** испугаться, вздрогнуть

**нулимс(ан)** слезы

**дутуу** пехватает

**бурууг хүлээх** признать вину

**алга** нет

**гологдсон** отвергнутый, забракованный

**тогтворгүй** неустойчивый

**суух эд.** жить вместе; быть супругами

**хэл бичгийн** филологический

**шалгагдах** сдавать экзамены

**алдарт дурсгал** книга почета, почетный список

**хуруу(н)** палец

**ноцолдуулах** ломать (о пальцах)

**зугтаах** убегать, сбегать

**саваагүйтэх** эд. бездельничать

## ҮҮРИЙН ЦОЛМОН

Зуны нарлаг халуун өдрүүдийн нэг билээ. Энэ өдрүүдэд, сүүний машинууд улам хурдан эргэж, ноос ачсан хөсөг улам хурдан урагшилж, уурхай дотор өрөмдөгч машинын дуу улам чанга, улам хурдан тарчигнаж, суурь машинууд улам хурдан хүнгэнэн шуугиж байлаа. Бидний сууж явсан ЗИС—5 гэдэг ачааны машин ч улам хурдан давхиж байв.

Машин хурдан довтловч бидний хажуугаар үргэлжлэн өнгөрч байгаа мэт үзэгдэгч тариалангийн их талбай барагдахгүй байв. Улаан буудай, хар будаа, арвайн энэ их тариалан, хөх тэнгэрийн дор ногоон далай мэт үргэлжилж байв. Энэ бол Жаргалантын сангийн аж ахуйн тариалан юм.

Тэртээ хол Зөөхийн хөндийн эхэнд сая хагалагдсан атар газар үзэгдэв. Түүний хажууд хэдэн гэр, майхан, гадна нь болд морид гэж нэрлэдэг тракторууд зогсжээ. Тракторчид, үдийн амралтаа хийж байгаа ажээ. Гэрүүдээс эгшигт хайрцгийн дуулал, хуучир хөгжмийн эгшиг сонсдож, зарим гэрт тракторчид сонин уншиж байв. Тогоонд нь хоол буцалж, аргалын утааны таатай үнэр анхилж байлаа.

Өнгөрөгч өвөл, хаврын шуурганы үед тракторчид, аж ахуйнхаа малын сууриудад өвс бордоо зөөж байв.

Нэгдсэн том аж ахуйн давуу чанар, зудын энэ үед бүр ч тодхон харагдаж байжээ.

Зудад малаа сайн арчилж, төлөө сайн бойжуулсан сайн малчид энэ аж ахуйд бий юм. Элгээр зүтгэлт малчин, аж ахуйнхаа түм гаруй малыг зутдай тэмцэн булаалдаж, онд мэнд оруулжээ.

Бас төл бойжуулах чухал ажил сайн өнгөрөв. Эцэнхий эх малаасаа төлөө тэжээх сүү гарахгүй байхад «зохиомол уураг» гэдэг нялх төлийн шинэ тэжээлийг хэрэглэв. Энэ ажлыг тус аж ахуйн дээд мэрэгжлийн залуу зоотехникч Дашдорж удирджээ. Буцалгасан 1 литр ус буюу сүүнд 5—8 өндөг, загасны тос 5 грамм, чихэр 8 граммыг найруулж, зохиомол уургийг хийж байв. Энэ зохиомол уураг нь олон зуун төлийг бойжуулан авахад шийдвэрлэх ач нөлөөг үзүүлжээ.

Пар хагалалтын 1 дүгээр бригад дээр нөхөр Гомбын зэрэг олон сайн тракторч ажиллаж байна. Энэ бригадынхан, шатахууныг хэмнэх талаар нэрд гарсан хүмүүс юм. Энэ хоёр бригадын дархны газар чөлөөгүй ажиллаж байна.

Эдний дархчууд, засварчдын дунд өндөр зүтгэл шинэ санаачлага их өрнөжээ.

Жаргалантын аж ахуйн идэшний ногооны газар, гахай, тахианы ферм хөгжиж байна.

1928 оноос эхлэн энд «Жаргалантын сан» гэдэг улсын сангийн аж ахуй байгуулагдаж, жил бүр өргөжин хөгжиж байна. Одоо энэ аж ахуй нь клуб, сургууль, хоршоо, гуанз, ажилчдын сууцны тохилог барилгуудтай хөдөө аж ахуйн тэргүүний техникээр тоноглогдсон, олон мянган га газар тариалсан, олон мянган мал сүрэг билчээсэн, юм бүхнээ мянга мянгаар ярьдаг лут их аж ахуй болоод байна.

Ардын хувьсгалын жилүүдийн дотор олсон амжилтуудын нэг салаа мөчир нь манай улсын сангийн аж ахуйнууд билээ. Улсын сангийн аж ахуйнуудын дунд Жаргалантын сангийн аж ахуй, дээгүүр суурийг эзэлж байна.

Жаргалантын аж ахуй бол манай оронд үүрийн туяа мэт гийгүүлэн ирж яваа социалист жаргалант сайхан амьдралын үүрийн цолмон юм.

По очерку Л. Бадарчи.

### С л о в а

үүрийн цолмон Венера, утренняя звезда	үнэр запах
нарлаг солнечный	анхилах пахнуть, издавать запах
сүү(н) молоко	өнгөрөгч прошлый
сүүний машин сепаратор	зөөх перевозить
ачих грузить	давуу чанар превосходство
хөсөг подвода; вьюк	зуд бескормица; сильные морозы
урагшлах итти вперед	булаалдах бороться за овладение
өрөмдөгч машин сверлильная (врубоя) машина	(ч.м.-л.)
тарчигнах трещать	мэнд(э) жив, здоров
суурь машин станок	зуд бескормица; сильный ослабевший
хүнгэнэх гудеть	зохиомол уураг искусственное молозиво
давхих мчатся	нялх младенец; младенческий
өнгөрөх проходить, миновать	эндөг яйцо
үзэгдэх показываться, появляться	загас рыба
барагдах кончатся, иссякать	найруулах составлять
улаан буудай пшеница	хагалалт вспашка
хар будаа рожь	шатахуун горючее
арвай ячмень	нэрд гарсан известный, прославившийся
тэртээ там, на той стороне	дархны газар эд. кузница
атар газар целина	дархчууд кузнецы, мастера
майхан палатка	засварчид ремонтники
гадна снаружи, вне	өрнөх развиваться, расти
тракторчид трактористы	идэшний ногоо(н) овощи
эгшигт хайрцаг патефон	гахай свинья
дуулал пение	тахиа курица
хуучир хөгжим нац. музыкальный инструмент	гуанз столовая
тогоо(н) котел	сууц эд. жилище
буцлах кипеть	тоноглогдсон оборудованный
аргал аргал, сухой помет	тариалах сеять
таатай приятный	лут эд. большой, крупный
	дээгүүр высоко; высокий

## ИНГЭТИЙН ТАЛД

Би, энэ намар Ингэт-толгой дахь улсын аж ахуйн тариа хуралтын ид үеэр Ингэтийн талд явж байсан дурсгалт өдрүүдээ ганаж байна.

— Бид, үүр цайхаас арай өмнө хүрэх нь байна шүү гэж миний хажууд сууж яваа залуу хэллээ. Би, тэр аж ахуйг анх удаа үзэх гэж байгаа учир гэрэл гэгээ орсон хойно очвол зүгээр юмсан гэж бодож явлаа.

Холын замд явж сурсан дадлагатай жолооч, ер ядарсан царайгүй, харин дуу аялаад л явж байлаа. Машин ч гэж яриагүй сайн. Моторын их хүч хүнгэнэн байв.

Тэнгэр зүүнтэйгээсээ судалтан цайраад, од сийрэгшин цөөрч, сэвэлзүүр салхи хөдлөн, шөнийн тогтуухныг өөрчлөн, үүр цайх дөхөж ирлээ. Харанхуйн дунд бүртгэр юм үзэгдэж байснаа ойртох тусам хар цагаан нь ялгагдан танигдах болов. Энэ нь бидний очихоор зорьж яваа Ингэт-толгой дахь улсын аж ахуй мөн ажээ. Гэрүүдийн яндангаар утаа савсаж, байшингийн цонхоор гэрэл харагдаж байв. Намын үүрийн нарийн бичгийн даргын нь гэрийг сураглан очвол ажилдаа явсан байлаа. Түүний ажлын байранд очвол бас алга, бригад дээр очихоор биднээс түрүүхэн явчихсан байв. Хүрэн цэмбэн бүтээлэгтэй ширээн дээр байгаа том шар цагийн богино зүү, тавын тоон дээр зааж байлаа. Өөр нэг тасалгаанд орлоо. Энд нягтлан бодогч нартай уулзав. Ерөнхий нягтлан бодогч нь нэг өндөр хүн байв. Энэ хун аж ахуйг анх байгуулах цагаас нь эхлэн ажилласан хүн юм байжээ.

Том шар сампин түүний өмнөх ширээн дээр харагдав.

Энэ аж ахуй 1938 онд хоёр зуу гаруйхан малтай байснаа одоо арван хоёр мянга шахам малтай баян аж ахуй болон хөгжжээ.

Энэ олон малын төлийг бүрэн бүтэн авч чадсан байна уу? Сүү шим, ноос үсийг нь гүйцэд ашиглан чадаж байна уу? Үгүй юу? гэдгийг бодож гаргах гэсээр байгаад энэ сампингий нь эрх элэгдэж, их өнгө орсон юм байхдаа гэж бодов.

— Ноднин жил арчилгааны муугаас гурван хурга үхүүлсэн гэж нягтлан бодогч тун их харамсаж ярьж байлаа. Тэхдээ харин тэр хоёр мянга шахам болгон өсгөж чадсан зүтгэлт хүмүүсийн их хөдөлмөрийг ер дурсан ярихгүй байгаа нь хачин санагдав. Энэ онд 404 хониноос 404 хурга бойжуулсан малчин Чойжамцын зэрэг хүмүүсийг ер юмын тоонд бодож ярихгүй байгаа нь бүр ч эвгүй шиг бодогдов.

Улсын сайн малчин Батын Чойжамц шиг зүтгэлт хүмүүс энэ аж ахуйд зөндөө олон байгаа нь гарцаагүй гэж бодоод тэдэнтэй чүүр учрахаар би, хөдөө тийшээ явахаар шийдэв.

Дөлгөөн урсгалт Сэлэнгэ мөрөн, алсынхаа замд аялсаар л байлаа. Түүний хөвөөг дагаж багсайж ургасан монос модод мөчрөө даахгүй бөхийгөөд, сагсгар ногоон навчин дунд тас хар мойл баарцаглан байх нь хорхой хүрмээр. Зарим модны мөчрийг хугалснаар барахгүй бүтэн модыг ч сүхээр цавчиж унагаасан харагдаж байна. Энэ бол ой модны баялгийг хайрлан хамгаалахыг боддоггүй хатуу сэтгэлт зарим нэг хүний ажил байхаа. Энд байдаг ой хамгаалах цагдаа ер нь юу хийж байдаг юм бол гэж харамсаж явлаа.

Намрын зөөлөн шар нар зүүн уулын дээгүүр мэлтэлзэн цухалзаж, голын хоёр талын өндөрлөг уулсын модод ногоон шар өнгөөр алаглан байх нь бүр ч үзэмжтэй сайхан харагдлаа.

(Төгсөөдүй)

### С л о в а

**тариа(н)** хлеб, зерно  
**хураалт** уборка  
**ид үе** страда, разгар  
**арай** немного, чуть  
**зүгээр** неплохо  
**дадлага** опыт; привычка  
**жолооч** шофер, водитель  
**ядрах** уставать; утомляться  
**аялах эд.** напевать  
**яриагүй сайн** слов нет, хороший, отличный  
**судалтан цайрах** светлеть полосками  
**од(он)** звезда  
**сийрэгших** разрежаться, уменьшаться  
*(количественно)*  
**цөөрөх** количественно уменьшаться  
**сэвэлзүүр** легкий, приятный, прохладный  
**тогтуухан** спокойствие, тишина  
**харанхуй** темнота; темный  
**бүртгэр** неясный, еле заметный  
**ялгагдах** выделяться, отделяться  
**таних** знать; узнавать  
**яндан(г)** труба, дымоход  
**савсах** дымиться, подниматься  
**түрүүхэн** немного раньше, только что  
**цэмбэн** суконный  
**бүтээлэг** скатерть  
**богино** короткий  
**зүү(н)** стрелка; иголка, игла  
**нягтлан бодогч** бухгалтер

**сампин** счеты  
**баян** богатый  
**гүйцэд** полный; полностью  
**эрх эд.** косточки, кругляшки на счетах  
**элэгдэх** изнашиваться; полироваться  
**хурга** ягненок  
**үхүүлэх** допустить гибель, падеж  
**эвгүй** неудобно, неловко  
**зөндөө** много, сколько хотите  
**гарцаагүй** несомненно, наверняка  
**дөлгөөн** тихий, спокойный  
**мөрөн** река  
**алс** даль; далекий, дальний  
**аялах эд.** путешествовать  
**монос мод(он)** черемуха (*дерево*)  
**мөчир** ветка, сучок  
**даах** суметь поднять (*тяжесть*)  
**бөхийх** сгибаться, нагибаться; изгибаться  
**сагсгар** взъерошенный, пушистый  
**тас хар** очень черный  
**мойл** черемуха (*ягода*)  
**баарцаглах** висеть гроздьями  
**хорхой хүрмээр** возбуждающий аппетит  
**хугалах** [раз]ломать  
**цагдаа(н)** милиционер; охрана  
**мэлтэлзэх** светить  
**цухалзах** показаться, подняться  
**өндөрлөг** высокий; возвышенность  
**алаглах** пестреть, быть пегим

## ИНГЭТИЙН ТАЛД

(Төгсгөл)

Биднийг суулгасан жижиг завь, гүн усан дунд урагш тэмүүлэн, сэлүүрийн үзүүрийг дагаж ус хөөсрөн байв. Бид, голын хойт талд гараад, тосож ирүүлсэн морьдыг унаж, тариа хураалтын нэгдүгээр бригад дээр очихоор агь, шарилжны аагтай сайхан үнэр ханхалсан хээр талын дундуур цааш давхин одлоо. Явсаар нэг өндөр дэнж дээр гарав.

Алсад гэр, байшин, майхнууд ярайн харагдаж дүүрэн дүүрэн будаа ачсан машинууд давхилдан бас энд тэндгүй үхэр, морин тэрэгтэй хүмүүс ачих нь ачиж, буулгах нь буулгаж, ер нь их ажил өрнөж байгаа нь илэрхий байлаа. Бид, нэг жижиг байшинд буув.

Энд бас л сампин цохисон, данс бодсон хүмүүс дүүрэн.

Бригадын даргаа! Шуудайны боолт олс дутах нь байна, гаргуулж өгөөч. Бэруун склад зайгүй боллоо. Одоо будаагаа хаана хураах билээ? Голын урд талаас өнөөдөр шатахуунаа гаргуулж ирэхгүй бол дараагийн долоон хоногт шатахуун дутагдах болно, хэнийг явуулах вэ? гэх зэрэг олон асуулт үргэлжлэн сонсдож байлаа. Бригадын дарга, энэ дуусашгүй мэт асуултад тухай тухайд нь хариу өгч шийдвэрлэсээр л байв.

Бид, байшингаас гарч бэруун тийш явцагаалаа. Нүд гүйцэмгүй их талд тариалсан тариа будаа сэвэлзүүр зөөлөн салхинд ганхан байх нь далай долгион байх адил ажээ. Түүнийг захаас нь эхлэн, тойруулан хадаж цаад захад нь яваа комбайн машин ялигүй жижиг юм шиг харагдаж байснаа ойртох тусам аврага том бие нь тодорсоор байв. Тэр комбайн дээр час улаан туг дэрвэлзэн хийсч байх нь биднийг нааш ир! нааш ир! гэж даллан дуудаж байгаа юм шиг харагдлаа. Бид ч дөхөн хүрч очлоо. Би, комбайн дээр авиран гарч жолооч Дамдинжавтай зэрэгцэн зогсов.

Тоосонд дарагдсан энэ хүний цогтой нүдийг би бахархан харж, хатуу ширүүн ажилд дадсан лужир том гарыг нь чанга атган мэндэлсэн билээ. Энэ хүний өмнө нь улам багасаж байгаа хадах газар, ард нь савлагдан хоцорч байгаа олон шуудай будааг харсан миний сэтгэл хөдлөхгүй өнгөрч яахин чадах вэ. Комбайнч, хоёр хацраа дагаад урсаж байгаа хөлсөө ч арчихаа мартаад үргэлж газар ширтэн комбайнаа ажиллуулж байгаа нь ганц ширхэг будааг ч орхихгүй юмсан гэж хичээсэн нь илэрхий.

Би, Дамдинжавтай олон таван юм ярихаа ажилд нь саад болох магадгүй гэж бодоод, комбайнаас бууж, тракторын жолоочтой зэрэгцэн сууж харин түүнтэй овоо хэдэн үг солив. Тракторч

Чойжхорлоо бол Дамдинжавтай нэг нутгийн хүн юм гэнэ. Энэ хоёр багадаа хамт тоглож өссөн учир, их ижил дасал болсон улс гэнэ.

Хорь гаруй жилийн өмнө энэ хоёр Сэлэнгэ мөрний хөвөөнд арчгүй бага газар дээр атга чимх тариа будааг гар хадуураар хадан, үйл тамаа цайдаг байсан бол одоо мөн л Сэлэнгэ мөрний-хөө хөвөөнд байгаа боловч өргөн талын дунд арвин их тариа будааг тэргүүн зэргийн техникээр хадаж явна гэж бодоход их л сонин сайхан санагдаж байлаа.

— Дамдинжав бид хоёр, өдөрт 14 га газрын будааг хадаж үүрэг авч ажиллан яваа юм. Тэгээд энэ завсар өдөр тутам 14—20 хүртэл га газрын будааг хадаж байна. Энэ нь тийм ч их амжилт биш л дээ гэж нөхөр Чойжхорлоо даруу байдлаар ярилаа. Тракторын гинж харжигнан дуугарч, ургац урсах мэт иржигнэн, бид хоёр өндөр дуугаар ярилцан, бидний ар талд шуудайтай будааны тоо улам олшрон, гэр байшингууд их холдсоор байлаа.

\* \* \*

Тарианы бригадын жижиг байшингийн цонхоор харвал, мичид харагдаад, шөнө нэлээд орой болсон бололтой. Хол ойр олон газар тракторын моторын дуу тасралтгүй сонсогдсоор байв.

Гадаа гараад харвал Сэлэнгэ мөрний хойт урьд хөвөө, Ингэтийн уудам талд олон хэсэг газар хурц цагаан гэрэл газар дээр тусаад тун бахдамаар сонин сайхан харагдлаа. Ийм хүмүүсийг ёстой л баатруудын ёсоор ажиллаж байна гэж үзэхээс өөр юу гэж үзэх вэ гэж би, бахархан бодож байлаа.

Одоо нэг таван жил өнгөрсний дараа энд ирж үзэх юмсан. Яасан их хөгжөөд ямар сайхан болсон байх бол.

Үүр ч цайж, гэгээ орлоо. Хүсэлтэй сайхан маргааш ч хүрээд ирсэн билээ.

По очерку Ц. Уламбаяра.

### С л о в а

**завь** лодочка  
**тэмүүлэх** стремиться вперед, рваться вперед  
**сэлүүр** весло  
**үзүүр** кончик, конец  
**хөөсрөх** пениться  
**тосож ирүүлсэн** высланный навстречу  
**агь** польнь  
**шарилж** ромашка  
**аагтай үнэр** аромат, сильный запах  
**одох** отправиться  
**дэнж** бугор, холм; увал  
**будаа** зерно, хлеб  
**тэрэг** телега, арба  
**данс** журнал (*бухгалтерский*), ведомость, реестр, счет  
**шуудай** мешок  
**боолт олс** шнурок, веревочка

**дутах** нехватать  
**зай** свободное место  
**долоон хоног** неделя  
**дуусашгүй** бесконечный, нескончаемый  
**нүд гүйцэмгүй** необозримый  
**ганхах** колебаться, колыхаться  
**зах** край  
**тойруулах** кружить, итти кругом  
**цаад** дальний; тот  
**ялигүй** маленький, незначительный  
**час улаан** алый, яркочерный  
**дэрвэлзэн хийсэх** развеиваться  
**даллах** звать, приглашать, манить  
рукою  
**дөхөм** близко  
**авиран гарах** взбираться  
**зэрэгцэн зогсох** встать рялом

**дадах** привыкать  
**багасах** уменьшаться  
**ар(а)** за спиной, сзади  
**яхин** как  
**хацар** щека  
**хөлс(өн)** *зд.* пот  
**овоо** *зд.* много  
**ижил дасал** привыкшие друг к другу, друзья  
**арчгүй бага** клочок, небольшой кусочек  
**чимх** щепотка

**гар хадуур** *зд.* серп  
**үйл тамаа цайх** мучиться  
**арвин** богатый, обильный  
**энэ завсар** за это время  
**харжигнан дуугарах** звенеть, издавать звук  
**иржигчэх** рябеть  
**олшрох** увеличиваться (*количественно*)  
**мичид** звезды  
**ёстой** *зд.* настоящий  
**хүсэлтэй** *зд.* желанный

## 52 ТАВИН ХОЁРДУГААР ХИЧЭЭЛ

### СҮЛД МОДНЫ НААДАМ

Энэ өдөр бяцхан Цэцэг охины сэтгэл юутай их баяртай вэ? Байсгээд гарч гүйнэ. Аав нь үзэгдэхгүй л байна.

Дуугардаггүй яасан яндан бэ гээд орж ирээд цаг харахад цаг нь осолгүй шаг шаг гэж дуугарч байна. Секундийн зүүг харвал жирэв жирэв эргэлдэж байна.

Бяцхан Цэцэг охин хэзээд эелдэг хөөрхөн ааштай байдаг боловч, өнөөдөр бүр онцгой хөгжилтэй. Ээж нь юу л хэлбэл, Цэцэг «за» гэнэ. Гаднаас түлээ оруулахдаа ч, данхнаас цай хийж уухдаа ч нэг дууг үргэлж дуулна:

«Ногоон торгон дээр  
Сувд байх шиг.  
Ногоон талдаа  
Хурга минь билчинэ»

гэж дуулахдаа бүр ч их баяртай байна.

Удсангүй яндан дуугарч, маргааш шинэ жил, шинэ сарын нэгэн гэхэд, одоо хэдэн сар ч биш хэдэн өдөр ч биш, хэдэн цаг үлджээ.

Энэ өдөр Цэцэг, сургууль дээрээ очиж, хагас жилийн шалгалтын дүнгийн хурал дээр суухдаа «онц сайн» суралцсанаа дуулжээ. Ай бас энэ орой сургууль дээр болох сүлд модны тоглоомд аав ээжтэйгээ очих урилгын бичгийг авчиржээ. Гэвч Цэцэг түүнд очихдоо ч яарсан биш, маргааш хичээл хийхгүй кино цирк үзэхдээ яарсан биш, онц сайн сурсан гэдгээ аавдаа хэлэх гэж яаржээ. Аав нь ирэв. Цэцэг, ааваа гэж гүйн очиж, суухтай нь хамт хүзүүдэн авлаа. Аав нь, аа миний охин юу болов. Юунд их баярлав. Тэгтэл Цэцэг ааваа, май гэж, сургуулиас өгсөн урилгын бичгийг өгөв. Эцэг нь уншихад онц сурлагатан пионер

Цэцэгийн аав ээж нар танаа гээд, цааш нь 31-ний орой болох хүүхдийн сүлд модны наадамд ирэхийг урьсан байжээ.

Эцэг нь охиноо тэврэн миний охин «ёстой аавын хүү гэдэг нэрээ хадгалжээ». Би чамаас ганц ингэж сурахыг чинь хүссэн юм. Хойшид бас ингэж сурах биз гээд, хүүдээ хоёр алим өгөв.

Орой бяцхан Цэцэг, гоё дээлээ өмсөөд улаан галстугаа зүүгээд аав ээж хоёрын хамт том хүн шиг алхалсаар сургууль дээрээ очив.

Өчнөөн төчнөөн хүүхэд саруул сайхан танхимд цуг суужээ.

Цэцэг аав ээжийн хамт ортол, нэг багш за, онц сурлагатан Цэцэгийн аав ээж ирлээ гээд нэлээд дээрхэн аваачиж суулгав. Өвлийн салхинд займруулж, өргөн хөндийн аманд сагсайж байдаг өвгөн ногоон мод, одоо сургуулийн танхим дотор мөчирлөн харагдаж, бас түүний зуун салаа, мянган мөчир бүхнээс ан гөрөөс, араатан, жигүүртэн, өнгийн чийдэн, онгоц машин, түмэн зүйлийг унжилга болгон зүүсэн нь бүр ч сонин сайхан болоод хачин сүртэй болжээ.

Танхимын ерөнхий чимэглэлт нь аль цэцэг дэлгэрсэн зуны найман сар шиг санагдана.

Энэ наадам бол хоёр зүгт дайсан дарагдаж, хүн төрөлхтөн, амгалан тайван босгыг алхсаны анхдугаар удаад болж байгаа наадам байна, энх үе эхэлсэн цагт, эрднийн цэцэг, эх орны ирээдүйн үйлчин болсон, энэ хүүхдийн бүтээх босгох гавьяа нь их юм, ялангуяа талын монголчууд, сайн нөхрийн ачаар урьд олдоогүй зол заяаг олж авсан нь тун тэмдэглэлтэй хэрэг билээ.

(Төгсөөдүй)

## С л о в а

**сүлд модны наадам** ёлка (новогодняя)

**байсгээд** временами, время от времени

**яндан(г)** эд. гудок

**осолгүй** без помех, не задерживаясь

**шаг шаг гэх** тикать

**жирэв жирэв эргэлдэх** мелькать,

быстро вращаться

**хэзээд** эд. всегда

**данх(ан)** чайник

**хүзүүдэх** вешаться на шею

**май** на, возьми

**алим** яблоко

**гоё** красивый, нарядный, элегантный;

выходной

**өчнөөн төчнөөн** много, очень много

**онц сурлагатан** отличник(и) (учёбы)

**дээрхэн** эд. вперед; выше (о местах для почетных гостей)

**займруулах** качать(ся), покачивать(ся)

**ам(ан)** эд. вход; устье

**сагсайх** быть раскидистым

**мөчирлөх** обрасти ветками; стоять

широко раскинув ветки

**ан гөрөөс(өн)** звери

**жигүүртэн** пернатые, птицы

**унжилга** висячий предмет; эд. ёлочное

украшение

**амгалан тайван** мир, покой

**босго** порог

**алхах** эд. перешагнуть

**энх үе** мирный период

**үйлчин** творец, строитель

**зол заяа(н)** счастье, счастливая судьба

## СҮЛД МОДНЫ НААДАМ

(Төгсгөл)

Удсангүй шинэ жилийн сүлд модны наадам эхэлж цасны цагаан өвгөн ирнэ гэдэг дохио өгмөгц баярын хөгжим нижгэнэж, хүүхдүүд алга ташив. Зуун настай цуутай мэргэн, цагаан өвгөн таяг тулж өмөг түшиг болсон баавгай, буга, үнэг, туулай, чандгаа дагуулан гарч ирэв.

Өндөр дээд цагаас эхэлж хүндлэгдэж ирсэн цагаан өвгөн, өнөөдрийн ялалтын 1945 оны үдлэг болон, энх 1946 оны угталтын тухай ерөөлөө хэлэв. Оройн чимэг, оюун билгийн одон болсон оросын уудам нутгийн хаана нь ч болов, алдар, гавьяа зориг, баатарлагийн их үйлс өрнөж байгааг хэлэв. Багш, нөхөр, эрдэмтэн, жанжин, суут хүний бүх чанар шинжийг өөртөө агуулсан их Сталины ач гавьяаг дурсан хэлэхэд бүх хүүхэд Сталины тухай дуугаа дуулав.

Бүх хүүхдүүд эх орон, маршал Чойбалсангийн тухай дуугаа дуулав. Ингэж баясгалант шинэ жилийн баярын ногоон модны наадам эхлээд, орой болтол цөм хөгжилтэй үргэлжлэв. Зуун наст цагаан өвгөний дагуул болсон бор туулайтай хамт бяцхан Цэцэг хөгжилтэй танц хийж байхыг эцэг эх нь үзэв.

Танцын дараа хүүхдийн концерт эхлэх болоход, Цэцэг гэнт алга болов. Аав ээж нь гадуур тоглож яваа байх гэж санажээ. Тэгтэл, концертын бяцхан тасалгааны торгон хөшгийн өмнө концерт удирдагч гарч ирээд, программын анхдугаарт гуравдугаар ангийн онц сурлагатан Цагааны Цэцэгээс «даанч ухаангүй тогложээ», «Хургачин» гэдэг дууг дуулна, гэтэл бүх хуралдагсад алга ташив.

Цэцэгийн аав ээж маш баярлаж, жаахан охиныхоо хэрхэн дуулахыг сонсох гэж ихэд хүсэв. Хөшиг нээгдэж, тайзан дээр Цэцэг гарч ирээд заралсан 2 дууг хэзээний жүжигчин хүн шиг аялгуу хөдөлгөөн оруулж өнгө тохируулж үнэхээр талын хоньчин хургачин хүн шиг тоглоход цуглагсад түүний уран авьяаслаг ба эрдэм билгийг нь магтаж эцэг эх нь тэр гэж хүмүүс ярилцацгааж байв. Наадам үргэлжлээд бяцхан Цэцэг шинэ жилд бэлтгэсэн зүйлээ дуусаад аав ээжийнхээ дэргэд ирэв. Дараа нь цасны цагаан өвгөн, холын газраас авчирсан бэлгийг хамгийн түрүүн, онц сурагч Цэцэг, түүний аав ээжид өгөв. Сургуулийн захиргаа, Цэцэг зэргийн хэдэн хүүхдийн аав ээжийг тусгай зочилж, тэдний хүүхдийн шагналыг аав ээжид нь хүлээлгэн өгөв. Орой саруул сайхан танхимаас гарч Цэцэг, аав ээжтэйгээ буцаж явахдаа өнөөдөр, би концертод ямар тоглов гэж ээжээсээ асуув.

Эх нь хүүгийнхээ шагналын зүйлийг тэвэрч, эцэг нь хүүгээ тэвэрч, охиноо ийм хичээлтэй, эрдмийг сурч тийм сайхан, уран сайханч авьяасаа үзүүлсний нь дахин дахин магтан сайшааж явлаа.

По рассказу Б. Басто.

### Слова

**цасны цагаан өвгөн** лед мороз  
**таяг** трость; посох; костыль  
**өмөг түшиг** эд. надежный друг  
**баавгай** медведь  
**буга** олень  
**туулай** заяц  
**чандага(н)** заяц-беляк  
**үдлэг** прозода  
**энх** мирный  
**угталт** встреча  
**оюун билэг** ум, разум; талант, способность  
**билэг** способность, одаренность  
**алдар** слава  
**гавьяа зориг** доблесть, смелость  
**эрдэмтэн** ученый  
**агуулсан** эд. воплотивший

**дагуул** эд. свита; спутник  
**бор(о)** серый  
**хөшиг** занавес  
**даанч** слишком, чересчур  
**ухаангүй** без ума, неумно  
**хургачин** пастушок (*ягнят*)  
**зарлах** объявить  
**хэзээний** давнишний  
**аялгуу** мотив  
**тохируулах** приспособить, привести в соответствие  
**хоньчин** чабан  
**авьяас(лаг)** талант, дарование  
**тусгай** особо  
**хүлээлгэн өгөх** вручить  
**хичээлтэй** старательный

## 54 ТАВИН ДӨРӨВДҮГЭЭР ХИЧЭЭЛ

### ДУЛМАА ХҮҮХНИЙ УЧИР

Өндөр бөгөөд налуу энгэртэй уулын хормойгоор тэгшхэн зассан сайхан замаар шуудангийн машин улам хурдлав. Хангай газрын хаврын сэрүүхэн салхи өмнөөс угтаж сууж яваа хүмүүсийн нүүрийг сэрүүцүүлэв.

Баруун аймгийн Баясгалан эмгэн Улаанбаатар хотноо ирж сургуульд байгаа хүү Цогттойгоо уулзаад хөдөө гэр нутагтаа буцаж энэ машин дээр суулцаж яваа ажээ.

Баясгалан үүнээс урьд өмнө ямар нэгэн ажлаар гадагш гарч үзээгүй бөгөөд бага залуу насаа хөдөө малын ажлаар оролдож өөрийнхөө гэрт өнгөрүүлжээ. Хөдөөгийн хүдэр хатуу ажлыг хийхдээ чийрэг чадамгай аливаад нягт нямбай юу хийх гэж зорьсон бол түүнийгээ заавал бүтээж дуусгадаг айл саахалтынхандаа төлөв томоотой зан сайтай ажилч хичээнгүй хүн гэж магтагддаг байна.

Өнгөрсөн залуу насандаа урт богино дуу дуулах тун дуртай байжээ. Өөрийн хушууны нэгэн баян айлын хонийг хариулж явахдаа хээр талын өргөн билчээрт дуртай дуугаа дуулдаг байв.

Баясгалангийн уянгат цээлхэн хоолой уудам талын дээгүүр хол хүртэл цууриатаж малчин ардын сэтгэлийг татдаг байсан байна. Одоо ч бас сум багийнхаа хаана найр наадам болно түүнд уригдан очиж дуулдаг юм.

Монгол ардын хувьсгалт гэгээн төр мандахын өмнө харгис засгийн үед манай ард олон найр наадмаа чөлөөтэй хийж чаддаггүй байлаа. Тэр үед Монголын дарлагдсан ард түмний дотроос ардын гэмцлийг илчилсэн буюу эрх чөлөөний төлөө босч ирсэн суут баатруудын тухай дуу магтаалыг дуулах магтах авьяастан залуучууд төрж байсан боловч шар хар феодалууд элдэв аргаар эсэргүүцдэг байлаа. Зовж дарлагдсан ардын малчин, саальчин, анчин, жинчин залуучуудыг цовоо сэргэлэн зориг төгөлдөр, найр цэнгэлд дуртай байх явдлыг хориглож байсны хүнд бэрхийг эмгэн Баясгалан биеэр эдэлж иржээ.

— Би бага залуудаа дуу хуурт их дуртай, сонирхолтой байсан. Ойр хавийн бүстэй бүсгүй залуучуудын дуулдаг дууг бүгдийг мэддэг дуулдаг байв.

Гэвч манай аав ээж хоёр угаас шашны балар сурталд автагдсан бүдүүлэг учир «залуу хүн дуу их дуулбал жаргал буян эдэлдэггүй нас ахархан болдог» гээд дуулуулдаггүй байв. Би хулсан хуур татахдаа бас дуртай байсан. Гэвч «амандаа хөндлөн хулс зуувал амьтны хар нүгэл болно» гэж эцэг эх хоёр маань аашилдаг байсан учир аргагүй би тэдний үгэнд боогддог байж билээ. Тэгээд хээр аргал түүж явахдаа, билчээрт хонь хариулж дуу дуулж хуур татдаг байсан. Одоо нас жар хүрлээ. Дуу сайн дуулж, хуур сайхан татсанаас болж надад ямар ч болсон зүйлгүй. Ардын эрхт төрийн ачаар хэдэн мал маань улам өсч, үр хүүхэд маань жаргалтай сайхан явж байна гэж эмгэн Баясгалан цуг яваа нөхөлдөө ярив.

Энэ үгийг сонсоод нэгэн өвгөнөөс хэлэх нь:

— Өнгөрсөн үеийг санахад ер нь хэцүү санагдаж байна. Одоо ч яах вэ дээ, ёстой л түмэн зүйлийн буян жаргалаа эдэлж, юм бүхнийг сурч сонсож байна. Эрдэмтэй чадалтай ийм нарийн нандин тэргэн дээр суугаад аймаг алхаж хушуу дамжиж явах байтугай, морь унаад, баяд ноёдын үүдээр давшиж болдоггүй байлаа шүү дээ.

Одоо цагийн амар баясгалант цагт төрсөн хүүхдүүд хувь заяа ихтэй юм. Бид ч гэсэн яах вэ, үс маань цайж нас минь өтөлсөн боловч эрх чөлөөт төрийнхөө нүүрийг үзээд эрхэм саруул жаргал, энх сайхан чөлөөгөө ямар ч хавчлагагүй дураараа эдэлж явна гэв.

Өвгөний энэ яриаг сонсож явахдаа Баясгалан эмгэн Улаанбаатар хотноо танилцсан дууч Дулмаагийн тухай түр мартсан боловч өвгөний яриаг дуусмагц дахин Дулмааг бодов.

«Та Улаанбаатар очоод юу үзэж ямар сонин хачин юм сонирхов» гэж хамт яваа нөхдөөс асуувал сонирхон үзсэн бүгдийнхээ тэргүүнд дууч хүүхэн Дулмаатай танилцав. Тэр хүүхэн бол даруу номхон зантай, төв шударга яриатай олон зүйлийн уран сай-

ханд авьяастай хүүхэн шүү. Надад сэтгэл хөдлөм олон сайхан дуу дуулж өгсөн гэж хэлнэ дээ гэж бодож явав.

Гэтэл нөхөд нь энэ тухай юу ч асуусангүй явсаар аймгийн төвд ирэв. Баясгалангийн гэр аймгийн төвд тун ойрхон байдаг. Гэрийнхэн нь Баясгаланг хотоос гарсан гэж дуулаад бэр нь эмээлтэй морь хөтлөж урьд өдөр нь аймгийн төв дээр ирээд хүлээж байжээ.

Баясгаланг шуудан буудал дээр ирээд машинаасаа бууж байхад нь бэр нь хүрч ирээд, ээжээ сайн явав уу? Цогт мэнд сайн сууж эрдэм ном их сурч байна уу? гэж асуухад нь дууны суут билэгтэн Дулмаа хүүхний хөөрхөн хар алаг нүд, дун цагаан шүд нь Баясгалангийн нүдэнд үзэгдсээр л байв.

— Сайн явж ирлээ. Хүү Цогт минь сайн сууж байна. Эрдэм ном их л сурч байгаа юм байх, та нар мэнд сайн сууж байна уу? гэж бэрийнхээ үгэнд хариу хэлж байхдаа ч шинэ танилцсан авьяастан хүүхнээ бодсоор л байв. Хаврын урт өдрийн үд болов.

Баясгалан бэр хүүхнийхээ хөтөлж авчирсан номхон хүрэн морийг унаад хөтөл давсан урт нарийхан замыг дагаж гэрийн зүг мориныхоо жолоог залав.

Хадам эхтэйгээ зуузай холбон давхиж яваагаар бэр,

— Улаанбаатар хотноо ямар сонин юм үзэв. Цогттойгоо хамт ший кино олныг үзэв үү? гэж асуув.

Баясгалан хатирч яваа хүрэн мориныхоо амыг жаахан татаж аажимхан гэлдрээд,

— Олон зүйлийн сонин сайхан юм үзлээ. Манай улсын нийслэл гэдэг чинь тун сайхан хөгжилтэй хот юм байна. Улаанбаатарын хөгжлийг би магтаад ер барахгүй юм.

(Төгсөөдүй)

## С л о в а

**налуу энгэр** пологий склон  
**хормой эд.** подножие  
**шуудан(г)** почта  
**хурдлах** ускорять ход  
**хангай** хангай (*горно-лесистая зона МНР*)

**сэрүүцүүлэх** освежать, охлаждать  
**хүдэр хатуу эд.** тяжелый  
**чийрэг** сильный, дюжий  
**чадамгай** умельый  
**дуусгах** кончать, завершать  
**айл саахалтынхан** соседи  
**томоотой** степенный; скромный  
**ажилч** трудолюбивый, работающий  
**хичээнгүй** старательный  
**хушуу(н) эд.** хошун (*административная единица*)  
**уянгат цээлхэн** благозвучный, музыкальный; звонкий

**магтаал** хвала; ода  
**шар хар феодалууд** духовные и светские феодалы  
**зовох** мучиться, страдать  
**саальчин** доярка  
**анчин** охотник  
**жинчин** возчик, водитель каравана  
**цовоо сэргэлэн** смысленный, бойкий; бодрый  
**төгөлдөр** полный; совершенный  
**цэнгэл** веселье, забава  
**хориглох** запрещать  
**эмгэн** старушка  
**эдлэх эд.** испытывать  
**хуур** хур (*музыкальный инструмент*)  
**ойр хавийн** ближний  
**бүстэй (хүн)** мужчина  
**угаас** с самого начала, искони  
**балар** темный, запутанный

хулсан бамбуковий  
хөндлөн поперек  
хулс(ан) бамбук  
зуух схватить зубами  
аашлах ругать(ся), устраивать скан-  
дал  
өтлөх состариться  
хавчлага эд. притеснение  
дууч(ин) певец, певица  
тэргүүн эд. начало  
даруу скромный, степенный

төв шударга прямой, честный  
гэрийнхэн члены семьи  
бэр(э) невестка, сноха  
эмээл седло  
алаг пегий  
хөтөл седловина, перевал  
залах направить  
эхадам эх эд. свекровь  
зуузай холбон давхих ехать рядом  
гэлдрэх брести

## 55 ТАВИН ТАВДУГААР ХИЧЭЭЛ

### ДУЛМАА ХҮҮХНИЙ УЧИР

(Төгсгөл)

Улсын их театрт ажилтай Дулмаа гэдэг хүүхэнтэй ээж нь их сайн танилцав. Тэр хүүхэн надад олон сайхан дуу дуулж өгсөн. Би хэдэн сайхан дуу заалгав гэх зэрэг оюун билэг төгс дуучин Дулмаа хүүхний уран чадвар, цэцэн авьяасыг магтаж, нүүр царайн цэвэрхэн сайхан, бие цогцос нь эвлэгхэн гуалигийг их л бахархан ярьсаар гэрийнхээ ойр ирлээ.

Их хотын баян чимэг болсон олон хоньдын майлах чимэглэлт дуу хангинаад саальчин бүсгүй хоньчин хүүхдийн шуугилдах чимээ Баясгалан эмгэнийг угтав.

Өсөх наснаасаа өтлөх насаа хүртэл үнэрлэж дассан аргалын хөх утааны сайхан үнэрийг Баясгалан холоос үнэртэв.

Гүн шөнийн хав харанхуйг хага зүсэж дэлхий дахиныг гэрэлтүүлэх их үүргээ хүлээн авах гэж байгаа шиг сайхан сар мэлтийн гарч ирэв.

Гал шиг өнгөтэй, тооно шиг дугараг хэлбэртэй тэр сар руу урт мөнгөн бүгүйл хаях гэж байгаа шиг оройн улаан нар сүү мэт цагаан гэрлээ сацруулсаар жаргаж байв.

Энэ нэгэн хот айл байтугай бүх багийн ардууд Баясгаланг эх мэт хүндэтгэн хүрээлж, мал ажиллагаан дээрээ санал зөвлөлтөө авдаг, ялангуяа залуучууд, дууны үг аялгуу заалгаж сонин хачин үлгэр яриулдаг юм байжээ.

Баясгаланг энэ өдөр ирнэ гэдэг мэдээ аль хэдийнээ тарсан тул ойр хавийн хөгшид, залуу хүмүүс бараг цуглаж Баясгалангаас нийслэл хотын сониныг сонсох гэж хүлээж байв.

Уяан дээрх олон морь, гэрийн гадна овоорон зогсож байгаа хүмүүсийг хараад «Манайхан надаас хол газрын сониныг дуулах гэж цуглажээ. За одоо ч Дулмаа хүүхнийхээ тухай ярина даа. Чухам юу гэж эвтэйхэн ярьж өгдөг билээ» гэж бодсоор баясгалан гаднаа ирж буув.

Баясгаланг буумагц, «та сайн явж ирэв үү? ээжээ сайн явж ирэв үү?» гэдэг үг тал талаас нь зэрэг угтав.

Шөнийн цэнхэр огторгуйд одон мичид жижигхэн гал мэт гялалзсаар байв.

«Хайр хайрын дээжийг  
Хайрт эхдээ зориулъя  
Ачит эх Хорлоогийн  
Алдрыг бид магтъя»

гэж жавхлант малчны том цагаан гэр дотроос сайхан хоолойтой бүсгүй хүний уяхан дуу уянгалан сонсдов.

Баясгалан эмгэн саруул тунгалаг хоолойтой, сайхан хурц авьяастай, дуучин хүүхэн Дулмаагийнхаа тухай цугларсан хүмүүст бахархан ярьж өгөөд Дулмаагийн зааж өгсөн «Ачит эх» гэдэг дууг дуулж байгаа нь энэ байжээ.

Хүмүүс алга ташиж дахин дахин дуулахыг хүсэв. Баясгалан дахин дуулав. Тэгээд Цогт тайж гэдэг кино үзсэнээ ярих нь,

— Би очсон шөнөө хүүтэйгээ хамт «Цогт тайж» гэдэг кино үзэв. Миний хүүгийн нэртэй адил нэртэй энэ кино бол тун сайхан кино юм байна.

Миний хүү сургууль эрдмээ сайн сураад, манай эцэг өвгөдийн эрхэм дээдсийн нэгэн болох Цогт тайж шиг баатарлаг зоригтой, төрсөн орон, түмэн арддаа энхрий хайртай, олон түмнийг соён гийгүүлэгч билэг авьяас мэргэн төгөлдөр тийм хүн болно гэж бодлоо.

Бас маргааш орой нь улсын төв театрт «Миний Баясгалан» гэдэг жүжгийг үзэв. Хөдөө орон нутгийн малчин бидний ажиллагааг яруу тодорхой үзүүлсэн тун сайхан жүжиг юм гэх зэрэг нийслэл хотдоо очоод үзсэн сонссон бүгдийгээ нэгэд нэгэнгүй ярив.

Маргааш нь Баясгалан эмгэн Дулмаа хүүхэнд нэг захидал бичив. Захидал дотроо дурдсан нь «Хайрт дүү минь ээ, ариун тунгалаг бие чинь хэвийн мэнд сайн бөгөөд эрхэлсэн урлагийн ажил чинь амжилттай биз. Би замдаа сайн явж ирлээ. Зааж өгсөн хоёр дууг чинь би нутгийнхаа залуучуудад заах гэж байна. Би эрхэм хайрт дүү чамдаа шинэ танилцсаны анх удаагийн бэлэг болгож 25 жил хадгалсан нэг хуурыг явуулав. Би энэ хуураар монгол орныхоо урт богино дуунуудыг аялгуулан татдаг юм. Дуу сайтай хуур шүү. Дүү минь, хуурыг хүлээн авч уран сайхныхаа ажилд хэрэглэнэ үү. Над шинэ шинэ дууны үг ирүүлээрэй. Суут их билэг оюуны чинь хөгжил улам бадран дэлгэрэх болтугай гэж ерөөгөөд энэхүү захидлыг бариулж ёсолсон буурал эмгэн Баясгалан чинь» гэх зэргээр бичжээ.

Захидлынхаа дугтуй дээр «одон тэмдэгт төв театрын дуучин Дулмаад хүрэгнэ үү» гэж адреслаад сумын шуудангаар явуулав.

Түүнээс хойш сар илүү болов. Нэг өдөр багийн дарга нэг захидлыг Баясгалан эмгэнд авчирч өгөв.

Ашгүй Дулмаас минь ирүүлж үү? хүү Цогтоос минь, ирүүлж үү гэж бодоод, үзтэл өөрийн нь Дулмаад явуулсан нөгөө хууртай захидал нь буцаж ирсэн байв. Захидлын дугтуй дээр нь: «Төв театрт Дулмаа нэртэй дуучин хүүхэн байхгүй тул эзэнд нь эргүүлэн буцаав» гэж бичээстэй байлаа.

Эмгэн хэрэг бүтсэнгүй тул аль ч учраа олохгүй дэмий л «би нэрий нь буруу дуулсан юм биш байгаа даа, лав л Дулмаа гээд байх шиг байсан даа» гэж бодоод нэг үе гомдох шиг, нэг үе гайхах шиг болов.

— Та чухам яаж танилцсан юм бэ? танд тэр хүүхэн нэрээ Дулмаа гэдэг гэж хэлсэн үү? гэж багийн дарга асуув.

Би анх очмогцоо миний ба хүүгийн нэрээр нэрлэгдсэн кино жүжиг хоёрыг үзсэн билээ. Хоёуланд нь Дулмаа гэдэг хүүхэн тоглож байсан юм. Тэгээд би ихэд бэлэгшээж, тэр сайхан авьяаст Дулмаа хүүхэнтэй танилцъя гэж бодоод жүжиг тарсны дараа нөгөө Дулмааг харих гэж явахад нь хойноос нь Дулмаа! гэж дуудаад очиж уулзсан юм гэж Баясгалан хэлэв.

— Аа би мэдлээ тэр хүүхний чинь жинхэнэ нэр Дулмаа биш. Дулмаа гэдэг нэр бол тэр зохиолд гардаг хүнд зохиолчоос нь өгсөн зохиомол нэр гэж хэлэхтэй зэрэг Баясгалан тосон авч,

— Тэгээд би захидлаа хэнд гэж явуулах вэ? гэв.

— Миний хүүгийн нэртэй «Цогт тайж» кино, миний өөрийн нэртэй «Миний Баясгалан» гэдэг жүжиг хоёрт Дулмаа болж тоглосон залуучуудын эвлэлийн гишүүн гавьяат жүжигчин хүүхэнд гэж бичвэл амархан хүрнэ гэж багийн нь дарга хэлээд инээмсэглэв.

По рассказу Ч. Лхамсуруна.

### Слова

цэцэн умный  
цэвэрхэн сайхан красивый  
бие цогцос телосложение  
эвлэгхэн складный, стройный  
майлах бляеть  
хангинах звенеть  
үнэрлэх нюхать, вдыхать  
үнэртэх обонять, распознавать (ощу-  
щать) запах  
хав усиленная частица  
хага зүсэх разрезать  
дэлхий дахин люди мира  
мэлтийх блестеть  
тооно верхнее (дымовое) отверстие  
юрты  
бугуйл аркан, петля  
жаргах *з*д. заходить  
аль хэдийнээ давно  
уяан *з*д. коновязь  
овоорох скопиться  
хайр любовь, забота; милость; жалость  
дээж самое лучшее  
уяхан гибкий; мягкий

уянгалах исполнять, петь  
тайж тайджи (князь, дворянин)  
дээдэс *з*д. предки  
соён гийгүүлэх просвещать  
жүжиг спектакль  
биз вероятно  
аялгуулан татах петь, исполнять  
балран дэлгэрэх расцветать; совер-  
шенствоваться  
ёслох приветствовать  
дугтуй конверт  
одон тэмдэгт орденосный  
ашгүй незабвенный, прекрасный  
эргүүлэн буцаах вернуть, возвратить  
бэлэгшээх считать хорошим призна-  
менованием  
нөгөө *з*д. тот самый  
зохиомол *з*д. вымышленный  
тосон авах встретить, поймать на лету;  
*з*д. сразу  
гавьяат жүжигчин заслуженный ар-  
тист

## ИХ БАЯР

Исгэрэн үлээх салхи майхны хаяаг дэрвүүлэн хийсгэж хүйтэн жавар хучлагыг нэвт хайрч байвч өдрийн турш аялан явж зүдэрсэж бүсгүй унтаж орхив.

Удсан ч гүй үүр цайж аянчид ч босч цайгаа шалмаг гэгч чанаж уугаад үхэр тэргээ хөллөж хөдлөв.

«Хүний хүү санасандаа, хүлэг морь харайсандаа» гэж хүсэж зориглосон газраа хүрэх юмсан гэж бодоод хөр пасан дундуур туулж хэдэн өдөр явсны дараа, хэзээнээс мөрөөдсөн Улаан-баатарынхаа барааг харж бээрсэн царайд нь баярын туяа тусав.

Хүсэл зоригий нь дуудсан газраа, энэ эмэгтэй ирээд гар үйлдвэрт орж ажиллажээ.

Хэдэн сар ажилласны хойно бие нь өвдөөд докторт хэвтлээ.

Тэгээд хүнд ажил хийж болохгүй гэж акт гарчээ.

Энэ эмэгтэй анх миний хүсэж зориглосон зүйл минь биелэгдсэнгүй одоо улсдаа ажил хийж чадахгүй боллоо гэж ихээхэн гашуудан суутал түүний үерхдэг Ханд орж ирэв.

— Лхамсүрэн минь яагаад өнөөдөр ингэж гашуудан сууж байна гэхэд:

— Би анх хотод ирж, гар үйлдвэрт ажиллаад улсдаа ихээхэн бүтээлийг гаргана гэж бодож ирсэн, гэтэл азгүй амьтан, гар үйлдвэрт хэдэн сар ажилласны дараа бие маань өвдөж хүнд ажил хийж болохгүй гээд ажлаасаа гарлаа. Тэгээд түүндээ харамсаж байна гэв.

— Ажлаасаа гарлаа гэж гунихраад яах юм. Урьдаар биеэ сайн эмчлүүл, тэгээд биеэ сайжирсан хойно биедээ тохирох хөнгөн ажлыг хийх хэрэгтэй гэв. Энэ хоёр эмэгтэй ингэж ярилцаар байтал хүн цугларч гүйцэв, хорины дарга ч ирлээ, хурал нээгдэв. Энэ хурал, хорины эмэгтэйчүүдийн зохион байгуулагч нь нутагтаа бүрмөсөн явсан тул түүний орыг сонгох асуудлыг голчлон хэлэлцэх хурал байжээ.

Лхамсүрэн бол ажил бүрд идэвхтэй оролцдог, олонтойгоо эв найрамдал сайтай, төлөв томоотой хүн шүү гэж хуралд суугчид хоорондоо зөвлөж байлаа. Тэгээд хорины хурлаас Лхамсүрэнг эмэгтэйчүүдийн зохион байгуулагчид сонгожээ.

Лхамсүрэн тэр өдрөөс хойш ганцхан зохион байгуулагчийн ажлаар хөөцөлдсөнгүй хороо, хорины хэмжээн дээр явагдах, олон төрлийн ажилд идэвхтэй оролцож бас ч нэхмэл, хатгамлын бүлгэмд тасралтгүй оролцож, өөрөө сураад, бусдыг сургадаг болжээ. Эх орныхоо нийслэлийг боловсон тохилог болгохоор

хүн бүр зориг хүчээ дайчилж, өргөн субботникийг хийцгээж байлаа.

Лхамсүрэн хуучирсан чисчүү тэрлэг өмсөөд, жижиг тэргэнд дүүрэн шорой хийлгээд явж байхад, хажууд нь шорой зөөж байсан настайвтар хар хүн, та чинь дийлэхгүй байж ямар их хийлгэсэн юм бэ? наадхыгаа асгалгүй аваачвал дээрдээ гэж ёжилсон маягтай хэлэхэд, Лхамсүрэн урьдаас нь ээ зайлуул, тан шиг л атга шорой аваад явж байвал таархана уу? гээд түргэн түргэн алхлахад нь ажилч хичээнгүй чанар нь тодхон байлаа. Удсан ч гүй субботникийн ажил дуусав. Хорины дарга, энэ өдрийн субботникийн дүнг уншихад Лхамсүрэн нормоо 160 хувь биелүүлсэн байлаа. Лхамсүрэн гэртээ харьж гар нүүрээ угаагаад, хоолоо идэх завсар хүүтэйгээ ярилцаж байв.

— Хөгшин болсон би шинэ үсэг сураад байхад, чи одоо хүртэл шинэ үсэг сурахгүй байх чинь, ичхэвтэр хэрэг биш үү? номоо давт! Маргааш өглөө хичээлд очихдоо заалгаснаа сайн давтаж очоорой! Битгий гадуур хүүхдүүдтэй тоглоод байгаарай! Ээж нь маргааш хорины улаан буланд очиж тайлан сонгуулийн хурлын бэлтгэл ажлыг хийнэ. Миний хүү хичээлээсээ ирээд номоо сайн давтаж байгаарай! гэв.

Нарны халуун элч, дээл нэвт халааж байвч, намрын сэрүүн салхи сэнгэнэн улээгээд, сэргэлэн сайхан өдөр байлаа. Хорины эмэгтэйчүүд өөр өөрсдийнхөө хийж бүтээсэн зүйлээ авч 15 дугаар хорины улаан буланд ирэв.

— За энэ самбарг өөрсдийнхөө урлан хийсэн нэхмэл хатгамал урлалын зүйлүүдийг хадцагаа! гэж Лхамсүрэн зохион байгуулж өгөөд, Хандаа, оёсон сүлдээ дунд самбарын голд хадаарай, Долгор, таван хушуу мал оёсон алчуураа баруун талд нь хад. Сүрэн, нэхсэн өмд цамцыг зүүн талд нь хад, аль Цэрээн тэр цэцэг оёсон алчуураа энд хад, түргэн хадцагаагаарай! Дарга нар ирнэ шүү гэж шаардаж байлаа.

Эмэгтэйчүүд, зохион байгуулагчийнхаа удирдлага заавраар улаан булангийнхаа бүх самбар, зураг, диаграмм, нэхмэл, хатгамлын зүйлүүдийг бүрэн зохион байгуулж дуусаад байтал дарга нар ч ирлээ.

Хорины дарга, Лхамсүрэнгийн зохион байгуулсан энэ улаан булангийн самбаруудын чимэглэл нь маш сайхан болжээ.

Үүний дотор эмэгтэйчүүдийн хүчээр бүтсэн урлагийн энэ самбар тун аятайхан болсон байна. Энэ самбарыг хотын хөдөлмөрчдийн бага хуралд шилжүүлж өгнө, маргааш хориныхоо эмэгтэйчүүдийг хуралдуулж орон нутгийн засаг захиргааны тайлан сонгуулийг хэрхэн угтаж ажиллах тухай хэлэлцэх хэрэгтэй гэж эмэгтэйчүүдийн зохион байгуулагч Лхамсүрэнд хэлэв.

Нөхөр Лхамсүрэн бол хорины эмэгтэйчүүдийг зохион байгуулж олон төрлийн кампани ажлуудад дүүрэн оролцуулахын тулд чадамгай удирдаж ирсэн бөгөөд өөрөө ч хэзээ ямагт оролцохын төлөө эх оронч хүсэл санаагаа бүрэн зориулдаг тэргүүний сай-

чуудын нэг юм. Энэ учраас Лхамсүрэнг хотын сонгуулийн комиссын бүрэлдэхүүнд сонгосон байжээ.

— Хувьсгалын өмнө, эмэгтэйчүүд бол ноёд, лам нарын хүнд дарлалыг хүлээж, төрийн сонгуульд оролцох байтугай, ном руу харвал хонинд чоно өнгийсөнтэй адил үзэгдэж, ямар ч эрх мэдэлгүй бөгөөд адгуус малын оронд худалдагдаж байсан бол хувьсгалаас хойш эрэгтэйчүүдийн нэгэн адил эрх чөлөөг эдэлж чөлөөтэй хөдөлмөрлөх бүрэн эрхтэй болжээ.

— Би өнөөдөр улсынхаа засаг захиргааны дээд байгууллагад багтаж байгаадаа бахархан баярлаж байна.

Энэ эрхийг манай эцэг Чойбалсангийн үндсэн хууль, ард түмэнд бүрэн олгож өгсөн юм гэж Лхамсүрэн ярьж байлаа.

По рассказу Я. Дамбадаржаа.

### С л о в а

**дэргүүлэн хийсгэх** развевать, поднимать

**жавар** холодный ветер; прохлада

**хучлага** покрывало, одеяло

**нэвт** насквозь

**хайрах** ознобить

**зүдрэх** уставать; изнуряться

**аянчид** путники

**үхэр тэрэг** телега (*для воловьей запряжки*), арба

**хөллөх** запрягать

**хөр цасан** сугроб, снежный занос

**хэзээнээс** издавна

**бээрэх** коченеть, зябнуть

**тусгах** эд. отвечивать; озарять

**зориглох** вознамериться; направить-ся

**азгүй** несчастливый, неудачливый

**гунихрах** унывать, печалиться

**ор(он)** эд. вакансия

**голчлон** в основном

**зөвлөх** советоваться

**хөөцөлдөх** эд. усиленно заниматься; усердно работать

**хороо(н)** эд. городской район

**олон төрлийн** разный, разнообразный

**нэхмэлийн** вязальный

**хатгамлын** вышивальный

**чисчүү** чесуча; чесучевый

**тэрлэг** тэрлик (*летний национальный халат*)

**хар хүн** мужчина; муж

**асгах** эд. просыпать

**ёжлох** шутить, иронизировать

**ээ зайлуул** *иронически* бог ты мой

**атга** горсть, пригоршня

**таарах** годиться; соответствовать

**ичхэвтэр** стыдно

**тайлан сонгуулийн** отчетно-выборный

**сэнгэнэх** дуть; веять

**сэргэлэн** эд. свежий, прохладный

**нэхмэл** вязаные вещи

**хатгамал** вышивка

**сүлд** герб

**таван хушуу** мал пять видов скота

**алчуур** полотенце; платок

**нэлэх** вязать

**сайчууд** передовики

**бүрэлдэхүүн** состав

**эрх мэдэл** право; власть

**адгуус** мал скот, животное

**эрэгтэйчүүд** мужчины

## НОРМЧДЫН ДУНД

Чойбалсангийн нэрэмжит аж үйлдвэрийн комбинатын эсгийлэх фабрикийн нормчин Шагжхүү гэдэг сэргэлэн залуу, ударник Лхагваагийн ирэв. Шагжхүү пролетарийн их уран зохиолч Максим Горькийн «Миний их сургууль» гэдэг нэрт зохиолыг унших гэж Лхагваагаас гуйж аваад түүнийгээ дуусчаад өх гэж ирсэн юм байжээ.

— Нөхөр Лхагваа! танд их баярлав. Сайхан зохиол байна шүү.

— Тиймээ! сайн зохиол, би анх номын дэлгүүрээс авахтайгаа зэрэг дор нь уншиж дууссан юм шүү.

— Шагжхүү чи хэддүгээр ээлжинд явах вэ?

— Би 2 дугаар ээлжинд явна.

— Танай бригад энэ 5 дугаар сард төлөвлөгөөгөө хэдэн хувь биелүүлэв?

— 139 хувь биелүүлж залуучуудын эвлэлийн гавшгай бригадтай мөр зэрэгцэх шахаж байна. Бид 6 дугаар сард төлөвлөгөөгөө улам ахицтай биелүүлж чадна гэж их шургуу ажиллаж байна. Ер нь залуучуудын эвлэлийн гавшгай бригадын үлгэр жишээ манай энгийн залуучуудын дунд сайн нөлөөлж байна шүү.

Энэ хэдхэн үгийг ярилцсаны дараа таван цагт гучин минут дутуу байна. Харьж хувцсаа сольж өмсөөд ажилдаа очье гээд Шагжхүү суудлаас босов.

— Чи цай уугаад яв. Одоохон буцлах гэж байна гэж Лхагвааг хэлэхэд:

— Их баярлав. Би яараад байна гээд Шагжхүү гарлаа. Шагжхүүг гарсны дараа Лхагваа цахилгаан пишин дээр буцалж бий данхтай цайгаа өтгөн сүүгээр сүлээд зөөлөн түшлэгтэй сандаль дээр сууж гитар хөгжмийг хөглөж нэг дууны аяыг дарах гэж оролдов.

Энэ завсар:

«Хөвсгөл буйрын цэнхэр долгио давалгаалсан  
Хөвч хангайн өндөр оргил сүндэрлэсэн  
Хөгжүүн амьдралт сайхан монгол нутгийн  
Хөгжин давшигч үндэстэн бүгдээр  
Ханцуй шамлаад ажилд гарахдаа хөдөлмөрчин  
Хамтарч бүтээснээ эзэмшиж эдлэх нь эзэн  
Эдэлж хэрэглэх минь элбэг учраас баян  
Эрх мэдэл минь бүрэн учраас жаргалтай»

гэж эрэгтэй эмэгтэй хоёр хүн радиогоор дуулав. Энэ нь Лхагваагийн аяыг нь олохгүй байсан дуу мөн бөгөөд Лхагваа радиогоо

дагаж аман дотроо гунганан аялж байтал байшингийн үүдэнд нэг хүн ирээд гутлынхаа улыг арчиж байх нь мэдэгдэв. Төдийхөн зөөлөн харцтай хавтгайвтар нүүртэй хүүхэн орж ирсэн нь Лхагваагийн гэргий Жамьяншарав юм.

Махлаг царайд нь инээмсэглэл тодорч байгааг нь харахад боловсон амралтанд тохитой амраад ирсэн хүний шинж илэрхий байв. Жамьяншарав орж ирмэгц Лхагваа суудлаасаа босож за хайрт минь сайн амрав уу, ямар их таргалаав! гэхэд,

— За ажил сайн, чи чинь радиог дагаж дуулаад хөгжилтэй байх шив дээ гэж хэлэхэд,

— Чамайг амралтад явснаас хойш манай фабрикийн уран сайхны бүлгэм улам шургуу ажиллаж байна шүү. Одоо улсын 27 жилийн ойн их баярыг угтаж концерт бэлтгэж байна. Надад «Манай дуу»-г сурах даалгавар өгсөн юм. Тэгээд би давтаж сууна. Ашгуй амралт чинь сайн зохьсон байх шив дээ гээд, Лхагваа жижигхэн улаан шүүгээ дотроос гялалзтал арчсан хоёр эрээн шаазан гаргаж тавиад цайг аягалж байхад гэргий Жамьяншарав хөнгөн хувцсаа өмсөхөөр шинэхэн даавуу дээлээ тайлж энгэртээ байсан «хөдөлмөрийн хүндэт медаль», ударникийн тэмдэг хоёрыг авч далд хийв. Үүний дараа хуучивтар том шар ширээний хоёр талд зэрэгцэн суугаад цай ууж байх завсраа Жамьяншараваас,

— Эвлэлийн гишүүдийн бригад, энгийн залуучуудын бригад энэ 5 дугаар сарынхаа төлөвлөгөөг хэдэн хувь биелүүлсэн бол гэж асуув.

— Сая энгийн залуучуудын бригадын дарга Шагжхүү орж ирэв. Түүний хэлэх нь танай бригад 148 хувь, энгийн залуучуудын бригад 139 хувиар биелүүлсэн гэнэ.

— Манай бригад ч шижгэнэсэн бригад шүү. Нормоо гүйцэтгээгүй хүн гараагүй биз дээ. Хэн хэн сайн ажилласан бол, дүнг үзэв үү?

— Үзсэн, эвлэлийн гишүүн Норов, Гүндсамбуу, Загд, Батхүү нар нормоо 180-аас 300 шахам хүртэл биелүүлсэн байна билээ. Ялангуяа мастер Пүрэвдорж, Лодоншарав нарын ээлж тун сайн ажилласан юм даа. Энгийн залуучуудын бригадынхан дотроос сайчууд олон гарсан байна билээ. Эсгий гутлын Лхамхүү, Сүхбат, Сувд гэх зэрэг нэлээд хэдэн залуучууд 200-гаас 250 хүртэл хувиар нормоо биелүүлсэн гэж уралдааны улаан самбар дээр бичээстэй байнал гэж хэлээд Лхагваа ширээнийхээ том цагийг бугуйнхаа жижиг цагтай хосолж харав. 6 цаг болж байлаа.

— Бид хоёр гуравдугаар ээлжинд явна. Нэг цаг хүртэл сайхан амра. Би үсчинд очиж үсээ засуулаад ирье. Чамайг явснаас хойш бидэнд зав бага байсан шүү. Манайхан чинь 2 дугаар улиралынхаа төлөвлөгөөг давуулан биелүүлэх гэж тун шаргуу ажиллаж байгаа шүү гэж хэлээд гарч одов.

Жамьяншарав үргэлж авдар, сав, зураг, толийг арчиж цэвэрлэдэг цэвэр нямбай заншлаа дагаж Лхагвааг гарахтай зэрэг аяга, савнаасаа эхлээд авдар, чемодан, хананд хадаастай байгаа газрын том зургийг хүртэл арчив. Гэвч нөхөр нь Жамьяншараваас дутуу-

гүй цэвэр нямбай тул Жамьяншаравд арчиж цэвэрлэх ажил төдий л их байсангүй учир цонхныхоо нээлттэй салхивчийн дэргэд зогсож сэрүүцэв. Зун цагийн халуувтар боловч аятайхан санагдах урихан салхи цонхоор ороод сайхан сэрүүн агаараар дүүргэх гэсэн мэт орж байлаа.

22 настай энэ хүүхэн бол Дундговь аймгийн Цагаан-ово сумын нутагт төрсөн малчин бүсгүй байгаад, дараа нь ажилчин болжээ. 1943 оноос эхлэж Чойбалсангийн нэрэмжит аж үйлдвэрийн комбинатын эсгийлэх фабрикийн эсгий гутлын тасагт орж ажилласнаас хойш сар бүрийн нормоо 150-аас дорогшгүй биелүүлж иржээ.

Зөвлөлт Холбоот Улсын баатарлаг ард түмэн түүний эрэлхэг цогт Улаан Армиас германы фашисттай ширүүн дайныг явуулж байсан эх орны дайны хүнд жилүүдэд өөрийнхөө нормыг ямагт 100 гаруй хувь биелүүлж хэдэн мянган эсгий гутлыг гаргасан манай эх оронч зоригт хөдөлмөрч залуучуудын нэг юм. «Хөдөлмөр бол бидний ариун амьдрал мөн. Хэн их алдар гавьяа байгуулж цэцэглэн мандаж байгаа эрх чөлөөт эх орноо улам батжуулъя гэвэл хамгийн түрүүнд хөдөлмөрт амжилт гаргах хэрэгтэй» гэж боддог учраас энэ хүүхний хийсэн ажил нь чанарын талаар сайн тооны талаар нормоноос давуу байдаг нь ердийн заншил болжээ.

«Би Чойбайлсангийн анхдугаар таван жилийн төлөвлөгөөг биелүүлэх явдалд бие сэтгэлээ бүрэн дайчилж 5 жилийн дотор хийх төлөвлөгөөт ажлыг 3 жил хагасын дотор биелүүлнэ» гэж энэ хүүхэн хөдөлмөрчин хүний хэлдэг сайхан илэрхийлэлтүүдийг тавьжээ.

(Төгсөөдүй)

### С л о в а

**эсгийлэх фабрик** войлочная фабрика  
**нормчин** эд. ударник  
**сэргэлэн** эд. шустрый, бойкий  
**уран зохиолч** писатель  
**гуйх** просить  
**мөр зэрэгцэх** равняться; стоять плечом к плечу  
**шахах** эд. приближаться  
**ахиц** продвижение вперед; повышение  
**үлгэр жишээ** пример, образец  
**энгийн залуучууд** несоюзная молодежь  
**пишин** печка, плитка  
**сүлэх** забелить молоком  
**түшлэг** спинка (например, стула)  
**хэглэх** эд. настраивать, натягивать струны  
**ая** мелодия, мотив  
**давалгаалах** волноваться  
**хөвч** сопка, скала

**хөгжүүн** расцветающий; растущий  
**ханцуй** рукав  
**шамлах** засучивать  
**гунганах** напевать; мурлыкать  
**гутал** обувь  
**ул** подошва  
**хавтгайвтар** широковатый  
**махлаг** полный, мясистый  
**таргалах** поправиться, [по]полнеть  
**эрээн** пестрый, узорчатый  
**шаазан(г)** фарфор; фарфоровая посуда  
**аягалах** наливать в чашку (пналу)  
**хуучивтар** староватый  
**шижгэнэх** эд. шуметь; двигаться быстро  
**бугуйн** ручной  
**хосолж харах** эд. сверить  
**үсчин** парикмахер  
**үсээ засуулах** стричься  
**зав** свободное время

манайхан эд. наш коллектив  
сав(а) посуда  
цэвэрлэх чистить  
нямбай аккуратный  
аяга чашка, пиала  
сэрүүцэх освежаться  
халуувтар жарковато

дорогшгүй не ниже  
зоригт смелый; волевой  
хөдөлмөрч(ин) труженик; трудолюбивый  
алдар гавьяа(н) доблесть, слава  
батжуулах укрепить

## 58 ТАВИН НАЙМДУГААР ХИЧЭЭЛ

### НОРМЧДЫН ДУНД

(Төгсгөл)

Шинэхэн хийсэн хоёр том эрээн авдрын дунд давхарлан хураасан хэдэн чемоданы дээр битүү алхан хээтэй байшингийн ханыг түшүүлж тавьсан том тольны өмнөх гурван толгой суурьтай дугараг цагийн сэрүүлгээр сэрсэн Лхагваа орноосоо түргэн гэгч өндийн харвал цагийн урт богино хоёр зүү яг 12 дээр голлож байлаа. Эхнэр Жамьяншарав нь аль хэдийн түрүүлж босоод цай халааж талх шар тос зүсээд таваг дээр өрж байлаа.

Тэдний суудаг өрөө уужим цэлгэр бөгөөд цонхны нь нээлттэй салхивчаар зуны шөнийн хуурай салхи цэвэр агаарыг тууж оруулна. Цагаан толгойтой том төмөр орны араар татсан нэхмэл хөшиг дээр таван өнгийн утсаар урлаж оёсон таван хушуу малын дүрс маш их чимэгтэй үзэгдэнэ.

Саяхан будсан хүрэн будаатай шал нь өчүүхэн ч халцраагүй харин гялалзтал арчсан учир цоо шинэ хулдаас шиг бөгөөд дээр нь шар цоохор хивс тавьсан нь тун зохимжтой байв. Байшингийнхаа хивсний өнгөтэй өөрийнхөө үзэсгэлэн тэнцүүлэх гэсэн мэт цонхон дээр байгаа таримал цэцэг нь шар, цагаан, улаан навчаа гадагш нь дэлбийлгэжээ.

Хатуу зөөлөн хавтастай зузаан нэмгэн шинэ хуучин олон номыг үелүүлэн өрсөн номын тавьлуурын дэргэд байгаа оёдлын машинын тагны завсраар торгон утасны үзүүр, эдийн өөдөс цухуйж байгаа нь оройхон юм оёж байсны тэмдэг юм.

— Чи чинь амралтанд сар амраад ирсэн хүн гэсэндээ намайг бодвол нойр хөнгөнтэй бие чинь сэргэлэн байх шив дээ. Надаас хэдэн минутын өмнө босов гэж Лхагваа Жамьяншараваас асуув.

— Даанч дээ улсын амралтанд амарсан хүн байна, бие сэргэлэн байлгүй яхав. Би 11 цагт босоод техникийн дугуйлангийн хичээлийг жаахан давтлаа гэж хэлэв.

Тэгээд энэ хоёр цайгаа ууж хөнгөн зуушаа идээд, 1 цагт 35 минут дутуу байхад ажилдаа очихоор байшингаасаа гарлаа.

Баруун хойноос урьхан салхи үлээгээд цэлмэг хөх тэнгэрт одод гялалзаж, сарны дугуй цагаан гэгээ дээрээс гөлрөж байлаа.

Их хотоос 4—5 километрын зайтай байгаа комбинатын дэрэгдээс харахад, Улаанбаатар хотын олон барилгын чийдэнгүүд хурц гэрлээр бадарч галт одууд газар дэлхий дээр буусан мэт үзэгдэв.

Үйлдвэрийн хойт талаар их хотын зүг чиглэсэн засмал замаар бараа, түүхий эд тээвэрлэсэн ачааны том том машинууд гэрлээ асаагаад давхилдаж явна.

— Өнөө шөнө чинь их сайхан шөнө байна. Гадаа суугаад ном уншсан ч болмоор саруулхан шөнө байна шүү цэж Лхагвааг хэлэхэд,

— Ном уншсан ч болно, юм оёсон нь ч болно гэж Жамьяншаравыг хэлж явтал шөнийн ээлжний галт тэрэг сигналаа хангинуулж, сарны доогуур олон цувраа байшин нүүж байгаа шиг харагдав.

\* \* \*

Хашааны өргөн хаалгаар олон хүн цувран орж байлаа. Лхагваа Жамьяншарав хоёр ч мөн л түргэн алхлаж хашааны хаалгаар нэвтрээд фабрикийн хаалгаар ортол халуун салхи өмнөөс угтаж эсгий хийх индүү машинын хатуу дуу нижгэнэж байлаа. Эднийг орохтой зэрэг хэсэг ажилчид,

— За Жамьяншарав сайн амрав уу, одоо ажилдаа орох нь уу гэж мэндэлцгээв. Тэдний дундаас нэг залуу индүү машинынхаа дэргэд очоод том дөрвөлжин индүүг өөд нь болгож урт цагаан эсгийг эвхээд индүүдсэн олон цагаан эсгийн дээр тавьлаа. Цөм ажилдаа орцгоов.

Эсгий хийх индүү машинын хойт тал дээр машинаар зулсан хөвөн шиг цагаан ноосыг тавьж түүнийг тэгшлэн зэхцэлж байгаа дөрвөн хүүхэн чөлөө завгүй хөдөлмөрлөж байгаа нь дараагийн ээлжийг орохоос өмнө бас нэг хэдэн эсгий гаргая гэж чармайж байгаа нь мэдэгдэнэ.

Индүү машин баригч Батаа гэдэг залуугийн тавьсан эсгийнүүдийг хэдэн залуучууд хоёр хоёроороо дамлан аваачиж эсгий чангаруулах машинд хийж байлаа.

Лхагваа Жамьяншарав хоёр эсгийг хийх тасгаар дайраад ажлын тасалгаанд ортол фабрикийн бүх машинууд нэгэн зэрэг зогсоод ээлжээ солилцох 10 минут болсны дараа олон төрлийн дамжлага тасгийн машинууд нэгэн зэрэг нижгэнэж 3-дугаар ээлжийнхэн ажилдаа орлоо.

Жамьяншарав хуучин барьж байсан гутал өнгөлөгч машинаа хүлээн аваад хажуудаа хураалттай байсан эсгий гутлыг хамгийн түрүүнд өнгөлж эхэлснээр энэ тасгийн ажил нь буцлав. Өнгөлсөн гутлыг зарим нь хос хосоор нь нийлүүлээд номерлож байв. Зарим нь номерлосон гутлуудыг тусгай тавьлуур дээр хурааж байлаа. Тасгийн зүүн талын буланд булчин нь зангирсан хэдэн эрчүүд эсгий гутлыг хэвлэж байлаа. Жамьяншарав нормоо 4 цагт биелүүлээд дараагийнхаа нормод эхлэн ороод нэг гутлыг өнгөлж байтал,

— За сайн амарсан уу? Чи ч гялалзаж байх шив дээ, хичнээн гутал гаргаад байна гэж нэг хүн хашгирах шахаж хэлэх нь машинын дуунд өөрийнхөө дууг дарагдуулахгүй гэсэн мэт байлаа.

— Сайн амарсан, та сайн байна уу? гэж хэлээд Жамьяншарав эргэж ардаа зогсож байсан хоёр хүнтэй гар барьлаа. Энэ хоёр хүн бол фабрикийн намын үүрийн дарга Санжжав, захиргааны дарга Баягас нар үйлдвэрийнхээ тасгуудаар шөнийн ажиллагааны байдалтай танилцаж яваа нь юм байж. Эд тэндээс зүлх тасагт оров. Зүлхын суурь машин бүгдээрээ сайн явж байлаа. Баягас нарыг орохтой зэрэг тасгийн мастер Равдан угтан ирж манай ээлж тун сайн ажиллаж байна, ер нь бүх машинууд нормоо давуулан биелүүлэх төлөвтэй, зарим нь хоёр гурван норм хийчмээр байна гэж ярив. Энэ завсар 28 дугаар машиныг баригч Жав бүдүүн барабан бүтэн ороосон том сэвгэр ноосыг хуулан эвхэж эвтэйхэн тэвэрсээр килолуулав. Ноос килологч залуу чиний норм чинь биелэв гэж хэлээд таван хушуутай улаан тугийг Жавт шилжүүлж өгөв. Намын үүрийн дарга,

— Өнөө шөнийн танай ээлжний хамгийн түрүүнд Жав нормоо хийх шив дээ гэж хэлээд цагаа харав, фабрикийн дарга Баягас бас цагаа хараад одоо саадгүй сайн яваад байвал бас нэг норм хийх цаг үлдээд байна, өнөө шөнийн ээлжнийхэн бас л сайн ажиллах нь байна гэж хэлэв. Үүгээрээ бол эд нар Чойбалсангийн анхдугаар таван жилийн төлөвлөгөөг хугацаанаас нь өмнө биелүүлэхэд гарамгай амжилт гаргах залуучууд байна.

По очерку Ч. Лхамсуруна.

### С л о в а

**давхарлан хураах** ставить один на другой; сложить

**битүү алхан хээ** название орнамента

**түшүүлэх** подпереть, ставить подперев

**сэрүүлгэ** будильник, звонок будильника

**сэрэх** проснуться

**халаах** разогревать, нагревать

**таваг** тарелка

**цэлгэр** просторный

**туух** гнать, перегонять

**будаатай** крашенный

**халцрах** эд. быть потертым

**цоо шинэ** совершенно новый

**хулдаас(ан)** клеенка, линолеум

**цоохор** эд. пестрый

**хивс** ковер

**зохимжтой** подходящий; гармонизирующий

**дэлбийлгэх** распускать

**зузаан** толстый (о плоских предметах)

**нэмгэн тонкий** (о плоских предметах)

**үелүүлэн өрөх** эд. рядами ставить, сложить

**номын тавьлуур** этажерка для книг

**таг** подставка, полочка

**эдийн өөдөс** лоскутки, обрезки ткани

**цухуйх** торчать; высовываться

**нойр хөнгөнтэй** не сопливый; выспавшийся

**зууш** закуска; кушанье

**гөлрөх** обомлеть

**зайгай** эд. на расстоянии

**тээвэрлэх** грузить, класть; перевозить, транспортировать

**асаах** зажигать, засветить

**доогуур** под; ниже

**цувраа** вереница; стоящие друг за другом

**нүүх** кочевать

**цуврах** итти друг за другом, гуськом

**индүү** утгуг

**зулах** складывать слоями (шерсть);

счесать

**тэгшлэн зэхцлэх** выравнивать  
**дамлах** поднять [вдвоем] на пере-  
кладине, палке  
**чангаруулах эд.** уплотнить  
**дайраад** через  
**дамжлага** передаточный; перевалоч-  
ный  
**хураалттай** сложенный, собранный  
**өнгөлөгч машин** шлифовальная ма-  
шина; машина, при помощи кото-  
рой придается внешний лоск  
**өнгөлөх эд.** удалять шероховатости,  
шлифовать

**номерлох** нумеровать  
**тавьлуур** подставка, столик  
**булчин** мускулы  
**зангирах эд.** вздуваться буграми  
**эрчүүд** мужчины  
**хэвлэх эд.** насаживать на колодку  
**хийчмээр** могут выполнить  
**ороох** наматывать  
**сэвгэр** рыхлый, пушистый  
**хуулах** сдирать, снимать  
**килолох** взвешивать (*в килограммах*)  
**таван хушуу(н) эд.** пятикозачная  
звезда

## 59 ТАВИН ЕСДҮГЭЭР ХИЧЭЭЛ

### МОНГОЛЫН АРД ТҮМЭН СОЦИАЛИЗМЫН ЗАМД

Монголын ард түмэн, өөрийн түүхэндээ анх 1921 онд Оросын их ард түмний шийдвэртэй агуу их тусламжаар эрх чөлөөгөө олж авлаа. Хөдөлмөрчдийн их жолоодогч Ленин-Сталин нараас, Монголын ард түмэнд империалист хүнд дарлагдлын гинжнээс тасран ангижрахад нь тусалсан ба Зөвлөлт Оросын ялсан пролетари нартай холбоотой явж, эрх чөлөөт, энх жаргалант амьдралыг байгуулах гагцхан зөв замыг түүнд зааж өгсөн юм.

Улсын анхдугаар их хурал, 1924 оны 11 дүгээр сарын 26-нд манай анхдугаар үндсэн хуулийг баталж, Монгол улсыг Ардын бүгд найрамдах улс болгон тунхагласан юм. Монгол улсыг Ардын бүгд найрамдах улс болгон тунхагласан өдрөөс эхлэн, энэ өнгөрсөн 25 жилийн дотор Монголын ард түмэн, капиталист хөгжлийн шатыг алгасан, дундад эртний үе ба феодализмээс социализмд хөгжин давших замаар явж ирэхдээ, тус улсад тогтоогдсон ардын ардчилсан байгууллын хүчтэй ба амьд чадалтайг тодорхой үзүүлсэн гайхамшигт амжилтуудыг олов.

Монголын ард түмэн, Ленин-Сталин нарын зааж өгсөн, капиталист бус хөгжлийн замаар явж, тус улсын эдийн засаг, соёлын бүх салаа мөчир бүрд ихээхэн амжилтыг олжээ. Тус улс нь өөрийн эдийн засгийн үндсэн суурь болсон мал аж ахуйг хөгжүүлэх талаар нилээд ихээхэн амжилтыг оллоо. Ардын аж ахуйтны нийт мал нь 1924 оноос 1949 он хүртэл 201,3 хувиар өсчээ.

Ардын хувьсгалын өмнө ардууд мал ба эд хөрөнгийнхөө хамт феодалуудын мэдлийн бүрэн өмч болж мөлжигдөж байсан бол одоо бүх мал нь хөдөлмөрчдийн гарт байна.

Бид, Зөвлөлт Холбоот Улсын тусламжаар өөрийн био үйлдвэртэй болж, мал аж ахуйд хэрэгцээтэй янз бүрийн эмийн зүйлийг

боловсруулсаар байна. Жил тутам олон сая малд урьдаас сэргийлэх тарилгыг хийж байна. Малын халдварт өвчинтэй тэмцэх талаар арга хэмжээ авсны дүнд, халдварт өвчний улмаас мал бөөнөөр их үхэж хорогдох явдлыг устгалаа.

Монголын мал аж ахуйд тэжээлийг бэлтгэх явдал маш их ач холбогдолтой юм. Тэжээл бэлтгэх гэдэг юу болохыг саяхан болтол мэдэхгүй байсан олон мянган мал аж ахуйтан, өвөл, хаврын цагт малаа тэжээх өвсийг, одоо жил тутам хадаж, бордоо тэжээлийг бэлтгэсээр байна. Манай улсад өвсний морин станц 35 ажиллаж, мал аж ахуйтанд тэжээл бордоо бэлтгэхэд туслан, мал аж ахуйн ажиллагааны боловсон аргыг нэвтрүүлэхээр ажиллаж байна.

Жижиг бутархай мал аж ахуйг хойшид өөрчлөх явдалд тус оронд байгуулагдсан ардын үйлдвэрлэлийн нэгдлүүд ихээхэн ирээдүйтэй юм. Одоо ардын нэгдлийн тоо 121 болжээ. Улсаас эдгээр нэгдлийг бүх аргаар аж ахуй, зохион байгуулалтын талаар бэхжүүлэх зорилгыг тавьж байна.

Тариалангийн ажил бол үшэндээ Монголын хөдөө аж ахуйн шинэ салаа нь мөн юм. Тариалангийн ажлыг ихээхэн цөөхөн тооны ард эрхэлж байгаа ба манай оронд байгуулагдаж, одоо цагийн хөдөө аж ахуйн машинуудаар зэвсэглэгдэн хангагдсан улсын сангийн есөн аж ахуй улсын дотооддоо тарианы гол зүйлийг өгч байна.

Монгол Ардын Хувьсгалт Намын 11 дүгээр их хурлаас, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын аж ахуй, соёлыг 1948—1952 онуудад хөгжүүлэх таван жилийн төлөвлөгөөг 1947 оны эцсээр баталсан явдал нь Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хөгжлийн шинэ алхам мөн бөгөөд малыг цаашид үлэмжхэнээр өсгөж, түүний ашиг шимийг дээшлүүлэх, малын хорогдлыг бууруулахаар энэ төлөвлөгөөнд заажээ.

Хувьсгалаас өмнөх Монгол улсад, аж үйлдвэр огт үгүй байв. Зөвлөлтийн ард түмний ах дүүгийн тусламжаар манай орон, өөрийн үйлдвэрийг байгуулсаар байгаа ба залуу ажилчин анги, инженер, техникийн сэхээтний үндсэний боловсон хүчин хөгжсөөр байна. 1940 оноос 1949 он хүртэл улсын үйлдвэрийн бүх үйлдэхүүн нь 1940 оны хөдлөшгүй үнээр 280 хувиар өсчээ.

Манай орны байгалийн баялаг, олон мянган жилээр хөдөлгөөгүй хэвтэж байлаа. Гагцхан ардын ардчилсан байгуулал нь хөдөлмөрчдийн энх сайхан амьдралыг сайжруулах зорилгоор эдгээр ресурсыг ашиглах бололцоог бий болгожээ. Үүнд: Тус улсад хөгжсөөр байгаа уул, уурхайн үйлдвэр, сайн нүүрс, үнэт ба ховор металлын зэрэг малтмалын зүйлийг гаргасаар байна.

Жилээс жилд өргөжин хөгжсөөр байгаа орон сууц, соёл, үйлдвэрийн барилгууд нь барилгын материалын үйлдвэрийг ихээхэн хөгжүүлсээр байна.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын ардын аж ахуйд, гар үйлдвэр ихээхэн рольтой бөгөөд түүнээс өргөн хэрэгцээний янз бүрийн барааг үйлдвэрлэн гаргаж байна. Гар үйлдвэр нь олон мянган гар урчуудыг нэгтгэсэн олон арван артельтай юм.

Хуучин Монгол улс нь зам харилцааны талаар зөвхөн бүдэг балархай харгуй замтай ердийн хөсөг, тэмээн тээвэртэй байлаа. СССР-ийн ах дүүгийн чин үнэнч тусламжаар Монгол улс, одоо цагийн авто тээвэртэй болсон ба гол мөрний тээвэр хөгжихийн үүсгэлийг тавьсны дээр нэг мянга шахам километрийн урт засмал сайхан замтай болсон байна. Ачааны авто машинын тоо сүүлийн 10 жилд хоёр хагас дахин өсчээ.

Төмөр зам бол манай улсад маш их ач холбогдолтой бөгөөд энэ нь урьд, манайд огт байгаагүй юм. Улаанбаатар хотыг Зөвлөлт Холбоот Их Улстай холбож байгаа төмөр зам бол манай улсын эдийн засаг, соёлыг цаашид хөгжүүлэх, манай улс ардын аж ахуйн шинэ салаануудыг хөгжүүлэх явдалд маш чухал бөгөөд амьдралын онц ач холбогдолтой юм. Энэ төмөр замыг хугацаанаас нь өмнө тавьж гүйцээд, Октябрийн Социалист Их Хувьсгалын 32 жилийн ойн өдөр хөдөлгөөнийг энэ төмөр замаар нээсэн билээ. Монголын бүх ард түмэн манай оронд болсон энэ түүхт явдлыг асар их баяр баясгалантайгаар тэмдэглэн өнгөрүүлэв.

Зөвлөлт Холбоот Улсын зүйл бүрийн дэмжлэгийн ачаар одоо цагийн янз бүрийн харилцаа холбоо манайд бас амжилттай хөгжиж байна.

(Төгсөөдүй)

### С л о в а

**шийдвэртэй** решительный  
**ялсан** победивший; победоносный  
**тунхаглах** провозгласить; обнародовать  
**алгасах** миновать  
**байгуулал** строй  
**амьд чадал** жизнелюбие  
**өсөх** расти  
**мэдэл** ведение; владение  
**гар** рука  
**эмч** собственность  
**эм** лекарство  
**урьдаас сэргийлэх** предупредить; предупредительный  
**тарилга(н)** прививка  
**халдварт** заразный  
**өвч(ин)** болезнь  
**бөөн** масса; куча  
**үхэх** гибнуть; умереть  
**гэжээх** кормить  
**хадах** зд. косить; жать  
**бордоо(н)** зд. корм, фураж  
**жижиг бутархай** мелкий, раздробленный  
**тариалан(г)** земледелие  
**цөөхөн** мало, малочисленный  
**хангагдах** обеспечиваться  
**ардын нэгдлүүд** аратские объединения

**хорогдол** потеря; сокращение  
**бууруулах** уменьшить, снизить  
**хөдлөшгүй** неизменный; недвижимый  
**хөдөлгөөн** движение  
**уул** гора  
**үнэт** ценный, драгоценный  
**ховор** редкий  
**малтмал** ископаемое  
**өргөжих** расширяться  
**орон сууц** жилище, жилье  
**өргөн хэрэгцээний багаа(н)** товары широкого потребления  
**үйлдвэрлэх** производить, выпускать  
**гар урчууд** кустари, ремесленники  
**бүдэг балархай зам** зд. тропинка  
**харгуй** дорога, тропинка  
**ердийн хөсөг** гужевой транспорт  
**тэмээн тээвэр** зд. вьючный транспорт;  
**верблюжий транспорт**  
**чин үнэнч** бескорыстный  
**гол мөрний тээвэр** речное судоходство  
**үүсгэлийг тавих** положить начало  
**ачааны** грузовой  
**холбох** соединить  
**түүхт явдал** историческое событие  
**харилцаа холбоо(н)** связь  
**амжилттай** успешно; успешный

## МОНГОЛЫН АРД ТҮМЭН СОЦИАЛИЗМЫН ЗАМД

*(Өмнөхийн үргэлжлэл)*

Хувьсгалын өмнө Монголын бүх хүн ам нь бичиг мэдэхгүй байсны дээр ноёдын хүүхэд суралцдаг зөвхөн гагцхан сургуультай байлаа.

Одоо Бүгд Найрамдах Монгол Ард Улсын дотор ерөнхий эрдмийн сургууль 412, техникум 14, багш нарын оройн дээд сургууль, нам ба улсын шинэ хүчний дээд сургууль байгаагийн дээр хүн, малын эмч, зоотехникч, эдийн засгийн мэрэгжилтэн, тоо физик, түүх, утга зохиолын багш нарын зэрэг мэрэгжилтэй боловсон хүчнийг бэлтгэдэг улсын их сургууль байна. Сургуулийн бүх сурагчдын тоо нь 25 жилийн дотор 127 дахин өсчээ. Манай орны арван хүн тутмын нэг нь бага, дунд, дээд сургуулиудад сурч байна. Ард түмнийг бичиг үсэгт сургах талаар үлэмжхэн ажлыг хийв. Олон зуун жилийн турш өөрчлөгдөөгүй байсан бөгөөд дээрээсээ доош бичдэг хуучин монгол үсэг, ард түмний одоогийн амьдралаас хэдийнээ хоцорчээ. Энэ учраас тус улсад, орос үсгийн үндсэн дээр шинэ үсгийг авч хэрэглэсэн явдал маш их давшилтат ач холбогдолтой бөгөөд манай ард түмнээс Зөвлөлтийн ард түмний социалист тэргүүний соёлыг түргэн эзэмшихэд ихээхэн тус дөхөм болж байна. Одоо манай орны хүн амын 55,4 хувь нь шинэ бичиг мэддэг боллоо. Тус улсын бүх хүн амыг ойрын жилүүдэд шинэ бичигт сургаж дуусах зорилгыг тавьж байна.

Монголын соёл ухралтгүй хөгжиж байгааг үзүүлэх зүйлийн нэг нь хэвлэл өсч байгаа явдал мөн. Одоо үед манай оронд төвийн сонин 8, орон нутгийн сонин 19, бас сэтгүүл 14-ийг хэвлэн гаргаж байна. Марксизм-ленинизмийн классик зохиол, дэлхий дахины уран зохиолын бүтээл, давшилтат эрдэмтний гарамгай сайн зохиолууд нь монгол хэл дээр орчуулагдаж гарсаар ирсэн бөгөөд орчуулагдсаар байна.

Монгол улсын Шинжлэх Ухааны Хүрээлэн, Монголын залуу эрдэмтэн нарыг нэгтгэн, СССР-ийн Шинжлэх Ухааны Академийн тусламжтайгаар улс ардын аж ахуйд зориулан, эрдэм шинжилгээний ажлыг явуулж байна. Мөн «Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх»-ийг эрт цагаас одоо үеийг хүртэл хамарч бичих ажлыг Зөвлөлтийн эрдэмтэн нарын тусламжаар хийж байна.

Ардын эрүүлийг хамгаалах ажлыг хөгжүүлэх талаар энэ завсар бас эрс өөрчлөлт гарлаа. Зөвлөлт Холбоот Их Улсын тусламжаар манай оронд больниц, амбулатори, эмчлэн сувилах газар, эмгэ-тэйчүүдийн ба хүүхдийн консультацийн зэрэг газрууд байгуулагд-

саны дээр үндсэний их эмч, дунд мэрэгжилтэн нарыг бэлтгэж ирсэн ба бэлтгэсээр байна.

Монгол Ардын Хувьсгалт Нам ба ардын засаг нь өөрийн орны соёл шинжлэх ухаан, урлагийг хөгжүүлэхийн тул анхаарлаа ихээр тавьж байгаа юм. Манай улсын төсвийн нийгэм-соёлын арга хэмжээний зардал нь зөвхөн сүүлийн 10 жилийн дотор 4 дахин өсчээ.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын бүх хөгжлийн хамгийн гайхамшигтай зүйл бол улс ардын аж ахуй, соёлын салаа бүхэнд үндсэний боловсон хүчин өсч хөгжиж байгаа явдал мөн юм. Хэрэв хувьсгалын өмнө, хөдөлмөрчин монгол хүн, ноёдын малыг хариулан хатуу ширүүнээр дарлагдан мөлжигдөж өлсгөлөн зовлонг эдэлж, тэд нарын ашгийн төлөөнөө амь сүйдэж байсан бол одоо тэр бүх зүйл арилж, түүх, туужийн хэрэг болсон бөгөөд Монгол ард улсын хөдөлмөрчин бүхний өмнө тус орны улс төр, аж ахуй, соёлын салаа бүхэнд оролцох өргөн уудам сайхан зам нээгджээ.

1949 оны 2 дугаар сард улсын их хурлаас, сонгуулийн системийг цаашид улам ардчилах талаар Бүгд Найрамдах Монгол Ард Улсын үндсэн хуульд шинэ өөрчлөлт, нэмэлтийг оруулсан юм. Энэ шийдвэрийн ёсоор тус улсын дотор нийт, шууд, тэгш сонгуулийг бий болгож, нууцаар санал хурааж явуулах болсон билээ.

Монголын ард түмний бүх ялалтыг зохион байгуулагч бөгөөд зоригжуулагч нь Ленин-Сталины хамгийг ялагч сургаалаар удирдлага болгосон ардын хувьсгалт яруу алдарт нам мөн юм.

Монголын ард түмэн, тусгаар тогтнолоо бэхжүүлэн, эдийн засаг, соёлоо хөгжүүлж эрх чөлөөт энх жаргалант амьдралаа байгуулах талаар олсон бүх амжилт ба Монгол ард улсын тусгаар тогтнон хөгжиж байгаа явдал бол манай чин үнэнч их түшиг Зөвлөлтийн ард түмэн, их Сталины эцэг ёсны хайр анхаарлын ач үр мөн юм.

Монголын ард түмэн, Октябрийн их хувьсгалын ач, хөдөлмөрчдийн их жолоодогч Ленин-Сталин нарын анхаарал ба хайр халамжийн үрээр эрх чөлөөгөө олж, ардын засаг төрөө тогтоох бололцоотой болсон юм.

Гагцхүү Оросын их ард түмэн, Зөвлөлтийн арми, тэдгээрийн шууд тусламж нь, гадаадын түрэмгийлэн эзлэгчдийг Монголын нутгаас хөөн зайлуулж, тус оронд ардын засгийг тогтоох явдлыг хангасан юм.

Зөвлөлт Холбоот Улс, Бүгд Найрамдах Монгол Ард Улсыг хамгийн тэргүүнээ зөвшөөрөн хүлээжээ.

Монголын хувьсгалын жолоодогч чин зоригт Сүхбаатар, хувьсгалын эхэн үед их Ленин, Сталин нартай уулзаад, Зөвлөлт оросын ард түмэнтэй нягт нөхөрлөх нь Монголын ард түмний хөгжлийн гагцхан зөв зам мөн гэсэн тэдний суут сургаалыг хамгийн ариун дархан зүйл гэж үзэж хүндэтгэн хүлээн авчээ.

(Төгсөөдүй)

бичиг мэдэхгүй неграмотный  
ноён князь  
зөвхөн всего-навсего, только  
ерөнхий эрдмийн общеобразователь-  
ный  
малын эмч ветеринарный врач  
хүний эмч медик  
эдийн засгийн мэрэгжилтэн эконо-  
мист  
бичиг үсэгт сургах обучить грамоте  
дээрээс доош сверху вниз, верти-  
кально  
хэдийнээ давно  
хоцрох отстать  
тус дөхөм болох способствовать  
ухралтгүй неуклонно  
хэвлэл печатъ  
уран зохиол художественная лите-  
ратура  
бүтээл эд. произведение  
гарамгай сайн выдающийся  
хүрээлэн(г) комитет  
шинжилгээний ажил исследователь-  
ская работа  
эрт цаг эд. древнее время  
хамрах эд. охватывать  
эрүүлийг хамгаалах ажил работа по  
здоровоохранению  
эмчлэн сувилах газар диспансер  
эмэгтэйчүүд женщины  
их эмч врач

төсөв бюджет, наметка  
нийгэм-соёлын социально-культурный  
зардал расходы  
сүүлийн последний  
малыг хариулах пасти скот  
хатуу ширүүнээр жестоко  
мөлжигдөх эксплуатироваться  
өлсгөлөн зовлон(г) мұка, голод  
амь сүйдэх умирать  
арилах уходить, отходить; пройти  
түүх тууж предание, история  
оролцох участвовать  
уудам зам простор, широкий путь  
сонгуулийн систем избирательная  
система  
ардчилал провести демократизацию  
өөрчлөлт изменение, реорганизация  
нэмэлт дополнение  
оруулах внести  
тэгш равный  
сонгууль выборы  
нууцаар санал хураах проводить  
тайное голосование  
зоригжуулагч вдохновитель  
зохион байгуулагч организатор  
хамгийг ялагч всепобеждающий  
энх жаргалант счастливый  
түшиг опора, оплот  
түрэмгийлэн эзлэгчид захватчики  
хөөн зайлуулах изгнать  
ариун дархан зүйл святыня; священ-  
ное дело

## 61 ЖАРАН НЭГДҮГЭЭР ХИЧЭЭЛ

### МОНГОЛЫН АРД ТҮМЭН СОЦИАЛИЗМЫН ЗАМД

(Төгсгөл)

Дотоод дахь хувьсгалын эсэргүүчүүд ба гадаадын дайсан им-  
периалист шунахайчуудаас Монголын ард түмний эрх чөлөө,  
тусгаар тогтнолд удаа дараа халдаж, манай ард түмний өөрийнх  
нь сонгон авсан Ленин-Сталины зөв замаас түүнийг салгахыг удаа  
дараа оролдож байлаа. Гэвч Монголын ард түмнийг энэ гагцхан  
зөв замаас нь ямар ч хүч салгаж чадаагүй бөгөөд чадах ч үгүй  
юм. Бидэнд аюул тулгарсан цаг тухай бүрд, манай хувираггүй  
түшиг Зөвлөлтийн ард түмэн, манай их багш бөгөөд хань нөхөр  
Сталин ямагт тусалж, манай эрх чөлөөг тулгарсан аюулаас нь  
аварч ирсэн юм.

Манай хоёр ард түмний нөхөрлөлийн түшиг суурь болж байсан  
ба болж байгаа зүйл нь 1936 онд Бүгд Найрамдах Монгол Ард

Улсын ба СССР-ийн засгийн газруудын хооронд байгуулсан харилцан туслалцах тухай протокол ба мөн түүнийг хувирган 1946 оны 2 дугаар сарын 27-нд байгуулсан бөгөөд Бүгд Найрамдах Монгол Ард Улсын цаашдын бэхжилтийн найдвартай баталгаа болсон нөхөрлөл ба харилцан туслалцах тухай гэрээ мөн юм.

Дэлхийн хоёрдугаар дайнд Зөвлөлтийн ард түмэн ялсан, дэлхий дахины түүхт ялалт, дэлхий дээр ардчиллын хүч өрнөж байгаа явдал, мөн Монголын ард түмнээс Зөвлөлтийн ард түмэнтэй мөр зэрэгцэн явж хувиа оролцуулж, японы империализмийг бут ниргэсэн явдал нь империализмийн суурийг улам ганхуулж, колонийн орнуудад үндсэний эрх чөлөөний хөдөлгөөнийг хүчтэй болгоод, Хятадын их ард түмний түүхт ялалтын их урьдчилал нөхцөл нь болсон юм.

Хятадын ард түмний түүхт их ялалт бол манай Монгол ард улсын ард түмэнд онц дотно зүйл мөн бөгөөд учир нь сүүлийн үе хүртэл гоминданы бүлэг этгээдийн дарлалын дор байсан ах дүү бусад монгол овогтнуудад эрх чөлөөт, энх жаргалант сайхан амьдралын зам нь энэ ялалтаар нээгдлээ.

Дэлхийн хоёрдугаар дайны дүнд ба Хятадын ардчилал ялахын хамт Зөвлөлт Холбоот Их Улсын тусламжийн ачаар Бүгд Найрамдах Монгол Ард Улсын гадаадын байдал хэзээ хэзээнээс их бэхжижээ. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын гадаад харилцаа өрөгжсөөр байна. Манай улс нь СССР, Ардын Бүгд Найрамдах Албани Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Ардын Ардчилсан Бүгд Найрамдах Солонгос Улстай тус тус дипломат харилцаатай байна. Дэлхийг ноёрхох гэсэн Америкийн империалистүүд ба түүний хоолны шавхрууг горьдогч нар нь Бүгд Найрамдах Монгол Ард Улсыг Нэгдсэн үндэстний байгууллагад оруулах явдыг болон бусад орнууд ба улс түмэнтэй харилцах явдлыг элдвээр саатуулахыг оролдож байгаа боловч ардчилсан хүчнүүдийн тусламжтайгаар гадаад харилцаагаа хөгжүүлэх талаар Монголын Ард түмэн, цаашид улам ихээхэн амжилт олох нь эргэлзээгүй хэрэг юм.

Зөвлөлтийн их ард түмний өдөр тутмын ах дүүгийн тусламжийн ачаар эрх чөлөөтэй, энх жаргалантай хөгжиж байгаа Монголын ард түмэн, манай хоёр Улсын ард түмний гайхамшигт их нөхөрлөл хийгээд их, бага үндэстний тэгш эрхийг зөвшөөрөн, дарлагдсан бага буурай улс түмний амьдралын эрх ашгийг хамгаалж байдаг Зөвлөлт Холбоот Улсын энх тайвныг эрхэмлэдэг тууштай шударга бодлогын их гайхамшигт ямагт шүтэн бахадсаар байна.

Монголын ард түмэн, ардчилал, социализмын лагерьт гуйвалтгүй зогсож Зөвлөлт Холбоот Улсын энх тайвныг эрхэмлэсэн бодлогыг хувиралтгүй дэмжиж байгаа бөгөөд дэмжих ч болно. Манай ард түмэн өнгөрсөн замаа баяр баясгалантай харж байна. Түүний хараа сайхан Москва, дэлхийн хөдөлмөрчдийн жолоодогч их Сталины зүг талархан ширтэж байна.

Х. Чойбалсан.

«Үнэн», № 278, 1. XII, 1949.

хувьсгалын эсэргүүчүүд контрреволюционерууд  
 шунахайчууд хищники  
 удаа дараа(н) не раз  
 халдах покушаться  
 сонгон авсан избранный, выбранный  
 салгах эд. столкнуть, сбить, свернуть  
 чадаагүй не смог  
 чадах ч үгүй и не сможет  
 аюул тулгарсан цаг в грозный час  
 хувиршгүй неизменный  
 ямагт всегда  
 хооронд между  
 харилцан туслалцах взаимопомощь  
 хувиргах превратить  
 баталгаа гарантия  
 гэрээ договор  
 мөр зэрэгцэн плечом к плечу  
 хувиа оролцуулах вносить свою лепту  
 империализмийн суурь устон империализма  
 улам ганхуулах еще глубже расширять  
 үндсэний эрх чөлөөний национально-освободительный

урьдчилал нөхцөл предпосылка  
 бүлэг этгээд клика  
 овогтнууд племена  
 хэзээ хэзээнээс как никогда  
 Ардын ардчилсан Бүгд Найрамдах Солонгос Улс Корейская Народно-Демократическая республика  
 дипломат харилцаа дипломатические отношения  
 дэлхийг ноёрхох мировое господство  
 хоолны шавхрууг горьдогч нар прихлебатели  
 Нэгдсэн үндэстний байгууллага Организация Объединенных Наций  
 элдвээр эд. всячески  
 саатуулах мешать, не допустить  
 эргэлзээгүй нет сомнения  
 бага буурай малый  
 эрх ашиг интересы  
 энх тайвныг эрхэмлэх быть миролюбивым  
 тууштай последовательный  
 шүтэх уповать; верить  
 гуйвалтгүй непоколебимо  
 хувиралтгүй неизменно

## 62 ЖАРАН ХОЁРДУГААР ХИЧЭЭЛ

### ОНЦ СУРЛАГЫН ТӨЛӨӨ

Төв аймгийн төвийн бүрэн дунд сургууль, 1951—52 оны хичээлийн жилийн тэргүүн хагасын шалгалтад сурлагын өндөр амжилт үзүүлэхийн төлөө эртээс шуурхай бэлтгэсэн юм. Энд, багш, сурагчдын ба дэргэдэх нам, эвлэлийн байгууллагын хурал, зөвлөлгөөн болж шалгалтад бэлтгэх тухай хэлэлцээд, тодорхой тогтоол, төлөвлөгөө гаргаж ажилласан билээ. Тэгээд сурагчдын давтлагыг багш нар тодорхой хуваартайгаар удирдан хийлгэж, ялангуяа хичээлд хоцорч яваа сурагчдад чухам ямар хичээлийн ямар сэдвүүдийг мэдэхгүй байна тэр сэдвийг давтаж, зөвлөлгөө өгч, сурагчдын дунд, сурлагын уралдаан, нээлттэй хичээл явуулах, лекц унших зэрэг ажлыг зохиосны үрээр энэ шалгалтаар сурлагын нилээд амжилт үзүүлээ.

Өнгөрөгч 1950—51 оны хичээлийн жилийн тэргүүн хагаст сургуулийн хэмжээгээр онц сайн сурлагатан 13%, сайн сурлагатан 43% байсан бол энэ 1951—52 оны хичээлийн жилийн тэргүүн хагасын шалгалтаар онц ба сайн сурлагатан 70% болжээ.

Тус сургуулийн сурагчид, зарим нөхдийнхөө хичээлд туслалцах, ном зохиолоос уншиж өх, биений тампын тэмцээнүүдийг зохион явуулах зэрэг хүмүүжил олон нийтийн ажилд чадамгай оролцдог юм.

Энэ сургуулийн онцчууд, ном зохиолыг унших туйлын дуртай, ялангуяа төрөл бүрийн хичээлд холбогдолтой номыг тусгай цаг гарган ашиглаж, заалгасан зүйлээ баяжуулан ойлгодог нь тэдний заншил болжээ. Үүний хамт тэд, бусад нөхдийгөө онц сайн сурлагатны зэрэгт хүргэх талаар байнга санаа тавьж тусалдаг.

Энэ тэргүүний сурагчдын бас нэг онцлог чанар нь хөдөлмөрт дуртай явдал мөн.

Тус сургуулийн энэ амжилтын зэрэгцээгээр сурагчдын дотор сул сурлагатан ба ялангуяа дунд сурлагатан байгааг онцлон анхаарч, дараагийн улиралд сурагчдын сурлагын чанарыг өндөржүүлэхийн төлөө багш нэг бүр их хүч гарган ажиллах, тэрчлэн сурагч бүр хичээлийг гүнзгий баттай эзэмших нь маш чухал байна.

Сурагч Дорж хэлэхдээ: тус сургуульд орж эрдэм ухааныг сурч байгаа явдал надад хэлж баршгүй сайхан тохиолдол юм. Би хичээлд бүх анхаарлаа чиглүүлж, заагдсан зүйлийг тэмдэглэж аваад, холбогдох ном, эх зохиолуудыг судалдаг. Ер манай сурч судлахын чухал арга бол биеэ дааж ажиллах ажиллагаа байдаг. Орос хэл бичгийг сайн сурах нь их тустай. Орос хэл сурахад дүрмийг сайн мэдэхийн хамт, орос ном зохиолыг их уншиж, мэдсэнээ бусдад ярьж өх нь тэдэнд тус болохоос гадна миний ойлгох, тогтооход их тус хүргэдэг. Иймэрхүү ажиллагааны үрээр Си энэ завсар онц сайн сурч байна. Би, 1951—52 оны хичээлийн жилийн тэргүүн хагасын ба жилийн эцсийн шалгалтуудад цөмд нь онц сайн дүн үзүүлнэ. Сургуулиа онц сайн сурлагатай төгсгөх эрхэм хүндэт зорилгыг нэр төртэй биелүүлэх зориг хүсэлтэй байна.

\* \* \*

Энэ сургуулийн хэл бичгийн багш Дамдин, багш нарыг бэлтгэх дээд сургуулийг төгсгөөд тав дахь жилдээ багшилж, энэ завсар туршлагажжээ. Энэ багш сурагчдыг учраа мэдсэн сахилга баттай, ариун цэвэрч, боловсон хүмүүжилтэй, эх орондоо хязгааргүй үнэнч, хөдөлмөрт дуртай болгон хүмүүжүүлэхийн төлөө чармайн ажилладаг. Ангидаа Зөвлөлт улсын хөгжилт, коммунизмын их барилгуудын тухай 7 хоног бүр ярьж өгдөг ба амралтын өдрүүдэд үдэшлэг, олон нийтийн ажлыг зохион байгуулалттай явуулдаг байна.

Багш Дамдин хичээлийг заахдаа шинжлэх ухааны шинэ нээлт, баялаг туршлагын ундсэн дээр сурагчдын орчин ахуй, өөрийн орны ба олон улсын байдал зэрэгтэй холбож заадаг учраас сурагчдын ойлгоц нь сайн байдаг байна. Багш Дамдин, сурагчдыг сурах бичигтэй ажиллан сургаж, сурлагаар хоцрогдож байгаа сурагч чухам ямар зүйлийг ойлгож мэдэхгүй байгааг судлаад, зохих

сэдвээр нь зөвлөлгөө өгдөг юм. Мөн гэрийн даалгаврыг өхдөө сурагч бүрийн онцгой байдалд тохируулан өгдөг учраас сурагчид даалгаврыг амжилттай биелүүлдэг.

### Слова

<b>бүрэн дунд сургууль</b> полная средняя школа	<b>эрхэм хүндэт</b> почетный
<b>тэргүүн</b> первый	<b>зориг хүсэл</b> чаяние, стремление
<b>эртээс</b> заранее	<b>багш нарыг бэлтгэх дээд сургууль</b> педагогический институт
<b>хуваар</b> зд. расписание	<b>туршлагажих</b> получить навыки, стан опытным
<b>тэмцээн</b> состязание, соревнование	<b>учраа мэдсэн</b> зд. сознательный
<b>холбогдолтой</b> связанный	<b>ариун цэвэрч</b> поддерживающий санитарное состояние; чистоплотный
<b>санаа тавих</b> уделять внимание	<b>коммунизмын их барилгууд</b> великие стройки коммунизма
<b>сул сурлагатан</b> отстающие по успеваемости, слабые (ученики)	<b>зохион байгуулалттай</b> организованно
<b>хэлж баршгүй</b> невозможно передать словами	<b>орчин ахуй</b> окружающий
<b>тохиолдол</b> зд. счастье, удача	<b>ойлгоц</b> усвояемость
<b>чиглүүлэх</b> направить	<b>онцгой байдал</b> специфическое положение; особенность
<b>тэмдэглэж авах</b> записать	
<b>эх зохиол</b> первоисточник, оригинал	
<b>хэл бичиг</b> язык; филология	

## 63 ЖАРАН ГУРАВДУГААР ХИЧЭЭЛ

### МОНГОЛ — ЗӨВЛӨЛТИЙН МӨНХИЙН ИХ НАЙРАМДАЛ

Монголын ард түмэн бол хүчирхэг Зөвлөлт Холбоот Улс, Зөвлөлтийн ард түмнийг өөрийн хамгийн шилдэг чин сэтгэлийн үнэнч хань гэж ямагт үздэг юм. Бүх хөдөлмөрчдийн их жолоодогч Ленин—Сталин, манай ард түмний гарамгай жолоодогч Сүхбаатар—Чойбалсан нарын үндэслэн байгуулсан Зөвлөлт ба Монголын ард түмний их найрамдал манай эрх чөлөө, тусгаар тогтнолын хүчирхэг тулгуур, манай эх орны хөгжил, цэцэглэлтийн гайхамшигт сайхан бүх амжилтын уг сурвалж, социализмын замаар манай урагшаа улам амжилттай давшихын баталгаа мөн гэдгийг манай бүх ард түмэн сайн мэддэг юм. Монголын ард түмний эрх чөлөө, энх жаргал, түүний хөгжил, цэцэглэлтийн төлөө эцэг ёсны анхаарал, санаачлага тавьж чин сэтгэлийн их тусламж үзүүлсээр байдаг Зөвлөлтийн их ард түмэн, их Сталинд манай эх орны хөдөлмөрчин бүхэн чин сэтгэлээсээ халуун хайр талархалтай байдаг.

Монголын ард түмэн өөрийн цогт жолоодогчид Сүхбаатар—Чойбалсангийн жолоодлого, М. А. Х. Намын удирдлагаар 1921 онд эрх чөлөөний тэмцэлд бослоо. Манай орны ард түмнийг харийн

түрэмгийлэгчдийн дарлалаас ангижрахад нь Зөвлөлт улс туслав. Ленин — Сталины даалгавар, Зөвлөлт засгийн тушаалаар түүний залуу Улаан Армийн ангиуд, манай ардын партизан цэрэгт тусалж, харийн түрэмгийлэгчдийг хөөн зайлуулж, цагаантны үлдэгдлийг бут ниргэхэд туслав. Тэр цагт Монгол Зөвлөлтийн ард түмэн жинхэнэ амьдрал дээр харилцан итгэлцэж, 2 улсын хооронд эвдэршгүй мөнх найрамдлыг тогтоож эхэллээ.

Манай орны эрх чөлөө, хөгжил цэцэглэлийн зам нь их Лениний сургалаар гэрэлтэн гийгүүлэгдсэн юм. Ленин, манай ард түмний жолоодогч Сүхбаатарт хэлэхдээ, танай орны хамгийн үнэн зөв зам бол СССР-ийн ажилчин, тариачинтай хэлхээ холбоо байгуулж, улс төр, аж ахуйн талаар тусгаар тогтнохын төлөө тэмцэх явдал мөн гэж сургажээ.

1921 оны ардын хувьсгалын ялалтын дараа, мөн оны 11 дүгээр сард, РСФСР ба Монгол Улсын хооронд найрамдлын харилцааг тогтоосон хэлэлцээрт үсэг зуржээ. Түүнээс хойш Монголын ард түмэнд, Зөвлөлт Холбоот Улс зүйл бүрээр тусалсаар ирэв.

СССР, Б. Н. М. Ард Улсын хооронд харилцах үндсэн зарчмуудын тухай хэлэлцээрийг 1929 онд Улаанбаатар хотонд байгуулсан билээ. Манай орны үйлдвэрлэх хүчнүүдийг дээд хэмжээгээр хөгжүүлэн ард олны аж амьдрал, соёл боловсролын хэмжээг өрнүүлэхэд чиглэсэн энэ хэлэлцээр бол гайхамшигт үр дүн өгч, манай хоёр улсын найрамдлыг цааш хөгжүүлэхийн үндэс болжээ. Дэлхий дахины байдал хурцдаж, манай орныг империалист япон заналхийлж байв. Энэ заналхийллаас манай орныг Зөвлөлт Холбоот Улс авран хамгаалж, үүрд ангижруулсныг монголын ард түмэн хэзээ ч мартаггүй.

Энэ үед «Хэрэв японоос Бүгд Найрамдах Монгол Ард Улсын тусгаар тогтносон байдалд халдан довтлохоор шийдвэрлэвэл бид, Бүгд Найрамдах Монгол Ард Улсад туслах болно... Бид, Бүгд Найрамдах Монгол Ард Улсад 1921 онд тусалсантай адилаар тусална» гэсэн Сталины халамжит үг дэлхий дахинаа цууриатав. Империалист японы зүгээс халдан довтлох аюул манай оронд тохиолдоод байсан энэ түгшүүрт өдрүүдэд, манай нам, засаг, өөрийн хувиршгүй нөхөр СССР-тэй монголын ард түмний найрамдлыг улам бэхжүүлэв. 1936 оны 3 дугаар сард, Зөвлөлт Холбоот Улс ба Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хооронд харилцан туслалцах протокол гэрээ байгуулагдав. Японы түрэмгийчүүд, 1939 онд, Халх голын чиглэлээр манай оронд халдан довтлож, Зөвлөлтийн Улаан арми ба манай Ардын хувьсгалт армийн ангиудад бут ниргэгджээ.

Харилцан туслалцах протоколыг байгуулснаас хойшхи жилүүдэд манай орон, Зөвлөлт Холбоот Улсын ах дүүгийн тусламжтайгаар их зүйлийг бүтээж, капиталист бус хөгжлийн зам дээр баттай зогсов.

Манай гайхамшигт амжилтнууд нь манай их хань Зөвлөлт Холбоот Улсын үргэлжийн халамжит тусламжийн ач билээ.

Монгол Зөвлөлтийн найрамдал, дэлхийн хоёрдугаар дайны үед улам нягтрав. Манай ард түмэн, фашистын германыг бут цохиход нь Улаан армид хир чадлаараа тусалжээ.

(Төгсөөдүй)

### С л о в а

**мөнхийн** вечный  
**гарамгай** выдающийся  
**цэцэглэлт** расцвет  
**уг сурвалж** источник  
**санаачлага** эд. работа  
**хайр талархал** благодарность  
**тушаал** приказ  
**хөөн зайлуулах** изгнать  
**үлдэгдэл** остаток  
**харилцан итгэлцэх** доверять друг  
другу  
**хэлхээ холбоо(н)** связь, союз  
**хээлцээр** соглашение  
**хооронд** между  
**үйлдвэрлэх хүчнүүд** производитель-  
ные силы

**чиглэсэн** направленный  
**заналхийлал** угроза  
**заналхийлах** угрожать  
**хэзээ ч мартахгүй** никогда не забу-  
дет  
**халдан довтлох** нападать; поку-  
шаться  
**түгшүүрт** тревожный  
**харилцан туслалцах** взаимно помо-  
гать  
**хойшхи** последующий  
**капиталист бус** некапиталистический  
**баттай** твердый, прочный  
**халамжит** эд. щедрый, бескорыстный  
**хир чадлаараа** по мере возможности

## 64 ЖАРАН ДӨРӨВДҮГЭЭР ХИЧЭЭЛ

### МОНГОЛ—ЗӨВЛӨЛТИЙН МӨНХИЙН ИХ НАЙРАМДАЛ

(Төгсгөл)

СССР дайны ширүүн бэрх үед ч манай улсад байнгын тусламжаа үзүүлж, сүүлчийн техникээр тоногдсон боловсон махкомбинатыг Улаанбаатарт байгуулж өгөв. Дайны үед улсын их сургуулийг байгуулахад Зөвлөлт Улс бүх талаар туслаж, бас манай соёл, урлагийн хөгжилтөд маш их тусламжийг үзүүлсэн юм.

Манай хоёр улсын ард түмэнд аюулыг учруулж байсан японы империалистүүдийг дэлхийн хоёрдугаар дайны шувтарганд бут цохих нийтийн хэрэгт Зөвлөлтийн Улаан армийн ангиудын хамт манай хувьсгалт цэрэг байлдан явжээ.

Дайны дараа Зөвлөлт-Монголын ард түмэн энх цагийн бүтээн босгох хөдөлмөрт шийдвэртэй шилжив. Энэ үе—1946 оны 2 дугаар сард СССР ба Б. Н. М. А. Улсын хооронд найрамдал ба харилцан туслалцах тухай гэрээ, эдийн засаг, соёлын талаар хамтран ажиллах тухай хэлэлцээр байгуулагдсан билээ. Үүний үр дүнд манай улсын улс төр, эдийн засаг, соёлын хөгжилд маш их өөрчлөлтүүд гарлаа. Манай улс, аж ахуй соёлоо 5 жилийн төлө-

влөгөөтэйгөөр хөгжүүлж байна. Нийтийн тэгш, шууд, нууц сонгууль явуулж, ард түмний сэтгэл зоригийг оргилуулсан ардчилсан шинэ зарчмыг тогтоов.

Монгол улс, Зөвлөлт Улстай найрамдаж ирсэн 30 жил илүү хугацаа бол, манай орныг капиталист хөгжлийг алгасаж, социалист хөгжлийн зам дээр гаргажээ. Энэ жилүүдэд, манай орны малын тоо 2 дахинаас илүү өсчээ. Мал аж ахуйд хөдөө аж ахуйн шинжлэх ухаан, техник нэвтрэв. Урьд нэг ч үйлдвэр байсангүй бол одоо үндэсний аж үйлдвэр, хүнс ба гар үйлдвэрийн өдий төдий байгууллага бий болж, ард түмний хэрэгцээт зүйлийг үлэмж хэмжээгээр гаргаж байна.

Урьд нэг ч сургууль байсангүй бол одоо олон зуун бага, дунд ба тусгай мэрэгжлийн сургуультай, улсын их сургууль, хэд хэдэн дээд сургуультай болж үндэсний мэрэгжилтэн, хувьсгалч боловсон хүчин бий болов. Манай оронд төмөр зам, засмал зам, байгуулагдаж тээвэр, харилцаа холбоо өргөжин хөгжөөд, улс, ардын хэрэгцээ, шаардлагыг хангаж байна.

Гагцхүү Ленин — Сталины сургаалаар явж, Зөвлөлт Холбоот Их Улсыг түшиглэн, түүний зүйл бүрийн тусламжийг хүлээж, өөрийн алдарт намын удирдлага, нөхөр Чойбалсангийн жолоодлогоор ухралтгүй тэмцэсний үр дүнд энэ их амжилтад хүрсэн билээ.

Зөвлөлт улсын аврага тусламжийн ач, манай хоёр улсын ах дүүгийн найрамдлын гайхамшигт ялалтыг дүгнэж маршал Чойбалсан, М. А. Х. Намын 11 дүгээр их хурал дээр хэлэхдээ, «хэрэв бид хувь заяагаа Зөвлөлтийн ард түмэнтэй холбоогүй бол дэлхий дахины 2 дугаар дайны үеэр буюу түүнээс урьд ямар нэг түрэмгийлэгч улсын олз болж мэдэх байсан юм гэдгийг манай ард түмэн сайн мэдэж байна. Бид үүнийг ойлгоод, фашизмын эсрэг тэмцэлд Зөвлөлт Улстай хамт гуйвалтгүйгээр орсон юм. Энэ бол Зөвлөлт ба Монголын ард түмний найрамдлын хүчийг үзүүлж байгаа бөгөөд манай агуу их зэргэлдээ улстайгаа нөхөрлөсөндөө бид чин үнэнээр бахархаж байна» гэжээ.

Манай орны тусгаар тогтнол, түүний эдийн засаг, соёлын ухралтгүй хөгжил нь, их Ленин — Сталины үндэсний бодлогын зөв бөгөөд гайхамшигт биелэлийн нэг баталгаа юм. Монголын ард түмэн, өөрийн намын удирдлага, хайрт Чойбалсангийн жолоодлогоор, Зөвлөлт Улстай тогтоосон мөнх найрамдлаа улам бэхжүүлэн Зөвлөлтийн ард түмний аврага тусламжийг цаашид хүртэж, социализм өөд амжилттай давших зориг хүсэл төгөлдөр байна.

Монгол — Зөвлөлтийн ард түмний эдвэршгүй мөнх найрамдал мандтугай!

Манай шилдэг хань бөгөөд дэлхий дахины улс түмний найрамдал, энх тайвны түшиг хүчирхэг Зөвлөлт Холбоот Улс мандтугай!

Бүх хөдөлмөрчдийн суут жолоодогч, багш, дэлхий дахины энх тайвны тугч, манай энхрий хайрт нөхөр Сталин мандтугай!

По материалам «Үнэн», 1951.

сүүлчийн последний; новейший  
 шувтарган завершение  
 энх цаг мирное время  
 шийдвэртэй решительно; решитель-  
 ный  
 шилжих переходить  
 хамтран ажиллах работать совмест-  
 но, сотрудничать  
 өөрчлөлт изменение  
 тэгш равный  
 сонгууль выборы  
 алгасах миновать  
 гар үйлдвэр кустарная промышлен-  
 ность  
 боловсон хүчин кадры  
 харилцаа холбоо(н) связь

тээвэр транспорт  
 тусгай мэрэгжлийн профессиональ-  
 но-технический  
 түшиглэх опираться  
 ухралтгүй неуклонно, неотступно  
 түрэмгийлэгч агрессивный, захвагши-  
 ческий  
 олз находка; добыча  
 болж мэдэх мог стать, может стать  
 гуйвалтгүй(гээр) непоколебимо  
 чин үнэнээр искренне, сердечно  
 баталгаа(н) залог, гарантия; подтвер-  
 ждение, доказательство  
 хүртэх отведасть; получить  
 амжилттай успешно

## 65 ЖАРАН ТАВДУГААР ХИЧЭЭЛ

### ХОЁУЛАА МИНИЙ ХҮҮ

Монголын өргөн талд шар өнгийн өвс халиуран хийснэ. Цас нилээд орсон боловч салхинд хийссээр өвс далдлах цас үл үлдэнэ. Шар талын дунд хэдэн цагаан гэр, дээл дээр хадсан тана эрдэнийн товч мэт гялалзан харагдана. Талд олон хонь, адуу, үхэр мал билчжээ. Алсад харагдах арваад тэмээн хөсөг зэргэлгээтэн сүндэрлэж газар тэнгэрийг холбосон олон багана мэт үзэгдэнэ. Биднийг тэр айлын гадна хүрч очиход тэр арваад тэмээн ачаа бас айлын гадна хүрч ирэв.

Тэмээн ачааг хөтөлсөн цагаан нэхий дээлтэй залуу хар хүүтэй бид уулзаж мэндэлбэл тэр Ар булгаас гарав. Бэлгийн юм хүргэж явна гэв. Хоёр хар нохой хуцаж ирэхэд гэрээс настай авгай гарч нохойгоо хорьж биднийг гэрт оруулав.

Бид, тэр айлд ортол хотоос ирсэн хүнээс сонин юм сонсдог монголын ерийн заншлын ёсоор тэр айлуудын хүмүүс бидний буусан гэрт орж ирэв. Бид, тэдний онцлог сонирхож байгаа Зөвлөлтийн фронтын байдал ба Улаан Цэргийн ялалт хийгээд сүүлийн үед Улаан Цэргийн эзэлсэн хэдэн том хотыг дурдаж хэлсэнд:

— Хотын нэр, газрын зургийг мэдэхгүй тул хүний үгийг ойлоход хэцүү юм гэж гэргий Дулмаа санаа алдан хэлэв. Бидэнд үзүүлэн тайлбарлах газрын зураг байсангүй. Иймд хүү Цэрэн гүйж гараад бяцхан хэмжээний хуучирсан газрын зургийг олж

ирэв. Зураг дээр германы цэргийн гараас гаргасан нутаг ба хотыг харандаагаар тэмдэглэжээ.

Нутгийн ардууд цугларч энэ зургийг үздэг ба тайлбарлан хэлэлцдэг гэнэ. Энэ удаа мөн энэ зургийг зааж Улаан Цэргийн ялалтыг тайлбарлан таниулав. Үүний дараа Дулмаа, дэргэдээ суугаа арваад настай хүвүүн Цэрэнг бардмаар харж, энэ чөтгөрүүд тэр газар орныг сайн мэднэ дээ. Урьд гарсан чихнээс хойно гарсан эвэр урт болдог юм. Миний хүү 10 гаруй наслах зуур миний 40 хэдэн насандаа мэдээгүй юмыг мэдэж байна. Ямар ч бичгийг уншиж чадна. Саяхан цэрэгт байгаа хүвгүүнээс нэг захидал авсан. Тэр захидлын нэг үгийг манай өвгөн Дамба гаргаж бардаггүй. Гэтэл миний хүү Цэрэн үзээд гаргаж уншиж чадсан гээд үргэлжлэн ярих гэтэл гэрийн эзэн Дамба үгүүлрүүн:

— Ирсэн зочид хотын хүмүүсээс сонин юм сонсох нь чиний далан долоон үгнээс илүү чухал байна гэв. Үүнд бид, харилцан ярилцах нь чухал болохыг хэлээд тэдний хүссэн ёсоор хотын сонин ба ялангуяа Зөвлөлтийн Улаан Цэрэгт бэлгийн юмыг түргэвчлэн бэлтгэж байгаагийн тухай ярьж өгөв. Танай хүвгүүн хаа цэрэгт байна вэ? гэвэл Дамба үгүүллрүүн:

— Миний хүвгүүн Өлзий, Байшинтын цэрэгт даргаар байгаа юм. Та нар таних магадгүй гэж хайрцагаас зургийг гаргаж үзүүлэв. Үзвэл, орос монгол хоёр цэргийн зураг байна.

(Төгсөөдүй)

## С л о в а

<b>халиурах</b> переливаться	бурым н	<b>заншил</b> обычай, традиция; привычка
желтым оттенками		<b>онцлог</b> особый
<b>хийсэх</b> эд. колыхаться, волноваться		<b>сонирхох</b> интересоваться
<b>хийсэх</b> эд. выдуться		<b>дурдах</b> вспоминать, упоминать
<b>далдлах</b> укрывать, скрывать		<b>ойлох</b> понимать
<b>хадах</b> эд. пришить		<b>хэцүү</b> трудно
<b>тана</b> [эрдэнэ] перламутр		<b>санаа</b> алдах вздыхать
<b>адуу(н)</b> лошадь; табун лошадей		<b>бардам</b> гордый
<b>үхэр</b> крупный рогатый скот		<b>чөтгөрүүд</b> дуг. черти, чертенята
<b>билчих</b> пастись		<b>чих(эн)</b> ухо
<b>зэргэлгээ(н)</b> мираж		<b>эвэр</b> рога
<b>нэхий</b> овчина; козья шкура		<b>наслах</b> прожить; достичь (какого-л.)
<b>хар</b> хүү эд. юноша		возраста
<b>нохой</b> собака, пес		<b>зуур</b> в, в течение
<b>настай</b> эд. немолодой, пожилой		<b>бардаггүй</b> не может, не смог
<b>авгай</b> эд. женщина, тетья		<b>далан долоон үг перен.</b> болтовня
<b>хорих</b> эд. удерживать, запрещать, отгонять		<b>түргэвчлэн</b> быстро, скоро, ускоренно
<b>ерийн</b> обычный, обыкновенный		<b>хайрцаг</b> ящик

## ХОЁУЛАА МИНИЙ ХҮҮ

(Төгсгөл)

Танай хүвгүүн аль нь вэ? гэж бид тоглон асуувал Дулмаа үгүүлрүүн:

— Хоёулаа миний хүү дээ. Орос монгол ялгаваргүй. Энэ орос хүвгүүн, миний хүүтэй хамт Халхын голд байлдаж явсан. Миний хүүг байлдааны газар шархтаад байхад энэ хүвгүүн үүрч ирсэн юм. Одоо энэ орос хүвгүүнтэй миний хүү Өлзий захидлаар үргэлж харилцаар байдаг гэнэ билээ гэв. Өвгөн юм бодсон мэт дуугүй болж, зургийг үзэж байгаад хэлсэн нь: энэ гэрэл зураг гэдэг сайхан юм даа. Дүрс нь ингээд мөнх үлдэх юм. Урьд биднийг байлдаж явахад зураг авдаггүй байсан нь харамсалтай юм гэв.

Та байлдаж явсан уу? гэж бид асуувал өвгөн баясаж их хөгжилтэйгөөр нэг сэлмийг зааж үгүүлрүүн: энэ сэлмийг орос дарга над өгсөн. Тэр орос дарга байлдаанд хэзээд тэргүүлэн ордог билээ. Зоригтой эр юмсан. Ганцаараа арван хүнтэй тэнцэх чадалтай хүн. Байлдаанд тэр, хэдэн удаа шархтаж билээ. Манай монголын эрх жаргалын төлөө байлдаж явсан нэг сайн нөхөр минь тэр мөн. Одоо бодвол германы фашистуудтай байлдаж яваа биз. Их генерал болсон ч байж мэднэ. Монголчууд бол оростой харилцаатай, улаан цусаар барилдагатай болсон хүмүүс юм. Бидний эрх жаргал бол, хойт улстай нөхөрлөснөөс бүтсэн юм. Хувьсгалын урьд би ганц унагатай, өөр малгүй явсан хүн. Гэртээ хэдэн тарвага алж өгөөд ганц унагаа унаж Сүхбаатар, Чойбалсан нарын партизан цэрэгт элссэн юм. Түүнээс Монгол улс нүдний өмнө өөр болж мандаж ирэв. Улсын мандахад бидний амьдралга ч сайжраж мандаж байна. Одоо над хориод адуу, гучаад үхэр, зуугаад хонь байна. Биднийг мөлжих тонох этгээдгүй тул малыг өсгөж эрх жаргалаар амьдрахад ямар ч саадгүй. Би нам — засгийн буянаар, Зөвлөлт Улсын буянаар ингэж сайн сайхан сууж байна. Иймд Зөвлөлт оронд туслах хэрэгтэй. Орос нөхөддөө туслах хэрэгтэй гэж өөрсдийн бэлтгэсэн бэлгийг тэмээн ачаа хөтлөгч хүүд шилжүүлэн өгөв. Түүний дотор ямаан дах, хурган бээлий, шар тос зэрэг нилээд юм байна. Зэргэлдээ гэрийн бүсгүйчүүд бас дээл, арьс зэрэг бэлгийг авчраж өгснийг тэмээн ачаа хөтөлж ирсэн хүү ачаад явж одов. Өвгөн, Улаан Цэрэгт туслах гэсэн хоёр морио барихаар адуундаа мордов. Ан тохиолдох болзошгүй гэж буугаа авав. Бид аймгийн төв орохоор тэндээс мордов. Наран шингэж байна. Бүрэг тэнгэрийн хаяанд шингэх нарны гэгээн зурвас улбалзан харагдана.

По рассказу Ц. Дамдин Суруна.

**үүрэх** нести, вынести (на плечах, на спине)  
**захидлаар харилцах** переписываться  
**гэрэл зураг** фотография  
**дүрс** облик, образ  
**ингээд** так  
**байлдах** воевать  
**баясах** радоваться, оживиться; быть довольным  
**сэлэм** сабля  
**тэргүүлэх** итти впереди  
**зоригтой** смелый  
**эр(э)** мужчина  
**байж мэднэ** может быть  
**цус(ан)** кровь  
**барилдлагатай** скреплен, связан  
**бүтэх** исполниться, сбываться

**унага(н)** жеребенок  
**тарвага(н)** тарбаган (*степной сурок*)  
**тонох** [о]грабить; обобрать  
**буян** добродетель; благодеяние; благодаря  
**шилжүүлэн өгөх** передать  
**ямаан** козий  
**дах** доха  
**хурган** ягнячий  
**бээлий** рукавицы, перчатки, варежки  
**шар тос(он)** топленое масло  
**ан(г)** звери  
**болзошгүй** возможно, может быть  
**шингэх** зд. заходить  
**бүрэг** темный  
**хаяа(н)** край  
**зурвас** полоска  
**улбалзах** краснеть

## 67 ЖАРАН ДОЛООДУГААР ХИЧЭЭЛ

### САЛХИН ЗЭЭРД

#### I

Ард Жаргалын халиугчин гүү, үл мэдэгдэх нууц шалтгаанаар алдагдснаас хойш сар илүү болсны дараа тодорхойгүй нэгэн сураг гарав.

Жаргал, намрын нэгэн сайхан өглөө завхарсан халиугчнаа эрэхээр мордов.

Урт нарийхан ургын дунд биеэс барьж, зүүн тийш сүүжилдэн суужээ. Морины алхдлын аясыг даган ургын үзүүр нахилзан чирэх нь говийн зэргэлгээний долгион мэт санагдана.

Алсыг барьж довтлон явахад төрсөн нутгийн намрын урихан салхи өмнөөс үлээж, говь орны шавгийн үнэрийг анхилуулна. Зах хязгаар нь харагдахгүй далай мэт элсэн цөлийн чимэг бологч хаармаг, сундуулын бут, Жаргалын замд үргэлжлэн тохиолдоно. Намрын хаармаг гэх амттайхан жимс боловсрож хүрэн улаан өнгөтэй болсныг үзээд, хааяа морины амыг татан бууж, шүүслэг жимсийг амтархан иднэ.

Эргэн тойрон нам гүм, өмнөх нэгэн гүвээг давахад, цаана нь бас нэгэн гүвээ байна. Нэгэн бутыг өнгөрөхөд, цаана түүнтэй адил бут хязгааргүй олон үргэлжилнэ. Үд болохын үе наран тэсэшгүйгээр шарав.

Холын хол, нүдний үзүүрт тэнгэр тулам өндөр юмс сүмэлзэн харагдахыг хуурамч зэргэлгээн мөн гэж хашир малчин Жаргал

андахгүй мэднэ. Наран шингэтэл бүхэл эдөр явахад нэгхэн ч айл тохиолдсонгүй.

Жаргал, энэ газрын байдалд багаас дассан бөгөөд хаа айл байдаг, адуу хаа тогтдог, хаа ус бий зэргийг мэдэх тул, эзэнгүй цөлийн дундуур өрнө зүг зүглэж, ажиг сэжиггүй улам гүнээ нэвтрэв.

Гурван хоногийн дараа, өмнө орны алдар ихэт Номины говийн захад оров. Тэнд байгаа нэгэн багахан хотгорын эрэг дээр хүрэх сацуу, гэнт хэдхэн адуу үзэгдээд түүний дотроос өргөн цээжтэй, өндөр нарийхан хөлтэй, нуруун дээгүүрээ бараавтар судалтай, гуалаг сайхан биетэй, халиун зээрд зүсмийн морь, сугасхийн гарч, жигдхэнээр хатруулсаар цааш дутаахад говийн зөөлөн хөрснөөс, цагаан тоос суганаглан үзэсгэлэнт морин, дав даруй уужим цөлд үзэгдэх бараа, сондох чимээ огтгүй болон одов. Гагцхүү түүний далд орсон өрнө зүгийн алслан харагдах хөх манхан тэнгэрийн хязгаарт Монгол Алтайн нэгэн салбар болсон өндөр уулны цаст оргил, шөнийн дундахь одон мэт цайран үзэгдэнэ.

Жаргал, гшин зуур журавхийн өнгөрөх энэхүү үзэгдэл юун билээ? Зэргэлгээн буюу үнэхээр, уран хүний зурсан шиг гайхамшигт морин буюу? гэж бодон, хэсэг адуунд ойртох зуур «Алтайн цаадахь цөлөөс тахийн азрага ирж, монгол адуунд нийлээд гүү хураадаг, заримдаа сүргээс хэд хэдээр таслан цааш цөл орны гүнд аваачдаг, түүнийг ямар ч морин гүйцдэггүй, тахийн азрага хазгахад монгол азрага чичрэн зогсдог, түүнтэй тэмцэлдэж чаддаггүй юм» гэж эцгийн хэлдгийг тодорхой санасаар явав. Тэр хэдэн адууны дотор өөрийн халиугч гүү байсныг олж бөглөрсөн сэтгэл нээгдэн, үүр гийх мэт болсон билээ.

(Төгсөөдүй)

## С л о в а

салхин ветряный  
зээрд рыжий (*о масти лошадей*)  
халиугчин саврасый  
гүү(н) кобылица  
завхрах *эд.* отбиться от стада, заблудиться, потеряться  
нарийхан тоненький, тонкий  
урга аркан  
сүүжилдэх сидеть немного боком, сидеть наклонившись на бок  
сүүж бок, таз, тазобедренные кости  
алхдал шаг, топот  
нахилзан чичрэх прогибаться, извиваясь дрожать  
үлээж дуть  
шаваг польнь гобийская  
цөл пустыня  
элсэн песчаный  
хаармаг хэрмак (*гобийский кустарник*)

сундуулын бут бугорок с кустарником, кочка  
амттайхан вкусный, сладкий  
болговсрох попеть  
амыг татах *эд.* придерживать повод, остановить  
шүүслэг сочный  
амтархах ощущать сладкий вкус  
нам гүм тихо; тишина  
гүвээ(н) бугор, холм  
тэсэшгүй нестерпимый; нестерпимо  
шарх *эд.* палить, прилекать  
тулах упираться; подниматься до...  
сүмэлзэх маячить, мерещиться, еле казаться  
хуурамч ложный, обманчивый  
хашир осторожный, опытный  
андахгүй без ошибки; безошибочно  
дасах привыкать  
тогтох останавливаться; стоять; пастись

**бүхэл** цөлий, полный  
**өрнө** запад  
**зүглэх** направляться  
**ажиг сэжиггүй** эд. смело, уверенно,  
безбоязненно  
**хотгор** лощинка, ложбина  
**сацуу** эд. одновременно, в момент...  
**цээж** грудь  
**бараавтар** темноватый  
**судал** полоса  
**гуалаг** красивый, стройный  
**халиун зээрд** светло-рыжий (о масти лошадей)  
**сугасхийх** выскользнуть  
**хатруулах** пустить(ся) рысью  
**хөрс(өн)** почва, земля  
**суганаглах** подниматься, тянуться

**дав даруй** моментально, вмиг  
**уужим** широкий, просторный  
**бараа** видимость, вид  
**далд орох** скрываться  
**алслах** быть вдали  
**хөх манхан** голубой, бирюзовый  
**салбар** эд. отрог  
**цайрах** белеть; мерцать  
**журавхийн өнгөрөх** шмыгнуть  
**уран** искусный  
**цаадахь** находящийся за...  
**тахь** лошадь Пржевальского  
**азрага** жеребец  
**аваачих** уводить  
**гүйцэх** догонять  
**хазах** кусать  
**бөглөрсөн сэтгэл** дурное настроение

## 68 ЖАРАН НАЙМДУГААР ХИЧЭЭЛ

### САЛХИН ЗЭЭРД

(Төгсгөл)

#### II

Тэр жилийн өвөл цасгүй дулаан өнгөрч, хавар болов. Халуун наран шарав. Бут навчилж ногооны униар, уудам говийн орныг бүрхээв.

Халиугчин гүүний хээлтэй болсныг Жаргал хэдийнээ мэдээд, үргэлж харгалзан сахидаг байжээ.

Салхинтай тэнцэх, хурдан түргэн хүлэг морь гаргаж өгөх байх гэж бат итгэнэ.

Нэгэн өдөр халиугчин унагалав. Түүний дэргэд гүйн очвол, эхээс дөнгөж салаад, газар унасан унага, тэр даруй хөл дээрээ босоод эзнээ сонирхон харж байгаа нь, ерийн унаганаас тун өөр, гаж буруу юм шиг санагдлаа.

Бие богино, цээж өргөн, хөл урт бөгөөд нарийхан, өтгөн дэлтэй урт хушууны үзүүр нь цагаан, сайхан зээрд зүсмийн унага байхыг сайтар ажиглан харахдаа монгол азрагын унага лав биш, тахийн азрагын хүү байхаас зайлахгүй гэж бодов.

Удалгүй хол ойрд энэ унаганы тухай цуу тархав. Өвгөн хөгшид үзээд, тахийн унага мөн гэлцсэн билээ.

Халиугчны зээрд унага, өдөр сараар өссөөр хэдэн жил өнгөрөхөд, гайхамшигт сайхан морин болов. Түүнийг үрээ насанд нь Жаргал өөрөө сургаад, ямар ч морийг дагуулахгүй хурдан морь болов. Ав хийх цагт Жаргалын зээрд, олны дотроос онцлон гарч үнэг чоныг цаг зуурын дотор гүйцдэг байв.

Нас бие гүйцэж ирэхдээ, бүр ч догширсон бөгөөд, талын цагаан зээрийг төвөггүй гүйцдэг болов. Нутгийн ардууд түүнийг салхин зээрд гэж нэрлэх болов.

Жаргал, салхин зээрдээ онц хэрэг явдал, найр наадамд унана. Бусад цагт адуунд тавьж амар байлгадаг болов.

### III

1942 оны зун цаг, монголын ард түмэн, өөрийн эрх чөлөөний наран бологч, их Зөвлөлт Холбоот Улсын баатар Улаан Армид, үнэн зүрхний сайн сэтгэлээрээ морьдыг бэлэглэв. Нэгэн өдөр Говь Алтай аймгийн бэлгийн морийг хүлээн авах комиссын газраа, өвгөн Жаргал хүрэлцэн ирээд морьдоо үзүүлэхдээ хайрт салхин зээрд мориныхоо жолоог өндөр өргөн барьж ийн үгүүллүүн:

— Эх болсон, далай их Монгол нутаг минь, эрх чөлөөт, ивээл ихэт засаг төр минь, нэгэд нэгэнгүй цем амаржин жаргаж, цэцэглэн мандаж байгаа нь, наран саран мэт гэгээн гэрэлт, түмэн ачит их Зөвлөлт Холбоот Улсын ард түмний халуун тусламжийн үр мөнийг би сайн мэднэ. Эцэг эх мэт ивээлтнийхээ, атаатантайгаа байлдаж байгаа үед нь, би зүгээр сууж чадахгүй. Харгис араатан Гитлерийг устган дарахад зориулж, хайрт салхин зээрдээ өргөн барья. Миний сайн морь эсэн мэнд явж, төрсөн орныхоо түвшин сайхан мандахын төлөө, халдах дайснаас харилгүй, халуун сумнаас буцалгүй бүх чадлаараа зүтгэх болтугай! гээд комиссийн даргын гар дээр салхин зээрдийнхээ алтан жолоог тавив.

По рассказу Д. Цэбэгмида.

### Слова

**бут** кочка  
**навчлах** покрываться листьями; по-  
являться (*о листьях*)  
**ногоо(н)** зелень, трава  
**униар** мгла, дымка  
**бүрхээх** покрыть, подернуть(ся)  
**хээлтэй болох** забеременеть  
**хүлэг морь** хороший конь  
**бат** крепко; твердо  
**унагалах** ожеребиться  
**гаж бүруу** эд. неестественный, не-  
нормальный  
**дэл** грива  
**хушуу(н)** эд. морда  
**зайлахгүй** не избежать; неизбежно  
**цуу** слава, молва  
**хөгшид** старушки  
**үрээ нас** трехгодовалый  
**ав** эд. облага; охота  
**үнэг(эн)** лисица  
**чоно** волк  
**цаг зуур** быстро, вмиг  
**нас бие гүйцэх** стать взрослым, со-  
вершеннолетним

**догшрох** эд. становиться необуздан-  
ным; дичать  
**төвөггүй** без труда  
**найр наадам** надом (праздник, тор-  
жество)  
**Улаан Арми** Красная Армия  
**үнэн зүрхний** чистосердечный, сер-  
дечный  
**бэлэглэх** подарить  
**хүрэлцэн ирэх** прийти, прибыть  
**далай** эд. обширный, необъятный  
**засаг төр** власть; государственность  
**нэгэд нэгэнгүй** каждый; все  
**амаржих** успокаиваться  
**жаргах** испытывать счастье  
**ивээлтэн** благодетели, защитники  
**атаатан перен.** противник, враг  
**зүгээр суух** эд. просто сидеть, си-  
деть без участия  
**араатан** хищник, зверь  
**өргөн барих** пожертвовать, подносить  
**эсэн мэнд** жив, невредим  
**түвшин** мирный; спокойный  
**харилгүй** не отступая, не боясь  
**болтугай** да будет

## МАНАЙ ОРНЫ МАЛ АЖ АХУЙН ХӨГЖИЛТ БОЛ ЗӨВЛӨЛТ ХОЛБООТ УЛСЫН ТУСЛАМЖИЙН ҮР МӨН

Монголын ард түмэн, засгийн эрхийг байлдан авснаас хойш 30 гаруй жил өнгөрөв. Түүхийн урт биш энэ хугацаанд манай ард түмэн улс төр, эдийн засгийн талаар асар их амжилтуудыг олж хөгжөөд, социализмын замаар итгэлтэй явж байна.

Хувьсгалын өмнөх Монгол орон бол хамгийн хоцрогдмол эдийн засагтай, ард түмэн нь хэдэн давхар дарлал мөлжлийг хүлээж маш гашуун бэрхийг амсаж байв.

Нэг талаас, гадаадын шунахай худалдаачид, мөнгө хүүлэгчид, нөгөө талаас дотоодын феодалууд тус орны бүх баялгийг дээрэмдэн тонож, ард түмнийг улс төр, эдийн засгийн эрх мэдэлгүй, соёлын талаар хамгийн бүдүүлэг хоцрогдсон байдалд оруулж, тэднийг олон төрлийн албан татвараар хавчиж мал хөрөнгийг цөлбөсөөр байв. 1918 онд бүх феодал ба сүм хийдийн мал нь улсын бүх малын 35 хувийг эзэлж байсан нь дундыг баримталбал феодалын нэг өрхөд 2370 мал, сүм хийдийн нэг жас буюу дацанд 4285 мал оногдож байжээ. Энэ нь тэр үед ардын нэг өрхөд оногдож байсан бүх малын тооноос 40—70 дахин илүү байжээ. Тус орны хамаг сайн ус билчээрийг мөн л феодал, сүм хийдүүд ноёрхон эзэмшдэг байв.

1917 онд Орос оронд ялсан Октябрийн Социалист Их Хувьсгалын нөлөө нь колонийн харанхуй орон байсан манай орныг эрх чөлөөт тусгаар тогтносон орон болгон хувиргав.

Манай ард түмэн, ардын шилдэг хүү Сүхбаатар-Чойбалсангийн удирдан байгуулсан М. А. Х. Намын удирдлага, Зөвлөлт Холбоот Улсын тусламжтайгаар 1921 онд гадаадын түрэмгийлэгчдийг өөрийн эх нутгаас хөөн зайлуулж, феодал ноёдын засаг төрийг түлхэн унагаагаад оронд нь жинхэнэ ардын хувьсгалт засгийг тогтоосон билээ. Энэ өдрөөс Зөвлөлт, Монголын ард түмний үүрдийн найрамдал тогтсон юм.

1924 онд Зөвлөлт Холбоот Улсын тусламжтайгаар манай орон, мал эмнэлэгтэй болжээ. Хувьсгалын жилүүдэд мал эмнэлгийн байгууллагуудын тоо улам бүр өсөн нэмэгдлээ. 1924 онд тус улсын дотор мал эмнэлгийн 4 тасаг ажиллаж байсан бол 1950 онд мал эмнэлгийн байгууллага 603 болж өсөв.

Мал эмнэлгийн эдгээр байгууллага нь манай ардын аж ахуйтан, сангийн аж ахуй, ардын үйлдвэрлэлийн нэгдлүүдийн малд эмнэлгийн тусламж үзүүлэх үүргээ амжилттай биелүүлж ирлээ.

Одоо тус улсын дотор 30 шахам төрлийн тарилгын эм үйлдвэрлэн гаргадаг тэргүүн зэргийн төхөөрөмжтэй хэд хэдэн био

Үйлдвэр ажиллаж байна. Үүний ачаар жил бүр олон сая малыг элдэв халдварт өвчнөөс урьдчилан хамгаалж чадах бололцоотой болов. Үхрийн боом, хонины цэцэг зэрэг халдварт өвчнийг эсэргүүцэх тарилгын эм үйлдвэрлэх явдлыг манай био үйлдвэрүүд амжилттай хийж байна. Зөвхөн сүүлийн 4 жилийн дотор мал эмнэлгийн шинжлэх ухааны 20 гаруй ажлыг гүйцэтгэлээ.

Мал аж ахуйг амжилттай хөгжүүлэхэд тэжээлийн суурьшилтай баз ихээхэн ач холбогдолтойг нам, засаг үргэлж зааж байна. 1937—1938 онуудад Зөвлөлт Холбоот Улсын тусламжтайгаар машинаар өвс хадах морин станцыг байгуулсан бөгөөд тэдгээрийн тоо энэ завсар 5, 5 дахин өссөн ба мөн энэ хугацаанд хадлангийн талбай хэдэн 10 дахин өсчээ. Малын тэжээл бэлтгэх явдал сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэв.

Мал аж ахуйг хөгжүүлэхэд билчээрийг усжуулах асуудал маш их рольтой юм. Энэ асуудалд нам, засаг онцгой анхаарлыг тавьж, ялангуяа худгийн тоог олшруулах, ардуудад худгийг эзэмшүүлэн хариуцуулах, худаг малтаж гаргахад ардуудад улсын зээллэгээ олгох, усгүй билчээрүүдийг судлах, улсын зардлаар худаг малтах зэрэг арга хэмжээнүүдийг тасралтгүй авч ирсний үрээр малтмал худгуудын тоо сүүлийн жилүүдэд 5—6 дахин нэмэгдсэн ба бүх худгийн тоо 1930—1950 онд 12 мянгаас 40 мянга болж нэмэгдлээ. 1940 онд дундыг баримталбал 2000 малд нэг худаг оногдож байсан бол 1950 онд 665 малд нэг худаг оногдох болжээ. Малыг усаар хангах явдал 3,3 дахин өсчээ. Малд боловсон суурьшилтай хацаа барих явдал улам нэмэгдэн сайжирч байна. Мал аж ахуй дээр олсон эдгээр амжилт бол Зөвлөлт Холбоот Улсын үзүүлсэн гүн тусламжийн ач мөн.

Энэ сайхан амжилтыг улам бататган цаашид өрнүүлэх нь чухал юм. Гэтэл зоотехникийн ба мал эмнэлгийн арга ажиллагаа мал аж ахуйд хангалтгүй нэвтэрч байна. Мал элдэв шалтгаанаар ихээхэн хорогддог байна. Мал хээлтүүлгийн кампанийг эрчимтэй зохиодоггүй, малын төлийг сайн бойжуулдаггүй, мал бүрд өвөл, хаврын цагт хүрэл цэх хэмжээний өвс тэжээлийг нөөцлөн авдаггүй байна.

Мал сүргийг байгалийн гэнэтийн аюулаас хамгаалах арчилгаа муу байгаагийн шалтгаанаар мал хорогдож байхад манай орон нутгийн нам, захиргааны зарим байгууллагууд тодорхой арга хэмжээ авдаггүй байна. Манай мал аж ахуйн ажлын гол дутагдал үүнд оршиж байна.

Манай мал аж ахуйн ажилд оршиж байгаа дутагдлыг арилгахын тул орон нутгийн нам, захиргааны байгууллагын удирдамжийг мал аж ахуйд чиглүүлж, мал өсгөхийн ач холбогдлыг хөдөлмөрчдөд цуцалтгүй ухуулан таниулах, мал аж ахуйд зоотехникийн ба мал эмнэлгийн шинжлэх ухааны аргыг дэлгэрүүлэх, ялангуяа малын арчилалт хамгаалалт, тэжээлтийг бүх аргаар сайжруулж төлийг бүрэн бойжуулах явдалд гол анхаарлаа тавьж ажиллах ёстой.

Сүүлийн 10 жилийн дотор сангийн аж ахуйнуудын нийт малын тоо 1,5 дахин, тариалангийн талбай нь 3,5 дахин, тарианы ургац нь 2 дахин, тракторын парк 2,8 дахин өсч, таваарын будааны өсөлт нь 1943—1950 онд 2 дахин нэмэгдлээ.

Сангийн аж ахуйнуудад дадлага мэрэгшилтэй бригадын дарга, фермийн эрхлэгч, малч, саальч олноор ажилладаг. Сангийн аж ахуйн ажилчдын аж байдал гуйвалтгүй дээшилж, клуб, улаан булан, сургууль гуанз, орон сууцын байруудтай болжээ.

Гэвч зарим аж ахуйнуудын ажилд үлэмж дутагдал байгаа бөгөөд малын үүлтэр угсааг сайжруулах, түүний ашиг шимийг нэмэгдүүлэх талаар Орхон, Баруун туруун, Түвшрүүлэхийн аж ахуйн удирдагч, зоотехникч нар тодорхой ажиллахгүй байна. Олонхи сангийн аж ахуйд хөдөлмөрийн бүтээмж дээшилж чадаагүй, үйлдвэр, санхүүгийн төлөвлөгөөг биелүүлдэггүй, арвилан хэмнэх ёс, хувьсгалт уралдаан нэвтрээгүй байна. Ийм учраас сангийн аж ахуйн ажлыг бүх талаар дээш татах хэрэгтэй.

Манайд хүч хөдөлмөрөө хамтатгасан ардын үйлдвэрлэлийн нэгдлүүд бий болж, түүний тоо сүүлийн 6 жилийн дотор 49,4 хувиар өссөн ба тэдгээрийн дундын хөрөнгө малын тоо 5,5 дахин нэмэгджээ.

Сангийн аж ахуйнууд ба ардын үйлдвэрлэлийн нэгдлүүд, машинаар өвс хадах морин станцууд нь мал, хөдөө аж ахуйд социалист өөрчлөлтүүдийг хийхэд маш их ирээдүйтэйгээ тод харуулж байна.

Сангийн аж ахуйнууд, Зөвлөлт Холбоот Улсын ашиг шим ихтэй хониор монгол хонийг эрлийзжүүлж байгаа нь манай орны мал сүргийн үүлтэр угсааг сайжруулахад ихээхэн тустай байна.

Манай нийт малын өсөлт хээлтэгч мал тутмаас бойжуулах төлийн тоо, малаас гарах ашиг шим дээшилсээр байна. 100 хээлтэгч мал тутмаас бойжуулан авсан төл 1940 оноос 1947 онд 14%, 1950 онд 19,5%-иар нэмэгджээ. Эдгээрийн үр дүнд тус улсын малын нийт тоо эрс нэмэгдэж түүнээс гарах ашиг шимийн хэмжээ дээшлэв.

1924 оныхыг 1950 оныхтой зэрэгцүүлэхэд тус улсын бүх малын тоо 2 дахинаас илүү өссөний дотор тэмээ 3,5 дахин, адуу 1,9 дахин, үхэр 1,6 дахин, хонь ба ямаа 2 дахин өсчээ.

Үүний зэрэгцээгээр мал аж ахуйн таваарын бүтээгдэхүүний хэмжээ нилээд дээшилжээ. Төрөл бүрийн малын таваарын ноосны гаралт 1938—1950 онд 2,1 дахин, цөцгийн тос боловсруулалт 1941—1950 онд 15,7 дахин нэмэгдсэн байна.

Манай орны мал аж ахуйн эдгээр хөгжилт нь гагцхан Зөвлөлт Холбоот Улсын цаглашгүй их тусламжийн үр мөн.

Ах дүү Зөвлөлтийн ард түмний дэмжлэгтэйгээр улам шинэ амжилттуудыг олж социализмд дэвших ирээдүйгээ манай ард түмэн тод харж байна.

**хоцрогдмол** отсталый  
**хүлээх** *эд.* испытывать  
**гашуун** горький  
**худалдаачид** торговцы; купцы; ком-  
 мерсанты  
**мөнгө хүүлэгчид** ростовщики  
**дээрэмдэх** [о] грабить  
**хавчих** притеснять  
**цөлбөх** забирать, обирать  
**сүм хийд** монастырь, храм  
**дундыг баримталбал** в среднем  
**жас** хозяйство монастыря  
**дацан(г)** кумирня, храм  
**оногдох** приходиться  
**ноёрхох** господствовать; владеть  
**үүрдийн** вечный  
**мал эмнэлэг** ветеринария  
**гасаг** *эд.* пункт  
**ардын үйлдвэрлэлийн нэгдлүүд**  
 аратские производственные объеди-  
 нения  
**гөхөөрөмжтэй** подготовленный; обо-  
 рудованный  
**урьдчилан хамгаалах** предохранять  
 путем профилактических мер  
**боом** сибирская язва  
**цэцэг өвчин** оспа  
**суурьшилтай** *эд.* прочный; оседлый

**хадлангийн талбай** покосные угодья  
**усжуулах** обводнить, обеспечить во-  
 дой  
**хариуцуулах** возложить ответствен-  
 ность  
**зээллэг** кредит, заем  
**хээлтүүлгийн кампани** случайная кам-  
 пания  
**хүрэлцэх** достаточный  
**нөөцлөн авах** запастись  
**гэнэтийн аюул** стихийные бедствия  
**хорогдох** сокращаться  
**дутагдал** недостаток  
**удирдамж** руководство  
**ухуулан таниулах** пропагандировать;  
 разъяснять  
**таваарын будаа(н)** товарный хлеб  
**мэрэгшилтэй** квалифицированный  
**үүлтэр угсаа(н)** порода  
**бүтээмж** продуктивность; выполнение  
**санхүү** финансы  
**хамтаггах** объединить, обобществить  
**эрлийжжүүлэх** скрещивать  
**хээлтэгч** мал маточный скот  
**зэрэгцүүлэх** сравнивать, сопостав-  
 лять  
**бүтээгдэхүүн** продукция

## 70 ДАЛДУГААР ХИЧЭЭЛ

### МОСКВА БОЛ БҮХ ДЭЛХИЙН ШУДАРГА ЁС АРИУН ХЭРГИЙН ЭХ ОРОН

Дэлхий ертөнц дээр Москва шиг ийм бүх улс орны дур хол-  
 боог оиедээ татан дуудсан нийслэл хот огтхон ч үгүй юм.

Москва ганц Зөвлөлт орны нийслэл төдийгүй түүний бадмаа-  
 раагаа эрднийн таван хушуу нь дэлхийн бүх улс орныг гийгүүлж  
 байдаг юм.

«Москвагийн агуу сайхан огторгуй, Кремлийн бөөрөнхий орой  
 ба жаргалын туг дээрх сүлд нь зах хязгаар бүхнээс харагдаж  
 байдаг» гэж бүх орон даяар магтан дуулцаагаадаг.

Москва бол эхнээсээ аваад эцсээ хүртэл энх тайвныг мөрөө-  
 дөгч хүн төрөлхтний аврал найдварын орон юм.

Москва бол чөлөө жаргалыг эрмэлзэн зоригч дарлагдсан хө-  
 дөлмөрчин пролетари нарт жаргалын түлхүүрийг бариулж өгдөг  
 газар гэж хэлж болно. «Москвагийн гавьяа нь шинэ дайн өдөөгч

нарыг цуцалтгүй илрүүлж энх тайвны тугийг хүрээлүүлэн энх тайвныг эрхэмлэгч бүх улс түмнийг цуглуулж байна. Энх тайвныг эрхэмлэгч улс түмнээс энх тайвныг эрхэмлэгч гүрний нийслэл энх тайвны хүчирхэг түшиг гэж Москваг найдварын нүдээр ширтэн харж байна» (Сталин).

Москва бол уран гуалгийн ба утга чанарын талаар зөвийг мэдэгч хүмүүсийн дурыг булааж, сэтгэлийг татагч ёстой жаргал баяслын орон юм.

Зөвлөлт Москвагийн гудамжаар явахад ариун сэтгэлт хүмүүсийн сэтгэл санааг сэргээсэн авиа дуулал сонсдож Зөвлөлтийн хүмүүсийн ариун хөдөлмөрөөр бүтээсэн гайхамшигт зүйлс үзэгдэж байдаг байна.

«Замаг сайт усанд загас олон, зан сайт хүнд нөхөр олон» гэгчээр Москва нь дэлхийн аль шилдэг сонгодог бүхний хуралдан цугларах газар болжээ.

Эрх чөлөөг ус агаар мэт тэмцэн талархагч бүхэн Москвагаар нөхөрлөж байна.

Москва бол харийн дарлалын дор нухлагдаж байсан монголчуудын жаргалын зүгийг зааж өгсөн амьдралын алтан гадас одон юм.

Ийм ч учраас монгол хүмүүсийн сайн үгийн түрүүнд Москва Сталин гэж ямагт цууриатаж байдаг.

Москвагаас үссэн эрх чөлөөний цуури манай оронд долгион ирж Монголын ард түмнийг дарлагдлын дор удаан жил үргэлжлэн хэвтсэн нойроос нь сэрээн эрх чөлөө тусгаар тогтнолын өлзийт замыг олгож өглөө.

Манай их удирдагч аймшиггүй чин зоригт Сүхбаатар монголын ард түмний нэрийн өмнөөс Москвагийн Кремльд Лениний халуун гарыг атгаж чин зүрхний нөхөрлөлийг тогтоосон түүхтэй юм.

(Төгсөөдүй)

### С л о в а

**дур(а)** любовь  
**бадмаараага** [эрдэнэ] рубин  
**бөөрөнхий** круглый, шарообразный, сферический  
**зах хязгаар** край, окраина  
**аврал** избавление, спасение  
**түлхүүр** ключ  
**өдөөгч нар** поджигатели; зачинщики (войны и т. п.)  
**хүрээлүүлэх** сплотить вокруг, собирать вокруг  
**энх тайвныг эрхэмлэгч** миролюбивый  
**уран гуалаг** красота, великолепие  
**утга чанар** содержание; суть  
**булаах** отнимать, овладевать  
**баясал** веселье, радость  
**ариун сэтгэлт хүмүүс** люди доброй

воли, люди с благородными сердцами  
**авиа(н)** звук  
**сэтгэл санааг сэргээх** вдохновлять; поднять настроение  
**замаг** типа  
**сонгодог** лучший, отборный  
**тэмцэн талархагч** борец; сторонник  
**нухлагдах эд.** испытывать угнетение, находиться под гнетом  
**түрүүн** вначале; сперва; начальный, первоначальный  
**дарлагдах гнет, угнетение**  
**удаан** долго; много  
**элзийт** счастливый, приносящий счастье  
**нэрийн өмнөөс** от имени  
**чин зүрхний** сердечный

## МОСКВА БОЛ БҮХ ДЭЛХИЙН ШУДАРГА ЁС АРИУН ХЭРГИЙН ЭХ ОРОН

(Төгсгөл)

Москвад Зөвлөлт Монголын төлөөлөгчид 1921 оны 11 дүгээр сарын 5-ны өдөр Орос Монголын найрамдлын гэрээнд гарын үсэг зурж хаант засгийн бүх харгис гэрээнүүдийг устгаж «Зөвлөлийн Засагт Орос Улсын засгийн газраас ганцхан хууль ёсоор эрхээ барьсан Монголын ард түмний засгийн газрыг зөвшөөрөн хүлээлээ.

Ийнхүү Зөвлөлт Монголын ард түмний цусаар гагнагдсан ах дүүгийн нөхөрлөл Москвад албан ёсоор батлагдлаа».

Тэнд бүх үеийн их хүн Сталинтай манай хайрт удирдагч Чойбалсан олонт уулзаж манай их нөхөрлөлийг улам бэхжүүлж, Монголын ард түмний хувь заяаны тухай нэг бус удаа шийдвэрлэсэн билээ.

Тэндээс их Сталин Монголын ард түмэнд цаг үргэлж ах дүүгийн ёсоор туслах чин сэтгэлийн үгээ дэлхий дахинаа зарлаж түүнийгээ хэрэг дээр нь Монголын ард түмэнд нэг бус удаа үзүүлэв.

Оросын их хувьсгалын 6 жилийн ойгоор манай удирдагч Чойбалсан Москвагаас Монголын ард түмэнд Орос улс баян чинээлэг болж байгаа ба хамгийн баялаг улс болно гэдэг нь сохор хүнд ч үзэгдмээр байна. Орос бол манай Монголын хамгийн итгэлтэй шилдэг хань нөхөр мөн бөгөөд бидний монголчууд энэ холбоогоо улам нягт болгох ёстой гэж уриалан дуудаж билээ.

Алсыг харсан энэ гүн үг монголчуудыг ямагт баясгаж байдаг.

Москва өөрийнхөө өдөр тутмын ялалтаар дэлхий дахины хамгийн ардчилсан эрх чөлөөт оронтой адил тэгш байх манай ард түмний эрмэлзэлгээг өдөр тутам дэмжин туслаж байдаг юм.

Москва, талын малчин Монголын хувгүүд охидыг нийгэм журмын шинжлэх ухааны дээд ололтуудаар зэвсэглэн туслаж байна. Түүнчлэн Москва өөрсдийн шилдэг хувгүүд нараа манай газар ирүүлдэг бөгөөд тэд манай хэргийн ялалт, манай орны цэцэглэлтийн төлөө бие хүч хайрлалгүй зүтгэж байдаг. Манай ард түмний хүсэл эрмэлзэлгээ бүхэн Москватай ах дүүгийн холбоог улам бататгаж түүний сайн сайхан бүтээлүүдээс үлгэр дууриалал авах, түүгээр өөрсдийн ололтыг батжуулахад оршино.

Манай оронд Москваг талархахгүй, түүнийг бахархан магтахгүй тийм хүн байхгүй.

Манай зохиолчид Москваг:

Өрнөгч дэлхийн өвчүүн дээр  
Өндрөөр хөгжин дэлгэрсэн  
Өнөр сайхан Москва  
Үнэхээр сайхан байна.

Багш Ленин Сталины  
Баатар түмэн хувгүүдийн  
Баттай мандах үйлсийн  
Бадрал болсон Москва.

Шинжлэх их ухааны  
Шим нь болон дэлгэрч  
Шинэ мандсан ертөнцийн  
Зүрх болон цохилж байна.

Заавал ялах хүчтэй  
Зангидсан болд эгнээтэй  
Залуу цогтой Москва  
Залгах их хөгжлийн  
Наран болон мандаж байна

гэж (Ц. Цэдэнжав) магтан дуулцаагаадаг.

Манай орны хувь заяаны хэрэг бүхэн Зөвлөлт Москвагаар холбоотой юм. Манай хамтын ажиллагаа их найрамдлын асуудал тэнд нөөцлөгдөж байдаг. Манай хөгжлийн сайн сайхан бүхэн нь Москвагаас гарч байдаг.

Өрнөд, германы фашизмыг, дорнод, японы империалистүүдийг ялахад оролцсон Монголын ард түмний гавьяа анх түрүүн Москва, Кремлээс даян дэлхийд цууриатсан юм. Монгол Зөвлөлтийн эдийн засаг соёл боловсролын их найрамдал нь анх Москвад тогтоогджээ.

Нарлаг Монголын уудам нутгийн талбарт орших бага балчир, өвгөд настан бүгд Москва Сталин гэхдээ баярын магнай нь тэнийж их хань Зөвлөлт Москвад харшлах бүхнийг сонсохдоо уур хилэн нь бадарч байдаг.

Ерөөс Москвагийн энх амгалан байх асуудал манай эх орны энх сайн байх гэсэн хэрэг гэдгийг манай монголчууд нэг бүр сайн мэдэж байна.

Фашизмын аюул Зөвлөлт оронд тулгарч ирэх үес Монголын хөдөлмөрчид үнэнч нөхрийн халуун тусламжийг сэтгэл харамгүй үзүүлсэн бөгөөд түүний гавьяаг Москвагийн Кремльд нөхөр Сталин «нөхрийн үнэнч нь ядрах цагт танигдана» гэдэг үнэт үгээр унэлжээ.

Энэ бол манай хоёр улсын өнгөрсөн ба ирээдүйн их нөхөрлөлийн бэлэг дэмбэрэл болно.

Москва бол манай ард түмний цаашдын цэцэглэлт, ирээдүйн гэрэлт сайхан байдалд итгэхийн охь юм.

Энэ бол манай хоёр улсын их найрамдлын эх сурвалж мөн. Бадрангуй сайхан Москва улам бүр өрнөн дэлгэрч байх болтугай!

По очерку Б. Дашцэрэна.

**гагнагдсан** скрепленный, спаянный  
**албан ёсоор** официально  
**бүх үеийн** всех времен, всех эпох  
**олонт** много раз  
**сохор** слепой  
**алхыг харсан** дальновидный  
**баясгах** радовать  
**эрмэлзэлгээ (н)** стремление, желание, чаяние  
**нийгэм журам** социализм  
**бие хүч хайрлалгүй** не щадя своих сил  
**талархах** *эд.* благодарить; любить  
**өрнөгч** развивающийся, возрождающийся  
**өвчүүн** грудь  
**өнөр** многосемейный; многолюдный  
**бадрал** *эд.* расцвет, возрождение  
**зангидсан** сжатый; собранный  
**залгах** соединять; продолжать  
**хамтын ажиллагаа** совместная ра-

бота, сотрудничество  
**нөөцлөгдөх** храниться; накапливаться  
**даян дэлхий** весь мир  
**талбар** простор, пространство  
**бага балчир настан** дети, малолетние  
**баярын магнай тэнийх** радоваться; испытывать счастье  
**харшлах** относиться враждебно  
**уур хилэн(г)** зло, злоба, гнев  
**ерөөс** вообще  
**энх амгалан(г)** мир, спокойствие; благополучие  
**ядрах цаг** беда, трудный момент  
**танигдах** познаваться  
**үнэлэх** оценивать  
**бэлэг дэмбэрэл** *эд.* символ; хорошее предзнаменование  
**охь** знамение, символ  
**эх сурвалж** источник; начало

## 72 ДАЛАН ХОЁРДУГААР ХИЧЭЭЛ

### ЗӨВЛӨЛТ ХОЛБООТ УЛС БОЛ ЭНХ ТАЙВНЫ ТӨЛӨӨ ТЭМЦЛИЙГ МАНЛАЙЛЖ БАЙНА

Зөвлөлт Холбоот Улс бол энх тайван байдал ба улсуудын хоорондын найрамдлын харилцааг бэхжүүлэх бодлогыг гуйвалтгүй явуулж байна. Зөвлөлтийн баатарлаг ард түмэн бол Ленин-Сталины намын мэргэн удирдлагаар энх тайвны бүтээн байгуулах хөдөлмөрийг эрхлэж байна.

Зөвлөлт Холбоот Улс ба ардын ардчилсан улсууд бол эдийн засаг, соёлыг гуйвалтгүй өрнүүлж байгаа бол капитализмын орнууд нь эдийн засаг, улс төрийн эвлэршгүй зөрчилд улам их чөдөрлөгдөж байна. Зөвлөлт Холбоот Улс, иргэний аж үйлдвэрийг өрнүүлж, коммунизмын том барилгуудыг босгож байгаа юм бол Америкийн нэгдсэн улсаар толгойлуулсан империалист лагерь нь зэвсэгт хүчнийг нэмэгдүүлэн, цэргийн аж үйлдвэрийг өрнүүлж, зэвсэглэхийн хойноос галзууртлаа хөөцөлдөж байна.

Зөвлөлт Холбоот Улс бол энх тайвны эдийн засгийн хүчирхэг өрнөлтийн үндэс дээр аж үйлдвэрийн бараа ба хүнсний зүйлийн үнэ үргэлж хямдруулж, ажилчин албан хаагчдын цалин хөлсийг

нэмэгдүүлж хөдөлмөрчдийн аж амьдралын байдлыг цуцалтгүй сайжруулан дээшлүүлж байгаа бол капитализмын орнуудад дайны бэлтгэлийг галзууртлаа явуулж, иргэний үйлдвэрийг хорогдуулж, албан татварыг нэмэгдүүлж, олон түмний хэрэгцээний бараны үнийг эрс нэмэгдүүлж байгаагаас хөдөлмөрчдийн аж амьдралын байдал улам доройтож, ажилгүйчүүдийн арми тасралтгүй өсөж, өлсөж байгаа гуйланчин хүмүүсийн тоо улам нэмэгдэж байна. Дэлхий дахины шинэ дайны аюул занал их болсон үед энх тайвныг хамгаалах ард олон түмний идэвхтэй, шийдвэртэй тэмцэл бол энх тайвныг хамгаалахад шийдвэрлэх ач холбогдолтой юм.

«Хэрэв ард түмэн, энх тайвныг хамгаалах хэргийг гартаа авч, түүнийг туйлд нь хүртэл хамгаалбал энх тайван хамгаалагдаж батжина. Хэрэв дайн өдөөгчид нь ард олон түмнийг худал үгээр үймүүлэн, тэднийг мэхлэж, тэднийг дэлхий дахины шинэ дайнд оруулбал дайн зайлшгүй болж болно» гэж нөхөр Сталин сургаж байна.

Их Сталины үг бол улс түмний эрх чөлөө, энх тайван, аз жаргалын төлөө тэмцэж байгаа бүх давшилтат хүн төрөлхтөний ажлын программ мөн.

Зөвлөлт Холбоот Улсад ба ардын ардчилсан орнууд дахь энх тайвны талынхны хөдөлгөөн нь жинхэнэ ард нийтийн шинж чанартай өрнөж байгааг таван их гүрний хооронд энх тайвны гэрээ байгуулах тухай Энх тайвны Дэлхий дахины Зөвлөлийн уриалалд үсэг зурж байгаа ажил яруу тод гэрчилж байна. Мөн капиталист ба колонийн орнуудад энх тайвны талынхны хөдөлгөөн өдөр ирэх тутам өсөн хөгжиж, бэхжсээр байна. Энх тайвныг сахин бэхжүүлэхийн тул энх тайвны төлөө тэмцлийг идэвхтэй болгох гэсэн энх тайвны үзэл суртлыг дэлхий дахины олон түмэн улам бүр эзэмшиж, дайн өдөөгчдийн гэмт бодлогыг илрүүлэн устгах давагдашгүй хүчин болсоор байна.

Энх тайвны тугч нөхөр Сталинаар удирдуулсан хүчирхэг Зөвлөлт гүрэн, улс түмний эв найрамдал, энх тайвны төлөө тэмцлийг манлайлж байна. Зөвлөлт засгийн газар нь дайныг зайлуулж, энх тайвныг сахих бодлогыг хэлбийлтгүй явуулж байна. СССР-ийн ард түмэн, пролетарийн интернационализмын үзэл сурталд туйлын үнэнч бөгөөд энх тайвны талынхны хөдөлгөөнд идэвхтэй оролцон, яруу алдарт хөдөлмөрийн бүтээлээрээ дэлхий дахинд энх тайвны үйлсийг бэхжүүлж байна.

Энх тайван, ардчилал, социализмын хүч барагдашгүй их бөгөөд ялагдашгүй билээ. Эдгээр хүч өдөр ирэх тутам өсөн бэхжиж, империалист түрэмгийллийн хүчний эсрэг, шинэ дайн өдөөгчдийн эсрэг тэмцэлд шинэ шинэ ялалтыг хийсээр байна.

Коммунист нам ба манай суут багш жолоодогч нөхөр Сталыныг хүрээлэн нягтарсан Зөвлөлтийн ард түмэн, саруул сайхан ирээдүй өөд итгэлтэй давшиж байна.

По материалам «Үнэн», 1952.

найрамдал д<sup>р</sup>ужба; мир  
 бүтээн байгуулах созидать, созидательный  
 чөдөрлөгдөх быть стреноженным; опутываться  
 иргэний гражданский; мирный (о промышленности)  
 барилга з<sup>д</sup>. стройка  
 босгох з<sup>д</sup>. воздвигать  
 галзууртлаа хөөцөлдөх бешеная гошка  
 хүнсний зүйл продукты питания  
 доройтох ухуудшаться; снижаться  
 өлсөх голодать  
 туйлд нь хүртэл до конца  
 батжих укрепляться  
 худал үг ложь  
 үймүүлэх вызвать панику, суматоху; опутать  
 мэхлэх обмануть  
 зайлшгүй неизбежно; неизбежный

аз жаргал счастье  
 талынхан з<sup>д</sup>. сторонники  
 шинж чанар признак и качество  
 уриалал призыв  
 үсэг зурах подписаться, расписаться  
 яруу тод прекрасно, ясно  
 гэрчлэх свидетельствовать, подтверждать  
 сахих з<sup>д</sup>. защищать, отстаивать  
 дайн өдөөгчид поджигатели войны  
 гэмт преступный  
 давагдашгүй непреоборимый  
 тугч знаменосец  
 зайлуулах предотвратить, устранить  
 хэлбийлтгүй без колебания  
 барагдашгүй неисчерпаемый  
 түрэмгийлэл агрессия  
 хүрээлэн нягтарсан сплоченный во-  
 круг  
 итгэлтэй уверенно

## 73 ДАЛАН ГУРАВДУГААР ХИЧЭЭЛ

### ЭНХ ТАЙВНЫ ИХ ЦУУРИА

Өвгөн Дорж, багийн цуглаанд очихоор яарч морио ташуурдан, нарийн зөрөг замаар хатруулсаар, Цагаан толгойн хөтлийг давав.

Хаваржаан дээрээ саяхан буусан гурван гэр, нэгэн хот айлын бараа, хаврын зэргэлгээн дунд бүрэлзэн харагдана. Ойртон иртэл, гэрүүдийн гадуур саяхан гарсан хурга ишиг билчиж шинэ ургаж байгаа зулзаган ногоотой хөөцөлдөн бужигнаж байв. Зарим гэрийн тооноор үл мэдэг цэнхэр утаа суунаглан, зарим нь үүдээ гэр дээрээ тавьсан нь хаврын дулаан өдөр үнэхээр зохистой харагдана. Баруун урд талын том цагаан гэрийн гадаа олон хүн бөөгнөрөн сууж, цуглаан эхлэхэд бэлхэн болсон бололтой. Өвгөн Дорж морины жолоог салж, багийн дарга Лхагваагийн гэрийн гадаа ирж буугаад, морио уяад, шууд цуглаан дээр ирэв. Цугларагсад өвгөн Доржийг хүндэтгэн мэндчилж, гол дундаа зассан хүрэн цэмбэн бүтээлгэтэй ширээний дэргэд урьж суулгав.

Багийн дарга Лхагваа, энх тайвны талынхны ардын цуглааныг нээж:

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Бага Хурлын тэргүүлэгч-дээс дэлхий дахины энх тайвны талынхны их хурлын байнгын хорооны анхаарлын тухай гаргасан тунхгийг тайлбарлаж Монголын ард түмэн, Зөвлөлт Холбоот Улсаар толгойлуулсан энх тайвны талынхны нэгдмэл лагерьт гуйвалтгүй зогсож байгаагаа зориг төгөлдрөөр илэрхийлж, баяр хүргэв.

Өвгөн Дорж:

— Багийн даргаа! Би үг хэлж болох уу? гэж зөвшөөрөл аваад, холоойгоо засаж, шингэн буурал сахлаа илэн байж хэлсэн нь:

«Би бол Монголын тал нутгийн жирийн малчин өвгөн юм. Би үргэлж, энх тайван, дайн дажингүй байгаасай гэж хүсдэг. Би дал гаруй нас наслахдаа манж автономитын үеийн гашуун зовлонг биеэр эдэлж урсах нулимсаа барсан хүн! гагцхүү ардын хувьсгалын ачаар гэр оронтой, эхнэр хүүхэдтэй, мал хөрөнгөтэй болж жаргал минь эхэлсэн юм. Би бол тарваган тахал, дээрмийн дайн хоёрыг үнэхээр жигшдэг юм. Нарт ертөнц дээр дайн, тахал шиг аюултай заналтай юм байхгүй. Одоо дайныг дэгдээгч махинууд дайн, тахал хоёроор түг түмэн хүний мах цусыг сорох гэж бэлтгэж байна. Бидэнд айхыг мэдэхгүй сэтгэл зориг, ялж дийлэх нэгдмэл хүч бүрэн байна. Бид, үр хүүхэд, хойч үедээ итгэдэг учраас энх тайвныг хамгаалж чадна. Дайн тахал хоёрыг дэгдээгч бүхэн алтан дэлхийн ариун хөрснөөс тонилтугай! гэж энх тал нутгаасаа өвгөн би хараая! Над шиг ингэж харааж байгаа хэдэн буман хүний хараал дайн өдөөгчдийн тархийг хага ниргэх нь лавтай гэж өндөр дуугаар хэлбэ. Миний үг түмний газар түгж, энх тайвныг хүсэгч мянга мянган хүний чихэнд сонсогдох болтугай!» гэж улам чанга дуугаар хашгиран хэлж дуусаад атираа суусан хүрэн бор нүүрийнхээ хөлсийг арчив. Өвгөн Доржийн өндөр дуугаар хэлсэн үг хуралдагчдын сэтгэлийг хөдөлгөж сүртэй алга ташилтаар угтав.

\* \* \*

Өвгөн Доржийн хилэн бадарсан омогт үг дэлхийн бөмбөрцгийн энтээ өнцөг дахь Монголын тал нутгаас тэртээ талын олон оронд түгж энх тайвныг хамгаалагч сая сая хүний чихэнд цууриатаж, дайн өдөөгчдийн зүрхийг чичрүүлэх ёстой.

Энэ бол энх тайвныг хамгаалагч орон бүхний шударга хүмүүсийн чин сэтгэлийн үг, энх тайвныг сахигч монголын эрэгтэй, эмэгтэй жирийн ард бүхний үг, дайныг өдөөгчдийн зүрхийг шархлуулах уур хилэнгийн хурц илд нь юм. Өвгөн Доржийн үзэн яддаг дайн, тахал хоёр бол энгийн нэг тохиолдлын занал биш, энэ зовлонг нуруундаа үүрч, нүдээрээ үзэж, халуун нулимсаараа бүрхүүлэн өнгөрүүлсэн занал юм.

(Төгсөөдүй)

цуглаан собрание, митинг  
 ташуурдах подхлестывать кнутом  
 зөрөг [зам] тропа, тропинка  
 хаваржаан весеннее стойбище, весенник  
 бүрэлзэх мерещиться; еле казаться  
 ишиг козленок  
 зулзаган ногоо(н) молодые побеги, молодая трава  
 суунаглах виться, тянуться  
 баруун урд юго-запад  
 бөөгнөрөх собраться, концентрироваться  
 нэгдмэл объединенный; сплоченный  
 шингэн жидкий; редкий  
 дайн дажин война  
 манж маньчжурский  
 гэр орон жилище, кров  
 тарваган тахал чума  
 дээрмийн грабительский, разбойничий  
 жигших ненавидеть; чувствовать отвращение  
 нарт солнечный  
 аюултай заналтай опасный, угрожающий

дэгдээгч эд. поджигатель, зачинщик  
 махчин эд. людоед  
 сорох высасывать  
 айхыг мэдэхгүй бесстрашный; не боящийся  
 хойч үе грядущие поколения  
 тонилтугай долой; пусть провалится  
 хараах ругать, проклинать  
 бум(ан) сто тысяч  
 хага ниргэх разбить, рассечь  
 өндөр дуугаар громко, торжественно  
 түгэх распространиться  
 атираа суусан морщинистый  
 хилэн бадарсан гневный  
 омогт гордый  
 энтээ өнцөг этот угол; эта сторона  
 чичрүүлэх заставить содрогнуться  
 сахигч блюститель; стоящий на страже  
 шархлуулах ранить, поразить  
 илд меч  
 үзэн ядах ненавидеть  
 тохиолдлын случайный  
 бүрхүүлэх покрыть

## 74 ДАЛАН ДӨРӨВДҮГЭЭР ХИЧЭЭЛ

### ЭНХ ТАЙВНЫ ИХ ЦУУРИА

(Төгсгөл)

Өвгөн Дорж энэ үгийг хэлж байхдаа дөчөөд жилийн өмнө аюулт тарваган тахлаар үхүүлсэн ачлалт аав, ээжээ санаж байгаа биз. Японы империализмийн довтолгооныг эсэргүүцсэн ариун дайнд амь үрэгдсэн ганц хүүгээ санаж байгаа биз. Гитлерийн дээрэмчид Зөвлөлтийн ард түмнийг алан талж, олон мянган хүүхдийг амьдаар газарт булж, хэдэн өдөр тасралтгүй шороо нь оволзож байсныг бодож байгаа биз. Би та нарт, өвгөн Доржийн дайн, тахал хоёрыг үнэн сэтгэлээсээ жигшдэг болсон явдлыг хэлж өгье.

Автомомит засгийн үед Дорж, хушууны ноёны тушаалаар худалдаачны хонийг явган тууж хүргээд, хэдэн сарын дараа аав, ээждээ эргэж ирэхэд нь хайртай төрсөн аав, ээж, охин дүү гурав нь аюулт тарваган тахлаар үхэж үрэгдээд, гэр нь түлэгдэж харлаад, хийсэх үнс ч үгүй болсон байжээ.

Хайртай аав нь босгоо дэрлээд, энхрий ээж нь охиноо тэвэрсэн хэвээрээ үхсэн юм гэж түүний сонссон нь өвгөн Доржийн

сэтгэлээс үүрд хагацдаггүй, үе үе харагдаж байдаг бизээ. Өвгөн Дорж бол цорын ганц хүүтэй байсан хүн юм. Хүний ганц хүү эцэгдээ наран саран болдог шүү дээ. Доржийн хүү үнэхээр нар сарны адил цогтой зоригтой хүүхэд байсан юм. Өвгөн эмгэн хоёр, хүүгээ цэрэгт мордоход нь ганц хүүгээсээ салав гэж бодох ч байтугай! «төрсөн нутаг, заяасан жаргалаа хамгаалахаас эрхэм хувь заяа байхгүй» гэж хэлээд баруун хацры нь үнсээд, зүүн хацры нь ирэхэд нь үнсье гэж хэлж байсан юм. Ингэж бодож байсан эцэг эх хоёр, хайртай хүүтэйгээ хэзээ ч хамт байна гэж бодож байсан байх ёстой.

Хамт байх ч ёстой байсан юм. Эцэг, үрийн энх тайвнаар хамт жаргахад гагцхүү Японы империализмийн дайн саад хийсэн юм. Доржийн хүү эх орноо хамгаалах шударгуу хэргийн төлөө Халхын голын байлдаанд орж, дайсны бөөн хүчтэй тулгарч цусныхаа эцсийн дуслыг дуустал дайсныг сөнөөн дараад, эх оронч баатрын ёсоор нас барсан юм. Доржийн хүү хэдий нас барсан боловч, эцэг эх, ард түмнээсээ үүрд хагацаагүй юм. Энхрий хайрт эцэг эхтэйгээ эрэлхэг баатрын ариун алдраар уулзсан юм. Өвгөн эмгэн хоёр нэг өдөр хүүгээсээ захидал авч, урьд удаагийн жирийн захидал шиг хэнэггүй задлахад, Монгол улсын алтан сүлд гялалзсан хүндэт улаан үнэмлэх гарсан юм.

Тэр үнэмлэхийн эхний хуудсыг нээж, баатар хүүгийнхээ гэрэлт гэгээн дүрийг үзэж, зүүн хацры нь үнссэн юм. Энэ баатар хүү, эцэг эх, ард түмэндээ үүрд амьд хэвээрээ харагдаж байгаа юм. Ингэж хүүтэйгээ уулзсан эцэг эх хоёр, алан хядагч дайныг үзэн яддаггүй байж яаж чадах билээ! Үнэхээр жигшин үзэж, хорсон занатай байх ёстой. Хорсон занхаар ч барахгүй, хэрэгтэй цаг тохиолдвол, амиа солилцохоос айхгүй ган болд хатан зориг зангирсан байх ёстой юм.

Энэ занал бол ганцхан тал нутгийн малчин өвгөн эмгэн хоёрт тохиолдсон биш, газар бүрийн жирийн олон мянган хүнд тохиолдсон юм. Энэ заналыг гитлерийн фашистын цусан гартай хүний махчинуудад үр хүүхдээ булуулж, эцэг эх, ураг садангаа дүүжлүүлсэн түг түмэн ардууд цөм өвөртөлж байгаа юм.

Одоо Англи, Америкийн цуст дайны балчгийг биедээ үүрч шаналан зовж байгаа Индонези, Вьетнамын зэрэг орны хэдэн зуун, мянган ард түмэн цөм занаж байгаа юм. Дэлхийн бөмбөргийн өнцөг булан бүрд оршиж байгаа энх тайвныг хүсэгч олон зуун мянган сая хүн, дайн өдөөгчдийг занацгааж «атомын бөмбөгийг цаазал! Цэргийн зэвсэглэлийг хорогдуул! Шударга хүн бүхэн энх тайвны талд байна!» гэж нэгэн зэрэг хашгирч байгаа өндөр дуу нь таван тив, дөрвөн далайн дээгүүр цууриатаж байна.

Энх тайвны их цуриа дайныг өдөөгчдийн нөжирсөн зүрхэнд жад болон тусаж байна.

Энэ их цуурианы нэг нь багийнхаа ардын энх тайвныг хамгаалагчдын цуглаан дээр хэлж байгаа малчин өвгөн Доржийн үг юм.

Өвгөн Доржийн энэ үгийг, багийн цуглааны эрэгтэй, эмэгтэй ард бүхэн цөм дэмжиж «бүгдээрээ энх тайвны төлөө!» гэж нэгэн зэрэг гараа өргөцгөөж, энх тайвныг хамгаалагчдын хуудсанд үсгээ зурцгааж байна. Гарын үсэг зурахад далан гурван настай өвгөн Дорж хамгийн түрүүн «Би, дайныг үзэн ядна» гээд үсгээ зурав.

По рассказу П. Хорло.

### С л о в а

довтолгоон нападение  
ачлалт благодетельный, дорогой  
амь үрэгдэх погибнуть, умирать  
дээрэмдэх [о]грабить  
алах талах убивать, истреблять  
булах зарыть  
оволзох шевелиться, двигаться вверх и вниз  
төрсөн *зд.* родной  
охин дүү младшая сестра  
түлэгдэх сгореть; быть сожженным  
харлах чернеть  
дэрлэх положить голову на...  
цорын ганц единственный  
заяах предопределять, предвещать;  
быть достигнутым, быть данным  
шударгуу хэрэг правое дело; про-  
грессивное дело  
тулгарах встретиться, войти в со-  
прикосновение  
дусал капля  
хэнэггүй *зд.* спокойно, благодушно  
үнэмлэх удостоверить; удостоверение,  
грамота, документ

амьд живой  
алан хядагч палач  
жигшин үзэх ненавидеть  
хорсон занах гневно протестовать  
амиа солилцохоос айхгүй не ша-  
дить своей жизни, не бояться смерти  
ган болд стальной; сталь  
хатан зориг стальная воля, твердая  
воля  
зангирсан собранный, концентриро-  
ванный  
ураг садан(г) родня  
дүүжлүүлэх быть повешенным  
өвөртлөх положить за пазуху; хра-  
нить за пазухой  
балчиг ужасы; бедствия  
шаналан зовох страдать  
бөмбөг бомба  
цаазлах *зд.* запрещать  
тив часть света  
нөжрөх свернуться, сгуститься (о  
*крови*)  
жад штык

## 75 ДАЛАН ТАВДУГААР ХИЧЭЭЛ

---

КОММУНИСТ НАМ БОЛ, ЛЕНИНИЙ ЗАМААР,  
ТҮҮНИЙ ҮНЭНЧ ШАВЬ АГУУ ИХ СТАЛИНЫ МЭРГЭН  
ЖОЛООДЛОГООР ЗЭВЛЭЛТИЙН АРД ТҮМНИЙГ  
КОММУНИЗМ ӨӨД АМЖИЛТТАЙ УДИРДАЖ БАЙНА

Ленин, Сталин нар бол Зөвлөлтийн ард түмнийг удирдан жолоодогч хүчин болсон СССР-ийн Коммунист Намыг үндэслэн байгуулагч бөгөөд жолоодогч нар мөн. Тэд Коммунист намыг байгуулсан бөгөөд түүнийг хамгийн тэргүүний хувьсгалт онолоор зэвсэглэж, программ, тактик ба зохион байгуулалты нь

үндсийг боловсруулан түүний боловсон хүчнийг өсгөн хүмүүжүүлж, тэмцэл ба үйл ажиллагааг нь шууд удирдсан юм.

Ленин, Сталин нарын суут жолоодлогын дор Коммунист нам, тэмцэл ба ялалтын их замыг туулжээ. Түүний мэргэн удирдлагын дор Оросын ажилчин анги, ядуу тариачидтай холбоотой явж, 1917 оны Октябрь сард помещик капиталистуудын засгийг унагаагаад, өөрийн засгийг тогтоосон билээ. Коммунист нам нь СССР-т социализмын ялалтыг зохион байгуулж Зөвлөлт орныг хүчирхэг социалист гүрэн болгон хувиргах явдлыг хангасан юм. Коммунист нам нь эх орны дайны үед герман фашистын эзэрхэгчдийн эсрэг бүх ард түмний тэмцлийг зоригжуулан зохион байгуулж, фашизмыг ялах ялалтыг хангажээ.

Дайны дараахь энх байгууллын үед Зөвлөлтийн ард түмэн нь Ленин — Сталин нарын үндэслэн байгуулсан Коммунист намын удирдлагын дор өөрийн орныг сэргээн босгож хөгжүүлэх зорилтыг амжилттай биелүүлэн коммунизмын туяат оргил өөд итгэлтэйгээр давшиж байна.

\* \* \*

Коммунист намыг зохион байгуулж жолоодогч Ленин, Сталин нар хувьсгалт тэмцлийн замд эрт оржээ. Тэд бүр залуу насандаа хаант оросын нийгэмлэг, улс төрийн байгууллагатай эвлэршгүй тэмцэж байсан бөгөөд марксизмын тугийн дор тэмцэх хувьсгалт тэмцлийн замыг ухамсартайгаар сонгон авсан юм.

Маркс-Энгельсийн сургаалын учрыг Ленин Сталин хоёр шиг гүн гүнзгийгээр хэн ч ойлгоогүй юм. Гэвч тэд марксизмын үг үсгийн боол нь хэзээ ч болж байгаагүй. Коммунист намын жолоодогч Ленин, Сталин нар бол шинжлэх ухааны жинхэнэ тэргүүлэгчдийн ёсоор, хуучирсан хуучин баримтлалуудыг дээд шинэ байдалд тохирсон шинэ баримтлалуудаар эрс зоригтой сольж байсан юм.

Ленин, Сталин нар бол бусад ангийн улс төрийн зүтгэлтнээс эрс өөр бөгөөд хамгийн эрэлхэг, хамгийн тууштай, шинийг бүтээгчид юм. Тэд Коммунист намыг Оросын хувьсгалт хөдөлгөөнд байгаагүй шинэ замаар итгэлтэй удирдаж, түүнийг дэлхий дахины нэн тэргүүний социалист төрийг удирдаж байгаа нам болгон хувиргасан байна.

\* \* \*

Ленин, Сталин нарын агуу их гавьяаны нэг нь юунд орших вэ? гэвэл тэд жирийн нэг социал демократ намыг бус, харин шинэ байдалд пролетари нарын өмнө тулгарсан асар их зорилгыг шийдвэрлэж чадах шинэ маягийн намыг байгуулсанд оршино. Хаант засгийг довтлох ба ажилчин ангийн диктатурыг байлдан олоход пролетари нарыг толгойлон удирдаж чадах шинэ маягийн хувьсгалт дайчин намыг Орос оронд байгуулах хэрэгтэй гэж Ленин, Сталин нар зааж байв.

Ленин, Сталин нар, Большевик намыг харгис бүх хүчин ба тэдний төлөөлөгчдийн эсрэг хатуу ширүүн тулалдааны дундуур байгуулсан юм. «Бүх Холбоотын Коммунист (большевикуудын) намын түүхийн суралцах товч дэвтэр»-ийн оршилд үгүүлэхдээ тус нам нь «Ажилчны хөдөлгөөн дотрох эсэр (тэдний өмнөх народникууд) меньшевик, анархист, баруунтны өнгө бүрийн үндсэний үзэлтэн зэрэг жижиг буржуйлэг намууд, түүнчлэн тус намын дотоодод меньшевикийн оппортунист урсгал, Троцкий ба Бухарины этгээд, үндсэний хэлбэрэгчид, Лениний эсрэг бусад бүлгүүдтэй тэмцсэн гол зарчимт тэмцэлд хөгжин батжив» гэжээ. (6 дахь тал)

Намыг байгуулах үед ч, засгийн эрхийн төлөө тэмцэх үед ч, социализмын ялалтын төлөө тэмцлийн жилүүдэд ч гэсэн, оппортунист ба өнгө бүрийн эвсэгчдийг цуцалтгүй илрүүлэн цохисоор иржээ. Элдэв зүсмийн оппортунистүүдийн эсрэг явуулсан эвлэршгүй тэмцэл нь намын нэгдлийг тогтоон, түүний хүч чадлыг бэхжүүлж ялалтыг хангасан билээ.

(Төгсгөдүй)

### С л о в а

**шавь** ученик  
**туулах** проходить; преодолевать  
**ядуу** бедный, маломощный  
**унагаах** свергать, низвергать; свалить, уронить  
**эзэрхэгчид** захватчики  
**энх байгуулал** мирное строительство  
**сэргээн босгох** восстановить  
**туяат** сверкающий, сияющий  
**оргил** вершина  
**хаант** царский; ханский  
**эвлэршгүй** непримиримый  
**ухамсартайгаар** сознательно  
**гүнзгий** глубокий  
**боол** раб  
**тэргүүлэгчид** эд. лидеры, руководители  
**хуучирсан** устаревший  
**баримтлал** учение; положение  
**солих** заменить  
**тохирсон** подходящий, соответствующий

**дээд** высший, верховный  
**зүтгэлтэн** деятель  
**жирийн** обычный; простой  
**тулгарах** вплотную встать  
**толгойлох** возглавлять, руководить  
**харгис** реакционный; лютый  
**дундуур** в обстановке; через, сквозь  
**баруунтан** правые  
**үгүүлэх** говорить  
**үндсэний үзэлтэн** националисты  
**жижиг буржуйлэг** мелко-буржуазный; мелкая буржуазия  
**урсгал** течение  
**этгээд** элементы; приспешники  
**хэлбэрэгчид** уклонисты  
**зарчимт** принципиальный  
**эвсэгчид** соглашатели  
**илрүүлэх** разоблачить  
**зүсэм** масть  
**өнгө бүрийн** разный; разноцветный

КОММУНИСТ НАМ БОЛ, ЛЕНИНИЙ ЗАМААР,  
ТҮҮНИЙ ҮНЭНЧ ШАВЬ АГУУ ИХ СТАЛИНЫ МЭРГЭН  
ЖОЛООДЛОГООР ЗӨВЛӨЛТИЙН АРД ТҮМНИЙГ  
КОММУНИЗМ ӨӨД АМЖИЛТТАЙ УДИРДАЖ БАЙНА

*(Өмнөхийн үргэлжлэл)*

Биеэ даасан нам болон бүрэлдэхийн тул большевикууд шиг нарийн нягт бэлтгэгдсэн улс төрийн бүлэг нэгхэн ч гүй. Большевик намыг бэлтгэх энэ ажилд Ленин, Сталин нарын гайхамшигт зохиолууд «Юу хийх вэ?», «Алхам урагшаа хоёр алхам хойш», «Анархизм буюу социализм» зэрэг зохиолууд болон «Искра», «Брззола» зэрэг сонинууд шийдвэрлэх ролийг гүйцэтгэсэн юм. Ленин, Сталин нар бол Коммунист намыг байгуулах бэлтгэлийг хийсэн төдийгүй, харин түүнийг шууд гардан зохиож байгуулсан хүмүүс юм.

1901 оноос эхлэн Грузид социал-демократын «Брззола» (Тэмцэл) гэдэг анхдугаар нууц сонин нөхөр Сталины санаачлагаар гарах болсон бөгөөд энэ сонин, Лениний «Искра» — ийн үзэл санааг тууштай баримтлан явуулж байв.

Энэ үед Ленин, Сталин нарын бүх үйл ажиллагаа нь ажилчин ангийн хувьсгалт дайчин намыг байгуулах нэгэн зорилгод чиглэгдсэн байв. Ийм намыг байгуулахын төлөө Ленин, Оросын ажилчны социал-демократ намын 2 дугаар их хурал дээр онц шургуу тэмцлийг явуулсан юм.

Оросын ажилчны социал-демократ намын 2 дугаар их хурал дээр хувьсгалт марксизм ба оппортунизм хоёр үнэндээ тусгаарлан салж, үндсэн бүх асуудлын талаар большевик, меньшевик хоёрын стратеги тактик нь эрс эсрэг тэсрэг байжээ.

Нөхөр Сталин, энэ үед Батумын гянданд байсан бөгөөд большевик, меньшевик хоёрын зөрөлдөөний тухай сонсмогц Лениний шугамыг баримтлагч большевикуудын талд эрс шийдвэртэй бөгөөд буцалт няцалтгүй зогссон юм. Оросын ажилчны социал-демократ намын 2 дугаар их хурлын дараа большевик, меньшевик хоёрын тэмцэл намхарсангүй, харин улам хурцаджээ.

1905 онд эхэлсэн Оросын анхдугаар хувьсгал бол Большевик намыг байгуулан бэхжүүлэх Ленин, Сталины зохион байгуулагч үйл хэргийг улам хүчтэй болгосон юм. Тэд большевикуудын хувьсгалт бүхий л ажлыг удирдан ажилчин ангийг зэвсэглүүлэх, тэднийг цэргийн хэрэгт сурган, хаант засгийн эсрэг бослогод бэлтгэх ажлыг шургуугаар удирдан явуулж байв.

Ленин, Сталин нар 1905 оны 12 дугаар сард Таммерфорст хуралдсан Бүх Оросын большевикуудын анхдугаар бага хурал дээр анх удаа биеэр уулзжээ.

1905 оны 12 дугаар сарын бослого дарагдсаны дараа намыг сахин хамгаалж бэхжүүлэх явдал улам нарийн бэрхтэй болсон, харгислалын довтолгоо чангарч, меньшевикууд, намыг устгах гэж илээр хөдлөх болжээ. Тулгарсан аюулын өмнө сандрахгүй байж, өөрийн хэргийн үнэнийг ухамсарласны үндсэн дээр ялалтдаа итгэх явдал бол большевикуудын онцлог чанарын нэг нь болсон бөгөөд элдэв бэрхшээлийг давах, хөдөлмөрчдийн зоригийг бадруулж байсан юм. Хувьсгалт шинэ өрнөлтийн өмнө, большевикуудын гол зорилго бол меньшевикуудээс бүрмөсөн салж тэднийг намаас хөөх явдал мөн гэж Ленин, Сталин нар үзэж байв. 1912 оны 1 дүгээр сард Прага хотноо Оросын ажилчны социал демократ намын бага хурал хуралдсан бөгөөд тус хурал нь меньшевикуудийг намаас хөөж шинэ маягийн нам, Большевикуудын намын эхийг тавьсан билээ.

Прагын бага хурлаас Ленин тэргүүнтэй Большевик намын Төв Хороог сонгожээ. Энэ үед нөхөр Сталин, цөлөлгөнд байсан боловч Лениний саналаар түүнийг төв хорооны гишүүнд сонгож Орос орон дахь намын бүх ажлыг удирдах жинхэнэ төв болсон Төв Хорооны Оросын товчоог толгойлуулсан билээ.

Бүх Холбоотын коммунист (большевикуудын) намын анхдугаар шат ингэж төгссөн юм. Энэ шатны гол утга нь орос орноо Большевик намыг байгуулахын төлөө Ленин, Сталины тэмцэлд оршино. Ийнхүү удаа дараа гагцхүү Орос орноо оппортунистүүдээс цэвэрлэгдсэн бөгөөд олон түмнийг засгийн төлөө тэмцэлд удирдаж чадах нам социалист хувьсгал ялахаас аль өмнө бүрэлдэн тогтсон билээ. Энэ намыг үндэслэн байгуулагчид нь Ленин, Сталин нар байв.

(Төгсөөдүй)

### С л о в а

**биеэ даасан** самостоятельный  
**бүрэлдэх** оформиться  
**нарийн нягт** тщательно  
**төдийгүй** не только  
**гардах эд.** лично работать  
**нууц нелегальный;** секретный  
**баримтлах** придерживаться  
**чиглэгдэх** быть направленным, нацеленным  
**шургуу** упорный  
**тусгаарлан салах** разделиться, отделиться  
**эсрэг тэсрэг** непримиримый; несоместимый  
**гяндан** тюрьма  
**зөрөлдөө(н)** противоречие, расхождение  
**шугам** линия  
**буцалт няцалтгүй** бесповоротно, неуклонно  
**намхрах** утихать, успокаиваться  
**хурцдах** обостряться

**цэргийн хэрэг** военное дело  
**бослого** восстание  
**биеэр** лично  
**анх удаа** впервые  
**сахин хамгаалах** сохранить  
**бэрхтэй** тяжело; тяжелый  
**чангарах** усиливаться  
**илээр** открыто  
**сандрахгүй** не растеряться  
**онцлог чанар** особое качество  
**бэрхшээл** трудность  
**давах** преодолеть; перевалить  
**өрнөлт** подъем, рост  
**хөөх** изгнать; исключить  
**тэргүүнтэй** во главе  
**цөлөлгө(н)** ссылка  
**товчоо(н)** бюро  
**цэвэрлэгдсэн** очищен; проведена  
**чистка**  
**аль өмнө** задолго  
**бүрэлдэн тогтох** зародиться

КОММУНИСТ НАМ БОЛ, ЛЕНИНИЙ ЗАМААР  
ТҮҮНИЙ ҮНЭНЧ ШАВЬ АГУУ ИХ СТАЛИНЫ МЭРГЭН  
ЖОЛООДЛОГООР ЗӨВЛӨЛТИЙН АРД ТҮМНИЙГ  
КОММУНИЗМ ӨӨД АМЖИЛТТАЙ УДИРДАЖ БАЙНА

*(Өмнөхийн үргэлжлэл)*

Большевикуудыг биеэ даасан намд зохион байгуулсны дараа Ленин — Сталин нар түүнийг бэхжүүлэх хэрэгт бүх хүч чадлаа дайчилсан юм. Шинээр байгуулагдсан намын үндсэн зорилго бол хаант засаг, хөрөнгөтнийг түлхэн унагаах, улс төрийн засгийн эрхийг байлдан олох, социалист нийгмийг байгуулах зорилго бүхий пролетари нарын ангийн тэмцлийг зохион байгуулах явдал мөн гэж тэд сургаж байлаа.

Хувьсгалт шинэ өрнөлтийн жилүүдэд Ленин, Сталин нар ил, далд ажлыг хослуулах, намын нууц байгууллагыг бэхжүүлэх ба ажилчин ангитай түүний холбоог өргөтгөн бататгахын төлөө тэмцэлд өөрсдийн бүх үйл ажиллагааг захируулж байлаа. Империалист нэгдүгээр дайны үед Ленин — Сталин нар т хэдий асар их бэрхшээл аюул тохиолдож байсан боловч, Большевик намыг улам эрчимтэй удирдсаар байжээ. Энэ үед Ленин — Сталины бүх үйл ажиллагаа нь хаант засгийг түлхэн унагаах ба социалист хувьсгалын төлөө тулалдахад ажилчин анги хийгээд түүний намыг үзэл суртал, улс төр, зохион байгуулалтын талаар бэлтгэхэд чиглэгдэж байв.

Социалист хувьсгалд ийнхүү бэлтгэх явдалд дайны үед Лениний бичсэн онолын зохиолууд онц их ролийг гүйцэтгэжээ. 1916 оны 6 дугаар сард Ленин «Империализм бол капитализмын дээд шат мөн» гэдэг алдарт зохиолоо бичиж дуусгасан бөгөөд энэ зохиолдоо, империализм бол ялзарч байгаа капитализм юм гэдэг бүрэн төгс дүн шинжилгээг гаргажээ. Империализмийн тухай Лениний энэ зохиол бол Марксын эдийн засгийн сургаалын хөгжилтөд шинэ алхам нь болсон бөгөөд марксист онолыг шинэ агуулгаар баяжуулан пролетарийн хувьсгалын чухал чухал асуудлыг шинээр шийдвэрлэхэд тусалсан билээ.

1917 оны 4 дүгээр сарын 3 (16)-д Ленин гадаадаас Петроград дад буцаж ирээд, ирснийхээ маргааш нь алдарт «4 дүгээр сарын сэдвүүд» — дээ, хөрөнгөтний ардчилсан хувьсгалаас социалист хувьсгалд шилжин орохын төлөө тэмцэлд суут төлөвлөгөөг Большевик нам ба ажилчин ангид гаргаж өгөв. Ленин, энэхүү сэдвийг гаргаснаар марксист шинжлэх ухаанд шинэ замыг тавьж Орос орноо парламентат бүгд найрамдах улсыг бус, харин зөвлөлүүдийн бүгд найрамдах улсыг байгуулах зорилгыг тавьжээ. Энэ шаард-

лага бол марксизмын онол, практикийн хөгжилтөд сүрхий алхам болсон юм. Ленинээс зөвлөлүүдийг пролетарийн диктатурын төрийн хэлбэр гэж нээсний ачаар Оросын ажилчин анги агуу их ялалтыг байгуулсан бөгөөд марксист онол шинэ агуулгаар баяжиж большевикуудын намын алдар хүнд улам нэмэгдсэн билээ.

1917 оны 2 дугаар сарын хөрөнгөтний ардчилсан хувьсгалын дараахь Орос орны онц нарийн бэрхтэй үед гагцхүү Ленин — Стазины жолоодсон большевикуудын нам нь бэрхшээлээс айлгүйгээр ажилчин ангийг засгийн төлөө тэмцэлд итгэл зоригтойгоор удирджээ. Ленин-Сталин нар бол капитализмыг довтолох их довтолгоонд Большевик нам ба ажилчин ангийг хатуу итгэлтэйгээр хөтлөн удирдаж, 1917 оны Октябрь сарын түүхт өдрүүдэд зэвсэгт бослогыг биеэр удирдан пролетарийн диктатурыг байлдан олох явдлыг шууд хангасан билээ.

Ленин — Сталины жолоодлого бол 1917 оны Октябрь сард Оросын пролетари нарын дэлхий дахины түүхт ялалтыг хангасан чухал нөхцөлүүдийн нэг нь мөн.

\* \* \*

Ленин — Сталин нар, пролетарийн диктатурыг тогтоосны дараа Зөвлөлт оронд социализмыг байгуулахын төлөө Зөвлөлт орныг хүчирхэг социалист гүрэн болгохын төлөө Большевик намын тэмцлийг удирдсан юм. Хүн төрөлхтний түүхэнд социализмыг байгуулсан туршлага байсангүй.

Их Ленин, «Зөвлөлт Засгийн ээлжит зорилго» гэдэг зохиолдоо, социалист байгуулалд шилжин орох төлөвлөгөөг боловсруулан гаргажээ. Гэтэл энэ төлөвлөгөөг биелүүлэх явдалд гадаадын цэргийн цөмрөлт, иргэний дайн саад болов.

(Төгсөөдүй)

### С л о в а

**асгийн эрх** власть  
**ангийн тэмцэл** классовая борьба  
**ил легальный;** открытый  
**далд нелегальный;** скрытый  
**хослуулах** сочетать  
**захируулах** подчинить  
**бататгах** укрепить  
**эрчимтэй** энергично; энергичный  
**үйл ажиллагаа(н)** деятельность  
**ялзрах гниль,** загнивать  
**бүрэн төгс** полный; исчерпывающий  
**дүн шинжилгээ(н)** вывод  
**хөгжилт** развитие  
**агуулга** содержание  
**шинээр** по-новому

**сэдвүүд тезисы**  
**шилжин орох** перерастать, переходить  
**зөвлөл совет**  
**шаардлага** требование  
**хэлбэр форма**  
**алдар хүнд авторитет**  
**айлгүйгээр** не боясь; без страха  
**зэвсэгт** вооруженный  
**дэлхий дахины** мировой  
**ээлжит** очередной  
**цэргийн цөмрөлт** военная интервенция  
**иргэний дайн** гражданская война.

КОММУНИСТ НАМ БОЛ, ЛЕНИНИЙ ЗАМААР,  
ТҮҮНИЙ ҮНЭНЧ ШАВЬ АГУУ ИХ СТАЛИНЫ МЭРГЭН  
ЖОЛООДЛОГООР ЗӨВЛӨЛТИЙН АРД ТҮМНИЙГ  
КОММУНИЗМ ӨӨД АМЖИЛТТАЙ УДИРДАЖ БАЙНА

*(Өмнөхийн үргэлжлэл)*

Ленин, Сталин нараар удирдуулсан Большевик нам, ард түмнийг 1918—1920 оны иргэний дайнд босгож, гадаадын цэргийн цөмрөлт ба цагаантныг ялах явдлыг хангасан билээ. Ленин, Сталин нар бол иргэний дайнд дайсныг ялах явдлыг шууд зохион байгуулагчид нь байв. Тэр үед В. И. Ленин, ажилчин, тариачны батлан хамгаалах зөвлөлийг толгойлж байсан бөгөөд түүний орлогч нь нөхөр Сталин байжээ.

Большевик Намын Төв Хороо ба Ленин, хувьсгалд хамгийн аюултай бөгөөд шийдвэрлэх фронтуудад нөхөр Сталиныг явуулдаг байв. Иргэний дайны үе дахь гол гол ялалт бол цөм нөхөр Сталины нэртэй холбоотой юм.

Иргэний дайн төгссөний дараа Ленин, Сталин нар, Зөвлөлт орныг энх байгууллын замд шилжүүлэх явдлыг хангажээ.

1920 оны 12 дугаар сард бүх Оросын зөвлөлүүдийн 8 дугаар их хурлаас ардын аж ахуйг социалист эхлэлийн үндсэн дээр сэргээн босгож өөрчлөн байгуулах тухай Лениний боловсруулсан улс орныг цахилгаанжуулах төлөвлөгөөг баталжээ. Тэгээд Ленин, өөрийн дотнын шавь нөхөр Сталины хамт социализмын эдийн засгийн суурийг тавихын төлөө тэмцэлд нам ба Зөвлөлтийн ард түмнийг дайчлав.

1921 онд намын 10 дугаар их хурлаас Лениний саналаар эдийн засгийн шинэ бодлогод шилжих түүхт шийдвэрийг гаргасан бөгөөд энэ бодлогыг тууштай хатуугаар биелүүснээр, социализмыг байгуулахын тул ажилчин анги ба тариачны эдийн засгийн холбоог бэхжүүлэн, ардын аж ахуйг сэргээн босгох зорилго биелэгдсэн юм.

1922 оны 4 дүгээр сард Намын Төв Хорооны бүгд хурлаас Лениний саналаар нөхөр Сталиныг Намын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн даргад сонгосон бөгөөд нөхөр Сталин тэр үеэс эхлээд энэ эрхэм үүргийг тасралтгүй гүйцэтгэн ажилласаар байна.

1924 оны 1 дүгээр сарын 21-д Ленин нас барж, дэлхий дахины хөдөлмөрчдөд асар хүнд гарз тохиолдов. Лениний бүтээсэн их үйл хэрэг, түүний цаглашгүй их хэргийг нөхөр Сталин цааш нь үргэлжлүүлсэн юм.

Лениний нас барсны дараа, намын нэгдлийг бэхжүүлэх, Зөвлөлт засгийг бататгах, социализмыг байгуулах, асар их хариуцлага нөхөр Сталинд намын жолоодогчийн нь хувьд оногдов. Нөхөр Сталин, Большевик нам ба Зөвлөлт орныг Ленингүйгээр Лениний замаар жолоодсоор байна.

Нөхөр Сталин бол Большевик намыг улам бэхжүүлсэн юм.

Зөвлөлтийн ард түмний заналт дайсан, Троцкист, Бухаринтан, Зиновьевтэн нарыг нөхөр Сталины удирдлагын дор илрүүлэн бутцохисон бөгөөд нам нь энэ тэмцлээр өөрийн эгнээг улам бэхжүүлсэн билээ. Нөхөр Сталин бол Лениний хэргийг суутаар үргэлжлүүлэгчийн хувьд марксист-лениний онолыг цааш хөгжүүлэн, түүнийг шинэ нөхцөлд тохирсон шинэ агуулгаар баяжуулсан билээ.

1924 онд хэвлэгдэн гарсан «Ленинизмийн үндэснүүдийн тухай» гэдэг, нөхөр Сталины суут зохиол нь марксист, ленинист онолын санд үнэлж баршгүй нэмэр болсон.

Нөхөр Сталин Зөвлөлт орныг тэргүүн зэргийн хүнд үйлдвэртэй социалист том хөдөө аж ахуйтай, хамгийн тэргүүний шинжлэх ухаан, соёлтой хүчирхэг орон болгохын төлөө тэмцэлд Большевик намыг жолоодсон юм.

Нөхөр Сталин бол Лениний хоршооллын төлөвлөгөөг баримтлан, хөдөө аж ахуйг хамтралжуулах онолыг боловсруулаад, хамтралын байгууллын төлөө Большевик намын тэмцлийг зоригжуулан зохион байгуулагч нь болсон юм. Большевик нам нь улс орныг хүнд үйлдвэржүүлэх талаар байлдан олсон амжилтын үндсэн дээр, хөдөө аж ахуйг хамтралжуулах зорилтыг нөхөр Сталины жолоодлогын дор биелүүлсэн юм.

Нөхөр Сталины мэргэн жолоодлого, Большевик нам ба Зөвлөлтийн ард түмний цаглашгүй их зориг, аврага их зүтгэлийн ачаар ахар богино хугацааны дотор Орос орны олон зуун жилийн хоцрогдлыг устгаж тус орон нь хүчирхэг социалист гүрэн болон хувирав.

(Төгсөөдүй)

## С л о в а

**босгох** поднять  
**цагаантан** белогвардейцы  
**орлогч** заместитель  
**эхлэл** начало  
**цахилгаанжуулах** электрифицировать  
**эвхэмт** эд. коммунистический  
**ерөнхий нарийн бичгийн дарга** генеральный секретарь  
**гарз** эд. потеря  
**цаглашгүй** бесценный  
**хариуцлага** ответственность  
**оногдох** эд. возлагаться  
**бараг** почти  
**заналт дайсан** заядлый враг

**суутаар** гениально  
**хэвлэгдэх** печататься  
**тохирох** соответствовать  
**үндэснүүд** основы  
**сан(г)** сокровищница; казна, фонд  
**үнэлж баршгүй** неоценимый  
**нэмэр** вклад; лепта  
**хоршооллын төлөвлөгөө** кооперативный план  
**хамтралжуулах** коллективизировать  
**хүнд үйлдвэржүүлэх** индустриализировать  
**аврага их** гигантский, исполинский  
**зүтгэл** старание, усилие  
**ахар** короткий

КОММУНИСТ НАМ БОЛ, ЛЕНИНИЙ ЗАМААР,  
ТҮҮНИЙ ҮНЭНЧ ШАВЬ АГУУ ИХ СТАЛИНЫ МЭРГЭН  
ЖОЛООДЛОГООР ЗӨВЛӨЛТИЙН АРД ТҮМНИЙГ  
КОММУНИЗМ ӨӨД АМЖИЛТТАЙ УДИРДАЖ БАЙНА

(Төгсгөл)

Сталины таван жилийн төлөвлөгөөний жилүүдэд Зөвлөлт төрийн батлан хамгаалах явдал цаглашгүй хүчтэй болж, Зөвлөлтийн арми, хамгийн хүчирхэг зэвсэгт хүчин болов. Зөвлөлтийн ард түмний санал сэтгэл, улс төрийн нэгдэл бэхжиж ажилчин, тариачин, сэхээтний холбоо эвдэршгүй бат болов. СССР-ийн улс үндэстний хоорондох нөхөрлөл хөгжиж, Зөвлөлтийн ард түмний эх оронч үзэл улам бадран цэцэглэв. Зөвлөлт орон нь социализмын эвдэршгүй цайз болон хувирав.

Зөвлөлтийн ард түмэн, энэ агуу их ялалтаа бүх холбоотын зөвлөлүүдийн 8 дугаар онц их хурлаар батлагдсан Сталины үндсэн хуульд хууль ёсоор бэхжүүлээд, социализмээс коммунизмд аажмаар шилжин орох зорилгыг амжилттай шийдвэрлэх явдалд давшин оржээ.

Гэтэл 1941 оны 6 дугаар сарын 22-т Германы дээрэмчин фашистуудаас, Зөвлөлт оронд итгэлийг эвдэн довтолж, Зөвлөлтийн ард түмний энх байгууллыг түр тасалдуулав.

Германы фашистын эсрэг эх орны их дайны үед Большевик намын их жолоодогч нөхөр Сталин, Зөвлөлтийн бүх ард түмний тэмцлийг толгойлж, дайсныг бүрмөсөн бутцоох зорилгыг биелүүлэхэд, Большевик нам, Зөвлөлт төр, Зөвлөлтийн арми ба Зөвлөлтийн бүх ард түмний хүч зүтгэлийг дайчлан чиглүүлэв. Зөвлөлт Холбоот Улс, түүний арми нь Германы дээрэмчин фашистын цэргийн хүчийг хяар цохиж, фашистын германыг бүрэн ялсан билээ. Энэ бол юуны өмнө большевикуудын нам, их Сталины мэргэн удирдлагын ач юм.

Эх орны дайны өдрүүдэд Большевик нам нь ард нийтийн тэмцлийг фашистын булаан эзлэгчдийн эсрэг зоригжуулан удирдаж байв. Намын зохион байгуулах ажил нь дайсныг бут цохих хэрэгт бүх хүч хөрөнгийг захируулж, Зөвлөлтийн хүмүүсийн бүх зүтгэлийг нэг зорилтод чиглүүлэв,

Дайны үед нам, ард түмэнтэйгээ улам ойр дотно болж, өргөн олон хөдөлмөрчидтэй холбоогоо улам нягтруулав.

Лениний тугийн дор, суут их Сталины жолоодлогын дор Зөвлөлт улс эх орны их дайнд ялсан юм.

\* \* \*

Импералист ертөнц эвлэршгүй зөрчилдөө идэгдэн мухардсан байдлаасаа гарахын тул шинэ дайнд бэлтгэх замд шилжин орсон үед Зөвлөлт их улс, Ленин, Сталины үндэслэн байгуулж жолоодсон Большевик намын удирдлагын дор социалист нийгмийн байгууллыг босгож дуусган, коммунист нийгэмд аажмаар шилжих замд давшин оржээ.

Большевик намаас дайны дараахь таван жилийн төлөвлөгөөг биелүүлэхийн төлөө тэмцлийг өрнүүлж байна. Зөвлөлт улс дайнд хохирсон аж ахуйг сэргээн босгож чадсанаар үл барам одоо СССР-ийн үйлдвэр нь дайны өмнөх хэмжээнээс үлэмжхэн ихээр давж тарианы ургацын хэмжээ дайны өмнөх 1940 оныхоос хэтрээд, Зөвлөлтийн ард түмэн дайны дараахь, Сталины таван жилийн төлөвлөгөөг хугацаанаас нь өмнө биелүүлж чадах явдал эргэлзээгүй боллоо.

Зөвлөлт оронд Коммунист намын жолоодлогын дор ард түмэнтэй тасаршгүй холбоотой, жинхэнэ шинжлэх ухаан, урлаг, соёл асар их амжилтыг олж шинжлэх ухаан, үйлдвэр хоёрын холбоо нөхөрлөл хүчтэй болж байна.

Зөвлөлт орны аж ахуй, соёлын байгуулалтын ажил дээр гарч байгаа бүх ялалт, амжилт бол Зөвлөлтийн ард түмнийг коммунизмд улам бүр ойртуулж байна.

Зөвлөлтийн ард түмний энэ бүх ололт, амжилт Сол Коммунист нарын алдарт нам, түүнийг үндэслэн байгуулж жолоодогч Ленин, Сталины мэргэн удирдлагын ач мөн юм.

Зөвлөлтийн ард түмэн, өөрийн замд тохиолдсон үй түмэн бэрхшээл саад, дайсны сэргүүцлийг Коммунист нам, Ленин-Сталин нарын жолоодлогын дор давсаар дэлхий дахинаа түүхт ялалтыг байгуулсан юм.

Коммунист нам, өнөөдөр Ленин-Сталины ялагдашгүй тугийг өндөрт өргөн барьж, Лениний замаар, түүний үнэнч шавь их Сталины мэргэн жолоодлогоор Зөвлөлтийн ард түмнийг коммунизм өөд амжилттай удирдаж байна.

По статье  
В. Л х а м с ү р э н, С. У д в а л  
«Үнэн», № 289, 14.XII. 1949.

### С л о в а

зэвсэгт хүч(ин) вооруженные силы  
санал сэтгэл моральное состояние  
цайз крепость, форпост  
ажмаар постепенно  
давшин орох приступить  
дээрэмчин разбойник; разбойничий  
итгэлийг эвдэн вероломно  
довтлох нападать  
түр временно  
тасалдуулах нарушить  
хяар цохих разбить вдребезги

булаан эзлэгчид захватчики  
зөрчил противоречие  
идэгдэх эд. разъедаться  
мухардах оказаться в тупике  
дайны дараахь послевоенный  
үл барам не только  
ургац урожай  
хэтрэх превзойти  
тасаршгүй неразрывный; неразрывно  
ойртуулах приблизить

## АЛФАВИТНЫЙ СЛОВАРЬ

### А

**Аав(а)** папа, отец  
**аагтай үнэр** аромат; сильный запах  
**аажим** медленный; постепенный; тихий  
**аажмаар** медленно; постепенно; тихо  
**аар саар** небольшой, незначительный  
**ааш** поведение; характер, нрав  
**аашлах** проявлять свой характер; ругать(ся), устроить скандал  
**ав (I)** облава, охота  
**ав (II)** см. **аав**  
**аваачих** увозить, уносить; уводить  
**авгай** 1) тетя; 2) женщина  
**авдар** сундук; ящик, ларь  
**авиа(н)** звук  
**авиран гарах** взбираться  
**авах** получать, брать; принимать  
**аврага их** гигантский, громадный, исполинский, колоссальный  
**аврагч** спаситель, защитник  
**аврал** избавление, спасение  
**аврах** избавить, спасти  
**авчих** взять; сразить  
**авчрах** приносить, привозить; подвозить  
**авьяас (лаг)** талант, дарование  
**авьяаслаг** талантливый; талант  
**агаар** воздух; атмосфера  
**аги** полынь  
**агнах** охотиться  
**агуу их** великий  
**агуулах** 1) воплотить; 2) вмещать  
**агуулга** содержание  
**агшин зуур** мгновенно, моментально  
**адгуус мал** скот; животное  
**адил** одинаково, также; одинаковый, равный, подобный, сходный, адекватный  
**адуу(н)** лошадь; табун лошадей  
**аж амьдрал** жизнь  
**аж амьдрах** жить, существовать  
**аж ахуй** хозяйство

**аж ахуйч** хозяйственник; хозяйственный  
**аж үйлдвэр(и)** промышленность  
**ажиг сэжиггүй** без сомнения; без боязни; смело, уверенно  
**ажиглах** наблюдать; приглядываться; замечать  
**ажил** работа, труд  
**ажил хэргийн чанартай** деловой  
**ажилгүйчүүд** безработные  
**ажиллагаа(н)** работа, деятельность  
**ажиллах** работать, трудиться  
**ажиллацгаах** работать  
**ажилтан** работник  
**ажилгуй** работающий; труженик  
**ажилчин** рабочий  
**аз** счастье; удача  
**аз жаргал** счастье  
**азгүй** несчастливый, неудачливый  
**азрага** жеребец  
**ай даа** да, так  
**айдас хүрмээр** страшный, жуткий  
**айл аймаг** сосед; по соседству  
**айл саахалтан** соседи  
**айл хөрш** сосед; соседний  
**айлгах** пугать, устрашать  
**айлгүйгээр** не боясь; без страха  
**аймшиггүй** бесстрашный, неустрашимый, смелый  
**айх** бояться  
**айх(ав)тар** 1) чудовищный; 2) очень; исключительно  
**айхыг мэдэхгүй** бесстрашный; не боящийся  
**алаг** пегий  
**алаглах** пестреть, быть пегим  
**алан хядагч** палач  
**алан талах** убивать, истреблять  
**албан ёсоор** официально  
**албан журмаар** по закону; в обязательном порядке; официально  
**албан татвар(и)** налог  
**албан хаагч** служащий  
**алга** нет

**алга болох** исчезать  
**алга(н)** ладонь  
**алга таших** аплодировать  
**алгасах** миновать  
**алдар** слава  
**алдар гавьяа(н)** доблесть, слава  
**алдар нэр(э)** имя, репутация; престиж; слава  
**алдар хүнд(э)** авторитет  
**алдарт** славный, известный  
**алдарт дурсгал** славная память; книга почета  
**алдах** 1) уронить, упустить; потерять, утратить; 2) лишаться; прозевать, проморгать; 3) ошибаться, промахнуться  
**аливаа** всякий, любой  
**алим** яблоко  
**алс** даль; далекий, дальний  
**алслах** быть вдали; удаляться  
**алсыг харсан** дальновидный  
**алт(ан)** золото  
**алтан гадас(ан)** полярная звезда  
**алхам** шаг  
**алхах** шагать; перешагнуть  
**алхдал** шаг; топот  
**алхлах** шагать; перешагнуть  
**алчуур** платок, шаль; полотенце  
**аль?** который?, где?  
**аль болохоор** всемерно, всячески  
**аль вэ?** где?, который?  
**аль өмнө** задолго  
**аль хэдийнээ** давно  
**ам(ан)** 1) рот; 2) отверстие; вход, выход (*из ущелья и т. п.*)  
**ам нийлэх** иметь одно мнение  
**амар сайн байна уу!** Здравствуйте!  
Как поживаете?  
**амаржих** успокаиваться  
**амархан** легкий, нетрудный; легко, нетрудно  
**амгалан тайван(г)** мир, покой  
**амжилгүй** без успеха; безуспешно  
**амжилт** успех, достижение  
**амжилттай** успешно; успешный  
**амжих** успевать; суметь  
**амиа солилцохоос айхгүй** не щадить своей жизни, не бояться смерти  
**амралт** отдых; каникулы  
**амралтын цагаар** во время отдыха, во время каникул  
**амрах** отдыхать  
**амсах** попробовать, отведаг; испытывать, переживать; претерпевать  
**амтатан** сладости  
**амтархах** ощущать сладкий вкус  
**амттайхан** сладкий, вкусный  
**амыг гатах** поддерживать повод; остановить; молчать

**амь бие хайрлахгүй** не щадить своей жизни  
**амь сүйдэх** умирать, погибать  
**амь үрэгдэх** погибать  
**амьд** живой  
**амьд чадал** жизненность  
**амьдаар** живым, живьем; заживо  
**амьдрал** жизнь  
**амьсгаадаах** учащенно дышать, задыхаться  
**амьтан** животное; существо  
**ан(г)** зверь  
**ан гөрөөс(өн)** звери, дикие животные  
**ан гөрөө хийх** охотиться  
**ангаахай** птенчик; цыпленок  
**ангайхай** см. **ангаахай**  
**анги** класс; курс; часть  
**ангижрах** избавляться, освобождаться  
**ангижруулах** избавить; освободить; отделить  
**ангийн тэмцэл** классовая борьба  
**ангиуд** классы; части  
**андахгүй** не ошибаться; без ошибки, безошибочно  
**анх(ан)** первоначальный, начальный; впервые  
**анх удаа** впервые, первый раз  
**анхаарал** внимание  
**анхаарах** обращать внимание  
**анхилах** пахнуть, издавать запах  
**анхимал сайхан үнэр** аромат, благоухание  
**анчин** охотник  
**ар(а)** 1) спина; зад; 2) северный склон (*горы*); задняя сторона (*юрты и т. п.*)  
**араатан** хищник, зверь  
**арав(арван)** десять  
**арай** едва, еле, кое-как; немного, чуть  
**арвай** ячмень  
**арван гурав(гурван)** тринадцать  
**арван долоо(н)** семнадцать  
**арван дөрөв (дөрвөн)** четырнадцать  
**арван зургаа(н)** шестнадцать  
**арван ес(өн)** девятнадцать  
**арван найм (ан)** восемнадцать  
**арван нэг(эн)** одиннадцать  
**арван тав(ан)** пятнадцать  
**арван хоёр** двенадцать  
**арвилан хэмнэх** экономить, беречь  
**арвин** богатый, обильный  
**арга** способ, метод  
**арга хэмжээ(н)** меры; мероприятие  
**аргал** аргал (*сухой помет*)  
**ард олны хэрэгцээт** массового потребления  
**ард түмэн** народ; народные массы  
**ардчилал** демократия  
**ардчилах** демократизировать  
**ардчилсан** демократический  
**ардын аж ахуй** аратское хозяйство

**ардын ардчилсан** народно-демократический  
**ардын нэгдлүүд** аратские объединения  
**арзайж ярзайсан** оскаливший зубы  
**арилах** уходить, отходить; пройтн  
**арилгах** очищать, расчищать; устрани-  
вать  
**ариун** чистый, светлый; священный  
**ариун дагшин орон** святыня  
**ариун дархан зүйл** священное дело  
**ариун сэтгэлт хүмүүс** люди доброй  
воли; люди с благородными сердца-  
ми  
**ариун цагаан** чистый, светлый  
**ариун цэвэрч** поддерживающий чи-  
стоту, чистоплотный  
**ариунаар** свято, священо  
**арлууд** острова  
**архи** вино, водка  
**арчгүй бага** клочок, небольшой кусо-  
чек  
**арчигдашгүй** неопровержимый; неиз-  
гладимый  
**арчилгаа(н)** уход, опека; охрана  
**арчих** вытирать; очистить  
**арчлах** спасты; организовать уход  
**арьс(ан)** кожа, шкура  
**асаах** зажигать; засветить  
**асар богино** кратчайший  
**асар их** огромный, величайший  
**асгах** 1) выливать, лить, проливать,  
расплескивать; 2) просыпать  
**асрамж тусламж** помощь  
**асуудал** вопрос  
**асуулт** вопрос  
**асуух** спрашивать, задавать вопросы  
**атаатан** 1) завистники; 2) враги, про-  
тивники  
**атар газар** целина  
**атга** горсть, пригоршня  
**атгах I** захватить горсть; 2) дер-  
жать, пожать; сжимать (*рукой*)  
**атираа** морщина, складки  
**атираа суусан** морщинистый  
**аугаа их** великий  
**ах** старший брат; старший  
**ах дүүгийн** братский  
**ахар** короткий; низкий  
**ахиц** продвижение вперед; повышение  
**ахлах** быть старшим; возглавлять  
**ач** (I) внук; племянник  
**ач** (II) благодеяние, милость; услуга;  
заслуга; воздаяние  
**ач тус(а)** помощь; благодеяние  
**ач үрээр** благодаря  
**ач холбогдол** значение  
**ачаа(н)** груз  
**ачааны** грузовой  
**ачаар** благодаря

**ачийг хариулах** возблагодарить, от-  
благодарить  
**ачит** благодетельный  
**ачих** грузить  
**ачлалт** благодетельный  
**ашгүй** прекрасный, хороший; незаб-  
венный  
**ашиг** польза, выгода  
**ашиг тус** интересы  
**ашиг шим** продуктивность; польза  
**ашиглах** использовать, употреблять,  
пользоваться  
**ашигт малтмал** полезное ископаемое  
**ашигтай** полезный  
**аюул занал** опасность, угроза  
**аюул тулгарсан цаг** грозный час  
**аюултай** опасный, губельный; чревато  
последствиями  
**аюултай заналтай** опасный, угро-  
жающий  
**ая** напев, мелодия, мотив  
**аяар** постепенно; помаленьку; тихо;  
тише; осторожно  
**аяархан** легонько; медленно, посте-  
ленно; осторожно, тихо  
**аяга** чашка, пиала, стакан  
**аягалах** наливать в чашку, пиалу  
**аягүй л бол** если допустить оплош-  
ность, если оплошать  
**аялах** (I) путешествовать, странство-  
вать, находиться в пути  
**аялах** (II) напевать  
**аялгуу** 1) мотив, интонация, напев;  
2) возглас; междометие  
**аялгуулан татах** петь, исполнять  
(*песню или музыкальное произве-  
дение*)  
**аялгуут жүжиг** опера, музыкальная  
пьеса  
**аяндаа** само по себе, невольню; авто-  
матически; самотеком  
**аянчид** путешественники; путники  
**аятай** приличный, подходящий; бла-  
гополучный  
**аятайхан** 1) ловкий; 2) приятный;  
3) удобный, хороший

## Б

**баавгай** медведь  
**баарцаглах** висеть гроздьями; прили-  
пать  
**баатар** герой; героический  
**баатарлаг** героический; героизм  
**ба и**  
**баг баг** (*низовая административная  
единица*)  
**бага** мало; малый, меньший  
**бага балчир настан** дети, малолетние  
**бага буурай** малый; слабый

**бага нас(ан)** детство  
**багадаа** в детстве  
**багана** колонна; столб  
**багаж** инструмент; инвентарь  
**багасах** уменьшаться  
**баглаа цэцэг** букет цветов  
**багсайх** быть пушистым; расти густо  
**багтаж ядах** с трудом поместиться, с трудом вместиться, с трудом влезать  
**багтах** поместиться, вместиться, влезать; входить (*в состав чего-л.*)  
**багш** учитель, преподаватель  
**багш нарыг бэлтгэх дээд сургууль** педагогический институт  
**багшлах** учить, преподавать  
**багшрах** тесниться, толпиться  
**бадмараага [эрдэнэ] рубин**  
**бадрал** 1) расцвет; возрождение; 2) порыв, подъем  
**бадран дэлгэрэх** расцветать  
**бадрангуй** вдохновенный; пламенный, пылающий; лучезарный  
**бадрах** возрастать; увеличиваться, расширяться; расцветать, гореть, пылать  
**байгаль** природа  
**байгуулагч** строитель; организатор  
**байгуулал** режим, строй  
**байгуулах** организовать; основать; построить; заключить (*договор*)  
**байгууллага** организация  
**байдал** положение, состояние, ситуация; жизнь; уровень  
**байж мэднэ** может быть  
**байлдаан** бой, сражение, битва, война  
**байлдагч** боец; действующий (*об армии*)  
**байлдан олох** завоевать  
**байлдах** воевать, вести бой; биться, сражаться  
**байлцах** присутствовать  
**байнга** постоянно; постоянный  
**байр(а)** место; квартира  
**байсгээд** временами, время от времени  
**байхгүй** нет, не присутствует; отсутствует  
**байшин(г)** дом, здание  
**балар** темный, неясный, запутанный  
**балмад** авантюрист; авантюрный  
**балмадаар** авантюристически; преступно  
**балчаг** пучина; ужасы; бедствия  
**бараа** видимость, вид, форма, облик  
**бараа(н)** товар; имущество  
**бараавтар** темноватый  
**барааны** товарный; промтоварный  
**барааны саван(г)** мыло хозяйственное

**бараг** почти, безмала  
**барагдaшгүй** неистощимый, неиссякаемый  
**бараглавал** приблизительно, примерно  
**барагцаалбал см. бараглавал**  
**барах** кончать, исчерпать, израсходовать; довершить  
**барахгүй** не только  
**бардаггүй** не может, не смог  
**бардам** хвастливый, чванливый, кичливый, зазнавшийся; тщеславный; гордый, горделивый  
**бардамнах** гордиться, чваниться; хвастать  
**барилга** строительство, стройка; строение  
**барилдаа(н)** спорт. борьба  
**барилдлагатай** скреплен, связан  
**барилцах** держать (*что-л.*) вместе; обмениваться рукопожатием  
**баримт(а)** данные; доказательство; факт, обстоятельство; документ, справка  
**баримтлал** данные; факты  
**баримтлах** придерживаться, руководствоваться  
**барих** брать, взять; ловить; схватывать, держать; задерживать, арестовывать; строить, ставить (*юрту*); подавать, преподносить; щупать; вправлять (*вывих*)  
**барс** тигр  
**бартаа** скала, каменная гора; валуны; препятствия  
**баруун** правый; западный  
**баруун урд** юго-запад  
**баруунтай** на западе  
**баруунтан** правые  
**барьж явах** нести  
**бас(а)** еще, также, опять  
**овог** фамилия; род, племя  
**овогтнууд** племена  
**оволзох** шевелиться; двигаться вверх и вниз  
**овоо(н)** 1) куча; насыпь; гряда камней; курган; 2) много, обильно  
**овоорох** собираться в кучу; скопляться  
**овоохой** 1) шалаш, лачуга, балаган; 2) *перен.* истукан  
**огт** совершенно, совсем, вовсе; никак, нипочем, нисколько, ничуть, отнюдь  
**огтлох** 1) резать ножом, крошить; 2) рубить, вырубать (лес)  
**огторгуй** небосвод, небо  
**од(он)** звезда  
**одон** орден  
**одон орныг шинжлэх ухаан** астрономия  
**одон тэмдэгт** орденосный  
**одоо** теперь, ныне, в настоящее время  
**одоо цагийн** теперешний, нынешний, современный  
**одоо ч гэсэн** и теперь, и ныне  
**одох** пойти, отправиться, уходить, удалиться  
**оёдол** шитье; шов  
**оёдлын машин** швейная машина  
**оёулах** отдавать в пошивку  
**оёх** шить  
**ой** годовщина; юбилей  
**ой мод(он)** лес, бор, роща  
**ой тайга** тайга  
**ойлгох** понимать, разбираться (*в чем-л.*)  
**ойлгоц** усвояемость; понятливость; сообразительность  
**ойлох** понимать, разбираться (*в чем-л.*)  
**оймс(он)** носки; чулки  
**ойр(о)** близко  
**ойр зуурын** ближайший; минимальный; обиходный  
**ойр хавийн** ближний  
**ойртох** приближаться  
**ойртуулах** приближать  
**олгох** дать, выдавать, отпускать; предоставлять, вручать; присвоить  
**олдошгүй үнэт** редчайший, бесценный  
**олз** 1) прибыль, доход; 2) находка; 3) приобретение; 4) добыча; 5) трофей; 6) пленник  
**ололт** успех, достижение; находка  
**олон** много; многочисленный  
**олон нийт** общественность  
**олон төрлийн** разный, разнообразный  
**олон түмэн** массы (*людей*)  
**олон янзын** разнообразный  
**олонт** многократно, много раз

**олонхи** большинство  
**олох** находить; обнаруживать; завоевывать (*например, свободу*)  
**олшрох** увеличиваться (*количественно*)  
**олшруулах** размножать, увеличивать (*количественно*)  
**омог** 1) гордость, высокомерие, надменность; 2) гордый, высокомерный, надменный  
**омогт** гордый, кичливый, высокомерный  
**он** год (*календарный*)  
**онгойлгох** открывать, раскрывать, открывать  
**онгоц** лодка, корабль, судно, пароход  
**онгоц ховоо(н)** колода, корыто (*у колодца*)  
**онд оруулах** сохранить в зимне-весенний период (*о скоте*)  
**оногдол** начисление, обложение (*например, налогом*)  
**оногдох** приходиться; облагаться (*налогом*)  
**оногдуулах** начислять, облагать (*например, налогом*); возлагать; предназначать  
**онол** теория  
**онц** особый, особенный; отличный; чрезвычайный  
**онц сайн** отлично; отличный  
**онц сурлагатан** отличники учебы  
**онцгой** особенный, исключительный, специфический; обособленный, отдельный  
**онцгой байдал** специфическое положение  
**онцлог** особый; специфический  
**онцлог чанар** особое качество  
**онцлон** особо  
**онццууд** отличники  
**ор(он)** 1) кровать, койка; 2) место; 3) вакансия  
**ор нэр(э)** одно название, фикция  
**оргил** 1) вершина, пик (горы); 2) вышка, обсерватория  
**оргилох** кипеть, бурлить, подниматься  
**оргилуулах** вызвать кипение; вызвать подъем  
**орд(он)** дворец  
**орлогч** заместитель, помощник; временно исполняющий обязанности  
**орлогч гишүүн** кандидат (*в члены партии, бюро и т. п.*)  
**орой** (I) поздно; вечером  
**орой** (II) пик, вершина (горы); крыша, макушка  
**оролдох** стараться, стремиться, прилагать усилия  
**оролцох** участвовать

**орон** страна, государство  
**орон нутгийн** местный  
**орон сууц** кров, жилище, квартира  
**оронд** вместо, взамен  
**ороох** обвертывать, завертывать, оку-  
тывать; наматывать  
**орос** русский  
**Орос улс** Россия  
**оросын** русский  
**орох** 1) входить; вступать; попасть;  
2) выпадать (*о снеге и дожде*)  
**оруулах** впускать, вводить, вгонять;  
вносить; ввозить, импортировать;  
вовлекать, охватывать  
**орчим** около, вокруг  
**орчин ахуй** возле, около, вблизи;  
вокруг; окружающий  
**орчуулах** переводить (*на какой-л.*  
*язык*)  
**оршино** находится; располагается;  
заклучается  
**орших** существовать, находиться;  
располагаться; заключаться  
**осолгүй** без помех, не задерживаясь;  
безошибочно; безошибочный  
**охин** дочь; девочка  
**охин дүү** младшая сестра  
**охь** 1) запах, аромат; 2) знамение,  
символ  
**очих** пойти, поехать  
**очоод ирэх** сходиться, съездить  
**оюун билэг** ум, разум; талант, спо-  
собность  
**оюутан** студент

## Ө

**өв** 1) наследие, наследство; 2) сокро-  
вищница; наследие  
**өвгөд хөгшид** старики и старушки;  
предки  
**өвгөн** старик, старец; старый, пре-  
клонного возраста  
**өвгөн аав** дедушка  
**өвдөх** болеть  
**өвөл** зима; зимой  
**өвөлжүүлэх** организовать зимовку;  
дать возможность провести зиму  
**өвөр** (I) пазуха; *перен.* карман  
**өвөр** (II) юг; южная сторона (горы);  
южный  
**өвөр дээр** на руках; на груди  
**өвөртлөх** положить за пазуху; хра-  
нить за пазухой  
**өврийн дэвтэр** блокнот  
**өвс(өн)** сено  
**өвч(ин)** болезнь, заболевание  
**өвчлөх** болеть  
**өвчтэй** болен; больной, болеющий  
**өвчүү(н)** грудь, грудишка

**өглөө(н)** утро; утром  
**өглөөний хоол** завтрак  
**өгөрөх** обветшать, устареть  
**ө(гө)х** давать, выдавать  
**өдий төдий** несколько; некоторый  
**өдөөгч нар** зачинщики; поджигатели  
**өдөөх** поджигать  
**өдөр** день  
**өдөр ирэх тутам** с каждым днем  
**өлгий** колыбель  
**өлгөх** вешать, развешивать, повесить;  
привесить  
**өлгүүр** вешалка (*для одежды*)  
**өлзийт** приносящий счастье, счастли-  
вый  
**өлсгөлөн зовлон(г)** голод; страдание  
**өлсөх** голодать; проголодаться  
**өмд(өн)** штаны, брюки  
**өмнө юг**; южный; впереди; до, перед  
(*чем-л.*)  
**өмөг** заступничество; охрана, стража  
**өмөг түшиг** опора, оплот; надежный  
друг  
**өмсөх** одевать (одежду)  
**өмч** собственность  
**өнгийн** цветной  
**өнгийн** 1) приподняться; поднимать  
голову; 2) покушаться; нападать  
**өнгө** цвет  
**өнгө бүрийн** разный, разноцветный  
**өнгөлөх** чистить, полировать, шлифо-  
вать, отделявать,  
**өнгөрөгч** прошлый  
**өнгөрөх** миновать, проходить, проез-  
жать  
**өнгөрүүлэх** проводить  
**өндийх** приподняться; поднимать го-  
лову  
**өндөг(өн)** яйцо  
**өндөр** высокий  
**өндөр дуугаар** громко; торжественно  
**өндөрлөг** высокий; возвышенность  
**өнөө** теперь, ныне; тот самый, выше-  
упомянутый  
**өнөөгийн** нынешний, теперешний  
**өнөөдөр** сегодня  
**өнөр** много семейный, многолюдный  
**өнцөг булан** угол  
**өөд(ө)** на, к, в сторону; вверх; про-  
тив  
**өөр(ө)** иной, другой  
**өөрийгөө** самого себя  
**өөрийн** свой  
**өөрийн өртөг** себестоимость  
**өөрөөр хэлбэл** говоря иначе  
**өөрсдийн** свой  
**өөрчлөлт** изменение; перестройка; пе-  
релом  
**өөрчлөх** изменить; перестроить  
**өргөжих** расширяться

**өргөмжлөх** 1) присвоить почетное звание; провозглашать (*кем-л.*); 2) поднимать; возносить, возвышать, возводить (*кого-л.*)

**өргөн барих** пожертвовать, подносить  
**өргөн** широкий; широко  
**өргөн хэрэгцээний бараа(н)** товары широкого потребления

**өргөтгөх** расширять

**өргөх** поднимать; подносить, преподнести; иметь на своем иждивении, ухаживать (за детьми, родителями и т. п.)

**өрнө** запад

**өрнөгч** развивающийся, возрождающийся

**өрнөлт** развитие, подъем, рост

**өрнөх** развиваться, расти, повышаться

**өрнүүлэх** развивать; добиться подьема, роста

**өрөмдмөл худаг** артезианский колодец

**өрөмдөх** сверлить, бурить

**өрөө(н)** комната, зал

**өрөх** складывать, сложить; ставить мишень

**өртөө(н)** 1) уртон (*почтово-ямская станция*); 2) перегон (*между уртонами в 30—40 км.*)

**өрх** крышка дымохода (в юрте); двор, хозяйство

**өсгөх** разводить, выращивать (*напри- мер, скот*)

**өсөх** расти; размножаться

**өтгөн** 1) густой (*о жидкости*); 2) крепкий (*о чае*); 3) тучный (*о стаде скота*)

**өтлөх** состариться

**өцөгдөр** *см. өчигдөр*

**өчигдөр** вчера

**өчнөөн төчнөөн** много, очень много

**өчүүхэн** ничтожный, незначительный, маленький; немного

## П

**пансан** шелковый

**пишин** печка, плитка

**пүнз** хлев, помещение для скота

## С

**саад** помеха, препятствие; тормоз

**саальчин** доярка

**саатуулах** мешать, задерживать; тормозить, препятствовать

**сав(а)** посуда, сосуд;местилище

**саваагүй** не стесняющийся; бесстыд- ный; нескромный; праздный

**саваагүйтэх** вести себя нескромно, непристойно, не стесняться, быть бесстыдным; бездельничать

**савсах** дымиться; подниматься

**савхин гутал** сапоги (кожаные)

**сагсайх** быть раскидистым, пуши- стым, взъерошенным; расти густо, часто

**сагсар** пушистый, взъерошенный; густой

**сайд** министр

**сайжрах** улучшаться

**сайжруулах** улучшать, повышать качество

**сайн** хороший, добрый; хорошо; пере- довой, знатный

**сайн байна уу?** хорошо ли живете?; здравствуйте!

**сайтар** хорошо, хорошенько, как сле- дует

**сайхан** красивый; прелестный

**сайчууд** передовики

**сайчуул** передовики

**сайшаал** одобрение, похвала

**сайшаах** одобрять, находить хорошим, хвалить

**салаа(н)** ветвь; часть; филиал; приток, рукав реки; отрасль; взвод

**салаа мөчир** отрасль

**салах** 1) разобщаться, отделяться; расходиться, расставаться (*с кем- л.*); 2) избавляться (*от чего-л.*)

**салбаганан хийсэх** развеиваться

**салбар** 1) отделение, отдел, секция, филиал; 2) часть; 3) отрасль; 4) от- рог

**салбар мэдлэг** отрасль знаний

**салгах** отделять, разлучать, разоб- щать; отрывать; столкнуть, сбить, свернуть

**салхи(н)** ветер

**салхивч** форточка

**салхилах** дуть (*о ветре*)

**салхин** ветряный

**салшгүй** неразлучный, неотделимый, неразрывный

**самбар** доска классная

**сампин** счеты

**сан(г)** казна; сокровище

**санаа алдах** вздыхать

**санаа зовох** беспokoиться

**санаа тавих** заботиться, уделять вни- мание

**санаатай** преднамеренно, умышленно; намерен

**санаачлага** инициатива; забота

**санаачлагатан** инициатор(ы)

**санаж явах** помнить

**санал** мнение; предложение

**санал сэтгэл** моральное состояние

**санасандаа хүрэх** осуществить свою мечту  
**санах** думать, вспоминать  
**сангийн аж ахуй** госхоз  
**сандаль** стул, табуретка, кресло; диван  
**сандил см. сандаль**  
**сандрах** растеряться, приходиться в замешательство; быть в тревоге; быть в суматохе  
**сандрахгүй** не теряться, не растеряться  
**санхүү** финансы  
**сар(а)** месяц, луна  
**саравч** навес, сарай  
**сарвайх** протягивать руку; покушаться  
**саруул** светлый  
**сахал** борода; усы  
**сахигч** блюститель; стоящий на страже  
**сахилга бат** дисциплина  
**сахин хамгаалах** стеречь; сохранить  
**сахуус(ан)** талисман, амулет  
**сахих** соблюдать, блюсти; придерживаться; сторожить; защищать, отстаивать  
**сацрах** падать брызгами; излучать, светить; расцветать  
**сацуу** I) ровесник; 2) одновременно, в момент ...  
**сая** (I) миллион  
**сая** (II) недавно, только-что; только тогда, только  
**саяхан** недавно, только-что  
**сийрэг** редкий, негустой; редко, немного  
**сийрэгших** редеть, разрежаться; уменьшаться (количественно)  
**соёл** культура  
**соёл боловсрол** культура  
**соёлын хэмжээ** культурный уровень  
**соён гийгүүлэх** просвещать  
**солих** менять, обменивать; сменять, подменивать  
**Солонгос Улс** Корея  
**сонгодог** лучший, отборный; классический  
**сонгон авсан** выбранный, избранный  
**сонгох** выбирать, избирать  
**сонгуулийн** избирательный  
**сонгууль** выборы  
**сонин** 1) интересный; новость; 2) газета  
**сонирхол** интерес, заинтересованность  
**сонирхолтой** интересный, достойный внимания  
**сонирхох** интересоваться; смотреть с интересом  
**соносогх** объявлять, сообщать

**сонсдох** 1) быть слышимым; стать известным; 2) раздаваться, доноситься  
**сонсох** слушать; услышать  
**сорох** высасывать; тянуть (жидкость)  
**сохор** слепой  
**сочих** испугаться, вздрогнуть  
**сөнөөх** 1) уничтожать, истреблять; 2) погасить, потушить  
**сөнөх** гибнуть, сгинуть; угасать, прекращать существование, вымирать  
**сувд** жемчуг; жемчужина  
**суганаглах** подниматься, тянуться  
**сугасхийх** вырваться; выскальзывать  
**судал** (I) 1) полоска; 2) ложбина; овраг  
**судал** (II) 1) пульс, кровеносный сосуд, артерия; 2) жила (*например, рудодносная*)  
**судалтан цайрах** показываться светлыми полосками  
**судлах** изучать, исследовать  
**сул** слабый, бессильный, вялый; свободный, вакантный; порожний  
**сул сурлагатан** отстающие по успеваемости; слабые по успеваемости (*об учащихсья*)  
**сум(ан)** (I) 1) стрела; 2) пуля  
**сум(ан)** (II) 1) сомон (*низовая административная единица*); 2) рота, эскадрон  
**сундуулын бут** бугорок с кустарником, кочка с кустарником  
**сураг** слух, весть  
**сураглах** осведомляться, наводить справки; разведывать  
**сурагч** учащийся, ученик  
**суралцах** учиться, обучаться  
**сурах** 1) учиться; привыкать, приучаться; 2) осведомляться; искать  
**сурах бичиг** учебник  
**сурвалж** источник, корень; головка стрелы  
**сургааг** жердь  
**сургаал** учение; поучение; доктрина  
**сургамж** поучение, наставление; учение  
**сургах** учить, обучать, преподавать; инструктировать  
**сургууль** школа, училище; учеба  
**сурлага хичээл** учеба  
**суртал** учение; доктрина  
**суудал** место; сиденье  
**сууцах** присаживаться (*с кем-л.*); присутствовать  
**суунаглах** виться; тянуться  
**суурь** место; основание, база, фундамент; подставка; устои  
**суурь машин** станок  
**суурьшилтай** осёдлый, неподвижный; прочный

**суут** гениальный, мудрый  
**суутаар** гениально  
**суух** сидеть, садиться; присутствовать; жить, проживать; быть супругами  
**сууц 1)** поза, сидение; 2) жилище  
**сүйдсэн** разрушенный  
**сүйдэх** разрушаться; потерпеть аварию  
**сүйтгэх** опустошать, разорять; уничтожать; разрушать; расгранжировать, разбазаривать  
**сүлд(эн)** герб  
**сүлд модны наадам** ёлка (новогодняя)  
**сүлжих 1)** сплетать; сплетаться; перекрещиваться; 2) вязать; 3) штопать  
**сүлэх** забелить (молоком)  
**сүм хийд** монастырь; храм  
**сүмэлзэх** маячить, мерещиться, еле казаться  
**сүндэрлэх** возвышаться; громоздиться  
**сүр** величие, могущество, мощь  
**сүр жавхалан(г)** величие, могущество, мощь  
**сүртэй** величавый, мощный, могущественный  
**сүрхий** величественный; серьезный; тяжелый  
**сүрэг** стадо  
**сүсэг бишрэл** вера, набожность; суеверие  
**сүү(н)** молоко  
**сүүж** тазобедренные кости; бок  
**сүүжилдэх** сидеть немного боком, сидеть наклонившись на бок  
**сүүл** хвост; конец  
**сүүлийн** последний, заключительный  
**сүүлчийн** последний; новейший  
**сүүний машин** сепаратор  
**сүх** топор  
**сэвгэр** рыхлый, пушистый  
**сэвэлзүүр** легкий; приятный; прохладный  
**сэвсрэх** вытряхивать, выбивать (пыль); качать  
**сэдэв** тема; тезис  
**сэлбэн засварлах** ремонтировать; восстанавливать  
**сэлгүүцэх** беспрерывно приходить и уходить, бродить, слоняться с места на место  
**сэлүүр 1)** весло; 2) ж.-д. стрелка  
**сэлэм** сабля  
**сэнгэнэх** дуть, веять  
**сэргэлэн(г)** 1) бдительный, чуткий; 2) пронизательный; смысленный; бойкий, бодрый; 3) свежий, прохладный

**сэргээн босгох** возобновить, восстановить; реставрировать  
**сэрийлгэх** оттопырить; поднять  
**сэрүүлгээ** будильник; звонок будильника  
**сэрүүн** свежий, прохладный; не спящий, бодрствующий  
**сэрүүцүүлэх** проветрить, освежить, охлаждать  
**сэрүүцэх** проветриться, освежиться  
**сэрэх 1)** проснуться, очнуться; 2) оцутить  
**сэрээ 1)** вилка; 2) острога  
**сэрээх** будить, разбудить  
**сэтгүүл** журнал  
**сэтгэгдлүүд** мысли; чувства  
**сэтгэл** мысль, дума, настроение; душа, сердце  
**сэтгэл санааг сэргээх** вдохновлять, поднять настроение  
**сэтгэл харамгүй** щедро; не скупясь, не скрывая; подробно  
**сэтгэл хөдлөх** растрогаться; волноваться  
**сэтгэлийн** сердечный  
**сэтгэлийнхээ** задушевный, сердечный  
**сэхээтэн** интеллигент; интеллигенция

## Т

**тааварлах** предполагать, догадываться  
**тааз** потолок  
**таалах 1)** считать правильным; 2) ласкать, нежить  
**таарах** годиться, соответствовать, совпадать  
**тааруулах** подгонять, подбирать; привести в соответствие  
**таатай 1)** приятный; приемлемый; 2) соответствующий  
**тав(ан)** пять  
**таваар** товар  
**таваарын будаа(н)** товарный хлеб (зерно)  
**таваг** тарелка  
**таваглах** класть, наливать в тарелку  
**таван хушуу** пятиконечная звезда  
**таван хушуу мал** пять видов скота  
**тавгүй** не по душе; не подходящий  
**тавих** ставить; отпускать, пускать; уделять, обращать  
**тавтай** хорошо, удобно; приятный, удобный, подходящий; по душе  
**тавь (тавин)** пятьдесят  
**тавьлуур** полочка; подставка, столик; этажерка  
**таг** полка, полочка, подставка  
**таглаа** пробка, затычка; крышка  
**таглах** закрывать, затыкать

**тайван(г)** мир, спокойствие; мирный, спокойный  
**тайвшрах** успокаиваться; устанавливать (о мире, тишине)  
**тайж** тайджи (князь, дворянин)  
**тайз(ач)** сцена  
**тайлан** сонгуулийн отчетно-перевыборный  
**тайлах** 1) снимать одежду, раздевать (ся); развязывать, отвязывать; расшнуровывать, отстегивать; 2) открывать, отпирать (например, дверь); 3) растолковывать; объяснять  
**тайлбар** разъяснение, комментарий, толкование; примечание  
**тайлбарлах** разъяснять, комментировать; делать примечания  
**тал(а)** (I) сторона; половина  
**тал(а)** (II) степь, равнина  
**тал дугуй** полукруг  
**тал хувь** половина  
**талаар** 1) по линии, в области; 2) зря  
**талархаг** сторонник; почитатель, поклонник  
**талархал** благодарность, признательность; дружелюбие; сочувствие  
**талархах** 1) благодарить; 2) проявлять дружелюбие; сочувствовать  
**талбай** площадь; пространство; поле  
**талбар** площадь; простор, пространство  
**талх(ан)** хлеб (печеный)  
**тамхи(н)** табак  
**тана** [эрдэнэ] перламутр  
**танай** ваш  
**тангараг** клятва, присяга, обещание  
**танигдах** признаваться; быть признанным  
**танил** знакомый, приятель  
**танилцах** познакомиться (с кем-л.); ознакомиться  
**таниулах** ознакомиться, разъяснять  
**таних** знать; узнавать (знакомое), быть знакомым (с кем-л.)  
**танхим** зал; аудитория  
**таны** ваш  
**тарах** расходиться, рассеиваться; кончиться; распространиться  
**тарвага(н)** тарбаган (стенной сурок)  
**тарваган тахал** чума  
**таргалах** жиреть, тучнеть; [по]полнеть, поправиться  
**тарган** жирный, тучный, откормленный, упитанный, в теле  
**тариа(н)** 1) хлеб, зерно; 2) мед. сыворотка  
**тариалан(г)** 1) земледелие; 2) пашня, поле, нива  
**тариалах** сеять

**тариачид** крестьяне, земледельцы, хлебопашцы, пахари  
**тариачин** крестьянин, земледелец, хлебопашец; пахарь  
**тарилга** 1) [по]сев, сеяние; 2) прививка  
**таримал** посеянный, посаженный  
**тарих** 1) сеять; посадить; 2) мед. прививать (например, оспу)  
**тархи** головной мозг; голова  
**тарчигнах** трещать  
**тас хар** очень черный  
**тас хийх** раздаваться (например, выстрел)  
**тасаг** цех, отдел; пункт  
**тасалгаа(н)** комната  
**тасалдуулах** нарушать, срывать; прогуливать, пропускать  
**тасаршгүй** неразрывно, непрерывно; неразрывный, непрерывный  
**таслага(н)** см. тасалгаа(н)  
**таслах** 1) разорвать; оторвать; 2) прервать; 3) пропустить (например, замятие)  
**тасралтгүй** непрерывно, бесперебойно; бесценно  
**тасран ангижрах** избавиться  
**татаан оруулах** привлекать, вовлекать  
**татах** 1) тянуть, дергать; 2) вызывать, отзываться; 3) курить  
**тахи** курица  
**тахь** лошадь Пржевальского  
**тачгинатал** громко, звонко  
**ташуурдах** подхлестывать кнутом  
**таяг** трость; посох; костыль  
**техникч** техник; технический  
**тив** материк, часть света  
**тийм** такой; да  
**тийш** *послелог* к, в, в сторону  
**товч** (I) пуговица  
**товч** (II) краткий, сокращенный  
**товч тэмдэглэл** конспект, резюме  
**товчоо(н)** бюро  
**тоглоом** 1) игра, игры; 2) игрушка  
**тоглох** играть  
**тогоо(н)** котел  
**тогтвор** спокойствие; постоянство, устойчивость  
**тогтворгүй** непостоянный, неустойчивый  
**тогтвортой** постоянный; спокойный; надежный, устойчивый  
**тогтмол** постоянный, регулярный; постоянно, регулярно  
**тогтоол** постановление, решение, резолюция  
**тогтоон авах** запомнить; выучить  
**тогтоох** 1) остановить; 2) постановить, вынести решение; 3) установить; 4) разработать (например, план); 5) запоминать, выучить

**тогтох** 1) остановиться; стоять; 2) устанавливаться, оформляться, стабилизироваться; 3) договариваться; решать

**тогтуухан** 1) спокойствие, тишина; 2) спокойный, тихий

**тогших** см. **тонших**

**тод(о)** ясный, точный; ясно, четко

**тодорхой** ясный, точный; конкретный

**тодхон** ясный, четкий; точный; ясно, четко, точно

**тойрон** вокруг

**тойруулах** кружить, итти кругом

**толгой** 1) голова; глава; 2) вершина (горы); 3) кочан, головка; 4) кусок (материи)

**толгойлох** возглавлять; руководить

**толгойлуулсан** возглавляемый, ведомый

**толь** зеркало

**толь бичиг** словарь

**том** крупный, рослый

**том болох** вырасти, стать взрослым; укрупняться

**томоотой** выдержанный; воспитанный; степенный; скромный

**томоохон** большой, крупный

**тонилтугай** долой!

**тоноглогдсон** оборудованный

**тоноглол** снасти, снаряжение, оборудование

**тонох** [о]грабить; обобрать

**тонших** стучать(ся)

**тоо(н)** количество, число; цифра

**тооллого(н)** счет, исчисление

**тоолох** 1) считать; 2) выяснять количество

**тооно** верхнее (дымовое) отверстие юрты

**тоос(он)** шель

**торго(н)** шелк

**торгон** шелковый

**тормогор** блестящий (*о глазах*)

**тормолзох** блеснуть (*о глазах*)

**тос(он)** масло; жир, сало

**тосож ирүүлсэн** высланный навстречу

**тосон авах** встретить, поймать на лету

**тосох** 1) встречать (*о засаде*); 2) поджидать (*где-л.*); 3) подставлять (*посуду, ладонь*)

**тохилог** благоустроенный

**тохиолдлын** случайный

**тохиолдол** случай; стечение обстоятельств

**тохиолдох** попадаться, встречаться, случаться

**тохиолдуулах** приурочить; приспособить, привести в соответствие

**тохирсон** подходящий, соответствующий, годный

**тохируулах** приспособить, привести в соответствие

**тохитой** подходящий; с удобствами

**тохогдох** быть возложенным

**төв** центр; центральный

**Төв Хороо(н)** Центральный Комитет

**төв шударга** честный, правдивый, прямой

**төгөггүй** без труда, без хлопот

**төгөлдөр** полный; преисполненный

**төгрөг** 1) тугрик (*денежная единица МНР*); 2) круг, кружочек

**төгс** совершенный; полный, преисполненный

**төгсгөгчид** выпускники

**төгсгөл** окончание, завершение

**төгсгөх** кончатся, завершать

**төгсөх** кончатся, завершаться

**төдий** стоить; столько

**төдий чинээ(н)** настолько, столько

**төдийгүй** не только

**төдийд** тогда

**төдөлгүй** вскоре, скоро

**төдхөн** недолго; вскоре

**төл** приплод, молодежь

**төллүүлэх** принимать приплод, молодежь

**төлөв** 1) всегда; вообще; 2) вид, облик, форма

**төлөвлөгөө(н)** план; проект

**төлөө(н)** за, ради, для

**төлөөлөгчид** представители, делегаты, уполномоченные

**төлөөлөгчийн газар** представительство

**төмөр** железо; железный

**төмөр зам** железная дорога

**төр(ө)** строй, режим; государственность

**төрийн дуулал** государственный гимн

**төрийн хэрэг** государственное дело

**төрөл** 1) родной; 2) родство; родня; 3) род; отрасль, область

**төрөл бүрийн** разного рода, всех родов, разнообразный

**төрөх** родиться; происходить; появляться, возникать

**төрсөн** 1) родившийся; возникший; 2) родной

**төсөв** смета, бюджет

**төсөөлөх** 1) понимать, разбираться; 2) узнавать (*в лицо, по внешним признакам*)

**төхөөрөмж** приготовление, сборы, подготовка (*например, в путь*)

**төхөөрөмжтэй** приготовленный, подготовленный; оборудованный

**трактор** трактор

**тракторч** тракторист  
**туг** знамя, флаг  
**тугч** знаменосец  
**туйл** конец, предел: полюс  
**туйлд нь хүртэл** до конца  
**туйлын** 1) крайне, очень; 2) полярный  
**туйпуу** кирпич  
**тул** 1) для, для того, чтобы; за, ради;  
2) так как; потому что  
**тулалдаан** 1) столкновение; битва, сражение; 2) борьба  
**тулалдах** 1) столкнуться; 2) сражаться  
**тулах** 1) упереться; наткнуться (*на что-л.*) 2) подпирать; 3) сражаться  
**тулгарах** упереться, стать вплотную; встретиться  
**тулгуур** опора, оплот; подпорка, подставка  
**тун** весьма, очень  
**тунгалаг** чистый, прозрачный, светлый, ясный  
**тунхаглал** обнародование; воззвание, обращение; манифест  
**тунхагхлах** объявлять, оглашать; обнародовать; обращаться с воззванием  
**туранхай** тощий, слабый, худой  
**туранхайвтар** худошавый, худой, тощий  
**тургүй** худой, тощий; слабый  
**турш** в течение  
**турших** пробовать, испытывать  
**туршлага** опыт, проба; попытка  
**туршлагажих** приобретать навык; стать опытным  
**тус** данный, этот  
**тус (а)** польза; помощь  
**тус дөхөм болох** способствовать  
**тус тус** в отдельности, каждый в отдельности  
**тус тусын** каждый свое, каждый в отдельности  
**тусах** 1) попадать в цель; 2) отсвечивать; озарять  
**тусгаар тогтнол** независимость  
**тусгаарлан салах** выделяться, обособляться, разделяться, отделяться  
**тусгай** специальный, особый; специально, особо  
**тусгай мэргэжлийн** профессионально-технический (*об учебных заведениях*)  
**туслалцаа(н)** помощь; взаимная помощь  
**тусламж** помощь  
**туслах** 1) помогать; 2) подсобный, вспомогательный  
**тууж** повествование, повесть, сказание; былина  
**туулай** заяц

**туулах** проходить насквозь; преодолевать, одолевать  
**тууштай** последовательный  
**тухай** о, об, относительно, насчет  
**тухтай** не спеша  
**тушаал** 1) приказ; 2) должность; служебная обязанность  
**туяа(н)** луч; сияние, заря  
**туяат** сверкающий, сияющий  
**түвшин** 1) ровный, гладкий (*о поверхности*); 2) тихий, спокойный; 3) честный, правдивый; 4) мирный  
**түг түг цохих** стучать(ся), трепетать  
**түг түмэн** тысячи и тысячи, сотни тысяч, миллионы, очень много  
**түгшүүртэй** затруднительный, критический, трудный, тревожный, опасный (*об обстановке, времени*)  
**түгэх** распространяться  
**түлхүүр** ключ; отмычка; толкач  
**түлхэх** толкать  
**түлхэц** толчок, стимул, повод  
**түлэгдэх** сгорать; быть сожженным  
**түлэх** топить (печь); разводить огонь; обжигать (кирпич и т. п.)  
**тулээ(н)** дрова  
**түм(эн)** десять тысяч  
**түр** (кратко)временный; временно  
**түргэвчлэн** спеша; быстро, скоро, ускоренно  
**түргэн** скорый, быстрый; спешный  
**түрүүлэх** опередить, быть впереди, итти впереди  
**түрүүн** вначале; сперва; начальный, первоначальный; впереди  
**түрүүхэн** 1) немного раньше; только что, недавно; 2) немного впереди  
**түрүүч** сержант  
**түрэмгийлэгч** 1) агрессивный; захватнический; 2) агрессор; захватчик  
**түрэмгийлэгчид** захватчики; агрессоры  
**түрэмгийлэл** агрессия; захват; оккупация  
**түрэмгийлэн эзлэгчид** захватчики  
**түүвэр зохиол** избранные произведения  
**түүний** его  
**түүнчлэн** точно так же, также  
**түүнээс** от него, от нее; от того  
**түүх (I)** история  
**түүх (II)** собирать (*поштучно мелкие вещи*)  
**түүх тууж** предание  
**түүхий** сырой, незрелый, неспелый  
**түүхий эд** сырье  
**түүхт** исторический  
**түүхт явдал** историческое событие  
**түшиг** опора  
**түшиглэх** опираться

**гүших** 1) опираться; 2) уповать, надеяться  
**гүшлэг** 1) подпорка; 2) спинка (*у мели*)  
**түшүүлэх** подпереть, ставить подперев  
**төврөх** 1) обнимать; 2) брать в охапку  
**тэг дундуур** 1) через середину; напролом; 2) не стесняться  
**тэглээ** да; так именно сделал, так сделал  
**тэгнээ** да; так именно сделаю, так сделаю  
**тэгш** равный, ровный  
**тэгш эрх** равноправие  
**тэгшлэн зэхцлэх** выравнивать  
**тэгье** ладно; так сделаем  
**тэгэх** так сделать, так поступать  
**тэгэхлээр** тогда; при этом, когда так сделал  
**тэгээд** затем, потом, после чего; так, таким образом  
**тэд(эн)** они; те  
**тэдгээр** *см.* **тэд(эн)**  
**тэдний** их  
**тэжээл** корм, пища  
**тэжээх** кормить, питать; воспитывать  
**тэмдэг** примета; отметка; знак; значок, жетон  
**тэмдэглэж авах** записать; сделать для себя запись  
**тэмдэглэх** отмечать; примечать  
**тэмүүлэх** 1) упорно стремиться (*куда-л.*), пробиваться; толкаться; рваться вперед; 2) проявлять большое усердие  
**тэмцэгч** борец  
**тэмцэл** борьба  
**тэмцэх** бороться, вести борьбу  
**тэмцээн** борьба; состязание; матч  
**тэмээ (н)** верблюдо  
**тэмээн жин (г)** верблюжий караван  
**тэмээн тээвэр (и)** вьючный транспорт, верблюжий транспорт  
**тэнгэр (и)** небо  
**тэнгэс** море  
**тэнд (э)** там, туда  
**тэнцүүр(и)** равновесие; соразмерность  
**тэнцүүргүй** неравный; несоизмерный; несравненный  
**тэнцэх** 1) быть равным; 2) соответствовать; подходить, годиться  
**тэнэг** глупый  
**тэр(э)** он; тот  
**тэргүүлэгчид** президиум  
**тэргүүлэгчдийн газар** президиум (*орган*)  
**тэргүүлэх** 1) возглавлять; итти впереди; 2) быть впереди; опередить

**тэргүүн** 1) первый, передовой, начальный; главный; 2) начало  
**тэргүүний** передовой  
**тэргүү(н)тэй** во главе  
**тэрлэг** тэрлик (*национальный халат*)  
**тэртээ** то; там, на той стороне  
**тэрчлэн** точно также  
**тэрэг** 1) телега, арба; 2) шахм. ладья  
**тэсвэр(и)** терпение, выносливость, стойкость  
**тэсвэрлэшгүй** невыносимый, нестерпимый  
**тэсгэлгүй** 1) нетерпеливо; 2) невыносимо, нестерпимо  
**тэсэшгүй** *см.* **тэсгэлгүй**  
**тэхэгүй яах вэ** конечно, как же иначе  
**тэхэд** тогда  
**тэшүүр** коньки  
**тээвэр(и)** 1) груз, кладь; 2) транспорт  
**тээвэрлэх** 1) грузить, класть; 2) перевозить, транспортировать

## У

**уг** суть, сущность; данный; это  
**уг сурвалж** источник  
**угаас** с самого начала, искони  
**угаах** мыть; стирать  
**угталт** встреча  
**угтах** встречать  
**удаа** случай; раз  
**удаа дараа** не раз; подряд, последовательно  
**удаан** продолжительный, долговременный, длительный; долго, медленно  
**удалгүй** вскоре, незамедлительно  
**удах** медлить, мешкать; задержаться  
**удахгүй** не задерживаться  
**удирдагч** руководитель, лидер  
**удирдагчид** руководители  
**удирдамж** руководство  
**удирдан давшуулах** вести  
**удирдлага** руководство  
**удтал** долго  
**уйлах** плакать, рыдать  
**уйтгартай** скучно; грустно, печально; скучный; грустный, печальный  
**ул(а)** подошва (ноги, обуви)  
**улаан** красный  
**улаан буудай** пшеница  
**улам** еще, еще более, гораздо  
**улам илүү** еще больше  
**улбалзах** краснеть  
**улбар** красноватый; розоватый; рыжий  
**улирал** сезон, квартал; семестр  
**улмаар** затем

улс государство  
улс ардын аж ахуй народное хозяйство  
улс төрийн политический  
умарт северный  
унагаах сваливать; уронить, валить; свергать, низвергать  
унага(н) жеребенок  
унагалах [о]жеребиться  
унах (I) падать, сваливаться, отваливаться  
унах (II) сесть верхом  
унжилга висячий, привешенный, привязанный предмет (*например, елочное украшение*)  
униар мгла; дымка  
унтах спать; уснуть  
унишилгын танхим читальный зал  
унших читать  
унших бичиг книга для чтения  
ураг садан[г] родня  
урагшаа вперед  
урагшаа давшьяа вперед! (*букв. будем наступать!*)  
уралдаан соревнование  
урам хугарах разочароваться  
урам 1) мастер, искусник; 2) искусство, мастерство; 3) искусно, мастерски; 4) искусный, изящный  
уран гуалаг красота, великолепие  
уран зохиол художественная литература  
уран зохиолч писатель  
уран сайхан искусство  
уранхай рваный  
урга аркан  
ургамал растение  
ургах расти, вырастать  
ургац урожай  
урждар позавчера  
уриа призыв  
уриалал призыв  
уриалах призывать  
уриалга призыв  
урилга приглашение  
урин теплый; ласковый; тепло  
урих приглашать  
урихан тепленький; ласковый; милый; тепло  
урлаг искусство  
урлаг хийцтэй искусно сделанный, тонко выполненный (*о вещах*)  
урсах течь  
урсгал течение, поток; текущий  
урсгалаар самотеком  
урт длинный; долгий; долго  
урт удаан наслах долго, долго жить  
уруу *послелог* к, в; в сторону  
уруул губы  
урьд прежде, раньше

урцан гэр лачуга; хижина; обветшавшая юрта  
урьд урьдаас илүү лучше, чем раньше, как никогда лучше  
урьдаас сэргийлэх предупредить; предупредительный  
урьдахь прежний, предыдущий  
урьдчилал нөхцөл предпосылка  
урьдчилан хамгаалах предохранить, провести профилактические мероприятия  
урьхан тепленький; ласковый; милый; тепло  
ус(ан) вода  
ус тойром пруд; водоем  
усжуулах обводнить; обеспечить водой  
устгах уничтожить, ликвидировать  
утага(н) дым  
утга содержание; суть  
утга чанар *см. утга*  
утас(а) 1) нить, нитка; 2) проволока; провод, кабель; 3) телефон  
утга зохиол сочинение; художественная литература  
уудам обширный, необъятный  
уудам суд широкий путь, простор  
уужим широкий, просторный  
уул (I) гора  
уул (II) данный, тот самый, указанный  
уулзах встречаться  
уулс горы  
уур (I) водяной пар  
уур (II) зло, злоба  
уур хилэн(г) зло, злоба; гнев  
уурлах злиться, сердиться, беситься  
ууртай злой, сердитый  
уурхай шахта; копи; прииски  
уурын зуух батарея парового отопления  
уух пить  
уучлаарай извини, прости  
уучлах извинять, прощать  
ухаа хонгор светложелтый, светлосоловый, светлорыжий (*о масти лошадей*)  
ухаагүй безумный, неразумный; без ума; глупо, неумно  
ухаан ум, разум, сознание  
ухаан алдатлаа безумно; очень сильно  
ухаант хүн умный человек; мудрейший, умнейший человек  
ухамсар сознательность, сообразительность, смекалка; сознание  
ухамсартайгаар сознательно  
ухах (I) понимать, разуметь; соображать  
ухах (II) копать, рыть; выковыривать

**ухралт** отступление; регресс; деградация  
**ухралтгүй** неотступно, неуклонно  
**ухуулагч** пропагандист, агитатор  
**ухуулан таниулах** пропагандировать; провести агитационную работу; разъяснять  
**учир** причина, повод, обстоятельство  
**учир тоймгүй** очень, очень сильно  
**учиртай** 1) имеющий смысл, имеющий глубокий смысл; 2) необходимо, надо  
**учраа мэдсэн** знающий свои задачи; сознательный  
**учраа мэдэх** быть сознательным, звать свои цели  
**учраас** из-за  
**учруулах** 1) причинять, нанести; 2) свести, устроить свидание  
**уяа(н)** 1) привязь; 2) веревка, шпагат; шнур; 3) коновязь  
**уян** 1) мягкий; гибкий, эластичный, упругий; 2) слабый (*о характере*)  
**уянга** мотив; благозвучие  
**уянгалах** исполнять музыкальное произведение; петь  
**уянгат цээлхэн** благозвучный, звонкий, музыкальный (*о звуке, голосе*)  
**уяхан** гибкий; мягкий

## Ү

**үг** слово; речь  
**үгүүлэг(ээ)** рассказ; сочинение  
**үгүүлрүүн** сказал; изрек  
**үгүүлэх** говорить  
**үд(э)** полдень  
**үдийн хоол** обед  
**үдлэг** проводы  
**үдэх** сопровождать, провожать  
**үдэш** вечер  
**үдэшлэг** вечеринка, вечер  
**үе** 1) период, эпоха; 2) поколение; 3) *анат.* сустав  
**үелүүлэн өрөх** ставить рядами, сложить рядами, слоями  
**үерхэх** дружить; сдружиться (*о сверстниках*)  
**үзлээр** в духе  
**үзүүлэх** показывать, демонстрировать; оказывать (*например, помощь*)  
**үзүүр** 1) кончик, конец; 2) верхушка; острие, шпиль, игла  
**үзэг** перо; ручка  
**үзэгдэх** показываться, появляться  
**үзэл** взгляд, воззрение, мировоззрение, идеология  
**үзэл санаа(н)** идея, идеология  
**үзэл суртал** мировоззрение; идеология  
**үзэл** суртлын идеологический

**үзэмжтэй** привлекательный, приятный, благообразный (*на вид*)  
**үзэн ядах** ненавидеть  
**үзэсгэлэн(г)** выставка; великоление, красота  
**үзэсгэлэнтэй** прекрасный, прелестный, великолепный, замечательный  
**үзэх** смотреть, рассматривать; считать (*кем-л.*) принимать (*за кого-л.*)  
**үй түмэн** множество; бесчисленный  
**үйл** 1) деяние; дело; 2) рок, судьба  
**үйл ажиллагаа(н)** деятельность  
**үйл тамаа цайх** мучиться  
**үйл хэрэг** дело  
**үйл явдал** дело, деятельность  
**үйлдвэр(н)** производство; предприятие; промышленность  
**үйлдвэрийн байр(ан)** рабочее место  
**үйлдвэрийн газар** промышленное предприятие  
**үйлдвэрлэх** производить, выпускать  
**үйлдвэрлэх хүчнүүд** производительные силы  
**үйл үг** глагол  
**үйлдвэрчний эвлэл** профессиональный союз  
**үйлдэхүүн** продукция  
**үйлчин** творец, строитель  
**үйлчлэх** работать, служить; посвятить  
**үл отрицание** не  
**үл барам** не только  
**үл мэдэг** незаметно; едва заметно  
**үлгэр** 1) модель, образец, форма, выкройка; 2) сказка  
**үлгэр дууриалал** 1) пример, образец; подражание  
**үлгэр жишээ** пример, образец  
**үлгэртэй** образцовый, примерный  
**үлдэгдэл** 1) остаток; 2) пережиток  
**үлдэх** оставаться; отставать  
**үлдээх** оставить  
**үлэмж** весьма, значительно; значительный  
**үлэмжийн их** величайший, грандиозный, огромный  
**үлэмжхэн см. улэмж**  
**үлэх** отставать; оставаться (на месте)  
**үлээх** (I) дуть  
**үлээх** (II) оставить  
**үндсэн** основной, главный  
**үндсэн дээр(э)** на базе, на основе  
**үндсэн хууль** конституция, основной закон  
**үндсээрээ** своими корнями  
**үндэс(эн)** корень; основа  
**үндэслэн байгуулагч** основатель  
**үндэслэн байгуулах** основать  
**үндэснүүд** основы  
**үндэстний** национальный  
**үндэстний үзэлтэн** националисты

**Үндэстэн** народ, нация; националь-  
ность

**Үнсэх** 1) целовать; 2) нюхать; обонять

**Үнэ** цена, стоимость

**Үнэг(эн)** лисица

**Үнэгэн** лисий

**Үнэлж баршгүй** неоценимый; бесцен-  
ный

**Үнэлэлт** оценка

**Үнэлэх** 1) оценивать, производить  
оценку; давать, предлагать цену;  
2) ценить, дорожить

**Үнэмлэх** 1) удостоверять; 2) удосто-  
верение, документ, грамота

**Үнэн** 1) правда, истина; 2) правильный,  
истиинный, справедливый

**Үнэн зүрхний** чистосердечный, сер-  
дечный

**Үнэнч** правдивый, искренний; честный,  
бескорыстный

**Үнэнч шударга** правдивый, искрен-  
ный; честный; бескорыстный

**Үнэр** запах

**Үнэрлэх** нюхать, обонять, вдыхать

**Үнэртэх** 1) обонять, ощущать запах;  
2) пахнуть; приобретать запах

**Үнэт** ценный, драгоценный

**Үнэхээр** действительно, истинно; дей-  
ствительный, истинный

**Үнэхээрийн** действительный, истин-  
ный; подлинный

**Үнээ(н)** корова

**Үр(э)** 1) семя, плод; 2) дитя, ребенок;  
3) результат

**Үр бүтээлтэй** плодотворный

**Үр дун(г)** результат; плод

**Үр хүүхэд** дети

**Үргэлж** постоянно, всегда; сплошь;  
постоянный, сплошной

**Үргэлжид** постоянно, всегда

**Үргэлжлэх** продолжать(ся)

**Үржүүлэх** умножать

**Үрчиэх** сморщиться, нахмуриться

**Үрээ нас(ан)** трехгодовалый (*о ло-  
шадях*)

**Үс(эн)** волос(ы)

**Үс засах газар** парикмахерская

**Үсчин** парикмахер

**Үсэг** 1) буква; 2) алфавит, письмен-  
ность

**Үсэг зурах** подписаться, расписаться

**Үсээ засуулах** стричься

**Үүгээр** 1) этим; 2) здесь, по этой сто-  
роне, в этой местности; вот тут

**Үүд(эн)** дверь; ворота

**Үүд(эн)** облако

**Үүдтэр угсаа(н)** порода; породность

**Үүнд(э)** при этом; например; а имен-  
но

**Үүнээс урьд(а)** до этого

**Үүр** (I) гнездо; ячейка

**Үүр** (II) заря, рассвет

**Үүрд(э)** навеки; навсегда; вечно

**Үүрдийн** вечный

**Үүрийн цолмон** утренняя звезда; Ве-  
нера

**Үүрэг** 1) ноша, груз; 2) обязанность;  
долг; роль; обязательство

**Үүрэх** нести, вынести (*на плечах, на  
спине*)

**Үүсгэл** начинание, почин

**Үүсгэл тавих** положить начало

**Үүсэх** зарождаться, происходить

**Үхүүлэх** допустить гибель; допу-  
стить падеж (скота)

**Үхүүлэхгүй** не допускать гибели; не  
допустить падежа

**Үхэр** крупный рогатый скот

**Үхэр тэргэ(н)** бычья телега, арба

**Үхэх** гибнуть, погибать; умереть

**Үхээнц дорой** забитый, беспомощный

## Х

**хаа(на)** где? куда?

**хаалга** дверца; ворота

**хаан** хан; царь, монарх, император

**хаанаас** откуда

**хаанахь** откуда, из каких мест

**хаант** ханский; царский

**хаармаг хармаг** (*гобийский кустар-  
ник*)

**хааяа** иногда; редко, изредка

**хав усилительная частица**

**хавар** весна

**хаваржаан** весеннее стойбище, ве-  
сенник

**хавигүй** несравненный; несравнимо,  
значительно

**хавтас** папка; переплет

**хавтгай** плоский, широкий

**хавтгайвтар** широковатый; плоскова-  
тый

**хавчих** 1) теснить, притеснять; тра-  
вить; 2) зажать, прищемить; при-  
жать

**хавчлага** 1) притеснение; травля;  
2) зажатие, прищемление; прижатие

**хавь** возле, около

**хавьгүй см. хавигүй**

**хага зүсэх** разрезать; рассечь

**хага ниргэх** разбить, разломать

**хагалалт** вспашка

**хагалах** 1) разбить; 2) порвать, ра-  
зорвать; 3) прорезать; 4) пахать

**хагас** половина

**хагас сайн өдөр** под выходной день

**хагас хугас** половина

**хагдах** 1) распространяться; распро-  
щаться; 2) избавиться

**хадам ав** тесть; свекор  
**хадам эх** 1) теща; 2) свекровь.  
**хадах** 1) подрезать, срезать; 2) ко-  
сить; жать, убирать (хлеб); 3) вби-  
вать (гвоздь); пришить (пуговицу)  
**хадгалах** хранить; воплощать  
**хадланг** 1) покос, сенокосный луг;  
2) сенокос  
**хадлангийн талбай** сенокосный луг,  
сенокосные угодья  
**хажуу** бок, сторона  
**хажуу дахь** находящийся рядом,  
сбоку  
**хажуугаар** мимо, около  
**хажуугийн** боковой; находящийся  
рядом, по соседству  
**хажууд(а)** возле, около  
**казах** кусать(ся)  
**хайгуул** 1) розыск; изыскание; 2) раз-  
ведка, дозор  
**хайр** 1) любовь; забота; 2) милость;  
жалость  
**хайр найргүй** беспощадно  
**хайр талархал** 1) любовь; 2) благо-  
дарность  
**хайр халамж** забота; жалость  
**хайр хүндэтгэл** уважение, почет  
**хайрах** 1) жарить, поджаривать;  
2) прижигать  
**хайрлах** 1) любить; ласкать; 2) жалеть,  
питать чувство жалости; сожалеть;  
3) подарить, пожаловать  
**хайрт** любимый, дорогой  
**хайрцаг** коробка, ларец; ящик  
**хайчих** куда итти, куда пойти  
**халаах** разогреть, нагревать; подо-  
греть  
**халамж** помощь, поддержка, под-  
спорье; любовь, преданность  
**халамжит** щедрый; бескорыстный  
(*о помощи*)  
**халдан довтлох** нападать, вторгаться  
**халдах** 1) покусаться, посягать;  
2) прилипнуть; 3) заразиться  
**халдварт** заразный  
**халиугчин** саврасый  
**халиун зээрд** светлорыжий (*о масти*  
*лошадей*)  
**халиурах** переливаться бурым и жел-  
тым оттенками  
**халуувтар** жарковато; жарковатый  
**халуун** горячий; жаркий  
**халцрах** 1) быть потертым; 2) стать  
голым; оголиться, лишиться расти-  
тельности; получить прогалины  
**хамаатай** причастный, имеющий от-  
ношение, принадлежащий  
**хамаг** все; весь  
**хамгаалах** защищать; оберегать,  
оборонять; предохранять

**хамгийг ялагч** всепобеждающий  
**хамгийн** самый  
**хамрах** охватывать; сгребать все  
**хамт** вместе, воедино  
**хамгарсан** совместный, объединен-  
ный  
**хамтагтах** объединить; обобществить  
**хамтрал** колхоз; объединение; артель  
**хамтралжуулах** коллективизировать  
**хамтралчид** колхозники  
**хамтран ажиллах** работать совместно,  
работать коллективно; сотрудничать  
**хамтран найрамдах** сотрудничать  
**хамтын ажиллагаа(н)** совместная,  
коллективная работа, сотрудничество  
**хана** стена, стенка; решетчатая стен-  
ка юрты  
**хангагдах** обеспечиваться; удовле-  
твориться  
**хангалтгүй** неудовлетворительно; не-  
удовлетворительный  
**хангах** удовлетворять, обеспечивать  
**ханых** удовлетворяется  
**Хангай** Хангай (*горно-лесистая зо-  
на МНР*)  
**хангинасан цэвдэг хөлдүү өвөл** су-  
ровая зима, зима с трескучими мо-  
розами  
**хангинах** звенеть; звучать  
**хандаж** обращаясь, повернувшись,  
смотря...  
**хандах** устремиться, направиться, по-  
вернуться  
**ханхалах** пахнуть, издавать запах  
**ханцуй** рукав (одежды)  
**хань** друг, спутник, товарищ  
**хар(а)** черный  
**хар хүн** мужчина; муж  
**хар хүү** юноша  
**хараа(н)** 1) зрение, взор; 2) мушка;  
прицел; 3) причина  
**хараах** ругать; проклинать  
**хараач** смотри же  
**харайлгах** скакать, пустить взапуски  
**харайх** скакать, прыгать  
**харамгүй** не скупясь; щедро  
**харамсал** сожаление  
**харамсах** сожалеть  
**харамсалтай** достойно сожаления  
**харандаа** карандаш  
**харанхуй** темнота; темный  
**харанх** видеть; смотреть, глядеть  
**харгалзах** учитывать, принимать во  
внимание  
**харгис** реакционный; жестокий, бес-  
человечный  
**харгуй** дорога, тропинка  
**харж хамгаалах** охранять, стеречь  
**харжигнан дуугарах** звенеть; изда-  
вать звук

**харийн** чужой; чужеземный, иноземный  
**харилгүй** не отступая, не боясь.  
**харилцаа(н)** связь, взаимоотношение  
**харилцаа холбоо(н)** связь  
**харилцан** взаимно, друг друга; между собою  
**харилцан итгэлцэх** доверять друг другу  
**харилцан туслалцах** взаимопомощь; взаимно помогать  
**харуу** 1) ответ; 2) отпор; опровержение  
**харуулах** 1) отвечать; отблагодарить; вознаградить; 2) пасти  
**хариуцлага** ответственность  
**хариуцлагатай** ответственный  
**хариуцлагатан** ответственные (работники)  
**хариуцуулах** возложить ответственность  
**харих** возвращаться (домой, на родину), итти домой  
**харлах** чернеть  
**харц** взгляд  
**харшлах** 1) относиться враждебно; 2) притеснять, преследовать  
**харь** чужой  
**харьяа(н)** подведомственный, подчиненный, находящийся в системе  
**харьяат** 1) подданный; 2) находящийся в подчинении, подведомственный  
**хасах** вычитать, отнимать; лишать, убавлять, сокращать  
**хатан зориг** твердая воля, стальная воля  
**хатгамал** вышивка  
**хатгамлын** вышивальный  
**хатруулах** пустить рысью  
**хатуу** твердый, крепкий; жестокий, строгий  
**хатуу ширүүнээр** жестоко, сурово, строго  
**хатуужил** 1) твердость, стойкость (характера); 2) закалка  
**хатуужих** закаляться  
**хатуужуулах** закалять  
**хацар** щека  
**хачин** 1) прелестный; 2) странный, непонятный  
**хачин сайхан** чудесно, прелестно; прекрасно; чудесный, прелестный, прекрасный  
**хашаа(н)** 1) загон; 2) изгородь; 3) двор  
**хашгирах** провозглашать; кричать; гаркать; воить  
**хашир** 1) осторожный; предусмотрительный; 2) имеющий житейский опыт

**хаяа(н)** нижние края стены (юрты, здания)  
**хаях** 1) бросать, отбрасывать оставлять; 2) терять  
**хивс** ковер  
**хий** 1) воздух, газ; 2) попусту; зря  
**хийгээд** и  
**хийморь** 1) флажок счастья; 2) символ счастья  
**хийсэх** 1) колыхаться; 2) быть развеванным ветром; выдуться  
**хийх** 1) делать, производить; 2) вкладывать; сыпать, наливать  
**хийчмээр** можно сделать, можно выполнить  
**хилэн бадарсан** гневный  
**хил** граница  
